

Organizer



Co-funded by the
Erasmus+ Programme
of the European Union



**European Union
Institutional Framework**

Co-organizers



MINISTRY OF FOREIGN AFFAIRS
MONGOLIA



NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA
DEPARTMENT OF
EUROPEAN STUDIES



NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA
DEPARTMENT OF
POLITICAL SCIENCE



MONGOLIAN ACADEMY OF SCIENCES
INSTITUTE OF INTERNATIONAL STUDIES

EUROPEAN UNION: CURRENT SITUATION, FUTURE TRENDS

INTERNATIONAL CONFERENCE

20TH OF OCTOBER, 2023

CONSENSUS HALL, MINISTRY OF FOREIGN AFFAIRS, ULAANBAATAR, MONGOLIA



Organizer



Co-funded by the
Erasmus+ Programme
of the European Union



**European Union
Institutional Framework**

Co-organizers



NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA
DEPARTMENT OF
EUROPEAN STUDIES



NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA
DEPARTMENT OF
POLITICAL SCIENCE



MONGOLIAN ACADEMY OF SCIENCES
INSTITUTE OF INTERNATIONAL STUDIES

**“ЕВРОПЫН ХОЛБОО: ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ИРЭЭДҮЙН ЧИГ
ХАНДЛАГА”**

ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

**“EUROPEAN UNION: CURRENT SITUATION, FUTURE TRENDS
INTERNATIONAL CONFERENCE**

20th of October, 2023

Consensus Hall, Ministry of Foreign Affairs

Ерөнхий редактор: С.Одхүү \ОТИС-ийн багш, доктор (Ph. D), профессор\

Техник редактор: Ч.Соёлмаа \ОТИС-ийн багш, доктор (Ph. D), дэд профессор\

Эмхэтгэж, эх бэлтгэсэн: Г.Жаргалсайхан \ОТИС-ийн багш

Цаасны хэмжээ: В5

Хэвлэлийн хуудас: 35

ISBN: 978-9919-9872-5-1

**“ЕВРОПЫН ХОЛБОО: ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА”
ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР**

2023.10.20

Гадаад Харилцааны Яамны Зөвшилцөл танхимд

08:30-09:00 **БҮРТГЭЛ**

09:00:09:30 **НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Н.Энхзаяа, Отгонтэнгэр Их Сургуулийн захирал, Доктор (Ph.D.), Дэд профессор,

Г.Амартүвшин, Гадаад Харилцааны Дэд сайд

Аксель Никейз, Европын Холбооноос Монгол Улсад суугаа Элчин Сайд

Ян Вытопил, Бүгд Найрамдах Чех Улсаас Монгол Улсад суугаа элчин сайд

НЭГДСЭН ЗУРАГ АВАЛТ

НЭГДҮГЭЭР САЛБАР ХУРАЛДААН

Салбар хуралдааны хэл: Монгол

Модератор:

Д. Золбоо /ШУА-ийн ОУСХ-ийн захирал, Доктор (Ph.D.)/

В.Ариунчимэг /Гадаад мэдээний хөтлөгч, Отгонтэнгэр Их Сургуулийн СЗОУХТ-ийн багш/

09:30-09:45 **Европын Холбоо-Монгол Улсын харилцаа, хамтын ажиллагаа**

Б.Биндэръяа, Гадаад Харилцааны Яамны Европын Газрын Дэд захирал

09:45-10:00 **Өнөөгийн хуваагдмал ертөнцөд ЕХ-ны эзэлж буй олон улсын байр суурь: Монголоос харахуй**

Г.Төмөрчулуун, Хүндэт Дипломатч, ОТИС-ийн зөвлөх багш, Доктор (Sc.D.), Профессор

10:00-10:30 **ЦАЙНЫ ЗАВСАРЛАГА**

10:30-10:45 **Монгол Улс, Европын Холбооны харилцааны тулгамдсан зарим асуудал: Пост-Брекситийн үе GSP+ жишээн дээр**

Д.Уламбаяр, ХИС-ОУХНСС-ийн захирал, Доктор (Sc.D.), Профессор

- 10:45-11:00 **Монгол Улсын гадаад хэлний сургалтын бодлогын асуудлууд ба Европын Холбооны жишиг**
- Н.Бээз, Боловсролын хөгжлийн онол, арга зүйн судлаач, Доктор (Sc.D.), Академич*
- С.Санжаабадам, Хүүхдийн хөгжлийн судлаач, Доктор (Ph.D.), Профессор*
- Б.Баярмаа, Докторант, Гадаад хэлний сургалт, хүүхдийн хөгжлийн судалгаа, боловсролын тогтолцооны судлаач*
- 11:00-11:15 **Боловсролын шинэтгэл: Финландаас суралцаж, Монголоор сэтгэхүй**
- Б.Энхмандах, Элчин сайд, Доктор (Ph.D.)*
- Э.Энхчимэг, Япон Улсын Киотогийн Их Сургууль, Доктор (Ph.D.)*
- 11:15-11:30 **Монгол хүний насан туршийн хүмүүнлэгийн боловсролд Европын сонгодог уран зохиолын нөлөө**
- Б.Галиндэв, Отгонтэнгэр Их Сургуулийн Сэтгүүл зүй, Олон улсын харилцааны тэнхимийн багш, Доктор (Ph.D.), Профессор*
- 11:30-11:45 **ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**
- 11:45-12:00 **Боловсролын дижиталчлал: Европын Холбооны боловсролын талаар баримталж буй стратеги, сургалтын арга зүйд гарч буй өөрчлөлтүүд**
- Г.Туяагэрэл, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн ахлах багш, Доктор (Ph.D.)*
- 12:00-12:15 **Европын Холбооны байнгын аюулгүй байдал, гадаад бодлогын парадигм шилжилт: Өөрчлөлтөөс уян хатан хандлага руу**
- Ш.Эвсанаа, ДХИС-ийн Эрх зүй, Нийгмийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, Ахмад*
- 12:15-12:30 **Европын хэлний бодлого, Монгол Улсын гадаад хэлний сургалтад тусгах нь**
- М.Одонтуяа, МУИС-ийн Европ судлалын тэнхимийн багш*
- 12:30-12:45 **Соёл иргэншлийн ялгаа ба нутгийн өөрөө удирдах ёсны хөгжил: Европын Холбоо, Британи, Монгол Улсын жишээн дээр**
- Т.Есүхэй, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш*
- О.Мөнхжаргал, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш*
- 12:45-13:00 **Европын Холбооны хөгжлийн чиг хандлага, сорилт**
- О. Цэрэнчимэд, Удирдлагын Академийн докторантур, магистрантурын албаны дарга, Доктор (Ph.D.), Дэд профессор*

Э.Халиунаа, Удирдлагын Академийн Бодлого улс төр судлалын тэнхимийн ахлах багш

13:00-13:15 **ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

13:15-14:30 **ӨДРИЙН ХООЛ** (Аюуд тауэрын 1 давхарт, REVO GARDEN ресторанд)

ХОЁРДУГААР САЛБАР ХУРАЛДААН

Салбар хуралдааны хэл: Англи (Синхрон орчуулгатай)

Модератор:

Н.Мөнх, МУИС-ийн Европ судлалын тэнхимийн эрхлэгч, Доктор (Ph.D.)

Г.Золзаяа, Отгонтэнгэр Их Сургуулийн Сэтгүүл зүй, Олон улсын харилцааны тэнхимийн эрхлэгч

14:30-14:45 **Европын Холбоо ба боловсролын даяаршил: Европын Дээд боловсролын ирээдүйн голлох чиг хандлага**

Ян Вытопил, Бүгд Найрамдах Чех Улсаас Монгол Улсад суугаа элчин сайд

Лукаш Янечек, Бүгд Найрамдах Чех Улсаас Монгол Улсад суугаа элчин сайдын орлогч дарга

14:45-15:00 **Европын Холбооноос Монгол Улсад хэрэгжүүлэх Олон жилийн баримжаат хөтөлбөр (2021-2027) Гишүүн орнуудтай үргэлжлүүлэн түншлэх, хамтран ажиллах зарчим, заалтуудын таван нэмэлт өөрчлөлт.**

Энтони Миллер, ОТИС-ийн Сэтгүүл зүй, Олон улсын харилцааны тэнхимийн зочин профессор, Швейцарийн Бизнес Судалгааны сургуулийн Доктор (Ph.D.)

Ж.Золбаяр, ОТИС-ийн Бодлого, Хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал, Докторант

15:00-15:15 **Европын Холбоонд тулгарч буй өнөөгийн сорилтууд (Zoom платформоор)**

Ник Маринеску, Румын Улсын Трансилваниа Их Сургуулийн багш, Доктор (Ph.D.), Профессор

15:15-15:30 **Европын Холбооны хууль, эрх зүйд гишүүн улсуудын парламентын үүрэг, оролцоо (Zoom платформоор)**

Шуш Адит, Унгар Улсын Сегедийн Их Сургуулийн багш, Доктор (Ph.D.), Дэд профессор

15:30-15:45 **Европын Холбоо ба цагаачлал дахь орох/оршин тогтнох боломж (Zoom платформоор)**

Омер Догукан Услу, Олон улсын харилцаа судлаач, Унгар Улсын Сегедийн Их Сургуулийн Улс төр, Хуулийн сургуулийн докторант

15:45-16:00 **Хуулийн засаглал ба нэгдсэн төрийн бодлого (Zoom платформоор)**

Рихард Кусу, Олон улсын харилцаа судлаач, Унгар Улсын Сегедийн Их Сургуулийн Улс төр, Хуулийн сургуулийн докторант

16:00-16:15 **Банкны тогтвортой байдлын шинэ чиг хандлага дахь Европын контент (Zoom платформоор)**

Наталия Шулга, Украины Эдийн засаг, худалдааны их сургуулийн Банкны тэнхимийн эрхлэгч, Доктор (Sc.D.), Профессор

Серхий Савлук, Украины Эдийн засаг, худалдааны их сургуулийн Банкны тэнхимийн багш, Доктор (Sc.D.), Дэд профессор

16:15-16:30 **ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

16:30-16:40 **ХААЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА: БАТЛАМЖ ГАРДУУЛАХ**

CONFERENCE AGENDA

“EUROPEAN UNION: CURRENT SITUATION, FUTURE TRENDS ”

INTERNATIONAL CONFERENCE

08:30-09:00 **REGISTRATION**

09:00:09:10 **OPENING REMARKS**

Dr. Enkhzaya Namsrajav, Associate Professor, Director of Otgontenger University

09:10-09:25 **WELCOMING SPEECH**

Amartuvshin Gombosuren, Deputy Ministry of Foreign Affairs of Mongolia

Axelle Nicaise, Ambassador of the European Union to Mongolia

Jan Vytopil, Ambassador, Czech Embassy

09:25:09:30 **PHOTO SESSION**

MORNING SESSION PROGRAM

Session Language: Mongolia

Moderators of the First Session:

Dr. Zolboo Dashnyam, Associate Professor, Director of the Institute of International Studies, Mongolian Academy of Sciences

Ariunchimeg Viktor, Anchor of Foreign News, Lecturer, Departments of Journalism and International Relations, Otgontenger University

09:30-09:45 **“European Union, Mongolia Partnership and Cooperation”**

Binderiya Batsukh, Vice Director, Department of Europe, Ministry of Foreign Affairs of Mongolia

09:45-10:00 **“The International Position of The European Union in A Fragmented World: A View from Mongolia”**

Dr. Tumurchuluun Guudai, Sc.D., (Honorable Diplomat), Professor, Department of Journalism and International Relations, Otgontenger University

10:00-10:30 **COFFEE BREAK**

10:30-10:45 **The Key Issues of Mongolia and EU Relationship in the Post BREXIT: The Case of Generalized System of Preferences Plus**

Dr. Ulambayar Denzenkham, Sc.D., Professor, Dean, School of International Relations and Social Studies, University of the Humanities

- 10:45-11:00 **Problem of Foreign Language Education Policy in Mongolia and the European Union Standard**
Dr. Begz Nadmid, Sc.D., Academician
Dr. Sanjaabadam Sed, Professor & Specialist in Educational Quality Research
Bayarmaa Bazarsuren, Ph.D. Reader, Foreign Language Training and Child Development Researcher
- 11:00-11:15 **Educational Reform: Learning from Finland, Thinking as a Mongolia**
Dr. Enkhmandakh Baldan, Ambassador
Dr. Enkhchimeg Enkhmandakh, Kyoto University, Japan
- 11:15-11:30 **The Influence of European Classic Literature on the Humanitarian Education of Mongolians**
Dr. Galindev Budregch, Professor, Department of Journalism and International Relations, Otgontenger University
- 11:30-11:45 **DISCUSSION**
- 11:45-12:00 **Digital Education: Governments' Strategies, Teaching Tools in the European Union**
Dr. Tuyagerel Ganbat, Senior Lecturer, Department of Political Science, National University of Mongolia
- 12:00-12:15 **A Paradigm Shift in the EU's Common Foreign and Security Policy: From Transformation to Resilience**
Evsanaa Shambaa, Captain, Senior Lecturer, Department of Social Science, University of Internal Affairs
- 12:15-12:30 **The Impact of European Language Policy on Foreign Language Teaching in Mongolia**
Odontuya Mishigdorj, Senior Lecturer, Department of European Study, National University of Mongolia
- 12:30-12:45 **Diversity of Civilizations and Development of Local Governance: On the Comparison of Great Britain, EU, and Mongolia**
Yesukhei Tumurbaatar, Lecturer, Department of Political Science, National University of Mongolia
Munkhjargal Otgonbayar, Lecturer, Department of Political Science, National University of Mongolia
- 12:45-13:00 **Development Trends and Challenges of the European Union**

Dr. Tsernchimed Otgontogtool, Associate Professor, Head of Department for Post Graduate Studies, National Academy of Governance

Khaliunaa Erdenekhuu, Senior Lecturer, Department of Policy and Political Studies, National Academy of Governance

13:00-13:15 **DISCUSSION**

13:15-14:30 **LUNCH (Revo Garden Restaurant, 1st Floor, Ayud Tower)**

AFTERNOON SESSION

Session Language: English (with Simultaneous translation)

Moderators of the Second Session:

Dr. Munkh Namsrai, Head of the Department of European Studies, National University of Mongolia.

Zolzaya Gankhuyag, Head of the Department of Journalism and International Relations, Otgontenger University.

14:30-14:45 **European Union and Educational Globalization: Main Trends in the European Higher Education**

Jan Vytopil, Ambassador, Czech Embassy

Lukáš Janeček, Deputy Head of the Czech Embassy

14:45-15:00 **The European Union and its Vision for Mongolian Society Agreement (2021-2027) Five Amendments be implemented to the Principles and Provisions Currently in Force for Continued Partnerships and Cooperation with Member States**

Dr. Antony D. Miller, Visiting Professor, Department of International Relations & Journalism, Otgontenger University, Ph.D. from the Swiss School of Business Research, Zurich

Zolbayar Jargalsaikhan, Ph.D. Reader, Executive Vice Rector of Otgontenger University

15:00-15:15 **Current challenges of the European Union (Online via Zoom)**

Dr. Nick Marinescu, Professor, Transylvania University of Brasov, Romania

15:15-15:30 **The Role of National Parliaments in the EU Legislation (Online via Zoom)**

Dr. habil. Soós Edit, Associate Professor, University of Szeged, Hungary

15:30-15:45 **The possible effects of entry/exit system and the ETIAS on the EU and Immigration (Online via Zoom)**

*Ömer Doğukan Uslu, Ph.D. Reader, Faculty of Law and Political Science,
University of Szeged, Hungary*

15:45-16:00 **Cohesion Policy versus the Rule of Law (Online via Zoom)**

*Richárd Kószó, Ph.D. Reader, Faculty of Law and Political Science,
University of Szeged, Hungary*

16:00-16:15 **European Content of New Banking Stability Architecture (Online via Zoom)**

*Dr. Natalia Shulga, Sc.D., Professor, Head of Banking & Chair of the
State University of Trade and Economics, Kyiv, Ukraine*

*Dr. Serhii Savluk, Sc.D., Associate Professor of Banking & Chair of the
State University of Trade and Economics, Kyiv, Ukraine*

16:15-16:30 **DISCUSSION**

16:30-16:40 **CLOSING REMARKS**



**ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ ДОКТОР, ДЭД ПРОФЕССОР
Н.ЭНХЗАЯАГИЙН**

**“ЕВРОПЫН ХОЛБОО: ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА”
ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫГ НЭЭЖ ОТГОНТЭНГЭР ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ ДОКТОР, ДЭД ПРОФЕССОР Н.ЭНХЗАЯАГИЙН ХЭЛСЭН ҮГ**

Эрхэм хүндэт эрдэмтэн судлаачид аа!

Эрхэм хүндэт зочид төлөөлөгчид өө!

Олон улсын харилцаа, хамтын ажиллагааны чухал асуудлыг сонгон, хэлэлцэхээр хуран цугласан Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая

Отгонтэнгэр Их Сургууль, ГХЯ, МУИС-ийн Улс төр судлал, МУИС-Европ судлалын тэнхим, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс хамтран зохион байгуулж буй “Европын Холбоо: Өнөөгийн байдал, ирээдүйн чиг хандлага” Олон улсын эрдэм шинжилгээний хурал нь цаг үеэ олсон, онол арга зүйн өндөр ач холбогдолтой арга хэмжээ болж байна гэж үзэж байна.

Монгол Улс болон Европын холбооны эгнээнд багтдаг 450 сая гаруй хүн ам бүхий улс орнууд орон зайн хувьд алслагдсан, цаг хугацааны ихээхэн зөрүүтэй боловч ойлголцол, хүндэтгэл, итгэлцлийг зарчим болгон, хамтын ажиллагааны түвшинд ойр дотно, стратегийн түншлэгч хөршүүд билээ. Хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа жилээс жилд өргөжин тэлж, нийгмийн олон салбар, хүрээг хамрах боллоо.

Монгол Улс нь геополитикийн давтагдашгүй байршилтай Европын Холбооны хувьд Ази дахь “үнэ цэнтэй түнш” мөний хувьд олон талт, өргөн хүрээ бүхий бодлого, үйл ажиллагааг нь дэмжиж ирсэн билээ.

Хоёр этгээдийн хооронд байгуулсан “Түншлэл, хамтын ажиллагааны тухай хэлэлцээр”, бусад гэрээ, бодлогын баримт бичгүүдэд тусгасан заалтуудыг хэрэгжүүлэхийн төлөө талууд харилцан хариуцлага хүлээж, хичээн ажилладаг юм.

Хоёр талын харилцааны нэг тэргүүлэх, чухал чиглэл нь боловсролын салбар дахь хамтын ажиллагаа мөн. Энэ чиглэлд боловсролын салбарт хүндтэй байр суурийг баттай эзэлсэн, хувийн хэвшлийн анхдагч, БШУЯ-аас албан ёсоор зарласан Монголын их дээд сургуулиудын эрэмбэ чансаагаар наймдугаарт жагссан Отгонтэнгэр Их Сургууль өөрийн хувь нэмрээ оруулахыг ямагт хичээн ажиллаж ирсэн билээ.

Европын холбооны хөрөнгө оруулалттай Эрасмус хөтөлбөрийг тус сургууль амжилттай хэрэгжүүлж бодитой үр дүн гарч, энэ хөтөлбөрийн хүрээнд EUIF-Жан Моннет Модуль төслийн ажил ид өрнөж байна. Төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын явцад мэргэжлийн эрдэмтэн судлаачидтай ЕХ-ны бодлого, үйл ажиллагааны асуудлаар санал солилцох ярилцлага хийж, нөхцөл байдлыг тодруулан, сургууль дээрээ "Европын Холбоо, Европын Холбооны улс төр, олон улсын хамтын ажиллагаа" Профессорын судалгааны баг ажиллуулах, бусад олон хэлбэрийн ажил зохион байгуулж, "Европын холбооны институци" 2 багц цагийн хичээлийн хөтөлбөр боловсруулан, сургалт явуулсан нь оролцогчид оюутнуудын зүгээс талархал хүлээсэн болно. Профессорын багийнхан хичээлийн хөтөлбөрөө үндэс болгон "Европын холбоо" сургалтын гарын авлагыг бичиж, нийтийн хүртээл болгосныг хурлын хүндэт индэр дээрээс Та олны сонорт дуулгахад таатай байна.

Европын холбооны дэмжлэг, санхүүжилттэй Жан Моннет Модуль төслийн хүрээнд зохион байгуулж буй олон улсын эрдэм шинжилгээний энэхүү хуралд гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдаас 30 гаруй илтгэл ирүүлснээс ажлын хэсэг, редакторууд сонголт хийж, гадаад 7, дотоодын 11 илтгэлийг хэлэлцэхээр бид энд хуран цуглаад байна. Бусад илтгэлүүдийг хурлын эмхэтгэлд хэвлэж Та бүхний гарт хүргэсэн байна.

Ийнхүү олон улсын эрдэм шинжилгээний хурлыг нээснийг мэдэгдэж, хурлын ажиллагаанд амжилт хүсье.

Баярлалаа.



***AXELLE NICAISE, AMBASSADOR OF
THE EUROPEAN UNION TO MONGOLIA***

WELCOME SPEECH

Ladies and gentlemen, esteemed participants, and distinguished guests,

As the Ambassador of the European Union to Mongolia, it is truly an honour to stand before you today and inaugurate this exceptional gathering, dedicated to exploring the rich tapestry of knowledge exchange between the European Union and the academic community in Mongolia.

The partnership between the European Union and Mongolia has evolved in many ways since the first EU mission came to Ulaanbaatar in October 1990. We developed mutual ideals, fostered political and economic cooperation, expanded trade investments, and engaged in creating prosperity. Today, we are able to look back on more than 30 years of collaboration.

Since the establishment of the EU Delegation to Mongolia in 2017, we have witnessed, in the realms of scientific discovery and academic excellence, the profound impact of cooperation between our two regions. It represents a bridge between cultures and fosters mutual understanding. This collaboration creates an environment of shared learning that transcends geographical boundaries. A priority of this bilateral relationship is the consistent advancement of research, innovation, and education.

Together, we have established a vibrant partnership that enriches the academic landscape and opens new horizons for both our regions.

We celebrate today the implementation of the Jean Monnet Module project, which is part of the esteemed Erasmus Plus programme and enables European Union studies in Mongolia. From this milestone, this academic event has been established: a conference that celebrates the vision of our collective achievements, testifies the transformative power of international collaboration, and provides a vision for the future. It is a call to action and an opportunity to deepen our commitment to inspire the next generation of scholars who will create a bridge between Europe and Mongolia.

As we come together to honour the solid partnership between the EU and Mongolia, let us be mindful that our greatest success lies in the positive impact we have on cultural understanding and cooperation between our regions.

Let us pledge to continue our journey, embracing new challenges and opportunities with unwavering determination and a resolute commitment to nurturing the ties that bind us.

It is evident that this international academic conference holds immense theoretical and practical significance for the advancement EU studies in Mongolia. I extend my warmest wishes for the success of this conference, expressing my support to all the academics, organising bodies, and participants who play a vital role in driving forward our collective research efforts.



**JAN VYTOPIL, AMBASSADOR,
EMBASSY OF THE CZECH REPUBLIC
TO MONGOLIA**

WELCOME SPEECH

Distinguished guests, ladies and gentlemen,

I extend my warm greetings to all of you this morning. It is a privilege to stand before you today, not only as a speaker at this conference but also as a representative of one of the European Union member countries, steeped in a long history of partnership with Mongolia and a rich tradition of educational collaboration.

Today, we find ourselves in a new era of educational cooperation, an exchange between two democratic nations with intertwined histories and a strong tradition of friendship. The substantial number of graduates from Czech educational institutions in Mongolia, the sizable Mongolian community that has experienced Czech culture and language, and the equally prominent Mongolian community in the Czech Republic all underscore the imperative to strengthen our collaboration.

Over the past three decades, our societies have undergone profound transformations. The recent global pandemic has posed challenges, leading to a slowdown in student exchanges. However, it has also prompted us to embrace online learning, introduce shorter-term study abroad programs, and engage a growing number of students in international partnerships, ensuring that more of our students gain valuable global experience.

A parallel trend can be observed with our Mongolian partners, as contacts have increased, and initiatives like the Presidential Mission 2100 program have facilitated the presence of more Mongolian students in Czech universities. We have revitalized Czech language education at the National University of Mongolia and have jointly reactivated our bilateral educational agreements, initiating new student exchange programs. Furthermore, we have welcomed a distinguished Mongolian diplomat for specialized education and research in Prague.

Today, we embark on a new chapter and must adapt to the aforementioned changes. As we venture into an increasingly competitive global landscape, we must flex our academic muscles to

harness the synergy between research and academic training. These goals are unattainable without transcending national boundaries. However, we face obstacles due to the fragmentation of the international academic environment and the complexity of administrative rules and procedures.

This conference serves as a pivotal forum through which we may deepen our comprehension of these processes from both perspectives. Its primary objective is to streamline the procedures for subsequent student exchanges, thereby broadening the horizons for our future collaborative endeavors.

Czechoslovakia and now Czechia have consistently stood by Mongolia as steadfast allies. Our history of support spans across decades and encompasses diverse scientific and educational domains, from medicine and mining to geology. Pioneering projects such as the successful reintroduction of the Przewalski horse stand as a testament to our collaborative efforts, encompassing extensive educational and research endeavors.

As we deliberate upon the current state and future trends of the European Union during this conference, let us not forget the significance of collaboration and shared values. I wish to emphasize that we hold common values with Mongolians; we place our faith in the power of open dialogue and the efficacy of democratic processes. Let us employ these principles as guiding lights to inspire and empower the younger generation.

Thank you for your attention.

НЭГДҮГЭЭР САЛБАР ХУРАЛДААН

ЕВРОПЫН ХОЛБОО-МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Б.Биндэръяа


Гадаад Харилцааны Яамны Европын Газрын Дэд захирал



MONGOLIA – EU RELATIONS

Speaker: Binderiya Batsukh, Vice Director, Department of Europe,
Ministry of Foreign Affairs of Mongolia

CONSENSUS HALL, MINISTRY OF FOREIGN AFFAIRS IN ULAANBAATAR 2023.10.20



- 1 August 1989 – Establishment of diplomatic relations
- Mongolia’s third neighbor – Concept of Foreign Policy of Mongolia
- 2013 Partnership and Cooperation Agreement (entry into force 2017)
- Development cooperation since 1993
- Multi-Annual Indicative Program since 2007

CONSENSUS HALL, MINISTRY OF FOREIGN AFFAIRS IN ULAANBAATAR 2023.10.20



- Establishment of the EU Delegation in Ulaanbaatar 2017
- Generalised Scheme of Preferences – GSP+
- Trade turn-over 968.2 million USD (export 294, import 674.2)
- Forest partnership MOU signed between President Ukhnaa Khurelsukh and President Ursula von der Leyen, in support of “Billion trees” national movement



Cooperation mechanisms:

- Mongolia-EU Parliamentary group
- Joint Committee between Mongolia and the EU
- Policy dialogue
- Human rights dialogue
- Development cooperation working group
- Trade and investment subcommittee



Current MIP 2021-2027 (2021-2024 31 mil.usd grant projects in Green development, democratic and economic development and other)



**Thank you for
listening.**

Speaker: BINDERIYA BATSUKH, Vice Director, Department of Europe, Ministry of Foreign Affairs of Mongolia

**ӨНӨӨГИЙН ХУВААГДМАЛ ЕРТӨНЦӨД ЕХ-НЫ ЭЗЭЛЖ БҮЙ ОЛОН УЛСЫН БАЙР
СУУРЬ: МОНГОЛООС ХАРАХУЙ**

*Г.Төмөрчулуун
Улс төрийн шинжлэх ухааны доктор /ОУХ/, Проф.
Хүндэт дипломатч*

Энэхүү илтгэлд хийсэн дүгнэлт, гаргасан санаанууд яригдаж буй сэдвээр Монгол Улсын Засгийн газрын албан ёсны байр суурийг илэрхийлээгүй, зөвхөн зохиогчийнх гэдгийг юуны өмнө тэмдэглэн хэлэхийг хүсэж байна.

НЭГ. ЕХ-НЫ ӨДГӨӨ БА ИРЭЭДҮЙ

Монгол Улсын гуравдагч хөрш-Европын Холбооны тухай олон улсын энэхүү бага хурлыг санаачлан зохион байгуулж байгаа Отгонтэнгэр Их сургууль болон Улаанбаатар дахь ЕХ-ны төлөөлөгчийн газарт баяр хүргэж, талархлаа илэрхийлье.

Отгонтэнгэр Их сургууль Европын Холбоо, түүнтэй Монгол Улсын тогтоосон харилцааны асуудлыг ийнхүү хөндөж, энэ талаар дотооддоо хурал зөвлөгөөн зохион байгуулж, ном бүтээл туурвиж хэвлүүлэх зэргээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж, энэ асуудлаар Монголын их дээд сургуулиудыг тэргүүлэн манлайлж байгаа нь туйлын сайшаалтай хэрэг мөн.

Буурал Европын 27 улсыг эгнээндээ нэгтгэсэн Европын Холбоо бол орчин үеийн олон улсын харилцааны онцгой үзэгдэл бөгөөд улс төр-эдийн засгийн интеграцийн хамгийн содон жишээ яах аргагүй мөн.

Дэлхийн геополитикийн талаас нь аваад үзвэл ЕХ орчин үеийн олон улсын харилцаанд асар богино хугацаанд АНУ, БНХАУ-ын дараа гуравдагч хүч болж гарч ирэв. Энэ бол улс орнууд нэгдэн нийлж хүчээ зузаатгавал ямар их амжилтад хүрч болдгийг харуулсан тод жишээ юм.

ЕХ дэлхийн хүн амын дөнгөж 5,8 хувийг эзэлдэг ч түүний ДНБ 2020 онд америк доллароор 16.6 их наядад хүрч, дэлхийн гуравдагч том эдийн засаг болсон байлаа. ЕХ дэлхийд дотооддоо гаальгүй, бараа таваар, үйлчилгээ, хөрөнгө чөлөөтэй эргэлдэж, хүн хүч ямар ч хориг хязгаарлалтгүй зорчиж байдаг олон улсын бүс нутгийн хамгийн том байгууллага юм. ЕХ нэг иргэншилтэй, нэг паспорттай, Евро гэх нэг мөнгөн тэмдэгттэй.

Ийм үзэгдэл, феномен олон улсын харилцааны түүхэнд хэзээ ч гарч байгаагүй юм.

Дэлхийн хамгийн том 500 компаний 161 нь ЕХ-ны гишүүн улсуудад байдаг. 2021 онд ЕХ-нд дундаж орлого 25.000 Евро байв. Ажилгүйдэл, инфляци онцгой тохиолдлыг эс тооцвол үргэлж нэг оронтой тоонд багтаж иржээ.

ЕХ-ны Гадаад харилцааны алба нэгдмэл гадаад, аюулгүй байдлын бодлого явуулах зорилготой. Еврогоор дамжуулан нэгдмэл мөнгөний бодлоготой. Европын Төв банк мэт нь үүнийг зохицуулж байдаг.

ЕХ нь НҮБ, ДХБ, G7, G20-ийн гишүүн. Зарим эрдэмтэн судлаач ЕХ-г шинээр гарч ирж буй хэт их гүрэн хэмээн тодорхойлсон нь үнэний хувьтай юм.

Дэлхийн 2 дугаар дайны дараа үүсэж бий болсон ЕХ-ны үр хөврөлийг Европ тивд дахин дайн дэгдээхгүй байх гэсэн хүсэл эрмэлзлээс эрж хайх хэрэгтэй юм. 1950 оны Шуманы Тунхаглалын үзэл санаа тийм байсан юм.

ЕХ-ны өнгөрсөн 70 гаруй жилийн түүхэнд тэрээр дотоод, гадаадын элдэв дарамт шахалт, дайралтын бай болсоор иржээ.

ЕХ 2010-аад оны үед өрийн хямралд, 2015 онд дүрвэгсдийн хямралд өртөв. 2016 онд Англид Брекситийн санал асуулга явагдаж, англичуудын 51 хувь нь ЕХ-ноос гарах санал өгсөн нь ЕХ-ны хувьд хар дарсан зүүд болж үлдэв. Ковид 19 –ийн хямрал ЕХ-ны хувьд мөн л хүндхэн сорилт болов.

Үүнтэй зэрэгцэн зарим гишүүн улсад дүрвэгсдийн эсрэг протекционист, оппортунист, популист үзэл бодол газар авч, өнөөг хүртэл ЕХ-ны эв нэгдэлд заналхийлсэн хүчин зүйл болсоор байна. ЕХ-ны гол хөдөлгөгч хүч болсон Франц, Германы хэт барууны үзэлтэй улс төрчид ийм чиг хандлагыг өөгшүүлэн өдөөн дэвэргэж байгаа нь нууц биш юм.

Олон улсын харилцаа тал дээр энэхүү олон туйлт дэлхийд Европын Холбоо нэг туйл нь байх ёстой гэж Холбооны зарим удирдагч үзэж, бие даасан гадаад болон батлан хамгаалах бодлого явуулахыг эрмэлзэвч ийм оролдлого одоо болтол биеллээ олоогүй.

ЕХ –ны гадаад болон батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаа АНУ-аас хэт хараат байсаар иржээ.

ЕХ-ны гадаад бодлогын асуудал үүгээр хязгаарлагдахгүй. Холбооны гадаад талын хуучин хуримтлагдсан асуудал дээр шинээр эрсдэл, сорилтууд гарч ирж байна гэж ЕХ-ны удирдагчид, судлаачид үздэг байна.

Эдгээр сорилтуудын дотроос ЕХ-г дотроос нь хагалах гэсэн ОХУ-ын оролдлого гэж ЕХ үзэж байна. Түүний тодорхой жишээ нь Украины эсрэг дайн гэсэн гаргалгааг ЕХ хийжээ.

Энэхүү дайнтай холбогдуулан тэмдэглэн хэлэхэд ОХУ хөрш улсад халдан довтолсон явдал мэдээж улс бүр сахих ёстой НҮБ-ын Дүрмийг бүдүүлгээр зөрчсөн хэрэг гэдэг нь тодорхой. Асуудлыг шийдвэрлэх дипломат арга сүвэгчлэх ёстой байсан.

Нөгөө талаасаа улс орнууд өөрийн аюулгүй байдлыг бусдын аюулгүй байдалд хохирол учруулах замаар хангаж болохгүй. Энэ бол олон улсын харилцааны аксиом. ОХУ нь ЗХУ задарч бутарснаас хойш хил рүү нь тасралтгүй тэлсэн НАТО-г өөрийн язгуур дайснаа гэж үзэж, энэ тухайгаа албан ёсны баримт бичгүүддээ ил тодоор мэдэгдсээр ирсэн. Хөрш Украин НАТО-д элсэх нь Оросын хувьд хоолойнд нь хутга тулгасантай адил байсан. Үүнийг мэдсээр байж Украины удирдлага НАТО-д элсэх асуудлыг гадаад бодлогынхоо цөм болгосон. Өрнөд ч үүнийг нь дэвэргэж элдэв амлалт өгсөн. Өөрөөр хэлбэл, гал дээр тос нэмсэн. Харилцан хамаарал, уялдаатай энэ хорвоод улс бүр хүссэнээ хийж болдоггүй юм. Учир нь нэг улсын алхам нөгөө улсын эрх ашгийг хөнддөг. Өрнөд Оросын амин чухал эрх ашгийг бодолцох ёстой байсан. Энэ бол ЕХ, НАТО-гийн 21 дүгээр зууны хамгийн том алдаа байлаа. Одоо зарим нь Украинд барууны цэрэг оруулах тухай ярьж эхлэв. Хэрэв ингэвэл, энэ бол дэлхийн 3 дугаар дайн гэсэн үг болно.

Улс орон бүр өөрийн гэсэн уламжлал, шашин шүтлэг, зан заншилтай. Үүнийг гаднаас өөрчлөх гэсэн оролдлого буруу. Түүнийгээ өөрчлөх эсэх асуудал бол тухайн ард түмний л хэрэг. Монголчууд 1990-ээд онд ардчиллыг сонгосон. Энэ бол Монголын ард түмний ухамсарт сонголт байсан. Гэхдээ ардчилал бүх улсад тохирох албагүй. Өрнөдийн ардчилал

Орос оронд хэрэгтэй эсэхийг оросууд өөрсдөө л шийдэх хэрэг. Ийм нөхцөлд ардчиллыг Орост хүчээр тулгаж болохгүй.

Орос, Украин хоёр мөнхийн хөршүүд. Асуудлыг гаднын оролцоогүйгээр хоорондоо л шийдэх ёстой.

Одоохондоо Украин Өрнөдийн тусламжийн ачаар тэсэж байна. Гэхдээ энэ тусламж мөнх биш, хэр удаан үргэлжлэхийг хэн ч хэлж мэдэхгүй. Яваандаа энэ их хөрөнгө мөнгөний тусламж аажмаар буурахгүй гэх баталгаа байхгүй

Оросын Ерөнхийлөгч В.В.Путин жилээс жилд унасаар байгаа нэр хүндээ дээшлүүлэх гэж энэ дайныг хийж байна гэж үздэг зарим улс байна. Энэ ч бас үнэний хувьтай."Би Крымийг буцаан Орост нэгтгэсэн" гэж хэлэх үндэс Путинд байгаа боловч түүх бол Путинд нэг их нааштай хандахгүй л болов уу. Учир нь Крымээр өөрийгөө хязгаарлаж, дайнаа зогсоосон бол түүхийн дүгнэлт арай өөр байх байлаа.

В.Путины геополитикийн том алдаа юу байсан бэ гэхээр тэр Украины дайнд бүх Европ түүний эсрэг босно гэж тооцоолоогүй явдал юм. Энэ дайн тэртээ тэргүй ганцаардаад байсан Орос орныг бүр чөтгөр шулам аятай болгож орхив. Путин Оросын нуухыг авах гээд нүдийг нь сохлов. Энэ бол Путины эмгэнэл.

Украины дайн Кремлийн стратегичдын бодож байсан шиг Өрнөдийг хагалан бутаргах бус харин ч эсрэгээрээ Атлант дамнасан харилцааг идэвхжүүлээд зогсохгүй НАТО-д шинэ амьсгал өгч орхив. ЕХ ерөөс Европ бүхэлдээ Оросын эсрэг Украины талд баттай зогсож, эв нэгдлээ бэхжүүлэв. Украиныг дэмжсэн энэхүү эв нэгдэл хэр удаан үргэлжлэхийг хэн ч хэлж үл мэднэ.

Гэвч ЕХ-ны санааг зовоож буй асуудал ганц Путин биш. АНУ-ын өнөөгийн Ерөнхийлөгч Ж.Байден өмнөх ерөнхийлөгч Трампыг бодвол Атлантын далайг дамнасан харилцаанд илүү ач холбогдол өгч байгаа нь Украины хямралын талаар эзэлсэн байр сууриас нь харагдав. Гэвч АНУ-ЕХ-ны түншлэл нь худалдааны маргаанаас авхуулаад батлан хамгаалах зардлыг хуваалцах гэх мэт олон асуудал гарах үндэс болж байна. Эдгээр асуудал Украины дайнтай холбогдон түр намжсан нь үнэн, гэвч дахиад гарч ирэх эрсдэл энүүхэнд байна.

ЕХ-Хятадын харилцаа ихээхэн ээдрээ төвөгтэй байгаа. Энэ харилцаа Тяньанмений талбайн үйл явдлаас хойш нэг талаас хамтран ажиллаж нөгөө талаас сөргөлдсөн байдлыг хослуулж ирсэн. Брюссель Вашингтон-Бээжингийн стратегийн мөргөлдөөний гадна үлдэж, Хятадтай бие даан харилцахыг эрмэлзэв ч энэ нь нэг л бүтэл муутай байгаа.

Нөгөө талаас ЕХ түүний зах хязгаарын улсууд болох Турк, Беларусьтай харилцаагаа хэрхэн зохицуулах нь бас л гадаад бодлогынх нь чухал асуудлын нэг мөн.

Ойрын ирээдүйд ЕХ-ны олон улсын байр суурийг тодорхойлоход дараах асуудлууд ихээхэн чухал гэж бодно. Үүнд:

- Украин дахь дайны Европт үзүүлэх үр дагавар,
- Ойрх Дорнодод Хамас-Израйлийн дайн
- ЕХ АНУ-аас тусдаа ангид бие даасан, дэлхийн хэмжээний стратегийн тоглогч болж чадах эсэх,
- аюулгүй байдлын асуудлаарх АНУ-ын хамаарлаас салж чадах эсэх,
- хүч чадал нь өсөн нэмэгдсээр байгаа Хятад улстай харилцаагаа хэрхэн зохицуулах.

Хамгийн чухлыг нь Монголоос харахад ийм зураг харагдаж байна.

ХОЁР. МОНГОЛ БА ЕХ

Монгол-ЕХ-ны хоёр талын харилцааны асуудлаар жич илтгэлүүд тавигдана. Гэсэн хэдий ч Брюссельд ажиллаж байсан хүний хувьд хэдэн санаа хэлье гэж бодлоо.

ЕХ Монголын хувьд хэн юм бэ? Гурван зүйл хэлье.

- ЕХ нь Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах, уул уурхайн салбараас хэт хараат болсон манай улсын эдийн засгийг төрөлжүүлэх, улмаар Монголын эдийн засгийг Европын улс орнуудынх шиг сонгодог эдийн засгийн жишигт хүргэх **Гол түнш**,
- ЕХ бол Монголын хувьд түүний гуравдагч хөрш. ЕХ нь Монгол улсын социалист нийгмээс хүний эрхийг дээдэлсэн ардчилсан төрийн засаглалыг бэхжүүлэх, Монгол дахь иргэний нийгмийг хөгжүүлэх түншлэлийн **Гол хамтрагч**,
- ЕХ нь Монгол Улс Европын зах зээлд нэвтрэх гол үүд хаалга, Монголд ядуурлыг бууруулах, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалахад **Гол тулгуур** болж байна.

Монгол Улс нь ЕХ-той тогтоосон харилцаагаа тасралтгүй хөгжүүлэхийн тулд яах ёстой вэ ? гэвэл МОНГОЛЫН ТӨР, ЗАСАГ ЕХ-НЫ ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХ НЬ ЧУХАЛ юм.

fraudulent behavior, as well as misconduct and misuse of information on the Mongolian side

- Авлига, хээл хахуулийн асуудал/corruption, money laundering, tax evasion etc

- Хөгжлийн банкны зээл, ЖДҮ зээл

- Нүүрсний хулгай

- “татварын шударга бус тогтолцоотой”
- FATF-ын саарал жагсаалтад багтсан нь өөрөө татвараас зайлсхийдэг, ил тод биш, мөнгө угаах эрсдэлтэйг харуулж байгаа юм.
- Хүний эрх зөрчигдөж байгаа явдал тасрахгүй байгаа /шүүхийн шийдвэргүйгээр баривчилгаа явуулдаг гэх мэт/
- Хууль байвч хэрэгждэггүй, уриа, лоозонгийн шинжтэй, Law enforcement учир дутагдалтай

Монголын тал эдгээр алдаа дутагдлаа засаж чадвал ЕХ-Монголын харилцаа жам ёсны дагуу эрчимтэй хөгжих болно гэж миний бие бодож байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

МОНГОЛ УЛС, ЕВРОПЫН ХОЛБООНЫ ХАРИЛЦААНЫ ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ: ПОСТ-БРЕКСИТИЙН ҮЕ GSP+ ЖИШЭЭН ДЭЭР

Др.проф. Д.Уламбаяр

I. Европын Холбоо-Монгол Улсын «гуравдагч хөрш», чухаг түнш болох нь

1990-ээд оноос Монгол Улсын гадаад харилцаанд «гуравдагч хөрш»-ийн бодлогын үзэл санаа буй болж, тухайлсан онол-практикийн түвшний судалгааны хийгээд бодлогын шинэ чиглэл болов.

2011 оны “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”-ын 14.2-т «АНУ, Япон, Европын Холбоо... зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх»-ээр анх удаа бодлогын хэмжээнд заажээ.

Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын тэргүүлэх, нээлттэй чиглэл нь өндөр хөгжилтэй, ардчилсан улсуудтай түншлэлийн харилцааг бүх салбарт хөгжүүлэх явдал бол дагалдах, далд чиглэл нь “зөөлөн тэнцвэржүүлэхүйн” бодлого юм. Энэ бол “гуравдагч хөрш”-ийн бодлогын гол хэв шинж гэж хэлж болох юм. Монгол Улс өөрийн хүрээлэн буй геополитикийн орчинд «гуравдагч хөрш»-тэй болж, түүний эрхзүйн үндсийг тавьсан гэж үзэж болно. Эдүгээ “гуравдагч хөрш”-тэй тогтоосон хамтын ажиллагаа эдийн засгийн шинэ агуулгаар баяжин урагшилж байна.

Монгол Улс ЕХ-ны хувьд Ази дахь “үнэ цэнтэй түнш” мөн бөгөөд геополитикийн давтагдашгүй байршилтай хэмээн Европарламентын тогтоолд онцлон тэмдэглэв. 2017 оны 2 дугаар сарын 15-нд “ЕХ, гишүүн орнууд, Монгол Улсын хооронд Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг дүгнэж Европын Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг үндэслэн Европын Парламент тогтоолын төслийг баталсан юм. Түүнд: “...ЕХ, АНУ, Япон, БНСУ, Энэтхэг улсыг оролцуулсан Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого, Орос, Хятадтай тогтоосон стратегийн түншлэл, Монгол, Орос, Хятад болон Монгол, Япон, АНУ-ын хоорондын гурван талт байнгын өндөр түвшний уулзалтыг тус тус анхааралдаа авч...”, тогтоолын “Бүс нутаг, дэлхий нийтийн сорилт ба хамтын ажиллагаа” гэсэн хэсгийн 50 дугаар зүйлд: “ЕХ-г оролцуулсан Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын үзэл баримтлал, нөлөө бүхий стратегийн түнш, шууд хөрш Орос, Хятадтай тогтоосон бүтээлч, үр дүнтэй тэнцвэртэй харилцааг онцлон тэмдэглэж байна” гэжээ.

“Гуравдагч хөрш”-ийн бодлогын том сорилт нь хоёр хөрш, “гуравдагч хөрш” гүрнүүдийн хоорондын геополитик, гео-эдийн засгийн сөргөлдөөн болж байгаа нь Монгол Улсын хувьд таатай биш юм.

II. BREXIT-ийн *de jure* төгсгөл

Улс орон даяар бүх нийтийн санал асуулга явуулснаас хойш 3.5 жилийн дараа -ЕХ-ны Лиссабоны Гэрээний 50 дугаар заалтын дагуу «Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсыг Европын Холбоо, Европын Атомын Эрчим хүчний Хамтын нийгэмлэгээс гаргах Хэлэлцээр» хүчин төгөлдөр үйлчилж, 2020 оны 2 дугаар сарын 1-ээс BREXIT *de facto* төгсгөл болж, 47 жил үргэлжилсэн гишүүнчлэл нь 1 дүгээр сарын 31-ний Баасан гаригт орон нутгийн цагаар 23:00-т (GMT), Төв Европын цагаар (00:00 CET) албан ёсоор дуусгавар болов. Дээрх хэлэлцээртэй нэгэн зэрэг «Нэгдсэн Хаант Улс ба Европын Холбооны ирээдүйн харилцааг тодорхойлсон Улс төрийн Тунхаглал» хүчин төгөлдөр үйлчилж эхлэв.

2020 оны 12 дугаар сарын 24-нд Их Британи-ЕХ-ны хооронд 34 бүлэг, 34.9 зүйл заалт бүхий, 23 хэл дээрх 290 хуудас бүхий “Нэгдсэн Хаант Улс, Европын Холбооны хоорондын Иж бүрэн Чөлөөт худалдааны хэлэлцээр”-т гарын үсэг зурснаар ЕХ-ны Гаалийн Холбоо, “Европын Нэгдсэн зах зээлийн хэлэлцээр”-ээс (European Single Market or Common Market)

гарч, 12 дугаар сарын 31-нд Их Британийн Парламентын Нийтийн танхим дээрхийг баталж, Хатан хаан II Елизабет гарын үсэг зурж соёрхов.

Их Британи ЕХ-ноос гарсан нь Монгол Улсад тийм ч таатай зүйл биш байв. Brexit хэрэгжсэнээр тус холбооны “сайн засаглал, тогтвортой хөгжлийг” дэмжих хөтөлбөрийн хүрээнд хөгжиж буй 8 орон, түүний дотор Монгол Улсад олгосон гаалийн хөнгөлөлтийн GSP+ схем Британид үйлчлэхгүй болж, Монголоос Их Британид гардаг экспортын бүтээгдэхүүн болох самнасан ноолуур, ноолууран эдлэл, боловсруулсан алт, үнэт чулуу гаалийн татвартай болох байв. Хэдий тийм боловч 2021 оны 2 дугаар сарын эхээр Монгол Улсын Гадаад харилцааны дэд сайд Б.Мөнхжин Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Филип Малоун нар Монгол Улсыг Их Британийн худалдааны Хөнгөлөлтийн Ерөнхий Систем болох “Өргөтгөсөн нөхцөл”-д (*UK GSP Enhanced Framework*) хамруулах тухай ноот бичиг солилцов.

III. Монгол Улс, ЕХ-ны харилцаа, хамтын ажиллагааны эрхзүйн шинэ орчин

ЕХ-ны Зөвлөл 2017 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн Сайд нарын түвшний уулзалтаараа Монгол Улс, ЕХ-ны хооронд 2013 онд байгуулсан “Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг хүчин төгөлдөр болгох тухай шийдвэрийг гаргасан.

Уг хэлэлцээрийг өнгөрсөн хугацаанд ЕХ-ны гишүүн 28 улс орон үндэсний парламентаараа хэлэлцүүлэн баталсан бөгөөд Европын Парламент 2017 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн чуулганаараа соёрхон баталж, тогтоол гаргажээ. Энэхүү шийдвэрийг Европын Зөвлөл гаргаснаар хэлэлцээр 2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхлэв.

Монгол Улс, ЕХ-ны хооронд байгуулсан 9 бүлэг, 65 зүйл бүхий «Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр»-т 2013 оны 4 дүгээр сарын 30-нд Улаанбаатар хотод гарын үсэг зурсан билээ. Энэ нь 2009 оны 12 дугаар сарын 1-нд «ЕХ-ны гэрээ» буюу Лиссабоны гэрээ хүчин төгөлдөр болж, ЕХ-ны Гадаад хэрэг, аюулгүй байдлын Дээд төлөөлөгчийн газар, Гадаад харилцааны алба шинээр байгуулагдсан хийгээд шинэ нөхцөл байдалд ЕХ-ны зүгээс ЕХ-ны гишүүн бус оронтой хийж буй анхны томоохон хэлэлцээр болсон юм. Энэхүү хэлэлцээр нь ЕХ-ны зүгээс гишүүн бус хэдий ч харилцаа, хамтын ажиллагааны хувьд нэн чухалд тооцогддог орнуудтай байгуулдаг, харилцааны бүхий л салбарыг хамардагаараа онцлогтой, иж бүрэн түншлэлийн агуулгатай.

ЕХ Монгол Улсад байнгын ДТГ нээх шийдвэрийг 2017 оны 7 дугаар сарын 20-ны өдөр албан ёсоор гаргав. Чингэснээр ЕХ дэлхийн 140 оронд байнгын дипломат төлөөлөлтэй болов.

Еврокомиссын Ерөнхийлөгч Жан-Клод Юнкер (Jean-Klaud Juncker) уг шийдвэрт гарын үсэг зурсныхаа дараа хэлэхдээ: “Хятад, Оросын дунд орших стратегийн байршилтай, бидний чухал түнш, ардчилсан Монгол Улсад бүрэн хэмжээний ДТГ байгуулах амлалтаа ЕХ биелүүлж байна. Би Монгол Улсад анх 1998, сүүлд 2016 онд, нийтдээ 3 удаа айлчилсан. Энэ орны хийсэн дэвшил, хүрсэн амжилтад баяр хүргэхээс өөр аргагүй, ЕХ энд байнгын төлөөлөлтэй байх ёстой” гэж дурджээ.

Еврокомиссын дэд ерөнхийлөгч, ЕХ-ны Гадаад бодлого, аюулгүй байдлын Дээд төлөөлөгч Федеррика Могерини (Feredrica Mogherini) хэлэхдээ: “Монгол Улс **давтагдашгүй геостратегийн байрлалтай** тул ээдрээтэй харилцаа бүхий тус бүс нутагт чухал үүрэгтэй. Манай Суурин төлөөлөгчийн газар нь Монгол Улстай харилцаагаа бэхжүүлэх, ард түмнийг дэмжихэд чиглэсэн ЕХ-ны хөрөнгө оруулалт болно. ЕХ-ны зүгээс Монгол Улстай байгуулсан Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээрийг ойрын үед хүчин төгөлдөр болгоно. Энэ нь хоёр талын харилцааг хөгжүүлэхэд чухал ач холбогдол өгч байгаагийн илрэл юм” хэмээн мэдэгдэв. Монгол Улсад ДТГ байгуулах тухай тус шийдвэр нь ЕХ, Монгол Улсын хоёр талын харилцаанд гарсан томоохон дэвшил бөгөөд Улаанбаатарт ЕХ-ны бүрэн хэмжээний Төлөөлөгчийн газар байгуулснаар талууд улс

төрийн яриа хэлэлцээ, хамтын ажиллагааг урагшлуулж, түншлэлийн харилцааг цаашид бэхжүүлэх боломжийг нэмэгдүүлэх юм гэжээ.

ЕХ-ноос Монгол Улсад суурин суугаа хоёр дахь элчин сайд хатагтай **Аксель Никейз** (Axelle Nicaise) хэлэхдээ: “Европын Холбооны хувьд Монгол Улс бол Ази дахь үнэ цэнтэй түнш юм. Учир нь Монгол Улс бол газарзүйн байрлалын давуу талтай. Мөн олон улсын тавцанд ч **Монгол Улсын хувьд Европын Холбоо “гуравдагч хөрш” нь хэмээх нэгдсэн ойлголттой байдаг нь ч сайхан санагддаг**” гэсэн юм.

Дээрхээс үзэхэд Орос, Хятадын асар том зах зээлд нэвтрэн орох түшиц газар, Зүүн хойд Азийн бүс нутгийг ЕХ-той холбож болох гүүр хэмээн Монгол Улсыг ЕХ сонирхож байгаа нь тодорхой байна. Мэдээж нөгөө нэг чухал хүчин зүйл нь Монгол Улс дахь ардчилал, зах зээлийн эдийн засгийн хөгжил гэдгийг ЕХ онцлон тэмдэглэдэг.

2017 оны 11 дүгээр сарын 2-нд “ЕХ-ны Төлөөлөгчийн газрыг Монгол Улсад байгуулах, түүний эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар, ЕХ болон Европын Атомын эрчим хүчний хамтын нийгэмлэг хоорондын хэлэлцээр”-т Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, ЕХ-ноос Монгол Улсад суугаа элчин сайд Ханс Дьетмар Швайсгут (Hans Dietmar Schweisgut) нар гарын үсэг зурав. Монгол Улсад ЕХ-ны Төлөөлөгчийн газар байгуулагдаж буй нь Монгол Улс, ЕХ-ны харилцаанд гарсан томоохон дэвшил, Монголын гадаад харилцаа, дипломат албанд тохиож буй түүхэн үйл явдал болохыг Гадаад харилцааны сайд онцолж байв.

Тийнхүү Түншлэл, хамтын ажиллагааны Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгохоор гаргасан энэхүү шийдвэр, мөн Төлөөлөгчийн газраа 2017 онд багтаан Улаанбаатар хотноо нээх тухай 7 дугаар сард гаргасан шийдвэр зэрэг нь ЕХ-оос Монгол Улстай хөгжүүлж буй харилцаандаа өндөр ач холбогдол өгч байгаагийн илрэл, харилцаа, хамтын ажиллагаа шинэ шатанд гарч буй үйл явдал болсон юм.

ЕХ-ны удирдлага МУИС-ийн монгол судлалын салбарыг дүүргэсэн монгол судлаач Траян Лаурентий Христеег (Hristea Traian Laurentiu) Монгол Улсад суурин суух анхны Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар томилсон нь Монголын чиглэлд ач холбогдол өгч буйн тод илрэл болсон юм. Тэр бээр 2018 оны 5 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгчид Итгэмжлэх жуух бичгээ өргөн барив.

2018 оны 11 дүгээр сард ЕХ-оос Монгол Улсад суугаа Суурин Төлөөлөгчийн газрыг албан ёсоор нээв.

IV. Хөгжлийн хамтын ажиллагаа

Хөгжлийн туслалцаа нь ЕХ-Монгол Улсын хоорондох харилцааны чухал тулгуур бөгөөд тогтвортой хөгжлийг бэхжүүлэн, Мянганы хөгжлийн зорилтыг хангаж ядуурлыг бууруулах туйлын зорилготойгоор Монгол Улсын Засгийн газар, Монголын иргэний нийгмийн байгууллагуудад дэмжлэг үзүүлдэг.

ЕХ ба Монгол Улсын хоорондын хөгжлийн хамтын ажиллагааг багтаасан хоёр талын харилцаа нь Еврокомисс-Монгол Улсын хамтын ажиллагааны 1996 оны хэлэлцээрээр үндэс сууриа тавьсан юм. Түүнээс хойш хөгжлийн хамтын ажиллагаа тогтмол нэмэгдсээр ирэв. Үүнд:

- 2002-2006: ТАСИС-ын Монгол Улсад зориулсан Үндэсний баримжаат
- хөтөлбөр -15 сая евро;
- 2007-2013: DCI Үндэсний стратегийн баримт бичиг- 29 сая евро;
- 2014-2020: Олон талт баримжаат хөтөлбөр -65 сая евро;
- 2021-2027: Олон талт баримжаат хөтөлбөр-50.8 сая евро эдгээр болно.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 77 дугаар чуулганд оролцох үеэрээ Еврокомиссын Ерөнхийлөгч Урсула фон дер Лайентай уулзах үеэр тэр бээр олон улсын харилцааны өнөөгийн нөхцөл байдалд Монгол Улсын явуулж буй бие даасан, нээлттэй, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт гадаад бодлогын ач холбогдлыг

онцолж, газарзүйн байрлалын онцлогийг бүрэн ойлгож, хүндэтгэж буйгаа тэмдэглэж байсан. Цаашид хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлж, эрчим хүч, ногоон хөгжлийн салбарт хамтран ажиллах өргөн боломжтойг онцлон тэмдэглэж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж, Европын Холбооны “Ойн түншлэл” хөтөлбөрт Монгол Улсыг хамруулахаа нотолсон. Удалгүй 11 дүгээр сарын эхээр Египет Улсын Шарм эль-Шейх хотноо зохиогдсон Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний COP-27 уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх, Еврокомиссын Ерөнхийлөгч Урсула фон дер Лайен нар дахин уулзаж “Ойн түншлэлийн тухай Монгол Улс болон ЕХ-ны хооронд Харилцан ойлголцлын Санамж бичиг”-т гарын үсэг зурж, Монгол Улс ЕХ-ны ногоон санаачилгын нэг болох “Ойн түншлэл”-д оролцож буй Азийн анхдагч орон болов. ЕХ-ны Ойн түншлэл хөтөлбөрийн сан 2.2 тэрбум еврогийн хөрөнгөтэй.

Санамж бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЕХ-оос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газар, БОАЖЯ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар хамтран 2023 оны 1 дүгээр сараас “Ойн түншлэл”-ийг хэрэгжүүлэх “Замын зураг”-ийн төслийг хэлэлцэн тохиролцож, 2023 оны 7 дугаар сард эцэслэн батлав. Ойн түншлэл нь уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулан, үүнтэй уялдуулан ойн салбарт тулгарч буй сорилт, бэрхшээлийг даван туулах, улс орны хөгжлийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан байгаль орчныг хамгаалах, ойг нөхөн сэргээх зорилго бүхий үүрэг амлалт юм.

2023 оны 2 дугаар сард Монгол Улсын Засгийн газар, ЕХ хамтран Тогтвортой ногоон хөгжлийн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээг тодорхойлох дээд түвшний зөвлөгөөн Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан. Дурдсан зөвлөгөөн нийт 14 сая еврогийн буцалтгүй тусламжийн хүрээнд хөдөө аж ахуй, ойн аж ахуй, техник, мэргэжлийн боловсрол, сургалтын (МСҮТ) салбарт хэрэгжих төслүүдийн бэлтгэл арга хэмжээ болсон юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд 26.1 сая мод тарьж, 62.6 сая тарьц суулгацын нөөц бүрдүүлсэн байна.

V. ЕХ-ны GSP+ ба Монгол Улс


Ардчилал, сайн засаглал, зах зээлийн эдийн засгийг тууштай дэмжигч хөгжиж буй 16 оронд Нэмэлт Худалдааны хөнгөлөлтийн шинэ системийг (Generalised System of Preferences GSP+) гурав гурван жилээр хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Монгол Улс үүнд 2005-2017, 2018-2020 онд хамрагдсан бөгөөд мөн 2021-2023 он хүртэл хамрагдаад байна.

Монгол Улс ЕХ-ны Ерөнхий Хөнгөлөлтөд 1991 оноос хамрагдаж ирсэн бөгөөд экспортын голлох бараанууд, тухайлбал, нэхмэл, сүлжмэл, оёмол бүтээгдэхүүнүүд хамрагдаж 9.6 хувийн татвартай байсан бол шинэчилсэн ХЕС-ийн дагуу нэн тааламжтай нөхцөлөөс ч илүү 0 тариф хүртэл буурсан юм. Шинэчилсэн ХЕС-д хамрагдсанаар Монгол Улсаас гарал үүсэлтэй 7200 (6300) орчим нэр төрлийн бараа бүтээгдэхүүн гаалийн татваргүй нэвтрэх боломжтой болсон юм. Энэ нь Монгол Улсын экспортын бараа, бүтээгдэхүүн ЕХ-ны 500 сая хэрэглэгчидтэй том зах зээлд ижил төрлийн өрсөлдөгч бүтээгдэхүүнээс хямд өртгөөр нэвтрэх давуу талтай болж үйлдвэрлэл, экспорт, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэхэд чухал дэмжлэг болж байгаа юм. Европарламент болон Еврокомиссоос 2012 оны 10 дугаар сарын 25-д шинэчлэн баталсан 978/2012 тоот журам болон хөнгөлөлтөд хамрагдах барааны жагсаалтыг тусгасан бөгөөд шинэчилсэн журам нь 2023 оны 12 сарын 31 хүртэл үйлчлэх юм.

Европын Парламент болон ЕХ-ны Зөвлөл 2012 оны дараах Нэмэлт шинэ GSP схемд хамрагдах орны тоог бараг хоёр дахин багасгасан боловч Монгол Улс шинэ схемд 2020 он хүртэл хамрагдах болсон нь ЕХ тус улсыг тууштай дэмжиж буй тодорхой илрэл болсон юм. 7200 төрлийн барааны хөнгөлөлтөөс Монгол Улсын 70 гаруй төрлийн тухайлбал, оёмол, сүлжмэл бүх төрлийн бүтээгдэхүүн, арьс ширэн бүтээгдэхүүн, үслэг эдлэл, мал амьтны гаралтай ноос, ноолуур, ундаа, архи, модон эдлэл, электрон бараа, гутал, хивс, зэс, зэсэн бүтээгдэхүүн, төмөр, төмөр бүтээгдэхүүн зэрэг Монгол Улсын хувьд экспортын нэн ач

холбогдол бүхий бараа, бүтээгдэхүүн хамрагдаж, 2015 онд 15 сая евро, 2016 онд 18 сая, 2017 онд 17, 2 сая, 2018 онд 16, 4 сая, 2019 онд 19,02 сая, 2020 онд 14.06 сая еврогийн хөнгөлөлт эдэлсэн байна. Хөнгөлөлт эдэлсэн бараа бүтээгдэхүүний 90 гаруй хувь нь оёмол, сүлжмэл, нэхмэл бэлэн бүтээгдэхүүн эзэлж байгаа юм.


Хүснэгт 1. EX-д GSP+ хөнгөлөлт эдэлсэн Монголын экспорт (сая евро)



Source: EU

Монгол Улсыг маш эмзэг эдийн засагтай гэж үзэж болох ба 7.4 хувийн босгоос мэдэгдэхүйц доогуур байгаа нь 2019 онд түүний эмзэг байдлын харьцаа тэг байсан. Монгол Улсын экспорт цөөхөн бүтээгдэхүүнд өндөр төвлөрсөн. Экспортыг төрөлжүүлэх доод босго 75 хувьтай байгаа бол Монгол Улс 2019 онд 92.3 хувьтай байсан.


Монгол Улсын одоогийн экспортын бүтээгдэхүүний харьцангуй бага 31 хувь нь GSP-ийн дагуу тарифын хөнгөлөлт үзүүлэх боломжтой. Монгол Улс одоогийн байдлаар 91 хувийн давуу эрхийн ашиглалт өндөртэй байна.



Source: EU

Олон жилийн туршид давуу эрхийн (хөнгөлөлтийн) ашиглалтын түвшин, ялангуяа 2011-2016 оны хооронд ихээхэн хэлбэлзэлтэй байсан. Энэ хугацаанд давуу эрхийн ашиглалтын бууралт нь хамгийн таатай улсын ханшаар арилжаалагдсан GSP-ийн шаардлага хангасан экспортын өсөлтөөс улбаатай. 2016-2018 оны хооронд давуу эрхийн ашиглалт 8 пунктээр өссөн ч GSP-д хамрагдах нийт импорт буурсан байна. Үүний нэгэн адил, загас, гутлын импортын хувьд бүтээгдэхүүний бие даасан хэсгүүдэд давуу эрх ашиг нэмэгдсэн. GSP+ ашиглан Монголоос ЕХ-ны импортын үнэ харьцангуй тогтвортой буюу нийт импортын 28 орчим хувийг эзэлж байна. Ерөнхийдөө Монгол Улс одоогийн байдлаар GSP+-ийн давуу эрхүүдийг ихээхэн ашиглаж байгаа нь тус хэлэлцээрээс ашиг хүртэх боломжийг олгож байна.


Source: EU



н төрөлжүүлэлтийн хувьд салбарын болон бүтээгдэхүүний түвшинд дорвитой өөрчлөлт гарсангүй. Монгол Улсаас ЕХ-ны GSP+ хөнгөлөлттэй экспортын бүтээгдэхүүнд ихэвчлэн хувцас, хувцас, тавилга, тоглоом, ноос, загас багтдаг. Гэсэн хэдий ч хувцас нь GSP+ давуу эрх ашиглан экспортын 95 хувийг эзэлдэг экспортын хамгийн их бараа бүтээгдэхүүн юм. GSP+-ийн давуу талыг ашиглаагүй хэвээр байгаа хэсгүүд нь төмөр, ган эдлэл, машин механизм (S-16) бөгөөд ашиглалтын хувь нь тус бүр 23.4 хувь ба 0 хувь байна.

2017 оноос эхлэн ЕХ-ны “GSP”+ системийн хүрээнд импортын барааны гаалийн татварын хөнгөлөлт эдэлж буй бүтээгдэхүүний гарал үүслийн бүртгэлийг цахимжуулж, түүнийг Монгол Улс 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн ЕХ-ны REX буюу “Бүртгэгдсэн экспортлогчдын систем”-ийг нэвтрүүлж эхлээд байгаа юм.

Монгол Улс ЕХ руу хийсэн нийт экспортын 28 орчим хувьд GSP+ хөнгөлөлтийг ашигласан байх бөгөөд давуу эрхийн ашиглалтын түвшин харьцангуй өндөр бөгөөд хамгийн сүүлд 2019 онд 83.2 хувь, 2020 онд 90 хувьд хүрсэн байна. Тэгвэл ЕХ-ны GSP+ хөнгөлөлттөөр 2020 онд Пакистан 4.69 тэрбум, Филиппин 1.59 тэрбум, Шри Ланка 1.10 тэрбум, Армени 128 сая, Кабо Верде 54 сая, Болив 38 сая, Монгол Улс 14 сая, Киргизстан 4.5 сая еврогийн ашиг хүртсэн байна.



Source: EU

Анхны 2005-2012 онд үйлчилж байсан GSP+ схем буюу “Сайн засаглал, тогтвортой хөгжил”-ийг дэмжих хөтөлбөрт ардчилал, сайн засаглал, зах зээлийн явцад амжилт гаргасан хөгжиж буй 16 орон Тухайлбал: Сальвадор, Гүрж, Гватемал, Гондурас, Боливи, Колумби, Коста-Рико, Эквадор, Шри ланка, Монгол, Венесуэл зэрэг 11 улс хамрагдаж байсан юм. “Тогтвортой хөгжил, сайн засаглал”-ын болзол хангасан 2012 оны шинэ схемд 6,300 төрлийн бараа бүтээгдэхүүнийг оруулж 8 улс тухайлбал, Армени, Боливи, Кабо Верде, Киргизстан, Монгол, Пакистан, Филиппин, Шри Ланка улсыг оруулахад Монгол Улс үлдсэн байна.

Дээрх хугацаанд Монгол Улс ЕХ-ны 5 мянга гаруй стандартыг нутагшуулсан байна.

2020 оны 11 дүгээр сард *online* хуралдсан Монгол Улс, ЕХ-ны Хамтарсан Хорооны ХХ хуралдааны үеэр Монголын талаас ЕХ руу экспортлох амьтан, ургамлын гаралтай 18 нэр төрлийн 70 гаруй бүтээгдэхүүний жагсаалтыг 2020 онд Европын Комисст танилцуулсан юм. Тухайлбал, чацаргана, чацарганын бүтээгдэхүүн, хонины ноосоор хийсэн био бордоо, хушны самар (самрын идээ), гоо сайхны бүтээгдэхүүн, арьс шир, ноос, утас, даавуу, сарлагийн хөөвөр, торомны ноос мөн дайвар мах, нөөшилсөн бүтээгдэхүүн, өлөн гэдэс болон бусад бүтээгдэхүүнийг ЕХ-ны зах зээлд экспортлох, экспортыг нэмэгдүүлэх боломжтой гэж үзсэн юм.

ЕХ-ны “GSP+” хөнгөлөлт нь Монгол Улсын бизнесийн салбарт тодорхой үр ашиг үзүүлж байгаа боловч энэхүү давуу тал, боломжийг илүү дүүрэн ашиглах, тухайлбал ЕХ-ны гишүүн орнуудтай “GSP+” хөнгөлөлтөд хамрагддаг бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг хамтарсан үйлдвэр байгуулах замаар шинэ техник, технологи, *know how* нэвтрүүлэх, Европын зах зээлд өрсөлдөх чадвартай, олон улсын стандарт, хэм хэмжээ, чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах шаардлагатай. Дурдсан хөнгөлөлт нь Монгол Улсын экспортыг дэмжээд зогсохгүй, мөн хөрөнгө оруулалтыг ч нэгэн адил дэмжиж байгаа юм.

Монгол Улс хоёр хөрш, “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд бизнесийн моделио шинээр угсрах явдал чухал байна. ЕХ GPS+ худалдааны хөнгөлөлтийн 2016 оны шинэ схемд Монгол Улс дахин хамрагдсан. ОХУ ЕХ-ны эдийн засгийн хориг арга хэмжээнд орсон байгаа одоогийн нөхцөлд Монгол Улс, ОХУ, БНСУ-ын бизнесийн байгууллагууд мод, модон эдлэлийн хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг Монгол Улсад байгуулж, Сибирийн ой тайгаас мод, юуны өмнө царс модыг импортоор оруулж, БНСУ-ын санхүү, технологийн дэмжлэгтэйгээр ЕХ-ноос Монголд олгосон GSP+ийг ашиглан албан тасалгааны болон сургууль, гэр ахуйн бүх төрлийн тавилга болон модон эдлэл, бүх төрлийн

parquet шал, цонхны хүрээ, барилгын төрөл бүрийн материалыг үйлдвэрлэж, 448 сая хэрэглэгчтэй ЕХ-ны нэгдсэн зах зээл дээр гаалийн татваргүй гаргах их нөөц боломж ирээдүйд нээгдэх боломжтой болов уу.


Зураг 1.



Өнөөдрийн байдлаар ЕХ-ны 800 гаруй компани 3,2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн нь Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 13 орчим хувийг эзэлж байна.

Монгол Улс, ЕХ-ны гадаад худалдааны нийт эргэлт 2019 онд 562 сая евро, үүнээс импорт 485 сая евро, экспорт 76 сая евро байсан бол, COVID-19 цар тахлын үед 2020 онд нийт эргэлт 491 сая евро, үүнээс импорт 440 сая евро, экспорт 52 сая евро болж бага зэрэг буурсан байна. Үүний 30 орчим сая евро нь түүхий эд, 14 сая евро нь оёмол, нэхмэл, сүлжмэл бэлэн хувцас, 18 сая евро нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүн болж байжээ. ЕХ Монгол Улсын нийт гадаад худалдааны 6.9 хувь, экспортын 4.8 хувь, импортын 9.6 хувийг эзэлж байв.

Хүснэгт 2. Монгол, ЕХ-ны гадаад худалдааны нийт эргэлт (сая евро)



Source: EU


Монгол Улс GSP+д нийлүүлэх, экспортыг 13 хувиар нэмэгдүүлсэн үр дүн гарсныг ЕХ-ноос Монгол Улсад суугаа элчин сайд Ханс Дьетмар Швайсгүт 2017 оны 11 дүгээр сард тэмдэглэж байсан юм.

ЕХ-ны санхүүжилтээр Монгол Улсын ГХЯ-тай хамтран хэрэгжүүлсэн “Монгол Улсын худалдааг дэмжих” (TRAM) төсөл гадаад худалдааг төрөлжүүлэх замаар Монголын бараа бүтээгдэхүүнийг бүс нутгийн болон олон улсын зах зээлд амжилттай гарахад нь чухал дэмжлэг болжээ. “Монголын худалдааг дэмжих EU-TRAM” төсөл 2018 оны 3 дугаар сараас эхэлсэн бөгөөд нийт таван сая еврогийн өртөг бүхий 2018-2020 онд хэрэгжиж төслийн


хүрээнд ЕХ-ны стандартад нийцсэн олон төрлийн бараа бүтээгдэхүүнийг экспортлоход чиглэгдсэн юм.

Хүснэгт 3. ЕХ руу хийж буй Монголын экспорт (сая евро) 2019 онд 76 сая евро, 2021 онд 71 сая евро болов.

Source: EU



Хүснэгт 4. ЕХ руу хийсэн Монголын экспортын бүтээгдэхний төрөл



Source: EU

Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээрийн 27 дугаар хэсэгт “Талууд газарзүйн заалтын тухай хэлэлцээрийг аль болох хурдан байгуулахаар тохиров” гэж заасны дагуу 2019, 2020 оны Худалдаа, хөрөнгө оруулалтын Дэд хорооны хуралдааны үеэр талууд Газарзүйн заалтын тухай хоёр талын хэлэлцээр байгуулах талаар санал солилцож, үүний дагуу 2021 онд хэлэлцээг эхлүүлэх, бэлтгэл ажлыг хангах чиглэлээр ажиллажээ. Газарзүйн заалтын талаарх ойлголт Монгол Улсад шинэ тутам хөгжиж буй, бөгөөд цаашид хэлэлцээг албан ёсоор эхлүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын байр суурийг боловсруулах, хэлэлцээг эхлүүлэх зорилгоор холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан Хууль зүйн сайд, Гадаад харилцааны сайдын хамтарсан тушаалаар Ажлын хэсэг байгуулагдсан юм. Монгол Улс, ЕХ-ны хооронд “Газарзүйн заалтын тухай хэлэлцээр” байгуулах бэлтгэл ажлын хүрээнд “Газарзүйн заалт” цахим сургалтыг 2021 оны 11 дүгээр сард ГХЯ, Еврокомиссын Техникийн туслалцаа, мэдээлэл солилцооны газар (ЕС TAIEХ) Оюуны Өмчийн газар, Еврокомиссын ХАА, хөдөөгийн хөгжлийн газар, Монгол Улс дахь ЕХ-ны Төлөөлөгчийн газар, МҮХАҮТ хамтран зохион байгуулсан ач холбогдолтой болжээ.

Газарзүйн заалт (Geographical Indication) гэдэг нь тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл байдал, хүмүүсийн дадал заншил зэрэг хүчин зүйлээр тодорхойлсон чанар, нэр хүнд, бусад онцлог шинж чанар бүхий бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, бүс, газар нутгийн газарзүйн тодорхойлолтыг хэлдэг.

2010 оны 6 дугаар сард баталсан “Монгол Улсын Барааны тэмдэг, газарзүйн заалтын тухай хууль”-д УИХ 2021 оны 5 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан юм.

2022 оны 1 дүгээр сарын 21-нд “Увсын чацаргана” жимсийг ЕХ-ны газарзүйн заалтад бүртгэв. Энэхүү үйл ажиллагааг анх 2016 онд Монгол Улсын Оюуны өмчийн газар, Увсын чацаргана газарзүйн заалтын нийгэмлэг, Францын ЭСЯ-ны дэмжлэгтэй эхлүүлжээ. Улмаар 2019 оноос МҮХАҮТ, Увсын чацаргана үйлдвэрлэгчдийн холбоо, Германы Худалдаа, аж үйлдвэрийн Танхимуудын холбооны SEQUA төслийн баг чацаргана тариалагчдын нэмүү өртгийн сүлжээ бий болгох хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөрийг үргэлжлүүлэн ийнхүү үр дүнд хүрчээ. Увсын чацаргана газарзүйн заалтыг ЕХ-нд бүртгэснээр ЕХ-ны гишүүн орнуудад “Увсын чацаргана” газарзүйн заалт хамгаалагдаж, хуурамч бүтээгдэхүүн борлуулахаас сэргийлэх, европын хэрэглэгчид Увсын чацарганын жинхэнэ байгаль орчин, цаг уураас шалтгаалсан онцлог амт, чанар, амин дэмийг хүртэх ач холбогдолтой юм. Түүнчлэн орон нутгийн чацаргана тариалагч, үйлдвэрлэгчдийн орлого нэмэгдэх, тогтвортой бизнес эрхлэлтийг дэмжих, байгаль орчин, цаг уураас шалтгаалсан онцлог амт, чанарыг хадгалах, цаашлаад аялал жуулчлалын шинэ суваг бий болох, хэрэглэгч худалдан авагчид чанар, стандартад нийцсэн бүтээгдэхүүн хэрэглэх зэрэг давуу талтай юм. Энэхүү үйл ажиллагаанд МҮХАҮТ Увсын чацарганын лабораторийн шинжилгээ, баримт бичигт засвар өөрчлөлтийг хийх зэргээр хувийн хэвшилтэй хамтран ажиллажээ.

VI. Төгсгөл

Монгол Улс ЕХ-той 1989 оны 8 дугаар сард дипломат харилцаа тогтоосноос хойших 30 илүү жилд хоёр талын хамтын ажиллагаанд томоохон дэвшил гарсан бөгөөд эдүгээ иж бүрэн түншлэлийн хүрээнд өргөжин хөгжиж байна. Үүнд шинээр байгуулагдсан «Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр» гол эрхзүйн үндэс болж байна. Дорнод Европын уламжлалт харилцаатай байсан посткоммунист орнууд ЕХ-нд элссэн нь тус Холбоонд Монгол Улсыг дэмжигч түншүүдийн хүрээг өргөжүүлж, экспортын зах зээлийг тэлж, ЕХ-той иж бүрэн түншлэлийг хөгжүүлэх таатай боломжийг олгож байна.

Монгол Улсын эдийн засаг олон талаас хамааралтай байх, хоёр хөрш гүрэнтэй харилцах худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны зохистой тэнцвэрийг хангахад ЕХ, түүний нөлөө бүхий гишүүн орнууд тодорхой үүрэг гүйцэтгэж байна гэж үзэж байна.

Монгол Улс, ЕХ-ны Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр хүчин төгөлдөр болж, ЕХ Улаанбаатар хотноо ДТГ-аа албан ёсоор нээснээр харилцаа, хамтын ажиллагаа түвшин шинэ үе шатанд шилжсэн гэж дүгнэж болохоор байна.

Европын Холбооны гишүүн орнууд нь Монгол Улсын хувьд БНХАУ, ОХУ-ын дараа ордог худалдааны гуравдагч том түнш, томоохон хөрөнгө оруулагч түнш мөн.

Европын Холбоо нь худалдаа, эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагааны түнш чухаг төдийгүй улс төр, аюулгүй байдлын түнш мөн.

НОМЗҮЙ

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992
2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. УБ., 2020
3. “Шинэ Сэргэлтийн бодлого” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. УБ., 2021.12.30
4. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010
5. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. УБ., 2011
6. «Европын Холбоо-Монгол Улсын чухаг түнш мөн». “Олон улс судлал” сэтгүүл. ОУСХ, ШУА, 2001.№1 (55), 27-37 дахь тал
7. Д.Уламбаяр. Монгол Улс, Өрнө дахин: Харилцаа, хамтын ажиллагаа. УБ., 2007
8. Д.Уламбаяр. Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого: хоёр ба олон талт хамтын ажиллагаа. УБ., 2022
9. Д.Уламбаяр. «Монгол Улс-Европын Холбоо: Иж бүрэн түншлэл өөд»-“Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого. Монгол-Европ: Бодлого, зорилт. ҮАБЗ-ийн ССХ, Конрад Аденауерын сан. УБ., 2012, 30-60 дахь тал
10. Д.Уламбаяр. «Монгол Улс, ЕХ-ны түншлэл, хамтын ажиллагаа-25 жил»-“Стратегийн судалгаа” сэтгүүл, ССХ, ҮАБЗ. 2014 №2 (66) 41-59 дэх тал
11. D.Ulambayar. «Central and Eastern Enlargement of the European Union: Aspires and Challenges». *Journal of Central and Eastern Europe*. №3 2015, pp. 39-45
12. Д.Уламбаяр. «Европын Холбооны шинэ сорилт ба Монгол, ЕХ-ны түншлэлийн тулгамдсан асуудал»-*Европ Судлал-1* эрдэм шинжилгээний бичиг. МУИС, Шинжлэх ухааны сургууль. Боть 17/1, УБ., 2017, 209-219 дэх тал
13. Д.Уламбаяр. “Монгол Улс, ЕХ-ны түншлэл, хамтын ажиллагааны шинэ үе шат: Асуудал ба шийдэл” “*Европ судлал- 2*” №2. 2018, 16-29 дэх тал
14. “Европын Холбоо Монгол Улсын хамтын ажиллагаа 30 жил” *Зууны мэдээ* сонин. 2019.08.01 Пүрэв №152 (6119)
15. Д.Уламбаяр. Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого: Онолын баримтлал, түүх, орчин үеийн зангилаа асуудал. (Олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үе шат). Шинжлэх ухааны доктор зэрэг горилсон бүтээл УБ., 2023
16. Framework Agreement on Partnership and Cooperation between of the European Union and Its Member States, of the one part, and Mongolia, of the other part”
17. The European Union is intent on supporting Mongolia in its continued political and economic reform path, as a valuable partner for the EU in Asia. Factsheet on the EU-Mongolia Framework Agreement on Partnership and Cooperation. Bruxelles, 17/02/2017
18. European Parliament non-legislative resolution of 15 February 2017. (08919/2016-C8-0218/2016-2015/0114(NLE)-2016/2231(INI)
19. Mongolia: Multi-Annual Indicative Programme MIP for 2021-2027 https://ec.europa.eu/international-partnerships/system/files/mip-2021-c2021-9051-mongolia-annex_en.pdf
20. The Standard, Principles and Norms of the European Union (EU Law Terminology)
21. JOINT STAFF WORKING DOCUMENT The EU Special Incentive Arrangement for Sustainable Development and Good Governance ('GSP+') assessment of Mongolia

covering the period 2018 – 2019 [https://ec.europa.eu/transparency/documents-register/detail?ref=SWD\(2020\)23&lang=en](https://ec.europa.eu/transparency/documents-register/detail?ref=SWD(2020)23&lang=en)

22. EU Delegation to the Mongolia
23. Mongolian Permanent Representative to the European Union
24. European External Action Service <https://gsphub.eu/country-info/Mongolia>
25. https://webgate.ec.europa.eu/isdb_results/factsheets/country/details_mongolia_en.pdf

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХЭЛНИЙ СУРГАЛТЫН БОДЛОГЫН АСУУДЛУУД БА ЕВРОПЫН ХОЛБООНЫ ЖИШИГ

*Надмидын Бэгз-МУ-ын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич.
Сэдийн Санжаабадам-Доктор, профессор.
Базарсүрэнгийн Баярмаа- докторант.*

Хураангуй

Нээлттэй, олон үндэстэн зэрэгцэн оршиж буй өнөөгийн глобал ертөнцөд хүн хоорондын эдийн засаг, нийгэм, соёлын өрсөлдөөн нэмэгдэхэд олон хэлний боловсрол хүний өрсөлдөх чадварын нэг гол хүчин зүйл болж байна. Нутаг дэвсгэр томтой ч хүн ам цөөтэй, хүчирхэг хөршүүдтэй монголчууд бид дэлхийн том хэлнүүдийн боловсрол эзэмших нь туйлын чухал. Иймээс зохиогчид эл илтгэлдээ глобал орчинд үндэстнүүдийн өрсөлдөх чадварын нэг гол хүчин зүйл болж буй хоёр дахь, гурав дахь хэлийг монгол хүүхдэд бага наснаас нь зааж сургахыг оновчтой тогтоохын ач холбогдлыг харуулах зорилт тавьсан юм.

Түлхүүр үг: *хүний нийгэм, харилцааны хэрэгсэл, соёлын орчны өөрчлөлт, хэл баяжих, өрсөлдөх чадвар, олон хэлний боловсрол*

Нэг. Хэлний үүсэл, хөгжил

Хэл байгалийн бүтээл биш. Хэл хүний бий болгосон соёлын чухал хэсэг. Хэл бол хүн анх амьтны сүргээс тасарч, нийгмийн зохион байгуулалтаар амьдарч эхлэх үеийнх нь хөгжлийн үр дүн, нийгмийн хөгжлийн явцад үүсэж бий болсон харилцааны хэрэгсэл. Хүн хэлтэй төрдөггүй учир төрөлх хэл гэж байхгүй. Өсөн торниж буй амьдралынхаа орчинтой танилцаж, түүнээс суралцах явцдаа хүүхэд ойр харилцагчдынхаа хэлийг даган дуурайх замаар сурч эзэмшдэг. Энэ талаар их зохиолч Д.Нацагдорж аль тэртээ 1930-аад онд “Өсөхөөс сурсан үндсэн хэл, орхиж болшгүй соёл мөн”¹ гэж гайхалтай мэргэнээр тодорхойлсон байдаг.

Хэл бол хүн амьдралын орчноо тэмдэглэх дохионы системийг бий болгосны үр дүн тул орчны өөрчлөлт, хөгжлийг тусгаж, тэдгээр ухагдахууныг тэмдэглэх нэгж болсон үгийн сан нь байнга өөрчлөгдөн баяжиж байдаг, бас ядуурч ч болдог. Хэлийг сурч болдог, хэрэглэхгүй бол бас мартагддаг. Хүн орчинтойгоо харилцах хэрэгсэл болсон хэлээ бүтээж, хэрэглэж хөгжүүлсээр олон арван мянган жилийг өнгөрөөж, өнөөдрийг хүрч. Энэ хугацаанд маш олон хэл мартагдаж, мөн олон хэл үүсэж, төгөлдөржжээ. Хүн төрөлхтний хөгжил хурдсаж, оюуны бүтээлч үйлдвэрлэл өргөн дэлгэр болсноор сүүлийн 500 жилийн дэлхийн шинжлэх ухаан, технологийн ололтыг тусгасан асар их мэдээлэл, нэр томьёо улс үндэстнүүдийн хэлэнд нэвтэрч баяжуулж байна. Энэ үйл явцын цаашдын чиг хандлагыг одоо төсөөлөх гэвэл ярилцагчгүй, хэрэглээгүй болсон хэлнүүд мөхөж, хүчирхэг том хэл хоорондын ижилсэл, ууслын үр дүнд яваандаа глобал хэл үүсэх магадлал өндөр байж магадгүй.

Хоёр. Соёлын орчин ба хэл

Бидний амьдралын их орчныг байгалийн, соёлын гэж ангилах ба тухайн нутаг дэвсгэр, уур амьсгалд дасан зохицож амьдрахын тулд хүний гараар бүтээсэн хоёрдогч орчныг соёл гэдэг. Соёлын орчны өөрчлөлт, хөгжилт хэлийг баяжуулдаг. Нэг соёлын орчны бүтээл өөр соёлын хүрээнд шинэ ухагдахуун, шинэ агуулгатайгаар нэвтрэн орохдоо ихэнхдээ нэрээ хамт авч ордог. Бурхны шашин монголд анх дэлгэрэхэд хиндү шашин, энэтхэгийн соёлын агуулга манайд хэрхэн дагаж орж ирснийг самгарди үгс монгол хэлэнд тэр үед хэр их орж ирснээс харж болно. Монгол хэлний товч тайлбар тольд одоо 200 гаруй самгарди гаралтай үг байгаа гэнэ.² Тухайлбал, *авшиг, агшин, адьяа, бадмаараг, банзал, буян, гавар, гадил, далдуу, дээд, зандан, зул, маргад, нимбэг, рашаан, самбар, соёмбо, судар, тив, увдис, хот, цэрэг, шатар, шүлэг, эрдэнэ, ямранз* болон бусад олон үг болно.

¹ Нацагдорж, Д. Түүхийн шүлэг. Зохиолууд. УБ, 1961, 193-р тал

² Сүхбаатар, О. (2014). Монгол хэлэн дэх самгарди махбод. УБ, 21-р тал.

Дараагийн хэдэн зуун жилд нь бурхны шашны хоёр дахь удаагийн дэлгэрэлтээр манай хэлэнд төвөд хэлний үг хэр өргөн цар хүрээтэйгээр орж ирснийг зөвхөн монгол хүний нэрийн толиноос харахад л төвөггүй мэдэж болно. Энэ жагсаалтыг *Аюуш, Бадам, Бээз, Галиндэв, Жамсран, Лхам, Надмид...* гэхчлэн хэчнээнээр ч үргэлжлүүлж болно³. Бас бурхан шашны холбогдолтой олон зуун нэр томъёо орж ирсэн байна. Үүнд, *аграмба, ана мана, боть, бум, бумба, дамжаа, замбаа, лазан, мэгзэм, мяндаг, сант, тотгор, царван, шад, шүгэл, элээ, ядам болон бусад олон арван үгс* орно.⁴

Монголчууд 17-р зууны сүүлийн хагаст Манжийн эзэнт гүрний эрхшээлд орсноор түүний нөлөөгөөр хятадын соёл манайд хүчтэй түрэн орж ирж, монгол хэлний үгийн сан хятад гаралтай үгээр их баяжив. Өмнө нь ч орж ирж байж. Бид өнөөдөр монгол, хятад нь мэдэгдэхээ байсан үй түмэн үгийг өдөр тутам яриандаа хэрэглэдгээ тэр бүр анзаарч мэддэггүй. Хоол, ундны холбогдолтой нэрийн дотор л гэхэд *цай, банш, бууз, хуушуур, манжин, лууван, байцай, бууцай, шанцай*, барилга, байшинтай холбогдолтой нэрийн дотор *цонх, зуух, яндан, туйлуу, банз, дүнз* гээд л явж өгнө⁵. “Монголын нууц товчоо” хэмээх их хөлгөн сударт Чингисийн эхийг *Өүлүн үжин* (фүжин гэж хятадаар хатан гэсэн үг. Ц.Д) гэж нэрлэсэн буй⁶. Мөн “Арван тавны сар” хэмээх монгол ардын дуунд *Арван тавтай шоожуу нь ай хө Аав, ээждээ дэнлүү дээ хө*⁷ гэсэн мөрөнд *шоожуу, дэнлүү* гэх хятад үгс нэг их монголчлогдоогүйгээр тааралдана. Энэ дуунд гарч байгаа шиг хятад гаралтай үгс монгол хэлэнд арвин их бөгөөд манай хэлэнд орж ирсэн он цагийн хувьд тун саяхных гэх юм билээ⁸.

Хорьдугаар зууны эхнээс монгол хэлэнд орос гаралтай, мөн оросоор дамжин европын хэлнүүдийн үгс цутган орж ирсэн нь ХХ зууны 90-ээд он хүртэл эрчимтэй үргэлжилсэн бөгөөд монголчууд орос хэлээр дэлхийн соёлтой танилцахад энэ үйл явц чухал үүрэг гүйцэтгэв. Тухайлбал, *академи, аптека, аспирант, бассейн, биологи, вакуум, вино, дежур, декан, доктор, инженер, календарь, кино, клуб, комбинат, материал, машин, металл, нейлон, нитрат, пионер, профессор, радио, роман, салат, сантехник, спорт, стандарт, театр, телевизор, технологи, туфли, университет, факультет, физик, философи, фото, хими, цемент, цирк, экспорт...* зэрэг нь орос хэлээр дамжин орж ирсэн энэтхэг-европын гаралтай хэлнүүдийн үгс.

ЗХУ задарч, социалист систем нурсан, мөн 1992 оны Үндсэн хуулиараа бид нээлттэй гадаад бодлого тунхаглаж, манай түншүүд өөрчлөгдсөн зэргээс 1990-ннд оны ардчилсан өөрчлөлтийн дараах Монгол Улсад монголчуудын ахуйд урд өмнө нь байгаагүй шинжлэх ухаан, техникийн шинэ ойлголт, шинэ нийгмийн амьдралын олон талт онцлогийг илэрхийлсэн ухагдахуунууд бусад орноос янз бүрийн хэлээр илэрхийлэгдсэн нэртэйгээ орж ирсэн нь зүй ёсны үзэгдэл байв. Ийнхүү англи, япон, солонгос, франц, герман болон бусад хэлний үгсийг тээсэн соёлын шинэ орчин бүрэлдэв. Манайд урьд өмнө нь байгаагүй, нийгэм, эдийн засаг, соёлын “капиталист” шинэ орчныг тодорхойлсон *бирж, коллеж, компани, кредит, магистр, менежмент, патент, процессор, фермер, фирм* зэрэг үгс нь “социализмаас дөнгөж сая салсан” монголчуудын хэлний хөгжлийн энэ шатанд зайлшгүй шаардлагатай баяжилт юм. Учир нь эдгээр шинэ ухагдахуун, ойлголтгүйгээр бид “хүмүүнлэг, ардчилсан нийгэм”-д оюун санааны хувьд шилжин орох боломж тун тааруу юм.

Шинэ соёл, шинэ техник технологи өөрийнхөө нэрийг авч өөр соёлын орчинд орж ирдгийн тод жишээ нь *дижитал, имплант, интернет, интерфэйс, кибер, компьютер,*

³ Сүхбаатар, О. (2014). Монгол хэлний харь үгийн толь. УБ.

⁴ Мөн тэнд

⁵ Мөнхсайхан, С. (2014). Монгол хэлний хятад гаралтай үг. УБ,

⁶ Монголын нууц товчоо. Хоёр дахь хэвлэл. Ц.Дамдинсүрэн хуучин монгол хэлнээс одоогийн монгол хэлээр орчуулав. УБ, 1957, 33-р тал.

⁷ МААЗ-ын номын сан. Монгол ардын дуу. (V) Эмхэтгэсэн Ц.Өлзийхутаг. УБ, 1982, 190-р тал.

⁸ Мөнхсайхан, С. (2014) Монгол хэлний хятад гаралтай үг. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн. УБ, 65-р тал.

нано, робот болон бусад олон зуун үг манай хэлэнд шинээр орж ирж, бидний өдөр тутмын амьдралд хэрэглэгдэж байна.

Ийнхүү монгол хэлний үгийн сангийн баяжилтыг он цагаар нь хөөгөөд үзэхэд ийм дүр зураг, хэлний хөгжлийн бодит зүй тогтол харагддаг. Учир нь ямар ч хэл дангаараа, гадна дотнын нөлөөнд авталгүйгээр, цаг хугацаа, соёлын орчны өөрчлөлтөөс ангид, “цэврээрээ” тусгаар оршино гэж байдаггүй юм. Бидний дээдсийн үүсгэн байгуулсан Монголын эзэнт гүрэн, мөн түүний дараах үед Чингисийн үр ач нарын захирч явсан евро-азийн олон арван орны нийгэм, соёлын амьдралд монгол гаралтай үгс нэвтэрч, тэдгээр хэлний хөгжилд түүхэн чухал үүрэг гүйцэтгэснийг ч энэ далимд тэмдэглэх хэрэгтэй. Ингээд бодоход монгол хэл түүхийнхээ туршид бусад соёлын орчны нөлөөгөөр олон мянган үгээр баяжиж, түүгээр нь өнөөдөр бид хүний, өөрийн гэж ялгахгүйгээр “монголоороо” ярьж, бас монголын эзэнт гүрний нөлөөнд явсан бусад үндэстэн, ястнууд бас л манай үгээр баяжсан хэлээр ярилцаж байгаа биз ээ.

Гурав. Глобал орчин ба хэлний боловсролын хэрэгцээ

Соёлын орчин огцом өөрчлөгдөхөд өөр хэлээр харилцах шаардлага үүсдэг. Одоо Дэлхий дахинд глобал нээлттэй эдийн засаг, соёлын нээлттэй орчин бүрэлдээд байна. Социализмын гэдэг хаалттай орчинд, ЗХУ-ын цэрэг, улс төр, эдийн засгийн нөлөөнд 70 гаруй жил түгжээтэй байсан Монгол оронд минь ардчилсан өөрчлөлт гарч, 1990-ээд оноос гадаад хамтын ажиллагаа өргөжин тэлэв. Үүний үрээр, одоогоос 30-аад жилийн өмнө эхэлсэн эдийн засгийн их хямралын жилүүдэд монголчууд Дэлхийн олон тивд сурч, ажиллаж, амьдрахаар олон мянгаараа гадаад орнуудыг зорих болсон юм. Хэлгүй хүнийг ажиллуулах нь битгий хэл, улсынхаа хилээр оруулах виз олгохгүй байх журам олон оронд мөрдөгддөг. Иймд хүний нутагт ажиллаж амьдрах монголчуудаас шаарддаг мэдлэг, ур чадварын хамгийн эхэнд тухайн ард түмний хэлний мэдлэг (*хэрэглэх чадвар нь ч энд хамаарна*) орж ирсэн юм. Монголчууд ч энэ хэрэгцээгээр солонгос, япон, англи, герман, франц зэрэг хэл үзэж, сурч эзэмших болов.

Өөр соёлын нөхцөлд ажиллаж, амжилт гаргахад хүнээс ажлын дадлага чадвар, ачаалал даах тэвчээр, харилцааны өндөр ур чадвар зэрэг олон “эерэг үзүүлэлт” шаардагдана. Энэ бүхэн нь хэлний сайн мэдлэггүйгээр төсөөлөхөд бэрх бөгөөд “хэлгүй” бол алхам тутамдаа өрсөлдөөнд ялагдахад хүргэдгийг манайхан яс махаараа мэдэрч эхэлсэн юм. Глобал хөдөлмөрийн зах зээл дээрх ажлын байрны өрсөлдөөнд гадаад хэлний мэдлэг хэр их үнэ цэнтэй талаар сэтгэц зүйч том эрдэмтэн “*Орчин үеийн глобал соёлын эдийн засгийн үндэс нь хувь хүн хоорондын өрсөлдөөн юм. Нэг хүн өөр бүлэг хүмүүстэй өрсөлдөж, тэдгээрийн урд гарах хэрэгтэй болдог бөгөөд заримдаа тэднийг замаасаа “түлхэх” хэрэгцээ ч үүснэ. Ингээд нэг нь ялан дийлэхэд нөгөө нь сэтгэлээр унаж, яахаа мэдэхгүй байдалд орох нь элбэг. Ийм нөхцөл байдлын сэтгэл зүйн үр дагавар нь хүмүүсийн хооронд дайсагналцал үүсэхэд хүргэнэ*”⁹ гэж тэмдэглэжээ.

Хүн амжилтын төлөө тэмүүлэхэд нөлөөлдөг нэг шалтгаан нь *түүний алдаа, оноо, амжилт, бүтэлгүйтэл нь өөрийгөө хүндэтгэх хүний мэдрэмж, сэтгэл хөдлөлд гүнзгий нөлөөлж байдаг* явдлаар тайлбарлагдана. Ажилгүйгээс хүмүүс архи уух, гэмт хэрэг зөрчилд орох зэрэг нь тэмцэлд ялагдсан амьтны гаргадаг түгээмэл авирын илрэл бөгөөд өрсөлдөгчөө ялан дийлж чадахгүйдээ хорсох, өөрийгөө чамлахдаа түүний талаар сөрөг мэдээлэл, хов, гүтгэлэг тараахаас өгсүүлээд өрсөлдөгчөө “замаас зайлуулах” хүртэл өөрийгөө хүндэтгэх сэтгэл хөдлөл нь хөндөгдсөнөөс үндэстэй адгуусан зэрлэг авир гаргадаг.

Өөр соёлын орчинд хүн “хэлгүй” байх нь түүний мэдээлэл хүлээн авах боломжийг хаана. Харин мэдээлэл эзэмших нь амжилтын эх үүсвэр болдог. Гэтэл мэдээлэлгүй, өрсөлдөх чадвар муутай хүмүүст илэрдэг өөр нэг айдас нь ирээдүйд болох таагүй зүйлээс

⁹ Карен, Хорни. (2008). Соёл ба мэдрэлийн өвчин. *Дэлхийн нэрт сэтгэл судлаач эрдэмтдийн шилмэл зохиолын хураангуй*. УБ, х.226

“харанхуйгаар” болгоомжлох, айх явдал аж. Энэ нь ихэнхдээ орчноосоо шаардлагатай мэдээлэл авч чадахгүйтэй холбоотой үүсдэг хүний сэтгэлзүйн таагүй байдал юм. Амжилтад хүрэх гэхээсээ амжилтгүй болох, алдаа гаргах боломж ийм хүмүүст илүү өргөн байдаг учраас бүтэхгүй бол яана гэдэг айдас түгээмэл ажиглагддаг аж.¹⁰

Ийнхүү глобал соёл, эдийн засгийн нөхцөлд “хэлгүй” байх юм бол бид хаа ч явсан сохор, дүлий болсноос ялгаагүй бөгөөд гадаад орчинтой харилцах бидний боломжийг хааж, монгол хүнийг өрсөлдөх чадваргүй болгоно. Дэлхийн хэмжээнд болон монголчуудын хувьд эдийн засаг, соёлын ийм глобал, өрсөлдөөнт нөхцөл байдал үүсээд байгааг мэдсээр байж, нийгмийн зарим хэсгийн зүгээс монгол хүнд өсөхөөс нь “гадаад” хэл сургахгүй байх, зааж сургавал хүүхэд, залуус “монголоо алдаж, монгол хэлгүй болох” тухай мунхаг санаа бодлыг хөөрөгдөж, мэдээлэл муутай массыг турхирч байгаа явдал бол хувь хүний хөгжил, монгол үндэстний эрх ашгийн эсрэг гэмт үйлдэл мөн.

Глобал, нээлттэй эдийн засгийн орчинд, монгол хүн өөрийнхөө газар нутаг дээр ч гаднын олон үндэстэнтэй өрсөлдөн амьдрах нөхцөл үүсээд байна. Амьдрах орчны төлөөх энэ хатуу ширүүн тэмцэл нь олон хэлний мэдлэг, чадвар, хэрэглээг юуны өмнө шаардах бөгөөд монголчуудын хувьд үүнгүйгээр тэмцэлд ялагч болж гарах боломжгүй. Хэлийг хүн бага насандаа эхлэн үзвэл амжилттай төгс сайн сурдгийг шинжлэх ухаан баталсан нь үнэн. Иймд хоёр дахь, гурав дахь хэлийг монголчуудын хойч үе бага наснаасаа төгс сайн сурч эзэмших шаардлагатай болж байна. Эдгээр нь юуны өмнө англи, орос, хятад хэл байна гэж төсөөлж болно. Энэ нь өнөөдөр зарим хүмүүсийн хийрхэж байгаачлан, бид гадаад хэл үзсэнээрээ хэлээ устгах гэж, хүүхэд, залуустаа монгол хэлээ багаас нь сайн сурч эзэмшихийг нь үгүйсгэж байгаа хэрэг огтхон ч биш билээ.

Миний төрсөн нутгийн хоёр их хутагт Жалханз Дамдинбазар, Дилова хутагт Жамсранжав нар 5 наснаас төвөд хэлэнд суралцаж, 7 насандаа олон боть судрыг орчуулан уншиж байсан нь намтар түүхэнд нь тэмдэглэгдэн үлджээ¹¹. XX зууны эхэн үеийн Б.Цэрэндорж, Ц.Дамбадорж, Д.Пагмадулам болон монголын тэр үеийн бусад толгой сэхээтнүүд, мөн энэ зууны эхэнд манай нам, төр, засгийг тэргүүлж байсан С.Баяр, Н.Энхбаяр болон С.Оюун нарын зэрэг унаган гадаад хэлтэй зүтгэлтнүүд бусдаас илүү мэдээллийн орон зайтай байсан нь монгол хэлээ төгс эзэмшихэд тэдэнд садаа болсонгүй. Одоо УИХ-д сууж буй гишүүн Ц.Мөнх-Оргил, Х.Булгантуяа зэрэг хэд хэдэн гадаад хэлтэй залуучууд эх монгол хэлээрээ төгс сайхан ярьж бичиж, орчуулж байгаа ч монголчууд бүгд харж байгаа. Энэ бүгдийг нуршиж дурдахын учир нь багадаа гадаад хэл үзэж сурсан хүүхэд монголоо алдаж, монгол сэтгэлгээгүй болдог гэх бурангуй суртлын үндэсгүйг тэмдэглэх гэсэн санаа. Хэн хэдийд хэдэн хэл сурч, яаж хөгжиж дэвжих нь үнэндээ хувь хүнээсээ л хамаардаг хэрэг.

Ер нь бол хүүхдүүд бага насандаа унаган монгол хэлээ сайн сурч эзэмшихэд гадаад хэлний сургалт огтхон ч садаа болохгүй. Хүн бага насандаа нэгэн зэрэг хэд хэдэн хэлийг сурч эзэмшиж чаддагийг манайд сургуулийн практикт харуулж, гадаадад ч шинжлэх ухаанаар нотлогдсон үнэн юм. Японд бага насны хүүхдүүдэд ярианы англи, итали, герман, франц хэлийг зэрэг зааж, эдгээр хэлээрх тайлбартай нотоор хөгжим тоглуулж сургасан амжилттай туршилтын үр дүнг дэлхий даяар магтан шагшиж, ном бүтээлд бичигдэж түгж байсан талаар Масару Ибукагийн “Гурван нас хүрэхээс нь өмнө” хэмээх алдарт бүтээлийг “Боловсрол судлал” сэтгүүлийн 2004-2006 оны дугааруудад цувралаар нийтэлж байсныг тэр үеийн уншигчид санаж байгаа байх¹².

Хүн цөөтэй, хөгжил буурай монгол үндэстэн бусад хүчирхэг ард түмнүүдийн зиндаанд сурч, хөгжинө гэхэд дэлхийн том хэлнүүдийг сурч эзэмшихгүйгээр бүтэхгүй ажил. Ийм санаа, санаачилга гарангуут монгол үндэстнийг, монгол хэлийг авран хамгаалах тухай

¹⁰ мөн тэнд, х.227

¹¹ Дилав хутагт Б.Жамсранжав. (2000). Ариун сэтгэл авралын үндэс. УБ, х.153.

¹² Масару Ибука. “Гурван нас хүрэхээс нь өмнө” Боловсрол судлал. 2005/4, х.70-75

сүржин “эх оронч” уриа лоозон цуурайтуулж, монгол хүүхэд, залуустаа монгол хэлээ муу зааж ирсэн дутагдлаа засах тухай биш, харин гадаад хэл үзсэнээс хүүхэд, залуус монгол хэлгүй болж байгаа тухай суртлаар хаацайлдаг хэсэг бүлэг манайд олон жил оршиж, мэдээлэл муутай массыг турхирч хөөргөдөг болсон нь харамсалтай.

Санскрит, төвөд, хятад, орос хэлний нөлөө хуваарьгүй ноёрхож байсан тэртээ өмнөх зуун жилүүдэд устаж, уусаж алга болоогүй монгол хэл маань өнөөдөр ХХ1 зууны шинжлэх ухаан, технологийн мэдээлэл олж авах гол хэлнүүд үзэхээр л устаж, сөнөх гээд байгаа гэх нь ямар ч үндэсгүй хортой суртал мөн. Бид монгол хэлээ хүүхэд, залуустаа муу зааж сургасныхаа бурууг хүүхдэд гадаад хэл заасантай холбож, түүн лүү алдаагаа чихдэг муу аргатай. Үнэн чанартаа олон арван жилийн туршид ЕБС-ийн хүүхдэд бага ангиас нь хэрэглээний монгол хэл биш, хэл шинжлэл зааж ирсэн нь өнөөгийн залуусын монгол хэлний мэдлэг, чадварт хортой туссан гэж үзэж болно. Энэ сургалтын алдаатай бодлого, түүний хэрэгжилт сургуулийн практикт өнөөдөр ч үргэлжилж байгаа нь манай үеийн гамшиг мөн.

Дөрөв. Глобал орчин дахь монголчуудын гадаад хэлний сургалтын бодлого, хэрэгцээ

Өнгөрсөн үед том гүрнүүдийн хувьд хэл нь олон улсын харилцааны хэрэгсэл байхаасаа илүү хэн нэгэнд өөрийн нөлөөг тулган хүлээлгэх хэрэгсэл байсан тул дэлхий дахинд гадаад хэлний байр суурь, нөлөөний төлөөх тэмцэл сүүлийн 700-800 жилийн турш тасралтгүй үргэлжилж байгаа гэж үзвэл зохино. Монголын эзэнт гүрний үед ч олон улс, үндэстнийг нэгтгэж, дэлхийн талыг хамарсан супер гүрний улсын албан ёсны хэргийг хөтлөн явуулахад зохимжтой гэж дөрвөлжин бичгийг зохион, монгол хэлээр төрийн хэрэг явуулж байсан нь энэ том глобал үйл явцын эхлэл байсан бол уу. Түүнээс хойших үед дэлхийд газар зүйн их нээлт болсон, Америк тивийг нээсэн, Африкийг эзэлсэн, Азид лал, христийн шашны миссионерүүд нэвтэрсэн жилүүдэд дэлхий дээр ямар хэл тэргүүлэх талаар байнгын тасралтгүй тэмцэл явж ирсэн байдаг. Энэ тэмцэлд англи, франц, испани, герман, португали зэрэг хэлнүүд шалгаран үлдсэн бөгөөд Дэлхийн II дайны дараах үеэс орос хэл нэмж орж ирсэн юм.

Өнгөрсөн зууны 21 онд ялсан монголын үндэсний ардчилсан хувьсгалын үр дүнг өөрийн “дэлхийн хувьсгалын” бодлогод ашиглах зорилгоо хэрэгжүүлэхийн тулд 20-иод оны эцсээс барууны сонгодог боловсролыг түших гэж оролдсон монголын нам, төр, боловсролын зүтгэлтнүүдийг өөр хооронд нь хагаралдуулан баруунтан, зүүнтэн болгон хөнөөгөөд, орос боловсролын тогтолцоог тулган хүлээлгэсэн зөвлөлтийн большевик удирдлагын бодлогоор бидний дорой монголчууд боловсролын тогтолцоондоо ганцхан орос хэл үзэхээр тусган оруулснаас хойш 60-аад жилийг ардаа хийж 1990-ээд онтой золгосон юм.

Том гүрнүүдийн дунд хавчуулагдсан бусад жижиг улс, үндэстнүүдийн нэгэн адил бидний монголчууд хажуудах том хөршүүдтэйгээ болон түүнээс цааших дэлхий ертөнцтэй өөрийнхөө монгол хэлээр харилцах бодит боломж хомс. XVII зуунаас 1910-аад оны эцэс хүртэлх үед Манж Чин гүрний хятад хэлний бодлогын нөлөөгөөр тэр үеийн монголын толгой сэхээтнүүд манж, хятад хэлэнд нэвтэрч, үүнийхээ ачаар төрийн алба залгуулж явсан бол ХХ зуун, зөвлөлтийн нөлөөний он жилүүдэд орос хэлтэй монгол хүн ажил албаны хувьд ахиж дэвших илүү боломжтой байсан үеийг бид өөрсдөө гэрчилнэ. Ерөөс жижиг ард түмэн нөлөөнд нь байгаа том гүрнийхээ юм уу эсвэл дэлхийн аль нэг түгээмэл том хэлээр гадагшаа харилцдаг нь тохиолдол бус, амьдралын гашуун үнэн юм. Гэхдээ монголчууд ХХ зуунд орос хэлэнд суралцсанаар орчин үеийн дэлхийн соёлтой танилцах сайхан боломжийг олсон бөгөөд ХХ зууны 20-оод оноос хойших 70-аад жилд монголчуудын олсон оюуны болон материаллаг соёлын хөгжил нь орос хэл, кирилл бичигтэй салшгүй холбоотойг тэмдэглэх хэрэгтэй.

Бид орос хэл үзэж, түүгээр зарим сургуульд сургалт явуулж, дэлхийн бусад хэлийг сурч судлах явдал хаалттай байсан энэ он жилүүдэд гадаад орны сургалтын бодлогод өөр хандлага давамгайлах болсон байв. Үүний нэг тод жишээ нь англи хэлийг сургуулиудынхаа сургалтын хэл болгох хандлага өнөөдөр улс орнуудад глобал шинжтэй болсон явдал юм. Зөвхөн Ази, Номхон далайн сав газрын 24 орны сургалтын албан ёсны хэлнүүдийг сургуулийнх нь шат бүрээр харьцуулж үзэхэд их сонин дүр зураг гардаг. Судалгаанд авсан эдгээр орнуудын 25,0 хувь нь англи хэлийг төрийн албан ёсны хэл болгосон Австрали, Күүкийн арлууд, Фижи, Филиппин, Энэтхэг, Шинэ Зеланд зэрэг улсууд юм. Эдгээр орны сургуулийн бүх шатанд англи хэлийг аль нэг хичээл биш, бүр бүх сургалтаа англи хэлээр явуулдаг.

Дээр дурдсан судалгаанд орсон нөгөө хэсэг орнуудад англи хэлийг албан ёсны хэл болгож тунхаглаагүй ч түүнийг өдөр тутмынхаа харилцааны хэрэглүүр болгодог Баруун Самоа, Малайзын холбоо, Малдивийн арлууд, Папуа Шинэ Гвиней, Сингапур, Шри Ланка багтана. Эдний сургуулиуд ч бүх түвшиндээ англи хэлээр сургалтаа явуулдаг.

Судалгаанаас үзэхэд Бангладеш, Камбож, БНХАУ, Индонез, Япон, БНСУ, Тайланд зэрэг улсууд бүх сургалтаа англи хэлээр явуулдаггүй ч англи хэлийг бага, дунд сургуулийнхаа сургалтын нэгдүгээр гадаад хэл болгож үздэг бөгөөд дээд сургуулиудад англи хэлийг өндөр түвшинд үздэг, шинжлэх ухааных нь хэл болсон тул хүн амынх нь тодорхой хэсэг англи хэлийг харилцааны хэрэгслийнх нь хувьд зохих хэмжээнд мэдэж, олон улсын харилцаанд энэ хэлийг өндөр түвшинд ашигладаг орнууд юм. Өнөөдрийн байдлаар Азийн Япон, БНСУ, БНСВУ, түүнээс гадна Баруун Ази, арабын ертөнц тэр чигээрээ өөрийн үндэсний хэл, бичгийн зэрэгцээ англи хэлийг албан ёсны олон улсын харилцааныхаа хэл бичиг болгож авсан байна.

Судалгааны хамгийн сонирхол татаж байгаа гуравдагч бүлэг орнууд нь англи хэлээр ярьдаггүй, түүнийг төрийн албан ёсны хэлний хэмжээнд тунхаглаагүй, өөрийн үндэсний хэлтэй, түүндээ тохирсон өөрийн бичиг үсэгтэй Бутан, Мьянмар (хуучнаар Бирмийн холбооны улс), Непал, Пакистан зэрэг орнууд болно. Эдгээр орнууд саяхан болтол дэлхийн хамгийн хоцрогдсон бүс нутагт багтдаг байсан хийгээд хүн амынх нь бичиг үсгийн болон боловсролын бусад түвшний чанар, хүртээмж бусад орнуудтай харьцуулахад их хойгуур ордог байсан улсууд юм. Сониноос энэ хэсэг улсуудад сүүлийн жилд соёл, боловсролын хөгжил хурдсаж, олон улсын харилцаанд идэвхтэйгээр татагдан орох үйл явц өрнөж байгаа нь гадаад улс орнуудын харилцааны хамгийн нийтлэг хэл болсон англи хэлээр сургалтаа явуулж, дэлхийн олон улстай харилцах хэлний саад, бэрхшээлээ ухамсартайгаар арилгаж, түүнийг алсын бодлоготойгоор хэрэгжүүлж буйтай холбож үзэж болно.

Дэлхийн хөгжингүй олон улс, орон багтдаг Европын Холбооны боловсролыг XXI зуунд хөгжүүлэх бодлого-**EuroEducation Memorandum**-д заахдаа дунд боловсролын түвшинд суралцагчдад дор хаяж 2 гадаад хэл эзэмшүүлэх, дээд боловсролын сургууль төгсөгчдөд 2 гадаад хэл өндөр түвшинд эзэмшүүлэх... гэжээ.¹³ Европын комиссоос хэвлэн гаргадаг тайланд дурдсанаар Европт хүүхдүүд бүр бага наснаасаа, ихэнх нь 6-9 настайгаасаа гадаад хэл үзэж эхлээд байна¹⁴. Сүүлийн 15 жилийн дотор улс орнуудын болон бүс нутгуудын ихэнх нь суурь гадаад хэлийг сурч эхлэх насыг доошлуулсан бөгөөд зарим нь гадаад хэлийг бүр сургуульд орохоос ч өмнө үзэж эхлэхийг санал болгож байна. Дэлхийн хөгжлийн нэг том голомт, XXI зууны глобалчлалын жишиг болж байгаа энэ бүс нутгийн

¹³ Language Policies and Language Education. Hong Kong, 2014

¹⁴ Европын Комисс. Брюссель, 2012 оны IX-р сарын 20.

боловсрол дахь гадаад хэлний сургалтын бодлого нь бидэнд анхаарах авч үзэх, бүтээлчээр суралцвал зохих жишээ болох юм. Шинэ технологийн үсрэнгүй хөгжлийн энэ глобал орчинд бидний монголчууд дэлхийн соёл, шинжлэх ухаанаас суралцах, бусад том үндэстнүүдтэй эн тэнцүү хөгжихөд олон хэлтэй баймааж энэ том зорилт хэрэгжих боломжтой.

2002 онд, ЮНЕСКО-АПЕИД Хөтөлбөрт хамрагдсан орнуудын оролцоотойгоор, Японы Боловсролын бодлогын үндэсний хүрээлэнд, Ази, Номхон далайн сав газрын орнууд дахь гадаад/хоёр дахь хэлний боловсролын асуудлаар том семинар зохион байгуулсан юм. Уг семинарын материалаас үзвэл "...энэ бүс нутагт гадаад хэлний боловсролын хэрэгцээ нэмэгдэж байгаа, англи хэлний боловсролд илүү ач холбогдол өгөх болсон, олон оронд гадаад/хоёр дахь хэлийг хүүхдэд бүр нэгдүгээр ангиас өмнө заах сонирхолтой байгаа... тухай яригдсан байна¹⁵. Семинарт оролцогчдоос энэ бүс нутгийн орнуудад хандаж зөвлөмж гаргажээ. Үүнд: гадаад/хоёр дахь хэлийг хүүхдэд бага сургуулийн 3-р ангид орохоос нь өмнө зааж эхлэх; үүний өмнө хүүхдүүдэд эх хэлийг нь сайн эзэмшүүлсэн байх; 6-10 насны хүүхдүүд өдөр бүр дор хаяж 45 минут гадаад/хоёр дахь хэлийг үзэж байхаар сургалтыг зохион байгуулах; дунд, ахлах ангийнханд гадаад/хоёр дахь хэлийг 7 хоногт гурван удаа ангид 1 цагаар үзүүлж байх; гадаад/хоёр дахь хэлний сургалт ангид болон ангиас гадуур ч тасралтгүй үргэлжилж байхаар бодож Засгийн газрууд олон хэлний бодлого явуулбал зохино... гэсэн байна (2.18). Энэ бодлого хэрхэн хэрэгжиж байгааг дараах хүснэгтээс үзэж болно.

Зүүн, Өмнөд Азийн орнуудын сургалтын хэл*

Улс	Үндэсний / албан ёсны хэл буюу сургалтын нэгдүгээр хэл		Бусад (үндсэн) албан ёсны хэл буюу англи хэл L2 эсвэл FL		Сонгож үзэх гадаад хэл
	7 хоногт үзэх цаг ^{1,2}	норм	7 хоногт үзэх цаг ²	норм	
Бруней	малай	2-5	Англи	3-5	араб
Кампучи	кхмер	4-14	Англи	3-5	франц, хятад
БНХАУ	хятад (putong-hua)	4-10	Англи	2-5	орос, герман, япон
Хонг Конг (БНХАУ)	хятад (canton)	6-10	Англи	8-10	япон
Индонез Бахаса	индонез	4-6	англи	1-2	араб, япон, герман, франц, дани
Япон	япон	5-6	англи	3-5	герман, франц, хятад, испани
БНСУ	солонгос	4-5	англи	2-5	герман, франц, испани, хятад, япон
БНАСАУ	солонгос	2-8	англи	1-3	орос, хятад
Лаос	лао	16-18	англи	3	франц, орос
Малайз	бахаса малайз	4-7	англи хятад тамил	4 2 2	франц, япон, араб
Мьянмар	мьянмар	3-6	англи	2-5	мэдээ алга
Филиппин	филипино	3-5 ²	англи	2	хятад, испани
Сингапур	англи	4-9 ²	малай хятад тамил ³	2-8	япон, франц, герман

¹⁵ Trends in Foreign/Second Language Education in Asia and the Pacific. NIER, Tokyo, 2019

Тайвань (БНХАУ)	мандарин хятад	5	англи төрөлх хэл	2-3 1-2	франц, герман, испани
Таиланд	тай	10 ²	англи	2-7	франц, герман, араб, япон, хятад, итали, пали
БНАВУ	вьетнам	6	англи	2-3	орос, франц, хятад

Эх сурв: *Language Policies and Language Education. Hong Kong, 2014*

Глобалчлалын нөлөөгөөр гадаад орнуудад эх хэлний боловсролын зэрэгцээгээр хоёр дахь, гурав дахь хэлний боловсролын сургалт тулгамдсан асуудлын нэг болж байна. XXI зуун гарч, Дэлхийн хөгжилд глобал хандлага улам хүчтэй мэдрэгдэж эхлэх энэ үед гадаадад англи хэлний нөлөөг улам хурцаар мэдэрч байна. Үүний нөлөөгөөр гадаад орнуудын боловсролын бодлогод ч тодорхой өөрчлөлтүүд орж эхэллээ. Шинэчлэлийг зоригтой, алгуур, бодлоготой хийдэг БНХАУ 2001 оны хичээлийн жилээс эхлэн улсын хэмжээгээр бүх хятад бага сургуульдаа англи хэлийг үзэж эхлэв. Англи хэлний багш бэлтгэдэг дээд сургуулиудад АНУ, Англи зэрэг улсаас жил бүр 2000 багш урилгаар ажиллуулж байхаар Засгийн газрынх нь шийдвэр гарч байв. Энэ бол хөгжлийн хандлагыг хурц мэдэрч, урьдчилан шаардлагатай алхам хийж байгаа орны төрийн бодлогын илрэл бөгөөд бид энэ бүх байдалд үнэлэлт өгч, монгол хүний гадаад хэлний боловсролын бодлогыг илүү нарийн боловсруулж тавих шаардлагатай боллоо хэмээн бид одоогоос 15 жилийн өмнө бичиж байв

16

Өнөөдөр дэлхий нийтээрээ соёл иргэншлийн нэг хэв маягт ойртон жигдэрч байгаа энэ үед хүн төрөлхтөн, улс үндэстнийг зааглан холдуулах гол бэрхшээл болсон хэлний асуудлыг шийдвэрлэх нэг шижим нь дэлхий нийтийн мэдээллийн интернет хэмээх хүчирхэг системийг ашиглах болсон асуудал юм. Энэ системийг ашиглахад юуны өмнө англи хэл, компьютерийн боловсрол зайлшгүй чухал болсон бөгөөд дэлхий нийтийн энэ глобал хандлагын гадна үлдэхгүйн тулд улс үндэстнүүд XXI зууны боловсролынхоо шинэчлэлийн тэргүүн эгнээнд англи хэлний сургалтын асуудлыг тавьж, алхам алхмаар шийдвэрлэж байна.

Энэ хэлний нөлөөгөөр дэлхийн улс орнуудад төрийн албан ёсны болон үндэсний хэлээ латин үсгийг суурь болгож авсан бичгээр тэмдэглэх хандлага ч хүчтэй боллоо. Эдний дотор латин үсэгт суурилсан, зарим нэг цэг, тэмдэг нэмж өөрийн болгосон бичгээр албан хэргээ явуулдаг болсон орнууд гэвэл Азиас БНСВУ байна. Бүгд Найрамдах Турк Улсыг үндэслэн байгуулж, 1923 онд шинэ турк улсыг тунхагласан их удирдагч Ата Турк жанжин 1928 онд зарлиг гаргаж, олон зуун жил ашигласан араб бичгээ халж, латин бичгийг аваад, улмаар 1932 онд улсынхаа албан ёсны хэлийг англи хэл болгосон байдаг. Үүний ачаар энэ орон богино хугацаанд бичиг үсгийн боловсролынхоо асуудлыг шийдвэрлэж, бусад өндөр соёл бүхий орнуудын техник, технологийн дэвшлийг хүлээн авахад хэлний бэрхшээлгүй болж, хөгжлийн өндөр түвшинд хүрээд, Азийн европ гэгдэж, НАТО-ийн гишүүн, Европын холбоотой хамгийн ойр хамтран ажилладаг өндөр хөгжил бүхий Азийн хүчирхэг гүрэн болж чадсан байна. Англи хэлийг XXI зууны харилцааны гол хэл, олон улсын харилцаа, мэдээлэлд нэвтрэх гарц гэж үзэж, арабын ертөнц тэр чигээрээ, Зүүн Ази, Өмнөд Ази бүхэлдээ англи хэлээр ярьдаг болоод байна.

Бидний авч ашигласан дээрх судалгаанд хамрагдсан Азийн орнуудаас, ялангуяа Зүүн хойд Азийн худалдаа, эдийн засаг, улс төрийн харилцааны чухал бүсэд оршдог хэрнээ бүх

¹⁶ Бэгз, Н. 2008. Боловсролын хөгжлийн онол, аргагүйн асуудлууд. УБ, х.128.

нийтийн англи хэлний боловсролын гадна үлдсэн цорын ганц орон бол Монгол Улс юм. Бид газарзүйн байрлал, улс орнуудын хоорондын харилцааны түүхэн хүчин зүйлийн улмаас ЗХУ-ын улс төр, эдийн засаг, соёлын нөлөөнд олон жил байж, оросоос өөр гадаад хэлний хэрэгцээ бага байсантай холбоотой МУИС-ийн монгол хэлний 3-5 дугаар курсээс өөр газар англи хэлийг зааж сургалгүй байсаар 1990-ээд оныг үзсэн юм. Социалист систем, ЗХУ задарч, тэдгээрээс манай улсад үзүүлэх улс төр, эдийн засаг, соёлын нөлөө багассан, мөн Монгол Улсын гадаад бодлогод олон тулгуурт зарчим үйлчлэх болсонтой холбоотойгоор манай иргэдийн гадаад хэлний хэрэгцээ шинэ байдлаар тавигдах болов. Монгол Улсын Гэгээрлийн сайдын 1997 оны 7 дугаар сарын 25-ны “Гадаад хэлний сургалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 208 тоот тушаалаар 1997-1998 оны хичээлийн жилээс эхлэн бүх шатны сургалтын байгууллагад гадаад хэлний сургалтаар англи хэлийг эхний ээлжид заахаар зохион байгуулах шийдвэр гаргасан юм. Монголчуудын англи хэлний боловсролыг дээшлүүлэхэд энэ шийдвэр туйлын чухал ач холбогдолтой болсныг тэмдэглэх хэрэгтэй. Түүнийг дагалдан олон чухал арга хэмжээг хэрэгжүүлж, өнгөрсөн жилүүдэд дунд, дээд сургуулийн хүрээнд англи хэлний сургалтын талаар чамлалтгүй үр дүнд хүрлээ.

Монгол Улсын Их Хурлаар 2023 онд батлан гаргасан Боловсролын ерөнхий хуулийн 6.1.-д Монгол Улсад сургалтын үндсэн гадаад хэл нь англи хэл байна гэж заасан нь манай улсын англи хэлний сургалтад түүхэн чухал ач холбогдолтой бодлогын арга хэмжээ боллоо. Уг хуулийг хэрэгжүүлэх бодлогын хүрээнд БСҮХ-ээс сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулан гаргахдаа бага сургуулийн 3-р ангиас англи хэлийг заавал үзэх агуулга байдлаар төлөвлөж гаргах болно. Энэ зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор англи хэл заах багшийг бэлтгэх, сургалтын аргазүйг боловсруулах асуудлыг нийгмийн өргөн оролцоотойгоор шийдвэрлэвэл зүйтэй гэж үзэж байна. Дунд болон дундын дараах шатны боловсролын түвшинд англи хэлийг гүнзгийрүүлж үзэх, түүгээр сургалт явуулах асуудлыг одоогоос бодолцох хэрэгтэй. Ойрын жилүүдэд дээд боловсролын магистрын түвшинд суралцагчид төгсөхдөө TOEFL-ийн 400-450 онооны түвшинд уг хэлийг эзэмшсэн байх шаардлага тавьж ажиллах талаарх бидний санаачилга тэр бүр хэрэгжихгүй байна. Төрийн болон хувийн байгууллагад ажиллагчдад тавих мэдлэг, чадварын нэг үндсэн шалгуур нь англи хэлний боловсрол болох ёстой. Энэ талаар бизнесийн байгууллагуудаас гаргаж байгаа эхлэлийг дэмжиж урамшуулах, бүх нийтийн англи хэлний боловсролыг дээшлүүлэх албан бус сургалтыг өргөтгөх арга хэмжээ авах нь энэ талын бодлогын нэг хэсэг байх ёстой. Ингэж чадвал XXI зууны эхэнд бусад улс үндэстнээс илт хоцорч байгаа харилцааны нэг гол чадвараа нэмэгдүүлэх боломж бидэнд олдоно.

Манай түүхээс үзэхэд өнгөрсөн зуунуудад хоёр эрэгтэй хүүхэдтэй айлын нэг хүүхдийг нь, гурван эрэгтэй хүүхэдтэй бол хоёрыг нь 5 нас хүрэнгүүт нь хүрээнд өгч төвөд ном үзүүлдэг байв. Манай хөгшин аав эцэг эхээсээ арван нэгүүлээ бөгөөд тэдний найман эрэгтэй хүүхдийн дөрөв нь хүрээнд сууж, гавж мяндагтай болсон байдаг. 1918 оны хүн амын тооллогоор монголын бүх эрчүүдийн тэн хагас нь хүрээнд сууж байсан тоо бий. Энэ олон мянган лам нарын дотроос монгол хэлтэй, төвөд хэл бичигт боловсорсон эрдэмтэд үй олноороо төрөн гарчээ. XX зууны 30-аад оны сүүлч хүртэлх үед Монгол оронд Бурхны шажин өргөнөөр дэлгэрч ахуйд хутагт хувилгаадыг 5 хүртэлх насанд нь тодруулан, хүрээ хийдэд суулгаж, тусгай багш гарган ном заалгуулж байжээ. Манай нутгийн их хүн, Жалханз хутагт Содномын Дамдинбазар, Дилав хутагт Б.Жамсранжав нарыг таван насанд нь Дээрхийн гэгээн Богд Жавзандамбын шийдвэрээр хутагтын дүрээр тодруулж, Жалханзын хүрээ, Нарованчин хийдэд тус тус шавилан суулгасан ба тэд таван наснаас төвөд хэл үзэж, долоон насандаа монгол, төвөд хэлнээс алианаас нь ч олон боть ном орчуулах чадвартай болсон байжээ.

Өнгөрсөн зууны эхэн үеийн сэхээтнүүд дотроос багаасаа гадаад хэл үзсэн монголын сэхээтнүүд тухайн үедээ хамгийн боловсрол сайтай, тэргүүний эх орончид байв. Учир нь

тэд мэдээлэл хүлээж авах боломжоор “хэлгүй” хүмүүсээс давуутай байдаг болохоор юмны учрыг илүүтэй сайн олдог байсан бололтой. Ерөнхий сайд С.Дамдинбазар, Д.Бодоо, Б.Цэрэндорж, НТХ-ны дарга Ц.Дамбадорж, Намын Төв шалган байцаах комиссын дарга Б.Жадамбаа, Улсын Ерөнхий Прокурор М.Ядамсүрэн, Эмэгтэйчүүлийн Төв Зөвлөлийн дарга Д.Пагмадулам... зэрэг сэхээтнүүд нь хар багаасаа гадаад хэлэнд сайтар боловсорсон хүмүүс байв. Тэд монгол хэл, бичгээ гаргууд сайн мэддэг, түүнийг хайрлаж хамгаалах асуудлыг монгол хүнд өөр ямар нэгэн хэл заах асуудалтай хэзээ хольж хутгадаггүй, түүнд сөргүүлэн тавьж, эсэргүүцэж байгаагүй юм. Тэд нар гадаад олон хэлний боловсролыг талархан дэмжиж, хүүхдийг багаас нь олон хэлэнд сургахыг уриалдаг байлаа-

Энэ жилээс англи хэлийг монголчуудын нэгдүгээр гадаад хэл болгох асуудлыг төрийн бодлогын хэмжээнд тунхаглаж¹⁷, түүнийг хэрэгжүүлэх Үндэсний хөтөлбөр боловсруулж мөрдөх гэж байна. Англи хэлийг ингэж төрийн бодлогын түвшинд тавьж анхаарал тавихдаа орос хэлийг ор тас мартана гэсэн хэрэг биш гэдгийг тэмдэглэх ёстой. Өнөөдөр Орос гүрэн дотооддоо нийгэм, эдийн засаг, улс төрийн гүн хямралтай, түүнийг тойрон хамт нэгэн том эзэнт гүрнийг бүрдүүлж байсан 14 улс тусдаа тасран гарсан зэргээс ОХУ-ын олон улсын жин, нөлөө нь хуучин ЗХУ-ын орон зайг нөхөж хэзээ ч чадахгүй болсон ч энэ залуу ард түмэн түүхийн богино хугацаанд дэлхийн супер гүрэн болох эдийн засаг, оюун санааны асар их потенциалтай үндэстэн юм.

Нөгөө талаар бид энэ том гүрний мөнхийн хөрш бөгөөд бидэн шиг жижиг ард түмний хувьд орос хэл бол олон улсын шинжлэх ухаан, соёлын ололттой танилцах хоёр дахь гадаад хэл хэвээр үлдэнэ. Иймд орос хэлний бодлогыг өнөөдрийн тодорхойлсон тэр хэмжээндээ дунд, дээд боловсролын түвшинд мэргэжилтэйгээ холбон сурч эзэмших, дээд боловсролын магистрын зэргийн түвшинд суралцагчид нь ОХУ-ын Ерөнхий ба мэргэжлийн боловсролын яамнаас баталсан Гадаадын иргэдийг орос хэлээр шалгах сертификацийн II түвшинд, докторын зэргийн сургалтад хамрагчид сертификацийн III түвшинд (Министерство общего и профессионального образования Российской Федерации. Российская Государственная система тестирования граждан зарубежных стран по русскому языку. II, III сертификационные уровни) орос хэлийг мэргэжлийн дагуу эзэмшсэн байх шаардлагыг тавих нь зүйтэй гэж үзэж байна.

БНХАУ энэ зуунд дэлхийд хоёр дахь том эдийн засаг болж гарч ирсэн, цэрэг, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хөгжлөөрөө цойлон гарч ирж байгаа, манай мөнхийн хөрш том орон бөгөөд хятад хэлийг өнөө болтол сургалтад албан ёсоор үзэх эсэхийг манайд бодлогын түвшинд шийдвэрлээгүй байгаа юм. 1960-аад онд хоёр орны харилцаа сайн байх үед Улаанбаатар хотод БНХАУ-ын ЭСЯ-ны дэргэд нээгдсэн хятад сургуулиас өөр албан ёсны зөвшөөрөлтэй сургууль байхгүй ч өнөөдөр хятад хэлний сургалт телевиз, радио, бие даасан сургууль, курсээс өгсүүлээд албан ёсны сургалтад сонгон судлах хичээлийн түвшинд аль хэдийн яргаж шургаж орж ирсэн байна. Энэ нь алгуур, янз бүрийн зөөлөн явуур аргаар хятад хэл үзэх ажлыг сургалтын янз бүрийн түвшинд нэвтрүүлэх ажлыг өмнөд хөрш тууштай хэрэгжүүлсээр 30-аад жил болж байгаагийн үр дүн юм.

Ер нь хөрш орныхоо хэлийг, мөн дэлхийд хүчээ авч байгаа шинжлэх ухаан, техник, эдийн засаг, худалдааны том хэл гэдэг утгаар нь авч үзсэн ч хятад хэлийг үзэж судлах нь монголчууд бидэнд аль ч талаараа ач холбогдолтой болно. Иймд хятад хэлийг ойрын ирээдүйд манай гадаад хэлний сургалтын бодлогод зохих байдлаар тусгаж оруулах шаардлагатай гэж үзэж байна.

Дүгнэлт

XX зууны сүүлийн хагаст эрчээ авсан глобал хөгжлийн хандлага нь олон улсын харилцаа, хамтын ажиллагааг эрс түргэтгэж, дэлхийн хэмжээгээр нэгдмэл голлох хэл, мэдээллийн нэг систем, харилцааны нийтлэг зарчмыг бий болгож байна.

¹⁷ Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого. УБ, 2008.

Улс, үндэстэн бүрийн боловсролын тогтолцооны хөгжилд онцлогоосоо илүү нийтлэг шинж нь давамгайлах хандлагатай боллоо. Ингэснээр боловсролын хөгжлийн асуудал нэг улс, нэг үндэстний хэмжээнээс хальж, түүний хөгжлийн хүчин зүйлүүд нь нэг хэсэг улс, бүхэл бүтэн тив, цаашлаад Дэлхийн хэмжээний асуудлаас хамааралтай болж байна. Хөгжлийн энэ нийтлэг хандлага бидэнд ч бас хамаатай төдийгүй түүнээс хойш суух, үндэсний онцлог гэдгээр бамбай хийх нь манай мэт жижиг улсын хувьд нийтийн хөгжлөөс өөрийгөө тусгаарлахад хүргэх аюулыг бий болгох байдалтай боллоо. Энэ нь бидний гадаад хэлний сургалтын бодлого, сурч эзэмших хэлнүүдийн мэдлэг, чадварт ч мөн хамаарна.

Номзүй

1. Бэгз, Н. (2023). Монголын боловсрол судлал. УБ,
2. Бэгз, Н. (2011) Монголын боловсрол судлалын шинэ парадигм. УБ,
3. Карен Хорни. (2008) Соёл ба мэдрэлийн өвчин. *Дэлхийн нэрт сэтгэл судлаач эрдэмтдийн шилмэл зохиолын хураангуй*. УБ,
4. Монгол ардын дуу. *МАЗ-ын номын сан. (V) Эмхэтгэсэн Ц.Өлзийхутаг*. УБ, 1982,
5. Монголын нууц товчоо. (1957). Хоёр дахь хэвлэл. Ц.Дамдинсүрэн хуучин монгол хэлнээс одоогийн монгол хэлээр орчуулав. УБ,.
6. Мөнхсайхан, С. (2014) Монгол хэлний хятад гаралтай үг. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн УБ,.
7. Сүхбаатар, О.(2014) Монгол хэлэн дэх самгарди махбод. УБ,
8. Дилав хутагт Б.Жамсранжав. (2000). Ариун сэтгэл авралын үндэс. УБ,
9. Масару Ибука. (2005). Гурван нас хүрэхээс нь өмнө. Боловсрол сэтгүүл. 2005/4
10. Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого. УБ, 2008.
11. Language Policies and Language Education. Hong Kong, 2014
12. Европын Комисс. Брюссель, 2012 оны IX-р сарын 20.
13. Trends in Foreign/Second Language Education in Asia and the Pacific. NIER, Tokyo, 2019

БОЛОВСРОЛЫН ШИНЭТГЭЛ:**ФИНЛАНДААС СУРАЛЦАЖ, МОНГОЛООР СЭТГЭХҮЙ**

Б.Энхмандах- Онц Бөгөөд Бүрэн Эрхт Элчин, Доктор (Ph.D.)

Э.Энхчимэг- Япон Улсын Киотогийн Их сургууль, Доктор (Ph.D.)

Оршил

Монгол Улсын боловсролын салбарын шинэчлэл зөвхөн нэг намын асуудал биш, энэ бол үндэсний зөвшилцлийн хүрээнд шийдвэрлэх асуудал бөгөөд Монголын боловсролын тогтолцоог боловсронгуй болгож, шинэчлэхийн тулд өөрийн боловсролын түвшнийг харьцуулан ойлгох үүднээс, гадаадын тэргүүний ололт туршлагатай харьцуулан авч үзэх шаардлагатай санагддаг.

Английн Ерөнхий сайд асан Тони Блейр боловсролын шинэчлэлээр нийгмийн давхаргуудыг эрүүлжүүлье гэсэн санаагаа “Боловсрол, боловсрол бас дахин боловсрол” гэсэн үгээр илэрхийлж байсан нь одоо ч Европын улсуудын төрийн бодлогын энэ гол зарчим хэвээр байсаар байна.

Эрт дээр үеэс монголчууд “Суоми” гэж нэрлэж ирсэн Хойт туйлын сами иргэдийн өлгий нутаг болох Финланд улсын боловсролын тогтолцоог өнөөдөр дэлхийн хамгийн шилдэг боловсролын тогтолцооны нэг хэмээн магтаж байна.

Европын Эдийн засгийн Хамтын ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (Organisation for Economic Co-operation and Development /OECD/) хэл бичиг, тоо бодлого, байгалийн шинжлэх ухааны хичээлээр Олон улсын Суралцагсдын үнэлгээний Олон Улсын Хөтөлбөр (Programme for International Student Assessment /PISA/) нэгэн шалгалтыг зохион байгуулдаг. Уг байгууллага ЕЭЗХАХБ-ын гишүүн орнуудын 15 настай сурагчдын шалгалтад үнэлгээ өгөхөд Финландын сурагчид сайн дүн үзүүлж, өндөр үнэлэгдэж, олон улсын анхаарал сонирхлыг татсаар байна. Тиймээс олон орны судлаач, багш нар Финландын боловсролын тогтолцоотой танилцах, туршлагыг нь судалсаар иржээ.

Суомичууд өөрсдөө боловсролын салбарынхаа амжилтыг үндэсний хэмжээний дараах ололт, давуу талууд, олон хүчин зүйлээс хамаардаг гэж үздэг. Түүнийг нь монголчууд бид олж мэдэхийг хүсэж байна.

Боловсролын багц хуулийг шинэчлэх ажлын хэсэг туршлага судлах зорилгоор 2022 онд Бүгд Найрамдах Финланд Улсад хоёр ч удаа ажиллаж холбогдох төрийн захиргааны байгууллагууд, их сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцсан байна.

Бүгд Найрамдах Финланд Улсаас Монгол Улсад суугаа Онц Бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайд, хатагтай Лийна-Кайса Миккола 2023 онд Улаанбаатарт хоёронтоо хүрэлцэн ирж, айлчлалын хугацаанд Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайд, УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалантай уулзаж, тэд хоёр орны боловсролын салбарын хамтын ажиллагааны талаар санал солилцож, зарим тохиролцоонуудыг хийсэн байна.

БШУЯ, Финландын Турку Их сургуулийн дэргэдэх "Eduten" дижитал боловсролын компани харилцан ойлголцлын санамж бичгийг Финланд улсын "Eduten" математикийн сургалтыг

дэмжигч хиймэл оюун ухаанд суурилсан платформыг Монгол улсын ЕБС-ийн сурагчид эх хэл дээрээ ашиглах боломжтой болж байгаа таатай мэдээ ч байна.

Тиймээс суомичуудын хүн төрөлхтний нийгмийн шинэчлэлд боловсролын салбарт оруулсан шилдэг ололтуудыг Монгол хөрсөн дээр буулган ойлгохын тулд энэ илтгэлд зарчмын ач холбогдолтой зарим туршлагыг тодотгон авч үзэхийг зорилоо.

Бичиг үсэг тайлагдалт

Финландын боловсролын өндөр хөгжлийг гагцхүү сургуулийн тогтолцоотой холбон тайлбарлах боломжгүй, нийгмийн нөхцөл байдлыг, тэр ч байтугай түүхэн нөхцөлдөлгөөг авч үзэх шаардлагатай.

Финландад бичиг үсэг тайлагдалт өндөр хувьтай байдгийг ном уншихыг хөхиүлэн дэмждэг соёл, түүний урт удаан хугацааны уламжлал гэх мэт чухал хоёр хүчин зүйлтэй холбон тайлбарладаг.

Олон зуун жилийн туршид сүм хийд суоми хүмүүсийг бичиг үсэгт тайлагдахыг хариуцаж ирсэн бөгөөд протестант шашин хүн бүхэн юуны өмнө Библи болон шашны бусад судрыг уншиж чаддаг байх ёстой гэдэг зарчмыг баримталсан учир Финландад эхлээд номтой байх, дараа нь хүмүүс бичиг үсэгт тайлагдсан байх шаардлага тавигддаг байжээ. Тэр ч байтугай, “Гэрлэхийн тулд бичиг үсэгт тайлагдсан байх тухай” 1660 оны зарлиг хүн амыг бичиг үсэгт тайлагдахад чухал түлхэц үзүүлсэн гэж финнчүүд ярьдаг. Энэ бүхнийг сүм хийд нь ерөнхийдөө захиргаадлын хэлбэрээр зохион байгуулж байсан хэрэг.

Хэл бичиг, утга зохиолын нөлөөгөөр XIX Зуунд Финландын үндэсний үзэл идэвхтэй сэргэжээ. Одоо ч Финчүүд ном, сонин идэвхтэй уншдаг, жирийн фин айл Европын дундаж айлынхаас олон номтой байдаг. Финланд улс сонин хэвлэл уншигчдынхаа тоогоор дэлхийд тэргүүлдэг, хүүхэд, багачууд нь дуртай сэтгүүлээ гэрийнхээ хаягаар захиалж хэвшсэн, айл өрхийн амьдралд ном уншлага зайлшгүй багтдаг. Ийм болохоор Зул сарын баяр, Төрсөн өдөр, Сургууль төгсөхөд ном бэлэглэх нь түгээмэл, хэвшсэн заншил болсон байна.

Финландад хот, хөдөөд ялгаагүй явуулын номын сан бүхий номын сангийн иж бүрэн тогтолцоо ажилладаг.

Монгол Улсын хувьд бичиг үсгийн боловсролын 2000 жилийн түүхтэйгээс гадна XX Зуунд социализмын он жилүүдэд бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгаж, бүх нийтийг дунд боловсрол эзэмшүүлэх зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлж, 1970 онд Монгол Улс бүх нийтээр 100 хувь бичиг үсэгтэн болсныг үнэлэн ЮНЕСКО-оос “Бичиг үсгийн шагнал”-аар шагнуулж байсан орон билээ.

Тиймээс боловсролын тогтолцоог өндөр хөгжилтэй Финландын түвшинд хүргэн хөгжүүлэх хөрс суурь монголчуудад байгаа гэж үзэж болно.

Бүрэн дунд боловсрол

Хөдөө аж ахуй зонхилсон Финланд улс эрчимтэй аж үйлдвэржин 1960-аад онд зохих нөхцөл бүрдэх хүртэл бүрэн дунд боловсролын сургуулийн үндсэн тогтолцоо боловсролын салбарын хувьд мөрөөдөл төдий л байжээ.

Чинээлэг хангалуун нийгмийг байгуулах, олон улсад өрсөлдөж, өндөр чанартай бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд төр, хувийн хэвшил аль алинд нь боловсролтой

ажилчдыг шаардсан. Үйлчилгээний болон аж үйлдвэржсэн нийгмийн эрчимтэй хөгжил нь ур чадвар сайтай хүний нөөцийг бий болгож, үр дүнтэй ашиглахыг шаардаж эхэлсэн. Энэ бол боловсролыг эрчимтэй хөгжүүлэх нийгмийн хэрэгцээ байжээ.

Эдийн засгийн хүчин зүйлүүдээс гадна нийгмийн тэгш байдал Финландын улс төрийн үндсэн зорилго болж тавигддаг болсон. Эрх баригч Финландын Хөдөлмөрийн намын зүгээс суурь боловсролд бүрэн дунд сургуулийн тогтолцооны улс төрийн шаардлагатай эх суурийг бүрдүүлж өгсөн байдаг. Хаана оршин суудаг, эцэг эх нь ямар бэл бэлчинтэйг үл харгалзан хүүхэд, залууст 9 жилийн боловсрол заавал эзэмшүүлэх болзолтойгоор хуулийг Финландын Парламент баталсан. Бүрэн дунд сургууль чухамдаа нийтэд зориулагдсан сургууль болж чадсан.

Боловсролын салбарын шинэчлэл багш бэлтгэх тогтолцоог нэгэн зэрэг шинэчлэхийг шаардсан бөгөөд багш бэлтгэх үүргийг Магистрын зэрэг олгох сургалт явуулдаг их сургуулиудад хариуцуулсан. Дээд боловсролтой багш нарыг хөдөө орон нутагт хангалттай тоогоор бэлтгэхийн тулд Финландын Умард, Дорнод болон бусад бүс нутгийн долоон Их сургуульд тусгай сургалт явуулжээ.

Суурь боловсролыг эзэмшүүлэх, бүрэн дунд боловсролын тогтолцоог сайжруулж боловсронгуй болгох үүргийг нутгийн захиргаануудад ногдуулсан байдаг. Биеэ даасан эрхтэй орон нутгийн захиргаа болон үндэсний боловсролын тогтолцоог зохистой сайтар уялдуулж чадсанд өнөөгийн Финландын боловсролын бас нэг давуу тал нь оршдог гэж үздэг. Финландад 300 гаруй хот байдаг. Мөн орон нутгийн сургуулийн удирдлагад сурагчдын эцэг, эхчүүд идэвхтэй оролцдог. Тэр утгаар нь авч үзвэл бүрэн дунд сургууль гэдэг бол Финландын ардчиллын бас нэгэн бүрэлдэхүүн хэсэг болсон гэсэн үг.

Нэгдсэн бүрэн дунд сургууль бол Финландын хамгийн чухал шинэчлэлтийн нэг бөгөөд нийгэмд ялгарал явагдаж байгаа үед улс үндэстнийг нэгтгэх хүчин зүйл болж, мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургуулиудад чанартай боловсрол олгох нөхцөлийг бүрдүүлдэг боловсролын тогтолцооны бэлгэдэл нь болсон гэж үздэг байна.

Боловсролын тогтолцоог бүс нутгийн түвшинд удирддаг боловч сургууль бүхэн үндэсний хэмжээний сургалтын хөтөлбөрийг баримталж ажилладаг учир орон нутгийн онцлогоос үл хамааран улс орон даяар, хот, тосгон бүхэнд боловсролын чанар ижил баталгааждаг. Суурь боловсролыг эзэмшихэд улсын шалгалт авдаггүй, сургуулиудыг нийтэд нь зэрэглэдэггүй.

Суурь боловсрол эзэмшигчдийн тэн хагас орчим нь ахлах сургуулийг сонгодог бөгөөд түүнийг дүүргэсэн сурагчид улсын шалгалт өгдөг. Ахлах сургуулийн боловсрол төлбөргүй, сурагчид суралцах хурднаасаа хамаарч уян хатан, 2-4 жил суралцдаг, үндэсний хэмжээний сургалтын хөтөлбөрт тусгагдсан болон сонгон суралцсан хичээлээр боловсрол эзэмшдэг.

Финландын бүрэн дунд боловсролын салбарын дараах 3 өвөрмөц онцлогийг Монголчууд бид сонирхон гүнзгийрүүлэн судалж үзмээр санагддаг. Үүнд:

- Олон улсад манайд ч адил сурагчдын юу сурч мэдсэнийг тодорхойлох сонгомол арга нь урьдчилан бэлтгэсэн асуултад хариулуулах, тест бөглүүлэх хэмээн үздэг. Тэгвэл Финландад энэ маягаар түвшин тогтоох шалгалт олон авдаггүй. Хүүхдүүд нийт суралцах хугацаанд ердөө нэг шалгалт өгдөг нь ахлах сургууль төгсөхдөө өгдөг төгсөлтийн шалгалт ажээ. Сурагчид өөрсдийн онцлогт тохирсон байдлаар анги болон хуваагдаж, багшийнхаа

үнэлгээний системийн дагуу дэвшин суралцдаг. Мэдээж хэрэг сургалтын эдгээр үйл явцыг Боловсролын яамнаас нь хянаж байдаг.

- Ихэнх улс орон боловсролын системийг өрсөлдөөн гэж хардаг. Харин Финландын боловсролын систем нь мерит зарчимд суурилдаггүй тул өндөр оноотой сурагч, шилдэг багшийг шалгаруулж, шагнаж урамшуулах тогтолцоо байхгүй. Учир нь Финландын боловсролын тогтолцоо нь сурагчдыг өөр хооронд нь өрсөлдүүлэх бус багаар ажиллуулж сургахыг илүүд үздэг.

- Өсөж хөгжиж, тоглох насанд нь хүүхдийг албан боловсролоор шахах шаардлагагүй гэж финландчууд үздэг. Өөрөөр хэлбэл, хүүхэд насандаа хүүхэд хэвээрээ байх боломжийг бяцхан иргэддээ өгч буй хэрэг. Тиймээс хүүхдүүд долоон настайгаа эхлэн суралцдаг. Сургуульд заавал суралцах хугацаа нь ердөө есөн жил. Есдүгээр ангиа төгсөхөд сурагчид 16 настай байх бөгөөд энэ үе нь биологи, сэтгэл зүйн талаас авч үзвэл сонголт хийхэд хамгийн тохиромжтой нас гэж үздэг. Энэ үедээ сурагчид академик эсвэл мэргэжлийн боловсролын алийг эзэмшихээ шийдэх чадвартай болсон байдаг байна.

Багш бэлтгэх тогтолцоо

Финландын боловсролын салбарын шинэчлэл багш бэлтгэх тогтолцоог нэгэн зэрэг шинэчлэхийг шаардсан бөгөөд багш бэлтгэх үүргийг Магистрын зэрэг олгох сургалт явуулдаг их сургуулиудад хариуцуулсан байна. Дээд боловсролтой багш нарыг хөдөө орон нутагт хангалттай тоогоор бэлтгэхийн тулд Финландын Умард, Дорнод болон бусад бүс нутгийн долоон Их сургуульд тусгай сургалт явуулж эхэлсэн байдаг.

Дунд сургуулийн багш нарын цалин хангамж тийм ч өндөрт тооцогддоггүй ч амьдралдаа хүрэлцээтэй. үндсэн цалин нь 2300 евро орчим байх бөгөөд илүү цагийн хөлстэй нийлээд сард 3000 орчим еврогийн цалин авдаг аж. Мэдээж ажилласан жил, туршлага, ажлын амжилтаараа ялгаатай.

Багшийн мэргэжил хамгийн их өрсөлдөөнтэй, залуусын сонирхлыг ихээр татдаг, багш болох хүсэлтэй хүн олон мянгаараа байдаг. Тэр хэмжээгээр хамгийн мэдлэг, чадвартай залуус элсдэг салбар ажээ. Финландад багшийн нэр хүнд асар өндөр байдаг нь эрт дээр үеэс тэднийг “**Ард түмний дэнлүү**” гэж хүндэтгэн нэрлэдэг байсантай ч холбоотой байх талтай.

Тиймээс Финландын боловсролын системийн гайхамшиг нь багшлах боловсон хүчнийг бэлтгэж буй системийнх нь гайхамшиг гэж хэлж болно. Энэ бүхнийг шударга, нийцтэй хөтөлж явуулж байдаг багшийн мэдлэг, чадвар, багшийн сонгон шалгаруулалтад маш их анхаардаг бөгөөд багшид заавал байх ёстой үнэнч шударга зан чанар, мэргэжлийн ёс зүй, хууль журмыг нарийн сахих чадвар сул бол дээрх хатуу шүүлтүүрүүдийг даван тууллаа ч багш болж чаддаггүй ажээ. Финландын багш бэлтгэх системийн нэг онцлог нь багш болох оюутан заавал боловсролын мастер зэрэг хамгаалах ёстойг хуульчилсан байдаг. Иймийн тулд дор хаяж 5-6 жил онол судалж, практик дадлага хийнэ. Тухайлбал бага ангийн багш болохын тулд 312 цагийн практик дадлага хийсэн байх учиртай. Тэгэхдээ онолын лекц хичээлдээ ч суугаад, практик ажлаа ч зэрэг хийдэг ажээ. Багш мэргэжлээр суралцаж буй оюутны багшлах дадлага хийхэд хүртэл дадлага хийхийг хүссэн сургууль дээрээ сонгон шалгаруулах шалгалт өгч байж эрх олж авдаг. Практик дадлагыг 3 үе шаттай шалгалт өгч байж давна. Дороосоо дээшлэн дүгнүүлж явсаар хамгийн эцэст тэнцэв гэсэн үнэлгээ авч байж сая багшлах эрхтэй болно. Шат бүрд эзэмших ёстой мэдлэг чадвар дутуу байвал хугацаагаа сунган давтлага хийж байж шат ахина. Багшийг аргалах зэрэг бусармаг зүйл

гардаггүй, гарсан тохиолдолд хичээж сурсан бүх зүйлээ өөрийн гараар устгаж байгаатай адил хэрэг болно.

Бүх шатны сургуулиудад багш сонгон шалгаруулах шалгалт нэлээд чамбай явагддаг групп мэтгэлцээн, ярилцлага, бичгийн шалгалт өгдөг байна. Тэр байтугай тухайн сургуульд багшлах дадлага хийхэд хүртэл дадлагажигч, дадлагажуулагч багш нар тус тусдаа шалгалт өгч байж эрх олж авдаг.

Арай хийж олон даваа давж байж багш болоод ч сургалт дуусдаггүй. Жилд хамгийн доод тал нь 3 удаа мэргэжлийн сургалтад хамрагдахаар хуульчилсан байна. Бодит амьдрал дээр 8-аас доошгүй удаа хамрагддаг гэнэ. Голдуу иймэрхүү сургалт багш бэлтгэдэг дээд сургуулиудын харьяа сургууль дээр явагддаг аж. Зарим сургалт 1 хоногт багтдаг бол зарим нь 1-2 сар үргэлжлэх нь ч бий. Харин тэр хугацаанд нь түр ажиллах багшийг томилдог. Тэрхүү түр багш хүн амраах, сургалт семинарт явуулах үед ажилладаг тухайн сургуультай гэрээтэй өндөр зэргийн багш нар байна. Бас түр ажиллах багшийг ч сонгон шалгаруулах системтэй.

Финланд захирал

Финландчууд “Захирал бол сургуулийн толь” гэж ярьдаг. 1990-ээд онд Финландад боловсролын либеральчлал гүнзгийрснээр Боловсролын Яамны бага, дунд боловсролын хэргийг эрхлэх газар татан буугдаж, сургууль боловсролын бүхий л эрх мэдлийг сургуульд нь даатгах болсон ажээ. Ингээд боловсролын хэргийг захирлууд бие дааж шийдвэрлэх болжээ. Сургуулийн захирлын менежментийн үнэлгээ тэр сургуулийн үнэлгээ болох болов. “Багш, багш бас дахин багш” гэсэн үзэл санаагаар багшийн мэдлэг, чадвар, дадал, хариуцлага, ёс зүйг бүхий л талаар дээшлүүлж байж боловсролын чанарыг сайжруулж сургууль, боловсролын амьдралыг идэвхжүүлж гэдэгт Финландын төрийн бодлого чиглэж эхэлсэн.

Багш нараа сонгон шалгаруулж авдаг, сургуулийн менежментийг бүхэлд нь зангидаж, олон мянган иргэд, төр, засгийнхаа өмнө хариуцлага хүлээдэг захирлуудыг Финландад ямар шалгуураар сонгодог вэ?

Финландад дунд сургуулийн захирал болох хүн боловсролын хууль тогтоомж эрх зүйн мэдлэг, сургууль боловсролын менежментийн чиглэлээр өгөх аман ба бичгийн шалгалтад тэнцсэн байх учиртай. Түүнчлэн, тухайн хүний зан араншин, хувь чанар, амьдралын туршлага, тэр дундаа нийгмийн амьдралд идэвхтэй оролцсон баялаг туршлага зэргээс гадна IQ өндөртэй гэхээс илүү PQ (Potential intelligence Quotient inventory) буюу аливаа тулгамдсан асуудлыг оюуны хүчээр даван туулах чадвар өндөртэй байхыг шаарддаг ажээ.

Сургуулийн бүхий л амьдрал дан ганц захирлын хүчээр шийдвэрлэгдэхгүй нь мэдээж. Тиймээс багш нараа баг болгон сургуулийн менежментэд идэвхтэй оролцуулдаг, цаг хугацааны өөрчлөлт бүрд, аливаа тулгамдсан асуудал бүрийг чадварлаг, оюунлаг, хамтын хүчээр туулан гарах тэр чадамжийг захирал бий болгодог байна.

Багш мэргэжлийн онцлог, эцэг эх, багш, сурагчидтай харьцах харьцаа, сургуулийн орчин нөхцөл, сургалтын чанар, орчин үеийн сургалтын арга барил гээд өөр олон чадвар, мэдлэгийг харгалзаж захирлыг сонгодог байна.

Сургуулийн өдрийн хоол

Финландын бүрэн дунд болон ахлах сургууль, түүнчлэн мэргэжлийн сургуульд бүх суралцагчид хичээлийн өдрүүдэд сургууль дээрээ Үдийн хоолоор үнэгүй үйлчлүүлэх эрх эдэлдэг.

Финландад Сургуулийн хоолны газар бол урт удаан хугацааны арвин түүхтэй аж. Албан ёсны зохицуулалттай болоод бараг 100 гаруй жилийн нүүрийг үзэж байгаа гэдэг.

Сургуулийн үдийн хоол сурагчдын суралцах идэвхийг дээшлүүлдэг болохыг орон нутгаар аялж, сурагчдад хоол унд тараадаг байсан тэртээх 17 дугаар Зуунд анх ойлгож мэдэрсэн гэж финүүд ярьдаг. Тэр үед Латин хэлний сургалтыг үр дүнтэй явуулахын тулд сургуулийн хоолны газрыг үр дүнтэй ашиглаж байдаг байжээ.

Финландад Сургуулийн үдийн хоолны асуудлыг 1896 онд анх удаа нийгмээр хэлэлцүүлэгдэж, 1913 оноос үүнд төрөөс хөнгөлөлт үзүүлдэг болсон байна.

Финийн Ерөнхий Боловсролын Үндэсний Газар нь бага сургуулийн сурагчдын хоол тэжээлийн талаар тусгай ном хэвлүүлж, улмаар 1930 онд тусгайлсан хуулийн төсөл боловсруулах ажил эхэлсэн байна. Финланд бол нийт сурагчийг хамруулсан сургуулийн үнэ төлбөргүй үдийн хоолны тухай хуулийг баталсан анхны улс аж.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг хичээлтэй өдрүүдэд сургууль дээр нь үнэгүй үдийн хоолоор үйлчлэх зорилт Финландад 1948 онд бүрэн хэрэгжсэн бөгөөд энэ тогтолцоо өнөөдрийг хүртэл үргэлжлэн хэрэгжиж байдаг. Тэр цагаас хойш сургалтын дүрэм журам шинэчлэгдэж, сургуулийн үдийн хоолыг хэрхэн зохион байгуулах талаар тодорхой бөгөөд практик зааврууд ч гарчээ.

Сурагчид хоолны газарт туслах, дүү нараа сургаж дадлагажуулах зэргээр ажиллахаас гадна ажлын дадлага туршлага өөрсдөө олж авдаг. Бодит ажилд ингэж оролцох нь сурагчид хоол хүнсийг үнэлж сурах, хамтын үүрэг, хариуцлагаа мэдрэхэд тус дөхөм болдог гэж үздэг. Үндсэндээ фин үндэстний гол хоолнуудаас бүрддэг сургуулийн хоол бол финландын хоолны соёлын нэгээхэн хэсэг бөгөөд ердийн үдийн хоолонд нь халуун хоол, зууш, хүнсний ногоо, шинэ жимс жимсгэнэ, талх, цөцгийн тос, ундаа багтдаг.

Сургуулийн хоол бол сурагчдын сурч боловсрох, өсөж бойжих үйл явцын чухал бүрэлдэхүүн учир сургууль, эх, эцгийн хамтын хариуцлага гэж үздэг. Хооллох зуршил бага насанд тогтдог боловч насан туршид үргэлжилдэг, тухайн хүний эрүүл мэндэд шууд нөлөөлдөг хүчин зүйл гэж финчүүд сайтар ойлгосон байна.

Тиймээс Финландын боловсролын салбарын амжилтын ноу-хау, сайн сайхан аж байдлын нэг нууц бол “үнэгүй, халуун хоол” гэж хэлдэг.

Үнэ төлбөргүй дээд боловсрол

Финландын боловсрол дэлхий дахинд нэр хүндтэй. Түүний үндсэн шинж чанарыг “Үнэ төлбөргүй боловсрол” гэж хэлж болно. Финландад хүүхэд, залуус бүр сурч боловсрох тэгш эрхтэй гэж үздэг. Өөрөөр хэлбэл, сургалтын тогтолцооны онцлог нь Финландад оршин суугаа бүх хүүхэд, залуус яс үндэс, хүйс, нийгмийн гарал, үүсэл болон эдийн засаг, нийгэм, соёлын ялгаанаас хамаарахгүйгээр сургалтад хамрагдах бүрэн боломжтой байдаг гэсэн үг.

Суурь боловсрол эзэмшүүлсний дараа сурагчдыг үнэлэхдээ багш нар үндэсний хэмжээний удирдамжийг баримталдаг. Өргөдөл гаргах, үнэлэх үйл явц ил тод, дүнгийн үндэслэл нь

орон даяар тодорхой, нээлттэй учир хаана суралцсанаас үл хамааран эрх тэгш, бие даасан байдалтай.

Финландын боловсролын тогтолцоонд “мухар гудамж”, шат дамжлагатай албан байгууллагажсан зам гэж байдаггүй. Сурагч бүр хаана суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэнээс үл хамааран цааш үргэлжлүүлэн суралцахаар өргөдөл гаргаж болдог бөгөөд шалгалтаа амжилттай өгсөн тохиолдолд аль ч сургуульд элсэж болно. Суралцах эрхийг садан төрөл, мөнгө хөрөнгө, урьд өмнөх сонголтоос хамааралгүй зөвхөн сурлагын амжилтад үндэслэн өрсөлдүүлэх журмаар шийдвэрлэдэг.

Финландын бүрэн дунд боловсролын сургууль маш сайн боловсрол олгодог, 15 насанд хүрч, зохих шатны сургалтаа амжилттай дүүргэсэн сурагчдын 92 орчим хувь нь ахлах сургууль, политехникийн сургуульд дэвшиж, дотоод, гадаадын их дээд сургуульд суралцахаар бэлтгэгддэг байна.

Финландад мэргэжлийн сургалт өндөр чанартай, мэргэжил төлбөргүй эзэмшүүлэх чиглэлээр коллежид суурилан явагддаг, гадаадад ажиллуулах буюу сургуулиа дүүргэсний дараа ажил дээр гарахад шаардлагатай дадлагыг эзэмшүүлдэг.

Мэргэжлийн сургалт нь ахлах сургуулийн адил нэр хүндтэй, түүний хоёр дахь шатыг төгсөгчдийн олонход ажил шууд олддог, бусад нь дээд түвшинд эсвэл их сургуульд шилжин суралцах нь бас нээлттэй.

Сургалтын хоёр дахь шатыг ахлах болон мэргэжлийн сургуульд дүүргэсэн сурагч их сургууль, политехникийн сургуульд элсэн суралцах өргөдөл гаргаж, элсэлтийн шалгалт өгнө. Дээд боловсрол үнэ төлбөргүй, амжилттай дүүргэсэн суралцагч их сургуулийн болон политехникийн боловсролын зэрэг авна. Өргөдөл гаргагч нэмэлт шалгалт өгөлгүйгээр бакалаврын болон магистрын түвшинд суралцах боломжтой. Сурлага, төгсөлт төлбөргүй учир Европын Холбооны гишүүн орны залуучууд Финландад суралцахыг ихээр сонирхдог. Боловсрол үнэ төлбөргүйн зэрэгцээ өндөр чанартай байдаг нь олон улсыг ихээхэн гайхшируулдаг.

Үндсэн зарчим нь ижилхэн авьяастай, шаргуу хичээж хөдөлмөрлөдөг бүх оюутан адил хэмжээний дэмжлэг авах, дараагийн шатны сургуульд төлбөргүй суралцах боломжийг хүртэх эрхтэй. Оюутны тэтгэлгийн тогтолцоо тэдэнд санхүүгийн туслалцаа олгодог, дээд боловсрол хүртэл төлбөргүй нь боловсролын салбар дахь тэгш эрх, шударга ёсыг батлан харуулдаг.

Оюутны тэтгэлэг

Финландад “Оюутны зээлийг төрөөс баталгаажуулах тухай” хууль 1969 онд батлагджээ. Оюутанд зээл олгохын зэрэгцээ 1972 оноос хойш оюутны тэтгэлгийг олгож эхэлсэн түүхтэй юм байна. Тухайн үед оюутны зээлд харьцуулахад тэтгэлгийн хэмжээ бага учир оюутнууд зээл авахад хүрдэг байсан. 1970-аад оны дундуур оюутны зээл их олгосноос арилжааны банкууд тэтгэлэг олгохоос цааргалсан. Яриа хэлэлцээ явагдсаны үр дүнд зээлийн хэмжээг бууруулсан (1977 он) боловч энэ зөрүүг зөвхөн байр сууцны хөлсийг төлөх зориулалттай “орон сууцны тэтгэмж” хэлбэрээр өгч эхэлсэн. Тэр үед Ерөнхийлөгч Кекконен “Их сургуулийн оюутнуудын олонх өөрөөс нь сул биетэй байна” гэж үзээд их сургуулийн оюутанд хөнгөлөлттэй хоол олгох санаачилгыг 1979 оноос хэрэгжүүлж эхэлсэн байдаг.

Оюутны зээл мэт хөрөнгө оруулалт нь ажил эрхлэлтийн талаар хүссэн үр дүнд хялбар хүргэхгүй ч Финландын төр оюутнуудад зээлээ төлж барагдуулахад дэмжлэг үзүүлдэг.

Оюутны санхүүгийн дэмжлэгийг 1992 онд шинэчилж, оюутны зээлтэй харьцуулахад тэтгэлгийн хувь хэмжээг нэмэгдүүлж, татвар төлдөг болгосон төдийгүй хөнгөлөлтэй зээлийг арилжааны зээлээр орлуулсан. Дээд боловсрол эзэмшиж байгаа оюутанд тэтгэлэг олгоход эцэг, эх, гэр бүлийн нь орлого, хөрөнгө чинээг үл харгалзах, тэтгэлэгт хамрагдах дээд хугацааг тогтоодог болсон байна. Орон сууцны түрээсийн дээд хэмжээг нэмэгдүүлж, оюутны зээлийг татвараас чөлөөлсөн. Оюутны санхүүгийн дэмжлэгт хамрагдах нөхцөл, шалгуур үзүүлэлтийг тодорхой болгож, сурлага нь олигтой сайжирдаггүй оюутанд санхүүгийн дэмжлэг олгохгүй, орлогын өөр эх үүсвэртэй оюутан санхүүгийн дэмжлэгээ эгүүлэн төлдөг болгосон.

Оюутны санхүүгийн дэмжлэг тэдний суралцах нөхцөлийг хангаж, суралцах, мэргэжил эзэмших эрхийг нь баталгаажуулдаг байна. Түүнээс бус хувь хүний орлогыг нь нэмэгдүүлэх, баян чинээлэг амьдруулахад чиглэхгүй гэж төр үздэг байна. Оюутны санхүүгийн дэмжлэгийн нийт хэмжээ Финландын Үндэсний нийт бүтээгдэхүүний 2 орчим хувьд хүрдэг учир түүнийг дэмжигч, шүүмжлэгч аль алиан нь Финландад хангалтай олон байдаг. Нэг хэсэг нь Финландын нийгмийн өрсөлдөх чадварыг хадгалахын тул 2 хувийг зарцуулах хэрэгтэй гэх боловч нөгөө хэсэг нь Финланд мэт жижиг орны хувьд их зардал гэж үзэж шүүмжилдэг.

Гол нь хүн бүхэнд суралцах боломжийг хангах нь хамгаас чухал учраас 5 сая гаруйхан хүн амтай улс орон иргэдийнхээ аль сайныг гадагш алдахгүйн тулд оюутанд санхүүгийн дэмжлэг олгож байх нь зүйтэй гэж үздэг. Ийм ч учраас Финландын өрсөлдөх чадвар боловсролын чанар, боловсролын жигд тогтолцоо, боловсролтой ажиллах хүчинд үндэслэдэг бололтой.

Оюутны байр

Финландад сүүлийн үед хийгдсэн судалгаанаас үзэхэд, оюутны байрны хүрэлцээ хангалттай сайн хэмжээнд байдаг байна. Энэ бол нийгмийг бүхэлд нь хамарсан нүүдэл суудалд саад учруулдаг нэгэн бэрхшээл арилсан гэсэн үг. Сургуульд суралцахыг хүссэн хэн боловч сургуульд нь ойр, боломжийн үнэтэй, оюутны байр сууц олдоно гэж мэддэг тул оюутанд хотод суралцахын тулд байр худалдан авах, өрөө түрээслэн суух шаардлага огт байхгүй гэсэн үг.

Оюутны байрыг барьж байгуулахад зориулан төрөөс 1966 оноос зээл олгож эхэлсэн учир 1960–аад оны эцэс, 1970-аад оны эхээр “Оюутны байрны байгууллагууд” бий болсон. Оюутны байгууллагууд, хотын захиргаад, Сангууд эсвэл хотын захиргааны харьяа байгууллагууд Удирдах зөвлөлдөө оюутнууд, оршин суугчид, хотын захиргааны төлөөллийг оролцуулсан “Оюутны байрны байгууллага”-ыг үүсгэн байгуулжээ. Оюутны байрны байгууллага нь анх бий болохдоо баримталж ажиллах үндсэн зарчмуудаа Оюутны холбоодтой хамтран тодорхойлсон нь өнөөдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилсээр байдаг байна.

Хот болгонд тухайн хотын оюутнуудын байрны асуудлыг хариуцсан байгууллага ажилладаг. Их сургууль, коллежуудад оюутны байрны асуудал огт хамаагүй учир уг байгууллага сургуулиудаас хараат бус, бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулдаг. Финландад дунд сургууль дүүргээд ямар ч шатны сургуульд үргэлжлэн суралцах бүхий л оюутан оюутны байранд амьдардаг нь зөвхөн их сургуулийн оюутанд оюутны байр олддог Европын олонх улсаас олон талаар илт давуутай ажээ.

Финландад аливаа асуудлыг шийдэж ирсэн хүнд сурталгүй, хялбар бөгөөд шударга, ил тод арга барилаар оюутны байрны асуудлыг шийдвэрлэсэн байна. Хөрөнгө мөнгө хомс боловч хотын захиргаанаас энэ зорилгоор хуваарилсан газарт оюутны байр ганц нэгээр босож

эхэлсэн. Ингээд 30 жилийн дараа оюутны байрнууд баригдаж гүйцэхэд зээл ч эргэн төлөгдсөн бөгөөд элэгдэж хуучирсан байрнуудыг засаж шинэчлэн, оюутны байрны асуудал бүрэн шийдэгджээ.

Оюутны байрнууд голцуу их сургуулийн хотхоноос зайдуу байрладаг хэдий ч нийтийн байр бус ердийн орон сууцны байшин байдаг. Оюутны ийм байр ихэнхдээ 2-3 унтлагын өрөөтэй, оюутан бүр өөрийн тасалгаатай, дундаа гал зуух, угаалгын өрөөтэй, түүнийг хамтраад эзэмшдэг. Ийм байрыг гэр бүлтэй оюутнуудад тохируулан өөрчлөхөд хялбар. Оюутны шинэ байрууд нь ганц бие эсвэл цөөн ам бүлтэй оюутнуудад зориулагдсан, “студио” маягийн ганц өрөөнөөс бүрддэг. Байр шаардлагатай оюутан болгоныг хямд үнэтэй, аюул осолгүй найдвартай байраар хангах зорилт ингэж хэрэгжсэн байна.

Оюутны байрны байгууллагууд хөдөө орон нутгийн сургуулиудын гадаад харилцааг өргөжүүлэхэд ч тодорхой хувь нэмэр оруулдаг байна. Хамгийн гайхалтай нь Европын улсууд дотор Финланд улс оюутны солилцоог маш өргөн хэмжээтэй хийдэг. Үүнд сургуулиудын англи хэлний сургалтын түвшин нөлөөлдөг боловч хамгийн олон зочин оюутныг тохилог сууцаар хангахад Оюутны байрны байгууллагуудын оролцоо, хувь нэмэр ч их байдаг гэнэ.

Их сургуулиудын төвлөрлийг сааруулсан нь

Финландын их, дээд сургуулиуд 1920-иод оныг хүртэл Хельсинкид л төвлөрч байсан бөгөөд 1950-аад оны эцэст ч Их сургуулиудын ихэнх нь нийслэлдээ байжээ. Тухайлбал, Хельсинкийн Их сургуулиас гадна Хельсинкийн Технологийн их сургууль, Эдийн засаг, бизнесийн удирдлагын Хельсинкийн сургууль, Эдийн засаг, Бизнесийн удирдлагын Шведийн сургууль, Нийгмийн ухааны их сургууль, Мал эмнэлгийн коллеж, Урлагийн болон хөгжмийн Академи Хельсинкид ажиллаж байжээ.

Финландын Их сургуулийн тогтолцоо эрчимтэй хөгжиж эхэлсэн 1960-аад онд Ерөнхийлөгч Урхо Кекконен болон эвслийн Засгийн газрын санаачилгаар “Боловсролын хөгжлийн тухай” хууль батлагдсанаар төрөөс их сургуулиудад үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн хэмжээ нь аажмаар нэмэгдэж, хөрөнгийн баталгаа бий болж, оюутанд санхүүгийн туслалцаа үзүүлэх иж бүрэн тогтолцоог бий болгож, Финланд даяар хэд хэдэн шинэ их сургууль байгуулж, их сургуулийн төвлөрлийг багасгаж эхэлсэн байдаг.

Оулугийн их сургуулийг 1959 онд нээж, Яавэскилэгийн багш бэлтгэх хуучин төвийг 1966 онд их сургууль болгон, Куопио, Ёёнсууд их сургууль, Лаппиинранта, Тампирид Технологийн их сургууль шинээр нээсэн байна. Засгийн газрын шийдвэрээр Ваасад ч шинжлэх ухааны боловсрол олгодог болж, Рованиэмид Лапландын их сургууль 1979 оны намар сургалтаа эхэлсэн, бусад их сургууль ч салбаруудаа ойролцоо хотуудад нээсэн нь шинэ тогтолцоог улам бэхжүүлсэн.

Ийнхүү XXI Зууны эхэн гэхэд Финландын их сургуулийн оюутнуудын дийлэнх олонх нь нийслэлээс гадна сурдаг болжээ. Финландад их сургуулийн төвлөрлийг сааруулсан нь нийт Европт хамгийн түргэн хугацаанд өргөн хүрээг хамарч хийгдсэн төдийгүй олон талаар амжилттай болсон гэгддэг.

Их сургуулиудын төвлөрлийг сааруулснаар финчүүдэд хаана оршин суудаг үл хамааран их дээд сургуульд суралцах боломж улам бүр нэмэгдэж, улс орны хүч бололцоо, хүний нөөцийг ашиглахад их сургуулиудад ч амар хялбар болсон гэдэг.

Газар зүйн харилцан адилгүй бүсүүдэд тарж байрласан их сургуулийн тогтолцоо бараг бүх мэргэжлээр өндөр чадвартай боловсон хүчнийг улс орон даяар хангаснаар Оулу, Яавэскилэ, Вааса, Куопио, Ёоэнсуу, Лаппинранта зэрэг “Их сургуулийн хотхонууд” үүсэж, хөгжсөн нь жижиг хот, сууринуудыг зогсонги байдалд орж мөхөх аюулаас аварсан гэдэг.

Их сургуулийн тогтолцоонд төвлөрлийг сааруулснаар шинжлэх ухаан, боловсролын гадаад хамтын ажиллагаа ч их өргөжсөний зэрэгцээ аж үйлдвэр, үйлдвэржилтийн эрэлт хэрэгцээнээс үүдэн Финландын дээд боловсролын тогтолцоо улам нарийн мэргэшсэн салбаруудтай болсоор байдаг байна.

Их, дээд сургуулиудын орчин үеийн барилга байшин, сайтар хангагдсан сургалтын техник, тоног төхөөрөмж, хангалттай хөрөнгө мөнгө, дотоодын бизнесийн сүлжээ, эдийн засагтай сайтар холбогддог зэрэг давуу чанарууд нь шинэ нээлт гаргах, шинэлэх ухаан, үйлдвэрлэлийн салбар дундын уялдаатай ажиллагааг нэмэгдүүлэх, бусад орноос оюутнуудыг хүлээн авч суралцуулах боломжийг бүрдүүлдэг байна.

Насанд хүрэгчдийн боловсрол

Насанд хүрэгчдэд боловсрол олгох нь Умардын улсуудад нийтлэг, бас насан туршдаа суралцах, идэвхтэй, хариуцлагатай иргэн байх эрхэм дээд үзэл санаанд тулгуурладаг.

Данийн ардын ахлах сургуулийн хөдөлгөөн Умардын орнуудын боловсролын зорилгыг философийн, улс төрийн, практикийн гурван түвшинд тодорхойлсон байдаг байна. “Насанд хүрэгчдийн чөлөөт боловсролын тухай” хуулийн зохицуулалт бий болсноор нийтийн боловсролын философийн үндэс нь хүний үнэ цэнэ, сурч боловсрох эрэлт хэрэгцээгээ ойлгож мэдрэх, хувь хүний чадварыг хүндэтгэхэд чиглэгдэх болжээ. Гэгээрэл боловсрол бол ардчиллын үндэс учир нийтийн боловсрол бол улс төр гэж үздэг. Гэгээрсэн иргэн өөрийн амьдралд нөлөөлдөг асуудалд шийдэлцэж, бусдынхаа төлөө ч хариуцлага үүрч чаддаг.

Нийгэм өөрчлөгдөхийн хэрээр “нийтийн гэгээрэл”-ийн зорилго нь үндэстнийг төлөвшүүлэхээс өргөжин Умардын орнууд дахь үндсэн зорилго болсон соёлын олон төрөл зүйл, угсаатнуудын төрөл бүрийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих, цагаачдын хэв шинж, иргэншлийг бататган бэхжүүлэх зэрэгт чиглэгдэх болсон байна.

Насан туршид суралцах боломж, насанд хүрэгчдийн албан бус боловсролын Умардын маягийн бүтэц нь боловсролыг эрхэмлэх нийгмийн эрмэлзэлд тулгуурладаг.

Тухайлбал, Финландын “Насанд хүрэгчдийн чөлөөт боловсролын тухай” хууль нь насанд хүрэгчдийн боловсролын 330 орчим төв, 88 ардын ахлах сургууль, 11 сургалтын төв, 11 спортын хүрээлэн, 20 зуны их сургууль зэрэг олон боловсролын байгууллагын үндэсний сүлжээг зохицуулдаг ажээ. Тэдний үзүүлдэг боловсролын үйлчилгээнд нэг сая илүү хүн хамрагддаг нь дэлхийн аль ч орныхоос эрс давуу үзүүлэлт болж харагддаг.

Насанд хүрэгчдийн боловсролын төв ихэвчлэн нутгийн захиргааны мэдэлд багтдаг. Финландын бүх хотыг хамардаг тэдгээр төвийн үйл ажиллагаа өөр хоорондоо харилцан адилгүй, иргэдийн эрэлт хэрэгцээнд суурилдаг, нутгийн захиргаануудын мэдлийн боловсролын ийм байгууллага дэлхийд өөр хаана ч байдаггүй ажээ.

Ардын ахлах сургууль бол Финландын хувийн хэвшлийн боловсролын хамгийн том сүлжээ бөгөөд нийгмийн төрөл бүрийн хэсэг бүлгийнхэн түүнийг ажиллуулдаг. Тэрхүү зохион байгуулалттай сургалтын төвүүдийн зорилго нь Финландын нийгэмд тэгш эрх, олон янз

байдлыг хөхиүлэн дэмждэг бөгөөд гишүүн байгууллагуудынхаа боловсролын эрэлт хэрэгцээг хангахад чиглэдэг. Тэдний үйл ажиллагаа үндсэндээ хамтын оролцоо, өөрийн удирдлага, харилцан ярилцлагын зарчимд тулгуурладаг, уян хатан шинжтэй, суралцагсдынхаа байгаа газарт явагддаг. Сургалтын төвүүдийн сургалтын хамгийн гол сэдэв нь иргэний эрх болон байгууллагын удирдлага, үйл ажиллагаа байдаг байна.

Финландын спортын хүрээлэнгүүд олон нийтийн санаачилгаар байгуулагддаг бөгөөд 1961 оноос боловсролын бие даасан, өвөрмөц байгууллага гэж хүлээн зөвшөөрөгдсөн онцлогтой юм байна.

Зуны Их сургуулийн эхлэл мөн орон нутгийн боловсролын эрэлт хэрэгцээ, үндэсний хэв шинжээ хадгалах эрмэлзлээс үүдэлтэй бөгөөд ихэнх нь 1950-1960-аад онд орон нутгийн их сургуулиудын сүлжээний хүрээнд байгуулагдсан агаад одоогийн байдлаар Финландын 140 мужид Зуны их сургуулиуд ажилладаг байна.

Финландын насанд хүрэгчдийн албан бус, чөлөөт боловсролын үндсэн ажиллагаа нь Финландын Парламентын Насанд хүрэгчдийн боловсрол, сургалтын хорооны эрхэм зорилгод тусгагдсанчлан иргэний нийгмийг бэхжүүлэх, тэгш оролцоог хангахад чиглэдэг гэж дүгнэж болно.

* * *

Улсын Их Хурлын өнгөрсөн удаагийн Чуулганаар Боловсролын ерөнхий хуулиас гадна “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай”, “Дээд боловсролын тухай”, “Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай”, “Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай”, “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хууль гэсэн 6 хууль хэлэлцэгдэж батлагдсан.

Хууль тогтоох байгууллагын зүгээс боловсролын салбарын гадаадын туршлагаас суралцах ажлыг анхааралдаа авч, тэдний туршлагыг харьцуулан судалж, өөрийн орны нийгэм, эдийн засаг, соёл, ёс заншилд зохицуулан нутагшуулах хувилбарыг сонгон авч, хуулиа хэрэгжүүлэхэд цаашид анхаарч, хяналт тавих шинэ зорилт тулгарч байна.

Иймд хөгжлөөрөө дэлхийд тэргүүлэгдэг Европын Холбооны орнуудын дотроо ч боловсролоороо тэргүүлэх байр суурьтай байдаг Финландын туршлага илүүц зүйл биш нь ойлгомжтой буй за.

Энд дурдагдсан Финландын боловсролын тогтолцооны туршлагаас харахад манай орны боловсролын салбарт нэгэнтээ хийж, хэрэгжүүлж чадсан, одоо хийж хэрэгжүүлж эхэлж байгаа шинэчлэлтийн олон ажил байна.

Гэхдээ “Шинэ юм гэдэг сайн мартагдсан зүйлийг хэлдэг” гэсэн хэлц үг байдаг. Авах гээхийн ухаанаар харвал алс холын Алтай язгуурын хэлтэн суомичуудын боловсролын тогтолцооноос авууштай цөөнгүй зүйл ажиглагдах буй за хэмээн найдна.

Ном зүй

1. “100 social innovations of Finland”, Helsinki, 2012. “Финландын нийгмийн 100 шинэчлэл”, Ред: Илкаа Тайпале, (Орч: Г.Ганболд, Ред: Б.Энхмандах), УБ, 2013 он.

2. Mary Nilson, "The Nordic Model: Scandinavia since 1945", Contemporary Worlds, 2008. Мэри Хилсон, "Нордик загвар: 1945 оноос хойшхи Скандинавын орнууд" (Орч: Б.Билгүүндарь, М.Батчимэг, Ред: Б.Ганбат), Улаанбаатар, 2013 он.
3. Б.Энхмандах, "Нийгмийн хөгжлийн загварын тухай", УБ, 2013 он.
4. Б.Энхмандах, Э.Энхчимэг, "Дундчуудыг түшин хөгжих хөгжлийн хандлага ба Монгол орон", УБ, 2017 он.
5. CMI Marri Ahtisaari Peace Foundation, "A recipe for a better life: Experiences from the Nordic countries", Helsinki, 2013. Марти Ахтисаарын Энхтайвны Сан, "Сайхан амьдруулах жор: Умардын орнуудын туршлага", (Орч: Э.Энхчимэг, Ред: Б.Энхмандах) УБ, Непко, 2021 он.
6. Enkhchimeg Enkhmandakh, "Mongolian path of market transition: From the viewpoint of Labour market", Kyoto University, 2023.
7. Блог: <http://baabar.mn/author/enkhmandakh>

МОНГОЛ ХҮНИЙ НАСАН ТУРШИЙН ХҮМҮҮНЛЭГИЙН БОЛОВСРОЛД ЕВРОПЫН СОНГОДОГ УРАН ЗОХИОЛЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН АСУУДАЛД

Б.Галиндэв

ОТИС-ийн багш философийн ухааны доктор, профессор

Түлхүүр үг: Насан туршийн боловсрол, хүмүүнлэг үзэл, ёс суртахуун, гоо сайхны боловсрол, хүмүүжил

Юнеско-ийн Насан туршийн боловсролын хүрээлэн 2016 онд гаргасан өөрийн тайландаа “Насан туршдаа суралцахуй нь хувь хүн, иргэн, нийгэм хийгээд ажиллаж, суралцах бүхий л үйл ажиллагааг багтаасан ойлголт” гэж тодорхойлжээ. АНУ-ын улс төрч, эдийн засагчидтай хамтран ажилласан боловсрол судлалын эрдэмтэд “Насан туршийн боловсрол бол хүний амьдралын туршид шаардагдах мэдлэг, чадвар ойлголт, зан чанарыг олгох, улмаар түүнийгээ ямар ч орчин нөхцөлд өөртөө итгэлтэй, урам зоригтой бүтээлчээр хэрэглэж чадах чадвар чадамжийг суулгах замаар хувь хүнийг нийгэмд идэвхтэй байр суурь эзлэхэд нь дэмжлэг үзүүлж, чадваржуулж байдаг тасралтгүй дэм туслалцаа, үйл ажиллагаа мөн бөгөөд энэ үйл хэрэг хэзээ ч зогсдоггүй, гэхдээ дангаараа явагддаггүй, хувь хүний хүсэл эрмэлзэлд хөтлөгдсөн үйл ажиллагаа мөн” гэж тодорхойлжээ.

“Боловсролын олон улсын стандарт ангилалд насан туршдаа суралцахуй нь албан, албан бус, амьдрах орчноос суралцах замаар олж авч өөриймшүүлж байгаа мэдлэг, чадамж, ур чадвар, зорилтод чиг баримжаа-хандлага, мэргэшил эзэмших боломж” хэмээн үзэж байна.

Насан туршийн боловсролын нэг чухал чиглэл бол нийгэм-хүмүүнлэгийн боловсрол болно. Учир нь 1-д Асар хурдан өөрчлөгдөж байгаа нийгмийн иргэн өөртөө тавигдаж байгаа асуудлыг бие даан шийдвэрлэх оюун санааны хэрэгцээ байнга тавигдаж байна. 2-д Олон ургалч үзлийн ертөнцөд амьдарч буй хүмүүн бид шинээр түрэн ирж буй мэдээллүүдийг олон талаас нь эргэцүүлэн бодож, гүн гүнзгий ухаарч, зохистой шийдэл олох шаардлага тулгардаг болсон. 3-д Аль ч цаг үед ардчилагдаж байгаа нийгэм эрх чөлөөт иргэнээсээ шинэчлэгдэж байгаа боловсрол, амьдралын идэвхтэй байр суурь, бүтээлч хандлагын хүлээлттэй байдаг зэрэг шалтгааныг юуны өмнө дурдъя Академич Батын Ч.Ган-Өлзий Хүмүүнлэгийн боловсролыг өргөн утгаар нь “Хүмүүнлэг боловсрол гэж хүний эрхэм чанарыг цогцлуулан соёолуулах мэдлэгийн бүх төрөл, хэлбэр үнэт зүйлс, сургалтын арга хэлбэр ба хүрээлэн буй орчинд хандах... оюун билгийн түгээмэл зүй тогтлыг ойлгодог” гэж тодорхойлжээ.

Боловсролыг хүмүүнлэг болгон өөрчилнө гэдэг бол юуны өмнө боловсролын үйл ажиллагаанд оролцож буй бие хүмүүс төдийгүй нийгмийн олон талт харилцаанд оролцож буй хувь хүн бүр өөр хоорондоо харилцан хүндэтгэлтэй, нөхөрсөг байх утгыг илэрхийлнэ. Тогтвортой амар амгалан хөгжиж буй нийгмийн зан үйлдэл, ёс суртахууны туршлагыг хувь хүн өөрийн болгож эзэмшинэ. Хүмүүнлэг боловсрол юуны өмнө хүнийг өөрийн үзэл итгэл, тодорхой зорилго, чиг баримжаатай, ажил хөдөлмөр эрхлэх мэдлэг чадвар, туршлагатай бие хүн болгон төлөвшүүлэх үйл явц мөн. Суралцагчдын эрх чөлөө, хүнийх нь эрхэмлэлийг дээдэлж, боловсрох хэрэгцээг нь хангаж, түүний бие даасан чөлөөт хөгжлийн нөхцөлийг хангах үйл явц болно. Хувь хүний эзэмшсэн мэдлэг, чадвар, туршлага нь түүний өөрийн хөгжилдөө хүрэх зохистой хэрэгсэл болох учиртай юм.

Хүмүүнлэгийн боловсролын дотор урлаг, уран зохиол онцгой байртай байдгийг эрдэмтэд анхааран судалдаг. “Уран зохиол нь үг, хэлний их баялгийг нээн ашиглаж, уран дүрийг зан төрхөөр амилуулж, түүгээрээ хүний амьдралын үзэгдэл, үйлийн нийтлэг түгээмэл, зүй тогтлыг баатрын үйлдэл, хэл яриа, сэтгэл зүй, сэтгэцийн орчилт харилцаа, шилжилтүүдээр үүтгэгдэн үүсэх сэрэл, мэдрэхүй, сэтгэл хөдлөлтэй нийлэгшүүлэн тэрхүү цогцолборын нөлөөгөөр дамжуулан хүний сэтгэлийн дотоод нууц ертөнц рүү нэвтэрдэг үгийн урлаг юм” (Дашлхүмбийн Галбаатар Уран зохиол. Нэвтэрхий толь УБ. 2012.376 дахь тал). Дэлхийн даяарших үйл явцын нэгэн чиглэл бол олон соёлын харилцаа, ойлголцол, нийлэгшил, сүлжилдээний замаар хэрэгждэг. Өнөөгийн монгол хүн өөрийнхөө өв соёлын их ололтыг үе дамжуулан эзэмшихийн зэрэгцээгээр Европын улс орнуудын эрт эдүгээд бүтээсэн соёлын ололтуудаар дамжуулж өөрийн ертөнц үзэхүй, ёс суртахуун, гоо сайхан, шашны гээд нийлмэл утгаараа нийгэм-хүмүүнлэгийн ухааныхаа боловсролын том орон зайг дүүргэж, өөриймшүүлэн эзэмшиж шинэ хэрэгцээ гарч ирлээ.

Улс орнуудын хооронд тогтож бүрэлдэн бий болж буй соёлын харилцаа бол тухайн ард түмнүүд амьдрах арга маягаа бие биедээ таниулж, ертөнц үзэхүйн агуулга, чиг баримжааг нь өөр хоорондоо нь зуучлан сэнхрүүлж, ард түмнүүд бие биеэ илүү гүнзгий ойлголцож, амьдрах арга болдог соёлоосоо харилцан суралцах урт удаан хугацааны өргөн боломж олгодог харилцааны өвөрмөц төрөл юм. Ардчилсан өөрчлөлтийн жилүүдэд зөвхөн реалист, шүүмжлэлт реалист төдийгүй өөр урсгал чиглэлээр бүтээсэн сонгодог болон шилмэл уран зохиолын ном олноор орчуулагдан нийтэд уншигдах болов.

Европын соёлын ололт болж дэлхий нийтэд түгэн тархсан урлаг, уран зохиолын сод бүтээлүүдээр дамжуулж монгол хүн хүний зориулалт, хүний амьдралын учир утга, түүний ертөнц үзэхүй, оюун санаа, сэтгэл зүйн олон талт өөрчлөлт хувьслын асуудлыг ухаарч ойлгох, хүний тухай орчин цагийн шинэлэг философитой болох ухаарал, зам мөрөө олох чиг баримжааттай болж, удмынхаа монгол ухаан, нүүдэлчний соёлынхоо байгаль дэлхийтэйгээ зохицон амьдрах арга ухаантайгаа нийлэгшүүлж, өөрийнхөө ертөнц үзэхүйгээ бүтээх өргөн боломж ч бий болсон.

Ромын Пап лам Францис саяхан манай улсад айлчлах үеэрээ өгсөн ярилцлагадаа “Оросын утга зохиол, сонгодог хөгжим, хүн төрөлхтний хүнлэг, гуманизмын үзэл бодолд ихээхэн хувь нэмрээ оруулсан шүү дээ. Ганцхан жишээ хэлэхэд Достоевскийн зохиолууд хүнлэг байхын утга учрыг яаж тод томруун дүрслэн илэрхийлсэн билээ” гэж онцлон дурдсан байх юм.

Оросын зохиолч Ф.М.Достоевский (1820-1881) хүн, түүний сэтгэл санаа, оюун ухааны чанад дотоод руу өнгийж, юу бодож, бясалгаж, юунд санаархаж, юуг хүсэмжилж байдаг төрөлх чанартай юм бэ? гэсэн асуудал дэвшүүлж өөрийнхөө бүтээл туурвилаар хариу өгөх зорилго тавьсан юм. Түүний уран бүтээлд юуны өмнө үзэл санаа онцгой байр суурь эзэлж байлаа. Учир иймээс энэ зохиолчийг хувь хүний сэтгэлийн чанад руу өнгийсөн сэтгэл зүйч байсан гэхийн зэрэгцээ хүн судлалын том философич-сэтгэгч байсан гэж үздэг болжээ. Уран бүтээлээрээ Достоевскийн дэвшүүлэн тавьсан үзэл санааг тоймловол: хүн, түүний сэтгэл санаа, эд хөрөнгө, эрх чөлөө, ёс суртахуун, гоо сайхан, ертөнц, хүн, бурхны холбоо хамаарал, шүтлэг бишрэлийн тухай байдаг.

Энэ зохиолчийн уран бүтээлд “үзэл санаа” онцгой байр суурь эзэлж байсныг Оросын философич Н.А.Бердяев тэмдэглэж, Достоевскийн зохиолуудын олон талт үзэл санааг эмхэтгэн цэгцэлж зохиолчийн оюун санааны дүр төрх, төлөв байдал, хүн, эрх чөлөө, хайр сэтгэл, хувьсгал, социализм, Оросын хувь заяа, агуу эрүүчин гэсэн сэдвүүдээр бүлэглэж судалсан номоо 1913 онд бичжээ.

“Уран зохиолын дүр” тухайн ард түмний тодорхой түүхэн үеийн нийгмийн аль нэг нийтлэгийн амьдралын хэв маяг, үзэл бодол, дотоод сэтгэлийн нууцлаг хувирлуудыг

дүрслэн урлаж тодорхой нэг хүн-дүрд төвлөрүүлэн илэрхийлэн уншигчдад толилуулж, тэдний сэрэл мэдрэмж, бодол саналыг өдөөн дуудаж, эргэцүүлэл, мэтгэлцээний замд хөтөлдөг онцлогтой.

Хүний оршин амьдрахуйн зайлшгүй хэрэгсэл болох эд баялаг, хөрөнгө, мөнгөний тухай үзэл санаа зохиолчийн бүтээлд их том байр эзэлдэг “Мөнгө бол өчүүхэн амьтныг ч тэргүүн байранд гаргаж ирдэг цорын ганц зам” мөнийг дурдаж, мөнгө ийм хүчтэй гэж өгүүлэх Аркадий “Мөнгө бол мэдээж, харгис хүч мөн, гэвч үүний зэрэгцээ хамгийн дээд тэгшитгэгч, Би мөнгөнөөс айдаггүй, мөнгө намайг навс дарахгүй, бас албадаж бусдыг дарамтлуулахгүй”¹⁸ гэж мөнгөнд эрх мэдлээ булаалгаж өөрийн хүн ёс, хүний мөн чанараа алдахгүй гэдгээ хэлж байна. Мөнгө, сайхан сэтгэл хоёр нэг толгойд багтдаггүй. Балчир ахуй цагаасаа л “үзэл санаа”-г эрхэмлэсээр ирсэн Аркадий мөнгийг бус санааг нэгдүгээрт тавьдаг. “Би мөнгийг үгүйсгэдэггүй, гэхдээ эхлээд үзэл санаа, дараа нь мөнгө юм шиг надад санагдах юм... Эхлээд эрхэм дээд санаа, дараа нь мөнгө, эрхэм дээд үзэл санаагүй бол мөнгөтэй нийгэмлэг нурж унана”¹⁹ гэж Аркадий хөвүүн хэрсүүжсэн ухааныхаа үгийг хэлдэг. Эрхэм дээд санаа гэж юу вэ? “Татгалзахын аргагүй мөнгөний хэрэгцээ” ба “хүнлэг чанар” хоёрын эсрэгцэл дундаас Аркадий өөрийнхөө мөнгөний философийг гаргаж тайлбарладаг. Аркадийн “үзэл санаа” бол хүн чанарын өөрөөр хэлбэл ёс суртахууны соёлын илч гэрэл туссан хүнлэг үзлийн “санаа” юм. Ийм санаатай болсны дараа хүүхэд, өсвөр үеийнхэн хэн ч бай мөнгөтэй зүй зохистой харьцах, мөнгө олох, олсноо өөрийн болон бусдын сайн сайхан, хөгжил дэвшлийн төлөө ариг гамтай зардаг ухаан, сэтгэлтэй болно. Мөнгө хүмүүсийг тэгшитгэдэг, харин мөнгө хүмүүс бие биеэ дорд үзэх, нэгэндээ дээрэлхэх, баярхаж бардамнах эсвэл учир зүггүй хурааж хуримтлуулдаг эд хогшил болох учиргүй. Хувь хүмүүсийн хайр сэтгэл, гэрлэлтэд ч зүй нь мөнгө ямар нэг учир холбогдолгүй байх учиртай гэсэн санааг Аркадий “дээд санаа”-ны агуулгад багтаан ойлгоод эхлээд ийм л агуулга бүхий “санаа”-тай болсны дараа хэн ч бай мөнгө рүү гараа тосож болно гэж үздэг. Энэ бол Аркадийн үе тэнгийнхэн-өсвөр үеийнхний гол эрхэмлэл байх учиртай байлаа.

Ноён Валковский, Версилов, Федор Павлович Карамазов нар бол мөнгөний тухай огт өөр философитой хүмүүс. Удам угсаанаасаа хөрөнгө мөнгө ихтэй эхнэр олж суух, их хэмжээний эд мөнгө өвлөж авах, ямар нэг зарга үүсгэж, хамтран ажиллаж байсан хүнийхээ эзэмшилд байсан хөрөнгийг өөрийн болгож авах, элдэв булхай хэрэглэж олсон мөнгөө цаг зуурын зугаа цэнгэл, садар самуун явдалд зарж, бие махбодын цэнгэл таашаал эдлэхэд зориулахыг эрхэмлэж үздэг философитой “нөхөд” болж дүрслэгддэг. Валковский, Версилов нар Европоор хөндлөн гулд хэсэж, гоё ганган хүүхнүүдтэй цэнгэж зугаацахдаа их хэмжээний мөнгөө хайр харамгүй зарцуулж байснаараа харин ч бахархаж, нэг насныхаа амьдралыг хүн иймэрхүү л янзаар ад хүслээ тайлсан таашаал, цэнгэл, жаргалтай өнгөрөх учиртайг дорд үзэгдсээр залуу насаа өнгөрөөж байгаа Иван Петрович, Аркадий нарт тайлбарлаж, мөнгөний тухай өөрийнхөө дотор философийг илэрхийлж байдаг. 50 гарсан настай Федор Павлович “одоохондоо намайг эр хүнээрээ байхад авгай хүүхнүүд над руу өөрсдөө ирж байгаа юм, цаашдаа нас хөгшрөхийн хэрээр энэ садар самуун эмсийг чинь мөнгөөр татах хэрэг гарна, иймд надад хадгалж хямгадсан мөнгө хэрэгтэй болно гэж хүүтэйгээ ярьж суудаг.

“Гэм зэм”-ийн Раскольников эсрэг, тэсрэг үзэл санааны хүн. Оюутан ахуй насандаа сэтгүүлд бичсэн өгүүлэлдээ хүмүүсийг хоёр зэрэглэлд хувааж, дээд зэрэглэлийнхэн хүн амын олонх болж буй доодсыг оюун ухааныхаа чадвар, алсын хараагаараа араасаа дагуулж, нийгмийн дэвшилд хүргэнэ, дээдсийн хүрээний энэ цөөнх олонхынхоо сайн сайхны төлөө хууль ёс зөрчсөн үйлдэл хийж болно. Ийм жигшүүрт үйлдэл хийснийхээ төлөө нийгмээс ямар нэг буруутгал хүлээх ёсгүй гэсэн үзэл санаагаа чиг

¹⁸ Достоевский Ф.М. Хөвүүн заяа. УБ. 2016. х. 112, 113.

¹⁹ Достоевский Ф.М. Хөвүүн заяа. УБ. 2016. х. 185.

баримжаа болгож, хийрхсэн сонголт хийснийхээ улмаас хоёр ч хүний амь нас хөнөөсөн гэмт хэрэгтэн болдог.

Раскольниковын оюун ухааны сан хөмрөгт боловсроод байгаа өөр нэг үзэл бол Софья Мармеладова мэтийн өнчирч ядарсан хүмүүсийг хайрлан энэрч, чадахынхаа хэрээр амьдрал ахуйд нь тус дэм болж байх хүн ёсны үзэл санаа юм. Ядуу зүдүү амьдралтай ээж, дүү хоёроосоо ирсэн хорьхон рублийг өөрөө хоногийн хоолгүй шахам өлөн зэлмүүн амьдарч байгаа хэрнээ, золгүй учралаар нас нөхөцсөн нөхрийгөө оршуулах мөнгөгүй байгаа Катерина Ивановнад өгчихдөг. Өөрийн хийсэн хэргийнхээ гэм нүглийг онцын их байцаалт, мөрдлөггүйгээр шууд хүлээж, цөллөгт явж байгаа Раскольников өөрийнхөө хийрхсэн хэрцгий сонголтын үр дүн, хариуцлагыг хожим ч гэсэн ухаарч хүн ёсоор мэдэрч буй үзэл санааны хүн юм.

“Албингууд” романы Кирилов “Намайг бурхны тухай санаа насан туршид минь зовоож байна” гэж хэлдэг. Ямар нэг мөнхийн оршихуйг хүсэмжилсэн сэтгэл, мөрөөдлөөрөө хүн оюун санааны хувьд хязгааргүй хүчтэй, хоригдошгүй тэмүүлэл, эрмэлзэлтэй амьдардаг юм гэсэн санааг зохиолч Кириловоор хэлүүлж байна. Кирилов Бурханы оршин байгаад итгэдэггүй, ингэхлээр юу энэ хүний тухайд туйлын дээд үнэт зүйл нь болох вэ? Нэгэнт Бурхан үгүй бол ёс суртахууны дээд хууль тогтоогч үгүй болно. Кириловын тухайд хүний мөн чанарыг илэрхийлж буй өөрийнх нь “бие хүн” тал нь хамгийн дээд үнэт зүйл болдог. Хүн өөрөө өөртөө дээд үнэт зүйл болно гэсэн үг. Өөртөө дээд үнэт зүйл болохын тулд хүний өөрийнх нь бие хүн тал оюун ухааны хязгааргүй хүчин чадалтай, бүрэн эрх чөлөөтэй байх учиртай болж байна.

Ямар ч хүний хайр талархлыг хүлээгээд байгаа ядуу даржин амьдралтай, татаж унадаг өвчиндөө шаналж явдаг Мышкин ноён христ үзлийн элч болон Орос оронд хүрэлцэн ирж байна. Христийн биелсэн элч болж эх орныхоо хилийг алхаж байгаа ноён Мышкин хэнийг ч үл ялгаварлан хайрлаж, эрхэмлэх үзлийн гэгээн сэтгэлээр амьдар, туулж буй амьдралынхаа бүх л учрал, тохиолдол, түүгээр ч үл барам хүн чанарыг нь сорьж дэнсэлсэн эрсдэлийн үед ч нөгөө л энэрэнгүй үзэл итгэлээрээ хандаж харьцдаг гүнзгий итгэл, бишрэл, үзэл санааны хүн болсон байдаг. Мышкины хүнлэг энэрэхүй үзэл юуны өмнө хүүхэд, өнчин ядуусыг дээдлэх үзэл, үйлээр тодорч харагддаг. Өвчин зовлонтой ядуу эмэгтэйн харж хандах, асарч хамгаалах хүнгүй өвчтэй охин Мариг өрөвдөн хайрлаж, ахуй амьдралд нь тус нэмэр болох сэтгэлийн угаас тосгоны малчныд зарагдах ажил олж өгдөг. Хэнийг ч гэсэн үнэн сэтгэлээсээ хайрлаж, дотносдог ааш зангийнхаа нүнжиг, ивээлээр өөртөө дасгаж ээнэгшүүлсэн хүүхдүүдээр өөрийгөө тойруулж, Марид туслах сэтгэл ухаанаа ч олж байгаа Мышкин энэрэхүй үзлийн хүн болдог.

Достоевскийн бүтээлүүдэд Нийгмийн ёс суртахууны олон талт үзэгдлүүдийг хувь хүний амьдралд тохиолддог олон янзын сорилт, эрсдэлүүдтэй холбон авч үзсэн зохиолчийн үзэл санаа өөрийнх нь бүтээсэн нийгмийн янз бүрийн нийтлэгүүдийн төлөөлөл болсон дүрүүдээр дамжин илэрч байна. Ядуу зүдүү, өнчин өрөөсний зовлон амсаж, эцэг, эхийн хайр халамжаас гадуур өсөж өндийсөн Аркадий, Нелли, Софья Мармеладова нарын үнэнч шударга зан, өрөвч нинжин сэтгэл, эд мөнгөнөөс илүүтэй, хүнийг эрхэмлэж дээдэлдэг үзэл санаа нийгмийн ёс суртахууны нэг янзын хөрөг болон зурагдаж байна.

Христийн шүтлэгт гэгээнтэн Зосим, түүний шавь Алеша нар ноён Мышкины нэгэн адил хүнийг дээдлэх энэрэхүйн үзлийн зуучид болж орчин тойрондоо хайр халамж, хүнлэг үзлийнхээ гэгээ гэрлийг тусгаж байдаг.

Раскольников дүү охиноо Лужинтай гэрлэх гэж байгаа шийдлийг сонсоод Дуня чинь “Уул нь зөвхөн хар талх, хар ус хоёроор гол зогоож явлаа ч сэтгэлээ хэзээ ч худалдахгүй, хувийн ая тавын төлөөнөө зан суртахууны эрх чөлөөгөө өгөхгүй л хүн сэн, миний дүү хувийн ашиг завшаан хичээж, өөрийнхөө хүндэлдэггүй, хань болохгүй хүнтэй үүрд толгой холбож оюун санаа, ёс суртахуунаа бузарласнаас барлаг зарц болж дарлуулж явсан нь дээр... Бүх юмаа худалдчихна! Бид чинь хэрэгтэй бол зан суртахуунаа гишгэлчихнэ, эрх чөлөө, амар заяа,

тэр ч бүү хэл, хүний мөс гээд юу байгаагаа барааны хар зах руу аваад гарах улс”²⁰ хэмээн гайхширч, гомдож цөхөрсөн үгээ хэлж байна.

Зохиолч ёс суртахууны асуудлыг үнэн, гэмшил, өр зөөлөн сэтгэл, шударга ёс дөрвийн сүлжээнд тайлбарлаж, дүрсэлсэн байдаг. Үнэнийг эрж хайхад цэгц шударга зан хэрэгтэй байдаг бол хэн нэгэн хүн, адгуус амьтныг ч гэсэн энэрэн хайрлахад өр зөөлөн сэтгэл хэрэгтэй. “Өр нимгэн шударга хүн хамаг юмаа илэн далангүй тоочно” Эндээс үнэн тодорно. Хүн өөрийгөө болон бусдыг танин мэдэхүй, ёс суртахуун хоёр олон талаараа хүйн холбоотой.

“Хүний мөстэй хүн алдаагаа ухамсарлавал бүр зовно. Тэр чинь цөллөг шоронгоос гадна давхар шийтгэл болдог”²¹ гэсэн зохиолчийн үг ёс суртахууны “гэмшил хэмээх нэг эмзэг сэдвийг хөндсөн байдаг

Иван Фёдорович Карамазовтой гэрт нь ярилцаж суугаа жудагт эр хойд насны ертөнцөд “одоо бол ёс суртахууны юм их гарч ирсэн, “сэтгэлийн сэв” энэ тэр гээд энэ бүх дэмий балай юм чинь танайхаас, танай ёс заншил зөөлөрснөөс” үүдэн бий болсон, хэн хожив, зөвхөн сэтгэлийн мөсгүйчүүд л хожсон, яагаад гэвэл, тэдэнд сэтгэлийн мөс онхи байхгүй юм чинь сэтгэнэ гэж юу байх вэ дээ. Харин оронд нь одоо хэр мөс жудаг, нэр төртэй үлдсэн дэг жаягтай хүмүүс л хэлмэгдсэн...”²² гэж өгүүлдэг.

“Би сурвалжтан болох гэж зүтгэхгүй... Би хүүхний араас хөөцөлдөхгүй...их мөнгөнөөс найдвартай цөөн мөнгийг илүүд үзнэ” гэж Достоевский Аркадийгаар хэлүүлэн амьдралынхаа туршид энэ л зарчимдаа үнэнч байгааг дүрслэн үзүүлсэн. Аркадий хүүд Крафт “Ёс суртахууны элдэв үзэл санаа одоо ор тас байхгүй, гэнэт нэг нь ч байхгүй болж таарсан. Гол нь тийм үзэл санаа хэзээ ч байгаагүй юм шиг үгүй болсон”²³ гэж хэлээд “Одоо цаг бол алтан дунджийн цаг, нарийн мэдрэмжгүйн цаг, бүдүүлэг харанхуйг, залхуу хойргыг, юу хийж эс чадахыг, бүхнийг бэлэнчлэхийг тачаан хүссэн цаг. Хэн ч тогтож бодохгүй байна, үзэл санаагаа хадгалж үлдэх хүн ховор”²⁴ гэж хэлж байна.

Петербург даяар нэрд гарсан сайхан бүсгүй Настасья Филипповнагийн зургийг харж суусан Аделаид “Ийм гоо үзэсгэлэн бол хүч, ийм гоо үзэсгэлэнгээр ертөнцийг эргүүлсэн ч болно”²⁵ гэж эрсхэн өгүүлдэг. Настасья Филипповна бол зүгээр л гаднаа харагдах зүс царай, бие бялдар, хувцас хунараараа гоо үзэсгэлэнтэй бүсгүй биш, энэ бүхнээс илүү дотор сэтгэлийн их ариуслаараа гоёж яваа хүн. “... Гоо үзэсгэлэн бол аймшигтай, аймаар эд! Тодорхойлж болохгүй учраас аймшигтай”²⁶ гэж Грушенькад үнэн сэтгэлээсээ дурласан Митя дүү Алешадаа ярьж байна. Настасья Филипповнагийн гоо үзэсгэлэнгээр ертөнцийг аварч болох тухай ярьж байхад Грушенькагийн гоо үзэсгэлэнг аймшигтай гэж тодорхойлж байна. “Аймшигтай” гоо үзэсгэлэнд эцэг, хүү хоёр татагджээ. Грушенька хөрөнгө мөнгө ахиутайг нь тооцоолж эцэгтэй нь суух санаатай байгаа ч залуу хүнийх нь хувьд Митяд татагдсаар байдаг. Митя урьд өмнө сүй тавьсан Катерина Ивановнагийнхаа тухай Алешад “Гоё амьтан шүү. Гэхдээ тэр мөчид өөр юмаар гоё байсан юм. Хүүхэн ариун журмаараа, уудам сэтгэлээрээ, бас эцгийнхээ өмнөөс өөрийгөө золиослож агуу байгаагаараа гоё байсан юм”²⁷ гэж ярьж байна. Настасья Филипповна, Катерина Ивановна хоёрын гоо үзэсгэлэн ёс суртахууны цэвэр ариун чанараараа ижилсэж, ертөнцийг аврах утгадаа дүйж байна.

²⁰ Достоевский Ф.М. Гэм зэм. УБ. 2008. х. 48-49.

²¹ Мөн тэнд. х. 277.

²² Достоевский Ф.М. Гэм зэм. УБ. 2008. х. 864.

²³ Достоевский Ф.М. Гэм зэм. УБ. 2008. х. 80.

²⁴ Мөн тэнд. х. 81.

²⁵ Достоевский Ф.М. Солиот. УБ. 2015. х. 112.

²⁶ Достоевский Ф.М. Карамазовын хөвүүд. УБ. 2008. х. 147.

²⁷ Мөн тэнд. х. 160.

Достоевскийн урлан бүтээсэн дүрүүд бол ямагт оньсого мэт олон нууцтай, сэтгэл бодол бясалгал, баяр хөөр, зөгнөл, хүсэл мөрөөдөл, тэмүүлэл, эрмэлзэл, зорилго, цөхрөл, уйтгар гуниг бүхий хүмүүс байдаг. Достоевский “Зохиолчид роман, тууждаа нийгмийн нийтлэг дүрийг сонгон авч, тэднийг уран сайхнаар, яруу дүрслэн таниулахыг ихэнхдээ хичээдэг, тэр дүр нь бодит амьдрал дээр яг тийм байдалтай байх нь нэн ховор хэрнээ жинхэнэ бодит байдлаасаа бараг илүү бодитой байна” гэсэн дүгнэлт хийжээ. Шүтлэг бишрэл, итгэл үнэмшлээр нь өөрөөр хэлбэл нэгэн төрлийн үнэлэмжээр дамжиж хүмүүнийг таних зорилго тавихдаа түүний дотор сэтгэлийг сүсэг бишрэлээр нь өдөөж ариусгахаас өөр арга зам үгүйг ч зохиолч уран бүтээлээрээ хэлсэн юм.

Достоевскийн “урласан дүрүүд”ийн дотор шашин, ёс суртахууны ямар нэг хэм хэмжээнд захирагддаггүй, нийгэмшлийн ямар ч нөлөөнд автаагүй, нийгмийн нүүрвчний цаадах хүн, бодгаль төрхөөрөө, байгалиас заяасан уг чанараараа амьдарч байгаа зөн совингийн хүмүүс, хөөрч догдолсон сэтгэлээрээ, улайрч улангассан зан авираараа үйлдэл хийдэг, байгаль, нийгэмтэй бараг л харьцдаггүй, зөвхөн өөр хоорондоо харилцаж хайрлаж дурлаж, өшин зэвүүцэж, үзэн ядаж, бие биеэ хөнөөж, айдас түгшүүр бүтээж явдаг “хүмүүс” байдаг. Ойр тойрныхоо садар самуун хүүхнүүдийг гэртээ цуглуулж архидаж суудаг Фёдор Павлович Карамазовын зугаа цэнгэлд ямар ч хорио цээр байхгүй. Огтын шүтлэг бишрэлгүй, ёс суртахууны тогтсон байр суурьгүй Раскольников өөрийнхөө үйлдсэн аймшигт гэмт хэргийг нийгмээс тогтоосон ямар ч хорио цээрт захирагдалгүй хийдэг. Сэтгэц задлалын онолыг үндэслэгч З.Фрейд “Хорио цээр бол үлэмж хүчтэй шунахайрлуудын эсрэг чиглэгдсэн, гаднаас тулгагдсан” эртнээс уламжлагдсан, тов тодорхой ухамсарлагдсан”²⁸ байдгийг тэмдэглэсэн байдаг. Харин хүний байгаль чанараас гаралтай, дотроос зад тавьж байгаа үлэмж хүчтэй дур хүсэл, улайрсан шунал тачаал энэхүү хорио цээрийн хилийг давж ямар нэг үйлдэл рүү түүнийг түлхдэг. Достоевский хүний чухамхүү ийм галзуурч улайрсан дур хүсэл, шунахайрлын мөн чанарыг судалж шинжилсэн зохиолч юм.

Дмитрий Фёдорович Карамазов өөрийнхөө дотор хүнийг “Намайг хар, яг энд гутамшиг бүрэлдэж байна” гээд цээжин дээрээ дарж бухимдан өгүүлээд “Тэр гутамшиг бол үйлчилдэг, хэрэгждэг зүйл, түүнийг зогсоож чадах ганц эзэн нь би, би зогсоосон ч чадна, хэрэгжүүлсэн ч чадна, чи үүнийг тогтоож ав! Харин би үүнийг хэрэгжүүлэх болно, зогсоохгүй гэдгийг чи мэдэж ав! Би бузар санаагаа хэрэгжүүлнэ, урьдчилан ил ярьж байна, чи үүнээс хойш гэрч бол!”²⁹ гэж дүүдээ харанхуй шөнөөр хэлдэг. Дмитрий Фёдорович ийнхүү өөрийнхөө дотор сэтгэлд хадгалж буй санаа-экзистенцээ илэрхийлж байх юм.

Достоевскийн бүтээлүүдийн дотор эцэг, эх, нийгмийн хайр, халамжаас гадуур өсөж өндийж байгаа “шоовдор хүмүүс” тухайлбал амьдралын ээдрээ нугачаа, бэрхшээл зовлон туулсан Раскольников, Аркадий, Нелли, Смердяков, Мышкин уншигчдын анхаарлыг зүй ёсоор татдаг. Ийм шоовдор хүн-хөвүүд, охидын сэтгэл зүй, дотор санаа, ухамсрын хувирал, нийгмийн дүр төрхийн тухай асуудлыг сонгодог сэтгэц задлалын онолыг үндэслэгчид авч үзсэн байдаг. Зигмунд Фрейд ойр тойрныхон, бусад хүмүүсийн хайр энэрэл дутагдсаны улмаас хэн нэгэн өөрийгөө үнэ цэн муутай, дорд үзэгддэг хүн юм байна гэж ухаарах ухамсар, сэтгэлийн шаналлаас шоовдор хүмүүний өөрийгөө үл ойшоох, хүч, чадалдаа үл итгэх, эмзэг мэдрэмж үүсдэг гэж үзжээ. Шоовдорлогдсон хүний өөрийгөө дорд үзэх ийм сэтгэл зүй хүүхэд ахуй цагаас төлөвшдөг. Ийм эмзэг сэтгэлийн шаналал тухайн хүний бие эрхтний согогтой эсвэл нийгмийн гарал угсаа, хувийн амьдрал ахуйн ядуу дор түвшин зэргийн аль нэгтэй юм уу, эсвэл эдгээрийн хам үзүүлэлтүүдтэй холбоотой үүсэн бий болдгийг А.Адлер тэмдэглэсэн. Нөгөө талаар ийм шоовдорлогдсон сэтгэл зүй уйтгар гуниглал, урам хугаралт, өөрийгөө дорд үзэх үзэл рүү түлхэж болзошгүй байдаг янз бүрийн “азгүйдэл”, бүтэлгүйдлээс ч үүсэж болохыг дурдсан байх юм. Шоовдорлогдсон сэтгэл зүй хоёр утга санаа бүхий хандлага төрүүлдэг. **Нэгд:** Эрдэм боловсрол эзэмшиж, өөрийгөө

²⁸ Зигмунд Фрейд. *Онгон шүтлэг ба хорио цээр*. УБ. 2009. х. 27, 31.

²⁹ Достоевский Ф.М. *Хөвүүн заяа*. УБ. 2016. х. 218.

төгөлдөржүүлэн бусдын дор орохгүйгээр сайн сайхан амьдрах гэсэн хүсэл эрмэлзэлтэй болох, **Хоёрт**: амьдарч байгаа нийгмийнхээ дэг журам, хүрээлэн буй амьдрал, нийгмийн орчинд дасахгүй зожирч ганцаардах ийм хоёр хандлага бий болдгийг А.Адлер хэлжээ.

Эрх чөлөөний тухайх Достоевскийн философи хүний чөлөөт амьдрахуйг бурхны оршихуйтай холбоотой авч үзсэн онцлогтой. Бурханлаг нигүүлсэхүй сэтгэлээс л эрх чөлөөт хүн жинхэнэ утгаараа бусдад хал балгүй, буянлаг сонголт хийх ёс суртахууны ариусалтай байж чадна.

Раскольниковын чөлөөт хүсэл зориг сүүлдээ сэтгэлийн гэтлэн давж, тэвчиж барьж болшгүй хийрхэл болоод гэмгүй эгч, дүү хоёрын аминд хүрдэг. Эрх чөлөөний хэтийдэл нүглийг төрүүлнэ. Эрх чөлөөгүйгээр нүгэл тайлбарлагдах ч үгүй, эрх чөлөөг нүгэлтэй холбож үзэхгүйгээр түүний төлөө хүлээх хариуцлагын тухай ч ярьж болохгүй юм. Нүгэл бол эцэстээ зэрлэгшсэн адгууслаг, хэтийдсэн эрх чөлөөний төрүүлсэн хүүхэд болдог. Эрх чөлөөгүйгээр буян үйлдэж болдоггүй учраас буян ч бас л эрх чөлөөний үр сад юм. Эрх чөлөө хэтийдэж дур зорго болохоороо л нүгэл хилэнц рүү хөтөлж, гэмт хэрэгтэн болгож байна.

Эрх чөлөөний байвал зохих хил хязгаарыг нийгэм тогтоож байдаг ч хүн уг чанараараа энэ хил заагийг давж буян, нүглийн аль нэгийг үйлдэж болох байгалиас заяасан зөн совин, нууцлагдсан дур хүсэлтэй амьтан гэдгийг харуулсан зохиолчийн философи түүний романуудаас уншигддаг.

Ямар ч хууль дүрэм, ёс жаягт үл захирагдах галзуурсан шунал тачаал, далдаас оргилох дур сэтгэлээс ундрэн гарах хайр дурлалыг нарийвчлан судалж бичсэнээрээ Достоевский бусад зохиолчдоос ялгардаг. **“Идэвхтэй амин хайраар...** ойр дотныхныгоо байнга хайрлаж байхыг хичээж бай, Амин хайрыг мөрөөдлийн хайртай харьцуулах нь аймшигтай, хэрцгий явдал, Мөрөөдлийн хайр сэтгэл түргэн хангах бушуу ялалтын түүс болдог. Харин амин хайр гэдэг бол ажил бас тэвчээр, зарим хүний хувьд бүр бүхэл бүтэн шинжлэх ухаан болдог”³⁰ гэж Достоевский хайрын ялгааг тодруулсан байна. Ракитин “Карамазовынхон” та нар бүгдээрээ хуял тачаалтнууд, харин чи бол огт өөр хүн гэж Алешад хэлдэг. Эднийхэн нийгмийн ёс зүйн болон бусад ямар нэг дэг журамд баригдалгүй махан бодь, биологийнхоо уг чанараас үүсэлтэй бэлгийн дур хүслээ хангах хүсэл, сонирхол, тачаалаа хорьж, барьдаггүй садар самуун зантайгаараа эцгээсээ эхлээд ойр тойрныхондоо танигдсан аав, хүү, ах дүүс юм. Мышкин Настасья Филипповнаг энэрэн нигүүлсэхүй амин сэтгэлээр хайрлаж эрхэмлэдэг бол Рогожин энэ бүсгүйг эцэс төгсгөлгүй улангассан тачаал, шунал хүслээрээ хайрладаг. Достоевскийн зохиолуудын хайр дурлал бурханлаг сэтгэлийн илч гэрлээр л амилдаг. Ийм бурханлаг сэтгэлгүйгээр хайр дурлал хэзээ нэгэн цагт хатуу ширүүн өширхөл, өш хонзон болоход тун ч ойрхон байдаг. Хэзээнээсээ хөрөнгө, мөнгөний эв олж, ахиуг цуглуулж, багыг гарздах ухаантай Грушенька аав, хүү хоёрын алийг нь сонгохоо дотроо болгоож, хөгшин настайг нь дагавал хөрөнгийн их ноогдоно гэсэн холын тооцоотой явдаг.

Хайр сэтгэл, хардалт хоёр зарим учралаар гар гараасаа барилцаад бие биеэ асаагаад, мөхөөгөөд ч явдаг байж болох юм, ямар боловч хайр сэтгэл шиг аминч мэдрэмж байхгүй. Зохиолч “Карамазовын хөвүүд” романдаа “Жинхэнэ хартай хүн бол өөр: зарим хартай хүн юуг өршөөж чадах, ямар юмтай эвлэрч, юунд доль цохичихсон байхыг төсөөлөхөд бэрх! Хартай хүмүүс л хэнээс ч түрүүн өршөөдөг, үүнийг бүх хүүхэн андахгүй. Хартай хүн жишээ нь нэгэнт нотлогдсон урвалтыг, тэврэлдэж үнсэлдэж байхыг нь өөрөө нэгэнт харсан атлаа (мэдээж, эхлээд бөөн хэрүүл уруул болж байгаад) маш түргэн өршөөж чадна” гэсэн зохиолчийн үг хос хоёрын бие биедээ өгч буй сэтгэлээс гадна итгэл, хүлээлт уучлалгүйгээр хайр сэтгэл амилан цэцэглэнэ гэж үгүй гэсэн дүгнэлтэд хүргэнэ.

Зохиолч 1854 онд “Бурхан надад нэг эгшин хайрладаг юм. Энэ мөчид би бүрнээ тайвширч, өөртөө итгэл бишрэлийн бэлгэдэлтэй болдог” гэсэн санаа илэрхийлж байжээ.. Христийн тухай Достоевскийн үзэл санаа, төсөөлөл бол эцэстээ төгс төгөлдөр хүний тухай

³⁰ Достоевский Ф.М. Карамазовын хөвүүд. УБ. 2008. х. 84-85.

үзэл ойлголт болох нь тодорхой болсон юм. Эр зоригтой, сэтгэлд дотно зан авиртай энэ хүн тэнгэрийн бус газрын амьдралаа бүтээх учиртай байв. 1864 онд зохиолч “Христос энэ бол хүн юм, газар дэлхийн амьдрахуйн ахуйд өөрийнхөө төгс төгөлдөр шинжийг олж хөгжсөн хүн юм” гэж Христийн тухай өөрийнхөө үзлийг тодорхойлж байсан юм. Фёдор Павлович Карамазов Зосим гэгээнтнийг дагаж сүм хийдэд сууж, гэгээрэхээр шийдсэн Алеша хүүгээсээ “Бурхан байгаа” гэсэн нотолгоо сонсдог, харин “Агуу эрүүчин” найраглал бичсэн Иван хүүгээсээ “Бурхан байхгүй” гэсэн няцаалт сонсдог. “Би Иванаас айгаад байна, би Митягаас гэхээсээ Иванаас илүү айж байна. Би ганцхан чамаас л айхгүй байна” гэж Алеша хүүдээ аав нь хэлж байна. Христийн ном сонсож, шүтэж бишрэх болсон Алеша л эцэгтээ итгэгдэх дайны хүний мөс чанар, энэрэхүй сэтгэлтэй болсон хүн гэж итгэгдэж байна. Амьд ба үхэгсдийн гэм нүглийг гэгсээн цээрлүүлэхийн тулд Христ дахин заларч ирээсэй гэж хүсэмжлэх сэтгэлээ Шатов илэрхийлж байна. Зохиолч орос үндэснийхээ шашин, сүсэг бишрэлийн номлогч болгож Шатовыг бүтээсэн гэж зарим судлаачид үздэг. Тэр бээр бурхны оршин байгаад бүрэн дүүрэн итгээгүй байхдаа ч, орос үндэснийхээ шүтлэг бишрэлийн үзэл санааны төлөө өөрийгөө золиосолж, шатаж явсан хүн. Бид бие биеэ аливаа зорилт, хүсэл эрмэлзэлээ хэрэгжүүлэх хэрэгсэл бус, харин нэг нэгнээ өөрийнхөө дутууг нөхөж, гүйцээх хөгжил дэвшлийнхээ хөтөч, хамтрагч гэж ойлгож, ухаарах гэгээрлийн зам мөрөөр замнах чиг баримжаа болно гэсэн том санаагаар христ үзлийг Орост дэлгэрүүлэх агуулга бүхий бүтээлүүдийг Достоевский туурвисан юм.

“Урлагийн аугаа нь гоо сайхан ба гутрал шаналлын хооронд, хүмүүсийн хайрлахуй ба уран бүтээлд шунан адгахын хооронд, ганцаардан зовохуй ба олноос төвөгшөөн залгахын хооронд, эсрэгцэл ба зөвшилцлийн хоорондын энэ бүх хоёрдмол байдалд оршдог, Эсрэг тэсрэг зүйлсийг урлаг тэнцвэржүүлдэг” гэж урлаг уран зохиолын үүргийг тодорхойлсон **Альбер Камю “Этгээд хүн” (УБ.Мон судар.2009.) романы гол дүр** Мерсо Алжир хотын иргэн, бичээчийн ажилтай жирийн албан хаагч, өдөр тутмын нэг хэв маягаар амьдардаг. Эх нь нас барж, түүнийгээ оршуулдаг. Мари хэмээх залуу бүсгүйтэй явалддаг. Ням гаригт өглөө сэрэнгүүтээ орноосоо босдоггүй, талхандаа явахаас ч залхуурдаг, шарсан өндгөө хайруулын тавгаас нь иддэг, тамхи угсруулан татдаг ийм л хүн Мерсогийн тухай Францын академийн гишүүн зохиолч Андрэ Моруа “Мерсо бол тэмцэж босохын өмнө байгаа утга учиргүй хүн юм. Өөрөөр хэлбэл тэр өдөр тутмынхаа амьдралд баригдсан бүхий л хүмүүсийн нэгэн адил Үүнийгээ Мерсо төдий л анзаардаггүй” гээд “Мерсо үнэн сэтгэлээсээ худал хэлж чаддаггүй. Нийгэм нь түүнээс ердийн хэвшмэл загвар шаарддаг” гэсэн дүгнэлт хийж энэ хүний нийгмийн дүр төрхийг тодорхойлжээ. (А.Камю Этгээд хүн. УБ.2009 17 дахь тал) Мерсо эргэн тойрныхоо хүмүүст төдийгүй төрүүлж өсгөсөн эхдээ хүртэл хөндий хүйтэн сэтгэлээр хайхрамжгүй ханддаг нэгэн болдог.

Ойр дотно болж, бэлгийн харилцаанд нэг бус удаа орчихсон Мари бүсгүй Мерсогийн ирж, өөртэй нь гэрлэх хүсэлтэй байгаа эсэхийг асуужээ. Мерсо “Миний хувьд ялгаагүй, хэрэв өөрөө надтай суумаар байгаа бол сууж болох л юм гэж хэлсэн. Тэгэхээр өөрт нь хайртай юу гэж асууна. Өмнө нь нэг удаа хэлсэн шигээ энэ чинь юу ч биш шүү дээ. Ер нь хайргүй юм байна гэв. “Тэгвэл яагаад надтай сууна гэж байгаа бэ?” гэж мөшгөж асуусан “Наадах чинь ямар ч учир утгагүй юм шүү дээ, чамайг хүсч байгаа бол яагаад гэрлэж болохгүй гэж” (мөн тэнд 55 дахь тал) хэмээн тайлбарласнаа Мерсо өөрөө ярьж байна. Хүмүүнийг өөр хооронд холбон, халуун дотно сэтгэлээрээ ойртон ээнэгшиж, бие биедээ сэтгэлээ өгдөг гэр бүлийн үндэс болдог хайр сэтгэлийг Мерсо ямар ч “учир утгагүй юм” хэмээн тодорхойлж байна. Ээж нь таалал болсон цахилгаан авсан Мерсо амралтын ням гарагаа гарздах хайран санагдаж, автобусанд суухаар явахад төвөг чирэгдэл учрах, унааны тийз худалдаж авах, хоёр цаг замд явах ч бол бага хэрэг” гэж бодсоор ээжийнхээ оршуулгад ирэв. Асрамжийн газар амьдарч байсан ээжийнх нь оршуулга Мерсогийн тухайд ямар ч эмгэнэл, гашуудал гэж мэдрэгдэхээр шинж тэмдэггүй болж өнгөрнө. Эхийнхээ шарилын дэргэд зогсож буй Мерсогоос оршуулгын товчооны ажилтан “Энэ танай ээж юм уу гэж асуухад нь тийм ээ” л гэлээ “Настай хүн байсан юм уу? гэж асуухад нь За тийм л дээ” гэж хариулахдаа Мерсо

ээжийнхээ насыг мэддэггүй байснаа дотроо хүлээдэг. Хол газар автобусаар зорчиж ээжийнхээ оршуулгад оролцохоос дотроо дургүйцэж, цаг хугацаа, замын зардал гарах мөнгөндөө харамсаж байсан Мерсогийн оршуулах ёслолын үед бодож байсан “ганц юм нь ажил явдлыг нь дуусахтай зэрэг Алжир хотдоо буцаж, орондоо орон арван хоёр цаг унтах” байв.

Шүүх хуралд дээр прокурор ийн ярилаа. “Яг үнэнийг өчихөд Мерсод ямар ч зүрх сэтгэл, ямар ч хүнлэг юм байхгүй, улс амьтны зүрх сэтгэлийг гэм согогоос хаацайлдаг ёс суртахууны аль ч зарчим түүнд харш, Энэ хүн нэгэнт л олж авч чадаагүй юмыг алга байна гэж бид харуусаад ч яах юм билээ. Гэвч энд болж буй шүүх хурлын тухайд ...хүлцэмж, нигүүлсэхүйгээс гаралтай номой буянт үйл тун ч хатуухан, гэхдээ нэн эрхэм дээд, мөн чанартаа шударга ёсны буянт үйлд зайгаа тавьж өгөх хэрэгтэй байх аа. Учир юунд вэ гэвэл ийм хүнээс бидний олж харсан сэтгэлийн хоосрол нь манай нийгмийн унаж мэдэх хар ангал болно шүү дээ” (Мөн тэнд 101 дэх тал) гэж анхааруулан өгүүлэв. Хөдөө хээр зугаалж яваад өөртэй нь дайралдсан, урьд өмнө ямар нэг онцгой учир холбогдолгүй түр зуур маргалдаж байсан хоёр араб хүний нэгийг Мерсо буудаж алчхаад “нар хурц шараад л ийм хэрэг хийчихлээ” гэсэн мэдүүлэг өгч байдаг.

“Мерсогийн оюун санаанд гарч буй хувьсал нь хүрээлэн буй нийгэм-ахуйн утга учиргүй хийсвэр байдлын доторх аймшигт үнэнийг ухамсарласан явцын түүхийг өгүүлнэ. Тухайлбал Ж-П Сартрын “Огюдас” ын Антуан Рокентаний үзэл санааны хувьсалтай ямар нэг сэжмээр холбогддог. Антуан Рокентан ба Мерсо гэх хоёр баатрын оюун санааны өөрчлөлтүүд эцэстээ тэд хоёулаа энэ дэлхий ертөнц дэх “гаднын хүн” болж, өөрсдийнх хувьд үнэ цэнтэй, оюун санааны хувьд учир холбогдолтой бүхэн үгүй болж байгаа үйл явдлыг өгүүлнэ.

Мерсо туулсан амьдралынхаа дүгнэлт болгон өчихдөө “ Би харваас гуйрамч, хувь тавилангүй. Гэхдээ би өөртөө итгэлтэй, бүх юманд итгэлтэй, энэ санваартнаас хамаагүй илүү итгэлтэй. Энэ итгэлээс өөр надад юу ч үгүй. Гэхдээ энэ үнэнийг надаас хэн ч булааж авч чадахгүй. Намайг энэ үнэнээс бас салгаж чадахгүй. Би зөв, урьд нь ч зөв байсан, хэзээ ч зөв байсан. Би энэ л маягаар амьдарчээ, өөрөөр бас амьдарч болох байсан Энийг нь хийгээд, тэрийг нь хийсэнгүй” (мөн тэнд 118 дахь тал) гэж хэлж буй. Антуан Рокентан “Би оршиж байна. Ертөнц оршиж байна. Би-ертөнц оршиж байна. Ингээд л бүх зүйл дуусна” гэдгээ мэдэрч байна. Өнөөгийн иргэншсэн нийгмийн бүтээл болсон хүрээлэн байгаа орчин нийгэм, хүнд хайхрамжгүй хайр хүндэтгэлгүй, зөвхөн өөрийгөө бодож, эрмэлзэж амьдардаг хүн бий болж байгаа юм байна гэсэн дүгнэлт ч хийж болохоор өгүүлэмж уншигдаж байна. А.Камю АНУ-д хэвлэгдсэн “Этгээд хүн”(Хөндлөнгийн хүн) номынхоо өмнөх үгэнд “Манай нийгэмд эхийнхээ оршуулга дээр уйлаагүй хүн бүр цаазын ял авах эрсдэл хийж байна” гэж өгүүлсэн түүхтэй. Зохиолч иргэншиж хөгжсөн нийгмийн хүмүүс бие биедээ хайхрамжгүй, хөндийн хүйтэн ханддаг зан үйлдэл, ёс суртахууны уналт, аюул заналхийлж байгааг ийн илэрхийлсэн юм болов уу? **Франц Кафка “Шүүх ажиллагаа” роман** Монголын уншигчдад “манайд ийм үйл явдал болдог болов уу?” гэсэн асуулт өөртөө тавихад хүргэдэг. Банкны ажилтан Иозеф К-г өглөөнийхөө цайг уухаар зэхэн сууж байтал “Таны хэргийг шүүх эхлэл тавигдлаа, цагт нь та бүгдийг мэдэх болно” гэсээр хоёр хүн орж ирээд баривчилжээ. Иозеф К “эрх зүйт төртэй, хаа сайгүй энх амгалан, бүхий л хууль нь хэлбэрэлтгүй биелж байдаг улс оронд аж төрж байгаа шүү дээ. Тэгэхэд орон гэртээ байхад нь хэн надад халдаж зүрхэлдэг байна вэ?” асуулт тавьж өөртэйгөө ярих хэрэг гарав. “Гэм буруу өөрөө хууль зүйг өөртөө татдаг гэж хуульд заасан байдаг. Манай эрх мэдэл бүхий хүмүүс тэр цагт сая биднийг, өөрөөр хэлбэл харгалзагч нарыг тийш нь явуулдаг юм. Ийм хуультай Энд алдаа эндэл байж таарахгүй” (Франц Кафка. Шүүх ажиллагаа. УБ. 2007. 6 дахь тал) гэж Иозеф К- баривчилж буй хоёр ажилтан тайлбараа хэлж байна. Иозеф К-г байцсан анхны байцаагч “Би таны буруутгаад байгаа тэр хэрэг гэгчийн талаар хэлэх юм алга, надад энэ талаар мэдэх юм байхгүй. Харин та баривчлагдсан гэдэг нь үнэн, үүнээс илүүг би мэдэхгүй... Би буруугүй гэж битгий орилж хашхичаад бай, бусдад муугүй сэтгэгдлийг чинь баллаж байна” (мөн тэнд. 11 дэх тал)

Ням гаригт анхны мөрдөн байцаалт болно гэж Иозеф К-д утсаар мэдэгджээ. “Миний хэрэг гэдэг бол ердөө тохиолдлын юм, гэмт хэрэг гээд байхаар юм ерөөс үгүй. тийм ч учраас би нэг их санаа зовохгүй байгаа, гэхдээ энэ олон олон хүний хэргийг яаж шүүн тунгаадгийн тод жишээ болж байна. Би өөрийнхөө төлөө бус, өрөөлийн төлөө, чухамдаа ийм буруугүй буруутныг өмгөөлөн тэмцэх болно... Хуулийг илэрхий завхруулж байгааг л илт шүүн хэлэлцье гэсэн ганцхан зүйлийг би хүсэж байна” гэж Иозеф К шүүхийн байцаалтын үеэр зориглон хэлж буй. “Намайг баривчилсны цаана... нэгэн аварга том байгууллага байгаа нь эргэлзээгүй боллоо. Энэ байгууллагад сайндаа л төлөв даруу хэмээн магтагддаг худалдагдсан харгалзагчид, мөрдөн байцаагчид ажилладаг. Гэхдээ бас хамгийн дээд зэрэглэлийн шүүгчид, бас бус албан хаагч, бичээч, туслах ажилчид гээд олон орон тооны... хөлсний алуурчид ч байдаг. Би энэ үгийг хэлэхдээ айхгүй байна. Харин энэ нүсэр байгууллага юу хийдэг байна, ноёд оо? Яах гэж үүнийг байгуулдаг хэрэг вэ? Гэмгүй хүмүүсийг баривчлан, тэдний эсрэг утга учиргүй, ихэнхдээ жишээ нь надад тулгадаг шиг ямар ч үндэслэлгүй, үр ашиггүй шүүх ажиллагаа явуулах л гэж байгуулдаг. Зорилго, утга учир нь үүнд л байгаа юм. Тогтолцоо нь ийм учир утгагүй байгаа нөхцөлд түшмэдийг энэ аймшигт авилгаас яаж аврах вэ?” (мөн тэнд. 38 дахь тал) гэсэн Иозеф К-гийн үг өнөөгийн аль ч улс оронд байж болох, бий болж болох авлигажсан шүүхийн үйл ажиллагаанд бугшсан ёс суртахууны асуудлыг хөндөн цочоож байна. Иозеф К-г шүүхийн танхимд ирэхэд мэдүүлэг өгөхөөр хүлээж байгаа хүмүүсийн олонх нь дээд зиндааны гэдэг нь илт байв. Энэ бүгд сэжигтнүүд байгаа юм. Сэжигтнүүд бүгдээрээ эмзэг мэдрэмхий улс байдаг гэж зарлага хэлнэ. Иозеф К-гийн бие суларч хүний хараат болчихлоо. “Санаа зоволтгүй ээ. Энэ бол ердийн хэрэг. Энд анх ирж байгаа хүмүүс бараг толгой дараалан ингэж муужирдаг юм. Та энд анх удаагаа ирж байна уу? Ингэдэг юм, ингэдэг юм”, “Энэ ноённы бие эндэхийн агаараас болж муудлаа гэж би бодож байна. Тэгэхээр эмнэлгийн өрөө рүү явах биш эндээс гарах нь хамгийн ухаалаг шийдвэр болох болов уу. Ерөөс энэ байрнаас гарцгаая гэж нэмж хэлэв” (мөн тэнд 61,63 дахь тал) Энд агаар муутай байшингаас гарах тухай бус шүүхийн ялзарсан тогтолцоог яаж нураах тухай бэлгэдэн ярьж байна. Иозеф К олон сэжигтнүүдтэй танилцаж ярилцаад зарим сэжигтэн 6 өмгөөлөгч аваад ч хэрэг нь шийдэгдэхгүй байгаа, үйлдсэн гэх гэмт хэргээ шийдүүлж чадахгүй 5 жил болж байгаа гээд олон учрал тохиолдлыг мэдэх болжээ. Иозеф К-гийн байцаалт бүтэн жил сунжирсны эцэст үл таних, ганган дэгжин хувцасласан хоёр ноёнтон эзгүй хээр аваачиж тамлан зовоож байна. Иозеф К “Шүүгч хаа байна вэ? Эрхэм дээд шүүх хаа байна вэ? Би ярих ёстой. Би наманчилъя. Ганц удаа ч бараа нь харагдаагүй тэр шүүгч хаана байна вэ?” хэмээн Иозеф К хоёр гараа өргөж алгаа дэлгэв. Тэгтэл нэг ноён багалзуурыг нь шахаж, нөгөө нь зүрхэнд нь лав дүрсэн хутгаа хоёр удаа эргүүлэв.

Иозеф К-г баривчилж, шүүж, цаазалж байгаа нь эсэргүүцэж чадахгүй хүнийг тээрэмдэж, амь насыг нь хүртэл хөнөөхөд бэлэн байгаа шүүх тогтолцооны тухай хүүрнэл төдийгүй өөрийн экзистенциал буруугүй зан үйлдлийн төлөв байдал, хийсэн үйл үйлдлээ бүрнээ ухамсарлаж буй хувь бие хүний ухамсар дотоод сэтгэлийн гүнд хийж буй аялал, түүний шаналал зовлонг тэмтэрч мэдэрсний илэрхийлэл болсон юм гэж үзэж болно.

Дүгнэлт

Ф.М.Достоевский болон энд дурдагдсан зохиолчдын бүтээлүүдийг уншаад доорх дүгнэлт хийж байна:

1. XIX зуунаас эхлээд нийгмийг бүрдүүлж буй хүмүүсийн сэтгэл зүйн тогтворт тайван байдал алдагдаж, ёс суртахууны олон гаж үзэгдэл нийгмийн хэмжээнд илрэх болсны бодит жишээ нь “Гэм зэм” романы Раскольников, “Албингууд” романы Верхонвенский нарын зан авир, гэмт үйлдэл болсон.

2. Христосын үзэл баримтлал, номлолоор дамжуулж Оросын ард түмний оюун санааны орон зайд ёс суртахууны энэрэн нигүүлсэхүйн үзэл санаа дэлгэрүүлэн түгээж олон нийтийн сэтгэл, оюун санааг ариусгах үзэл санаа Достоевскийн бүтээлүүдээс уншигддаг. “Солиот”-ын Ноён Мышкин, “Карамазовын хөвүүд” романы Алеша ийм үзэл санааны бодит биелэл болсон гол дүр байв.
3. Газрын эзэн-помещикуудын зан үйлдэл, оюуны санааны хөгжлийн хоцрогдол, ялзрал, садар самуун амьдралыг эрхэмлэсэн ёс суртахууны алдрал “Карамазовын хөвүүд” романы эцэг Карамазов, “Хөвүүн заяа” романы Версилов нар ийм дүр, нийгмийн тодорхой нийтлэгийн төлөөлөл юм.
4. А.Камюгийн “Этгээд хүн” ийн Мерсо, Жан Поль Сартрын “Огюдас”-ын Антуан Рокатин мэтийн хүмүүсийн нийтлэг өнөөгийн иргэншсэн нийгмүүдэд томоохон байр суурь эзлэхээр өргөжин тэлж байна уу? гэх айдас, түгшүүр төрүүлж байна гэж үзэж болохоор байна
5. “Карамазовын хөвүүд” романы гоо сайхан, ёс суртахууны бэлгэдэл болж байсан Настасья Филипповна, аав, хүү хоёрын хайр сэтгэлийг зэрэг булааж, мөнгө олохыг амьдралынхаа зорилго болгосон Грушенко хоёрын гоо үзэсгэлэнгийн нийгмийн учир утгын эсрэг, тэсрэг талыг энэ зохиол дүрслэн үзүүлсэн юм.
6. Нийгмийн янз бүрийн анги, давхаргуудын ёс суртахуун, хүмүүнлэг, нигүүлсэхүй үзлийн төлөвшилд шашин тэр дундаас “Ертөнцийн эзэн-бурхан” байгаад гүнээ итгүүлж шүтэж бишрүүлдэг Христос шашны ертөнц үзэхүйн үзэл, ёс ёслол түүхийн хуучин цаг үед онцгой үүрэг гүйцэтгэж байсныг Достоевскийн романуудаас уншиж ухаарч болно гэж үзлээ.

Ном зүй

1. Дашлхүмбийн Галбаатар Уран зохиол .онол, түүх, шүүмжлэл нэвтэрхий толь УБ. 2012
2. Ф.М.Достоевский. Хөвүүн заяа. УБ. 2016
3. Ф.М.Достоевский. Албингууд.УБ. 2018
4. Ф.М Достоевский Карамазовын хөвүүд. УБ. 2008
5. Ф.М. Достоевский. Солиот УБ. 2015
6. Ф.М Достоевский. Гэм зэм УБ. 2008
7. Жеймс Жойс .Улисс. УБ. 2012
8. Франс Кафка .Шүүх ажиллагаа УБ. 2013
9. А.Камю Этгээд хүн .УБ.2009
10. Бүдрэгчийн Галиндэв. Достоевский ба хүний асуудал. УБ. 2017

**БОЛОВСРОЛЫН ДИЖИТАЛЧЛАЛ: ЕВРОПЫН ХОЛБООНЫ
БОЛОВСРОЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ СТРАТЕГИ, СУРГАЛТЫН
АРГА ЗҮЙД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД**

*Ганбатын Туяагэрэл (Ph.D), МУИС, УТСОХНУС, Улс төр судлалын
тэнхим, ахлах багш*

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хурдацтай дэвшил нь өнөөгийн дэлхий ертөнцөд шинэ нөхцөл, сорилтуудыг бий болгож байна. Боловсролын байгууллагуудын хувьд оюутан суралцагчдыг амьдралын шинэ хэв маягт бэлтгэх, хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөгдөж буй бодит нөхцөл байдалд нийцүүлэн мэдээлэл харилцаа холбооны технологийг ажлын байранд хэрэглэх чадвартай шинэ үеийн хүний нөөцийг бэлтгэхэд чиглэсэн хөтөлбөр, сургалтын арга технологийн бий болгох гэх мэт шинэ сорилтуудтай тулгарсаар байна. Энэ утгаараа мэдээлэл харилцаа холбооны технологи нь сургалтын хөтөлбөрийн хүрээнд ерөнхий чадамжийг хөгжүүлэх, мөн соёлын олон янз байдал, ялгаатай нөхцөлд хөгжлийн тэгш боломжуудыг бий болгох, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд оролцогч талуудын хамтын ажиллагаа, интеграцичлалыг дэмжихэд чухал ач холбогдолтой юм. Энэ өгүүлэлд дэлхий нийтийг хамарсан цар тахлын дараагаар сургалтын байгууллагуудад гарч байгаа дижитал шилжилтийн үйл явцыг Европын Холбооны жишээн дээр авч үзэхийг зорьсон. Мөн Европын Холбооноос боловсролын дижитал шилжилтийг хийхдээ бүрэлдэхүүн улсууд харилцан адилгүй стратеги баримталж байгаа хэдий ч Европын Холбооны хэмжээнд суралцагч төвтэй, оролцогч талуудын хамтын ажиллагааг хангасан, хяналт үнэлгээний нэгдсэн тогтолцоогоор чанарыг хянан баталгаажуулдаг дижитал шилжилтийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар судалсан.

ТҮЛХҮҮР ҮГ

Боловсролын дижитал шилжилт, сургалтын дижитал хэрэглэгдэхүүн, сургалтын технологийн шинэчлэл, дижитал шилжилтийг хийхэд чиглэсэн стратеги, дижитал шилжилтийн онцлог

УДИРТГАЛ

Дижитал технологи нь мэдлэгийг бий болгох, хуваалцах, дижитал эх үүсвэрийг дэмжих, орон зайд түгээх боломжийг хэрэглэгч талуудад олгодог. Сургалтын орчинд дижитал технологийн хэрэглэх боломжийг судлах нь сурган хүмүүжүүлэгчдэд онлайн болон программчлагдах боломжтой сургалтын шинэ хэрэглэгдэхүүнүүдийг бүтээлчээр бий болгох, харилцан суралцах боломжийг олгодог. Дижитал сургалт нь сургалтын туршлагыг нэмэгдүүлж, багш нарын цагийг хэмнэж, багш нарт суралцагчдад тохирсон суралцах боломжийг олгох, оролцогчдыг үр дүнтэй удирдан чиглүүлэх, сургалтын үйл явцад оролцогч бүх талуудад үйл явцыг ил тод болгох гэх мэт олон давуу талыг бий болгосоор байна³¹.

Боловсролын дижитал платформууд нь зөвхөн боловсролын салбарын хэрэглэгчид төдийгүй аж ахуйн нэгж байгууллага, төрийн байгууллагууд тэдгээр хоорондын харилцааг нэгтгэх, зохицуулах зорилготой дижитал архитектур юм. Боловсролын дижиталчлалын тухай үзэл баримтлал нь сүүлийн жилүүдэд боловсрол судлалын судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлүүдэд маш өргөн хэрэглэгддэг нэр томьёо болж өргөн утгаар авч үзвэл суралцахуй ба багшлахуйн үйл ажиллагааг "илүү дижитал" болгох гэсэн бүх

³¹ <https://www.ed.ac.uk/clinical-sciences/edinburgh-imaging/for-patients-study-participants/tell-me-more-about-my-scan/what-is-microscopy>

хөтөлбөр, хүчин чармайлтыг хамарсан нэр томъёо болж хувирч байна³². Боловсролын дижитал платформууд сүүлийн жилүүдэд улам бүр түгээмэл болж, үндэстэн дамнасан болон орон нутгийн технологийн компаниуд боловсролын хувийн болон улсын байгууллагын бага, дунд түвшний хөтөлбөрөөс эхлээд дээд боловсролын салбарт тусгайлан зориулсан платформыг нийлүүлдэг, түүний хөгжүүлэлтийг хийдэг болсноор сурагчдын суралцахуй, багш нарын багшлахуйн үйл ажиллагаа, сургалтад оролцогч талуудын гүйцэтгэлийг хянадаг орчин үеийн олон үйлдэлт технологийг хослуулсан дижитал орон зайг бий болгосон COVID-19-ийн дэлхийн хэмжээнд үзүүлж буй хамгийн эерэг өөрчлөлт гэж харж болохоор байна³³. Онлайн болон зайн сургалт сургалт руу шилжих нь ирээдүйн чиг хандлага болох нь үнэн боловч ухаалаг боловсролын тогтолцооны үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд багшлах суралцах үйл явцыг хэрхэн үр дүнтэйгээр дижиталчлах вэ гэдэг асуудал нь хамгийн чухлаар тавигдаж байна.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Европын холбооны боловсролын талаар баримталж буй стратеги, сургалтын арга зүйд гарч буй өөрчлөлтүүдийг судлахдаа боловсролын салбарт тулгамдаад байгаа асуудал, хэтийн төлөвийг голлон судлав. Ингэхдээ боловсролын дижиталчлал, сургалтын арга хэлбэрт гарч байгаа өөрчлөлтийг энэ чиглэлд хийгдсэн судалгаа шинжилгээний ажил, Европын холбооны зүгээс гаргасан бодлогын баримт бичгүүдэд анализ хийн, боловсролын бодлогын динамик өөрчлөлт тулгуурлан цаашдын нөхцөл байдлын тоймлон судалсан.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Инновац, технологийн хувьсалд хөтлөгдсөн дижитал өөрчлөлт нь нийгмийн зохион байгуулалт хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал, ажлын байрны ирээдүйн чиг хандлагыг ч шинэчилж байна. Ажил олгогчид тэр дундаа дижитал салбарт бизнес эрхлэгчид өндөр үр чадвартай ажилчдыг сонгон шалгаруулж авахад маш их бэрхшээлтэй тулгарах болсон. Өдөр тутам өөрчлөгдөж байгаа хөдөлмөрийн зах зээлийн дүр төрх, шинээр тухайн зах зээлд орж ирж байгаа хүний нөөцийн үр чадвар хоёрын ялгаатай байдал нь боловсролын салбарт шинэчлэл хийх, улмаар сургалтын хөтөлбөрийн агуулгад ажил олгогчоос санал авах, ажлын байран дээр зайлшгүй шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагад сургах шаардлагыг бий болгосоор байна.

Европын холбоо 2050 он гэхэд дараах хоёр салбарт дижиталчлалыг бүрэн нэвтрүүлэхээр зорилго тавьсан байна. Үүнд:

- Дэлхийн дулаарлын эсрэг, цаг уурын тогтвортой менежментийг бүрдүүлэхэд дижитал технологийг ашиглана. Дижитал технологи нь ногоон эдийн засагт шилжих, эрчим хүч, тээвэр, барилга, бүтээн байгуулалтын маш том хөшүүрэг болно гэж үзсэн байна. Үүний зэрэгцээ дижитал бүтээгдэхүүний давуу тал нь уур амьсгал, хүрээлэн буй орчны сөрөг өөрчлөлтийг бууруулж, хүмүүс өдөр тутмынхаа амьдралд экологид ээлтэй амьдрах зан үйл рүү шилжихэд түлхэц өгөх явдал юм гэж бодлогын баримт бичигтээ тусгажээ.
- Боловсрол, сургалтын тогтолцоо нь дижитал өөрчлөлтийн нэг хэсэг болно. Дижитал технологийг багш, сурган хүмүүжүүлэгчид чадварлаг, тэгш, үр дүнтэй ашигласнаар бүх суралцагчдад өндөр чанартай, хүртээмжтэй боловсрол эзэмшиж, сургалтын хөтөлбөрийн агуулгыг бүрэн эзэмших боломж бүрдэнэ. Боловсролын дижитал шилжилт нь сургалтын бүх үе шат тухайн хувь хүнд тохирсон, уян хатан, суралцагч төвтэй сургалтыг бий болоход хамгийн чухал нөлөөлөгч хүчин зүйл нь болно. Энэ нь суралцагч, багш нарт дижитал контентод хамтран бүтээх, харилцан хуваалцах, сайн туршлагаасаа суралцах боломжийг олгоно. Мөн хичээлийг лекцийн танхим, эсвэл ажлын байр, хаанаас ч явуулах боломжийг олгож, орон зай, цаг хугацаа, байршил, боломжийг

³² (Keskin, 2018)

³³ (Decuyper, 2021)

олгоно. Суралцах үйл ажиллагаа нь тухайн суралцагчийн хэрэгцээнд бүрэн тохирсон хэлбэрээр явагдах боломжтой байх ёстой³⁴.

Мөн 2025 гэхэд Европын холбоо дараах чиглэлд дижиталчлалын үр нөлөөг бий болгосон байхаар төлөвлөсөн байна. Үүнд:

1. Мэдээлэл, технологийн салбарын ажилчдын 1.4 хувийг эзэлж байгаа эмэгтэй ажилчдынхаа хувийг 6 хувьд хүргэх³⁵
2. Хиймэл оюун ухааны салбар дах хөрөнгө оруулалтыг 5.5 дахин нэмэгдүүлэх³⁶
3. Хөдөлмөрийн зах зээлийн ажиллах хүчний 52 хувийг дижитал ур чадварт бүрэн сургах³⁷
4. 2025 гэхэд их сургуулиудын бэлтгэн гаргаж байгаа мэргэжилтнүүдийн дунд дата аналит, их өгөгдөл дээр ажиллах шинжээч, дижитал сургалтын менежерийн эрэлт хэрэгцээ улам ихсэхийн хэрээр энэ чиглэлд мэргэжилтэн бэлтгэх боловсролын байгууллагын тоо улам бүр нэмэгдэнэ.

Мэдээллийн технологийн салбараас олох одоогийн орлого(ҮНБ-ийн 6.8 хувь) ҮНБ-ийн 10 хувийг эзэлнэ³⁸.

Европын холбооны хэмжээнд боловсролын салбарын дижиталчлах үйл явцыг дараах үе шатуудад хувааж авч үзэж болохоор байна. Үүнд:

1. 2000-аад оноос өмнөх үе- Суралцагчдын дэлхийн хөдөлмөрийн зах зээл дээрх өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд боловсролын салбарт мэдээлэл, харилцааны технологийг хэрэглэж эхэлсэн байна.
2. 2000-2002 оны үе- Боловсролын салбарт оюутан суралцагчийн суралцахуйн(суралцагч талтай холбоотой) хэлбэрийг олон талтай болгохын тулд мэдээллийн технологийг улам бүр ашиглаж эхэлсэн ба хамгийн эхэнд дэд бүтцийг бүрдүүлэх тал дээр илүү анхаарч эхэлсэн.
3. 2002-2011 он хүртэл боловсролын салбарт инновацыг нэвтрүүлэхэд мэдээллийн технологийн дэвшлийг улам бүр ашиглах болсон. Багшлах боловсон хүчний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, цахим сургалтын программ, контентуудыг үйлдвэрлэх, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх
4. 2011 оноос хойш үе- Сургалтын үйл ажиллагаанд оролцогч талуудыг мэдээллийн технологийн тусламжтайгаар харилцаа холбоотой ажиллах боломжийг бүрдүүлэх, талуудын оролцоог хангасан, зэх зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөр боловсруулах загварыг бий болгох, хөгжүүлж ирсэн байна. Гэхдээ 2011 оноос өнөөдрийг хүртэлх боловсролын салбар дах дижитал шилжилтийг дараах дэд хэсгүүдэд хувааж авч үзэж болохоор байгаа юм. Үүнд:
 - Багшлах боловсон хүчнийг чадавхжуулах
 - Сургалтын хэрэглэгдэхүүнд ухаалаг гар утсанд суурилсан программ хангамжийн шийдлийг бий болгосон
 - Суралцахуйн ялгаатай зорилгыг хангахуйц сургалтын хэрэглэгдэхүүнүүдийг олон хэлбэртэйгээр үйлдвэрлэх, сургалтын байгууллагуудад нийлүүлэх

Боловсролын салбарт дижиталчлалыг хийхийн тулд дэд бүтэц, стратеги ба манлайлал, багшийн ур чадвар, суралцагчийн ур чадвар, агуулга, сургалтын хөтөлбөр, үнэлгээ, үндэсний хууль эрх зүйн орчин зэрэг хэд хэдэн чиглэлээр шаардлагатай бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдаг. Гишүүн улсууд сургалтын агуулга, боловсрол, сургалтын тогтолцооныхоо зохион байгуулалтыг хариуцдаг бол ЕХ-ны түвшинд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь энэ чиглэл дэх хамтын ажиллагааг дэмжих, сайн туршлага

³⁴ (Commission, 2020)

³⁵ (Eurostata 2017)

³⁶ (Eurostata 2017)

³⁷ (Eurostata 2017)

³⁸ (Commission E. , 2020)

солилцох, судалгаа, шинжилгээ, хамтын ажиллагааг дэмжих замаар чанартай, хүртээмжтэй боловсролыг нэгдсэн платформыг бий болгоход чиглэгдэж байна.

Франц, Бельги, Эстони, Кипр, Финланд, Албани, Латви улсуудын хувьд боловсрол гэдгийг насан туршийн суралцахуй учраас боловсролын бүхий л түвшинд дижитал ур чадварыг эзэмшүүлэх, бүр шатны боловсролын байгууллагын багшлахуй, суралцахуйн зорилго хөдөлмөрийн зах зээлтэй уялдсан байх ёстой гэж үзэж байна. Харин Грек, Мальт, Португал, Монтенегро улсуудын хувьд боловсролын дижитал шилжилтийн хувьд мэдээллийн аюулгүй байдал, боловсролын аналогийг дижитал хэлбэрт шилжүүлэх замаар боловсролын байгууллагын үйл ажиллагаа, хичээлийн агуулга, багшийн заах аргыг дижитал технологитой хослуулах замаар хөгжүүлэхэд анхаарч байна. Харин Польш улсын хувьд шинжлэх ухаан, технологи, инженерийн салбарт дижитал технологийг түлхүү хэрэглэх арга замаар боловсролын байгууллагыг дижиталчлах стратегийг хэрэгжүүлж байна.

Боловсролын дижиталчлалын хүрээнд Европын холбооноос сургуулиудын хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн цөм нь суралцагч байх бөгөөд ингэхдээ суралцахуйн зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. Суралцахуйн зорилго нь ирээдүйд бий болох ур чадварт харилцан суралцах, суралцахуйн зорилгын ялгаатай байдал, суралцах ур чадварын харилцан адилгүй түвшинд хамтран ажиллах, суралцагчид бие биеэ хүлээн зөвшөөрч сурах
2. Суралцахуйн зорилгын ялгаатай байдалд нийцсэн багшлахуйн ялгаатай арга барил, түүнд тохирсон дижитал эх үүсвэр, түүнийг загварчилсан сургуулийн удирдлагын тогтолцоо, хамт олны манлайлал
3. Шинээр бүтээсэн мэдлэгийг хамтаар суралцах орчин бүрдүүлэх
4. Суралцагч, багш, сургууль, эцэг эх асран хамгаалагчийн хамтын оролцоог дижиталчлахын зэрэгцээ цахим аюулгүй орчныг хангах
5. Суралцагч, багш нарын хувьд нийгэм, баг хамт олны өмнө тулгарсан асуудлыг хамтаар шийдвэрлэх арга замд суралцах
6. Суралцагчийн бие даан суралцах боломжийг сургалтын дижитал контентын тусламжтайгаар бий болгохын зэрэгцээгээр бүтээлчээр мэдлэг бүтээх үйл явцад багш, суралцагч хамтран оролцох нөхцөлийг бүрдүүлэх
7. Төсөлд суурилсан суралцахуйг хөгжүүлэхдээ нийгмийн олон талд байдлыг таньж мэдэхийн тулд салбар дундын сэдвээр төсөл хэрэгжүүлэх замаар суралцагчдад олон талт мэдлэгийг олгох
8. Туршилтад суурилсан суралцахуйг хөгжүүлэх. Ингэхдээ багш, суралцагчид асуудлыг хамтдаа шийдвэрлэхийн туршилтад тухайн нөхцөл байдалд үүссэн асуудлыг туршиж үзэх замаар хариултыг олох, ирээдүйн үр дагаврыг загварчлахыг тус тус оролдсон байдаг.

Европын холбооны зүгээс боловсролын салбар дах дижитал шилжилтийг дараах менежментийн хүрээнд зохион байгуулж байна. Үүнд:

- Санхүүжилт ба хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх: Европын холбооноос боловсролын салбар дах дижитал шилжилтийн санаачилгуудад илүү хариуцлагатай хандаж санхүүжүүлэх тал дээр маш нарийн бодлого баримталж ажиллаж байна. Доорх хүснэгтээс дижитал шилжилт, дижитал ур чадварыг хөгжүүлэхтэй холбоотой төслийн санаачилгыг хэрхэн санхүүжүүлсэн байдлыг харж болохоор байна.

Horizon 2020	Тэргүүлэх ач холбогдолтой төслүүдийг санхүүжүүлэх хөтөлбөрүүд хэрэгжсэн (2014-2020)	77 тэрбум евро
Horizon Europe	Судалгаа шинжилгээний тэргүүлэх төслийг санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр (2021-2027)	95.5 тэрбум евро
Erasmus+	Боловсрол, сургалт, залуучуудын хөгжил, спортыг дэмжих төсөл (2021-2027)	26 тэрбум евро
Digital Europe Program:	Дижитал технологи, ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр (2021-2027)	7.6 тэрбум евро

- Боловсролын салбар дахь дижитал шилжилтийг хийхэд зайлшгүй шаардлагатай бодлогын хийгээд эрх зүйн зохицуулалтаар ханган ажиллах. Үүнд:
 - European Declaration on Digital Rights and Principles for the Digital Decade
 - Decision (EU) 2022/2481 establishing the Digital Decade Policy Programme 2030
 - Declaration for the Future of the Internet
 - Global Gateway Joint Communication
 - DigComp 2.2
 - Digital Education Action Plan (2021-2027)
 - Digital transformation strategy for Africa 2020-2030.
 - European Green Digital Coalition
 - EU Action Plan for Human Rights and Democracy 2020-2024
 - Multiannual work programme for 2021-2025 - Connecting Europe Facility – Digital
- Боловсролын дижитал контент өгөгдлийн сангийн аюулгүй байдал, нууцлалын асуудлыг зохицуулах. Европын холбооны зүгээс их өгөгдлийг ашиглалт, хамгаалалтын журам, суралцагчийн хувийн нууцтай холбоотой эмзэг мэдээллийн аюулгүй байдлыг хангах янз бүрийн зохицуулалтуудыг хийж байна. Үүнд:
 - Зөвшөөрөл авах зарчим. Боловсролын байгууллага зөвхөн сургалтын дижитал хэрэглэгдэхүүнийг оюутан, суралцагч ашиглахтай холбоотой суралцагчийн хувийн мэдээллийг авахдаа өөрөөс нь болон асран хамгаалагчаас зөвшөөрөл зайлшгүй авах шаардлагатай болсон.
 - Суралцагчийн хувийн зарим эмзэг мэдээллийн найдвартай хадгалах зарчим. Сургалтын байгууллага их өгөгдөл цуглуулахдаа бус харин бага өгөгдлөөр өндөр үр дүн гаргах чиглэлд ажиллах ёстой төдийгүй мэдээлэл цуглуулах, хадгалах, дамжуулах бүхий л үйл явц хууль эрх зүйн хүрээнд зохицуулагдах ёстой.
 - Мэдээллийн аюулгүй байдал: Боловсролын байгууллагууд сургалтын үйл ажиллагаатай холбоотой дижитал контент, суралцагчийн хувийн мэдээллийг үндсэн зорилгоос гадуур ашиглах, дамжуулан өгөхийг хориглодог.
 - Өгөгдөл хариуцсан мэргэжилтэнтэй байх: Зарим боловсролын байгууллагад байгууллагын өгөгдлийн ашиглалт хариуцсан орон тооны ажилтантай болох хандлага ажиглагдаж байна.
- Дижитал ур чадварт суралцах тогтолцоог сургалтын үйл ажиллагаанд оролцогч талуудад тэр тусмаа багш, суралцагч бүр хамааралтай ойлголт гэж үзэн багшлах боловсон хүчний хувьд дижитал шилжилтийг хийхэд ур чадвар, хандлага, мэдлэг хэр бэлэн байгааг судлан шинжилсний үндсэн багшийг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулсан байдаг. Европын холбооны хэмжээнд дижитал ур чадварын бэлэн байдлыг судалж ажлын байран дээр хамгийн эрэлттэй байгаа дижитал ур чадварын жагсаалтыг гаргасан байдаг. Үүнд:
 - Энгийн дижитал ур чадвар: Сургалтын цахим платформуудыг ашиглаж сурах, суралцагчдад энгийн ойлгомжтойгоор тайлбарлах чадвар, цахим орчин хэрэгтэй байгаа мэдээллийг нарийсган хайх ур чадвар, цахим орчинд харилцах, файльтай зөв харилцах ур чадвар
 - Мэдээллийн үнэн зөв байдлыг нягтлах чадвар: Цахим орчинд байгаа мэдээллийн үнэн зөв байдлыг нягтлах, мэдээллийг үнэлэх, шүүмжлэл байр сууриас хандах,
 - Дижитал харилцааны ур чадвар: Албан болон албан бус харилцаанд дижитал хэрэгслүүдийг ашиглах чадвар
 - Дижитал контент бүтээх түүнийгээ сургалтад үр дүнтэйгээр ашиглах чадвар
 - Цахим орчин дахь харилцааны ёс зүй: Цахим орчинд бусдын эрдэм шинжилгээний бүтээл, дижитал сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглахад ёс зүйтэй хандах, бусдын зүй бус үйлдэлд шүүмжлэлтэйгээр хандах ур чадвар

- Тасралтгүй суралцах чадвар: Мэдээллийн технологийн хурдацтай хөгжлөөс шалтгаалан сургалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг болон сургалтад оролцогч талууд байнгын тасралтгүй суралцах үйл явцыг дадал болгох, сургалтын байгууллага цахим сургалтын хэрэглэгдэхүүний шинэчлэлтийг байнга хийх, хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтөөс урган гарч ирж буй шаардлагыг сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүнд байнга тусгадаг байх.
- Дижитал дэд бүтэц. Европын холбооны зүгээс дижитал шилжилтийг хийхэд зайлшгүй шаардлагатай өндөр хурдны интернет, сургалтын дэвшилтэт цахим болон танхим хосолсон аргуудаар сургалтыг зохион байгуулахад багшлах боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх ажлуудыг зохион байгуулж байна. Үүнд:
 - Дижитал сургалтын платформ: Европын холбооноос сургалтын онлайн болон цахим танхим хосолсон технологийг ашиглах боломжтойгоор анги танхимыг тохижуулах, тэрхүү дижитал платформыг ашиглахад шаардлагатай дэд бүтцийг үр ашигтайгаар хөгжүүлэхэд их анхаарч байна.
 - Интерактив сургалтын аргаар хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай анги танхимын тохижилтыг санхүүжүүлэн ажиллаж байна.
 - Сургалтад таблет, суурин компьютер, бусад хөдөлгөөнт хэрэглэгдэхүүнийг
 - Цахим ном, сурах бичиг, дижитал эх үүсвэрүүдээр хангах: Боловсролын байгууллагууд оюутан суралцагч нэг бүр хүрэлцээтэйгээр дижитал хэрэглэгдэхүүний нөөцийг бүрдүүлэх
 - Суралцахуйн үйлийг загварчлах, дижитал контентыг суралцахуйн ялгаатай арга барилтай суралцагч нэг бүрийн онцлог байдалд тохирсон байхаар зохиох, төлөвлөх
- Судалгаа, инноваци: Сургалт, сургах зүйд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах, сургалтын технологийн чиглэлд гарч байгаа шинэ Старт-апп компаниудыг бойжуулах, дэмжин ажиллах, судалгаан төсөл, үр дүнг сургалтын байгууллага дотооддоо нэвтрүүлэх
- Европын Холбооны гишүүн улсууд боловсролын салбарт дижитал шилжилтийг хийхэд сайн туршлагаасаа харилцан суралцах, мэдлэг мэдээллээ солилцох. Энэ чиглэлд Европын Холбооноос санал солилцох уулзалтуудыг үе шаттайгаар зохин байгуулж байна.
- Хяналт, үнэлгээний тогтолцоо: Европын Холбооны зүгээс боловсролын дижитал шилжилтийн үр өгөөжийг тодорхой тогтолцооны хүрээнд байнга хянаж үнэлж байдаг байна. Үүнд: Боловсролын салбарт дижиталчлалын бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах стратегийг баримталсан байна. Үүнд:
 - Чанарын хяналт үнэлгээний тогтолцоо: Дижитал сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын орчны дэд бүтцийн бэлэн байдал, сургалтын байгууллагын шилжилтийн үйл явцын тасралтгүй байдлыг байнга хянаж, үнэлж байдаг.
 - Хэрэглэгчийн үнэлгээний тогтолцоо: Сургалтын үйл ажиллагаанд оролцогч талууд болох оюутан, суралцагч, эцэг эх асран хамгаалагч, багш, ажилтан сургалтын байгууллагын дижитал шилжилтийн талаар өөрийн үнэлгээгээ улирал бүр тодорхой хуваарийн дагуу хийж байдаг.
 - Дижитал шилжилтэд шаардлагатай сургалтын байгууллагын нөөцийн ашиглалтын төлөв байдлыг судлах, шаардлагатай хэсгүүдэд нөөцийн дахин хуваарилалтыг хийж байдаг.
 - Урт хугацааны төлөвлөлт хийх гэм мэт боловсролын салбарын дижитал шилжилтийг хийх өөрийн гэсэн арга туршлага, технологийн дагуу хийж байна.

REFERENCES

1. <https://www.ed.ac.uk/clinical-sciences/edinburgh-imaging/for-patients-study-participants/tell-me-more-about-my-scan/what-is-microscopy>
2. patients-study-participants/tell-me-more-about-my-scan/what-is-microscopy

3. European Commission, (2017). *Eurostata 2017*.
4. European Commission, (2020). *Digital Education action plan 2021-2027*.
5. Decuyper, M. (2021). Introduction: Critical studies of digital education platforms. *Critical Studies in Education* 62(1), 1-16.
6. Europe, D. (n.d.). *Eurostata 2017*.
7. Keskin, B. (2018). Public Values in a Connective World. *Markets, Globalization & Development Review* 3(3)
8. O'Leary, M et al., 2018. The state-of-the-art in digital technology based assessment. *European Journal of Education*, Vol. 53
9. Panadero, E., Brown, G. T. and Strijbos, J. W., 2016. The Future of Student Self-Assessment: a Review of Known Unknowns and Potential Directions. *Educational Psychology Review*, 28(4)
10. Pelgrum, W. J., 2001. Obstacles to the integration of ICT in education: results from a worldwide educational assessment. *Computers & Education*, Vol. 37
11. Prensky, M., 2001. Digital Natives, Digital Immigrants. Part 1. *On the Horizon*, 9(5)
12. Redecker, C., 2013. The Use of ICT for the Assessment of Key Competences. European Commission
13. Joint Research Centre Institute for Prospective Technological Studies, Luxembourg: Publications Office of the European Union.
14. Redecker, C., Johannessen Ø., 2013. Changing Assessment – Towards a New Assessment
15. Paradigm Using ICT. *European Journal of Education*, Vol. 48(1)
16. Redecker, C., 2017. European Framework for the Digital Competence of Educators: DigCompEdu. Luxembourg: Publications Office of the European Union.
17. Schleicher, A. ed., 2012. Preparing Teachers and Developing School Leaders for the 21st Century: Lessons from around the World

ЕВРОПЫН ХОЛБООНЫ БАЙНГЫН ГАДААД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГЫН ПАРАДИГМ ШИЛЖИЛТ: ӨӨРЧЛӨЛТӨӨС УЯН ХАТАН ХАНДЛАГА РУУ

ахмад Ш.Эвсанаа (МА)

*Дотоод хэргийн хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш*

Хураангуй: ЕХ-ны Байнгын Гадаад, Аюулгүй байдлын бодлого нь НҮБ-ын дүрмийн зарчмын дагуу энх тайвныг сахин хамгаалах, олон улсын аюулгүй байдлыг бэхжүүлэх³⁹, олон улсын хамтын ажиллагааг дэмжих, ардчилал, хууль дээдлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх билээ. Эдгээр зорилго, үнэт зүйлсийн хүрээнд өнөөдөр шинэ парадигм ба уян хатан хандлага төрж байна.

Abstract: The Permanent Foreign and Security Policy of the EU is based on the principles of the UN Charter, to maintain peace, strengthen international security, support international cooperation, and respect democracy, the rule of law, human rights, and fundamental freedoms. Within these goals and values, a new paradigm and flexible approach is emerging today.

Түлхүүр үгс: Олон улсын нийгэмлэг, ЕХ-ны Байнгын Гадаад, Аюулгүй Байдлын Бодлого (CFSP), хуучин парадигм: өөрчлөлт, шинэ парадигм: уян хатан хандлага

Key words: International community, Common Foreign and Security Policy, old paradigm: transformation, new paradigm: resilience

ОРШИЛ

Аюулгүй байдал бол өөрөө туйлын зорилго биш, харин ард түмний сайн сайхныг хангах цор ганц чиг үүрэгтэй гэдгийг олноо хүлээн зөвшөөрөх болсонд энэхүү уялдаа холбооны учир утга оршиж байна.⁴⁰

“Гагцхүү хувь хүний бүрэн эрхт, халдашгүй дархан байдлаас эхтэй бол аливаа хамтын нийгэмлэг, бүс нутаг, үндэстэн, улс гүрний бүрэн эрхт байдал учир утгатай байна.”⁴¹

Вацлав Хавел

Эртнээс үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдал нь бие даасан аливаа улсын хувьд амин чухал асуудал байсаар ирсэн билээ. Зэвсэгт мөргөлдөөний шинэ төрлүүд бий болж, улс хоорондын харилцаа, хамаарал улам бүр нэмэгдэж байгаагаас үүдэн Европын Холбооны Байнгын Гадаад, Аюулгүй байдлын бодлого нь уян хатан хандлага руу шилжих, үйлдэл, арга хэмжээг нэвтрүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Нэгдсэн Европыг бий болгох санаа нь шинэ санаа биш байв. 9-р зуунд Франкийн эзэн хаан Чарльман Европын ихэнх хэсгийг захирч байв. 19-р зууны эхээр Наполеон Бонапарт Европын ихэнх хэсгийг хянах гэж оролдсон. 1930-аад онд Адольф Гитлер Европыг бүхэлд нь байлдан дагуулах зорилготой байв. Гол үйлдэл нь давамгайлах, хянах, байлдан дагуулах зорилготой байв. Түүхийн туршид Европт газар нутаг, шашин шүтлэг, нөөц баялгийн төлөө тулалдаж байсан дайнууд бүгд аймшигтай үр дагаварт хүргэсэн.

³⁹ https://fpi.ec.europa.eu/what-we-do/common-foreign-and-security-policy_en

⁴⁰ ОУПХ болон ЗХАХТЖТ – Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт, 2003

⁴¹ ОУПХ болон ЗХАХТЖТ – Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт, 2003

Дэлхийн 2-р дайны төгсгөлд хүчирхийлэл, үзэн ядалт Европыг нэгтгэж чадахгүй нь тодорхой болов. 1945 онд Европын олон хот балгас болж, хүмүүс орон гэргүй болж, үйлдвэрүүд сүйрч, гүүр, төмөр замууд бөмбөгдөлтөд өртөв. Гэр орон, амьжиргааны эх үүсвэргүй олон европчууд амьдрал нь дахин яаж хэвийн болохыг мэдэхгүй цөхрөнгөө барж байв.

Европыг сэргээн босгож, европчуудад амьдралаа сэргээн босгоход нь туслахын тулд сэтгэлгээний “цоо шинэ” арга барил шаардлагатай байв. Энэ нь хүмүүс тайван замаар хамтран ажиллах, түүхэн үйл явцын өрсөлдөөн, өрөөсгөл үзлийг хойш тавьж, хамтын ажиллагааны “шинэ” үзлийг бий болгох ёстой байв. “Гайхамшигтай” арга замаар тэд хамтран ажилласан. Тэд Европын түүхийн шинэ эриний эхлэлийг тавьж, Европыг энх тайвнаар нэгтгэх эхлэлийг тавьсан юм.

1921 онд Люксембург, Бельгийн Засгийн газрууд эдийн засгийн хувьд хамтран ажиллаж, худалдааны гэрээ байгуулж, цаашлаад томоохон улс орнуудтай илүү өрсөлдөх чадвартай болно гэсэн санааг аль хэдийн бий болгосон. Дэлхийн 2-р дайны үед Нидерланд, Бельги улсууд ч эдийн засгийн хамтын ажиллагааны алхмыг хийсэн. Эцэст нь 1948 онд Бенилюксийн гаалийн холбоо байгуулагдаж, улс орнуудын хооронд бараа, ажилчин, үйлчилгээ, хөрөнгийн чөлөөтэй шилжих боломжийг олгосон. 1958 онд Бенилюксийн гэрээнд гарын үсэг зурснаар Бенилюксийн орнуудыг чөлөөт худалдааны нэгж болгон албан ёсоор байгуулав.

Өнөөдөр бидний амьдарч буй цаг үед Европын Холбоог бий болгоход хамгийн их нөлөө үзүүлсэн хүмүүст Alcide De Gasperi, Alcide De Gasperi, Winston Churchill, Konrad Adenauer, Jean Monnet нарын зүтгэлтнүүд юм. Тэдний эрч хүч, хүсэл тэмүүлэлгүйгээр амар амгалан, тогтвортой байдлын хүрээнд амьдрахгүй байх байсан.⁴²

Европын бусад улс орнуудын эдийн засагч, төрийн зүтгэлтнүүд ч нэгдсэн Европ нь эдийн засаг, улс төрийн давуу талтай байх боломжийг санал болгож байв. Тэд эдийн засгийн тогтвортой байдал, европын тогтолцоог хөгжүүлэхэд тусалсан бөгөөд Европын соёлын баялаг түүх, хэлний олон янз байдлыг дэмжсэн. Тэдний орчин үеийн Европт оруулсан хувь нэмрийг тэмдэглэхээс гадна эр зориг, тууштай байдлын ачаар орчин үеийн Европ бол энх тайван, тогтвортой байдлын бүс нутаг болж чадсан.

Анархи нөхцөл дэх аюулгүй байдлын улс төрийн тодорхойлох хүчин зүйлүүдээс олон улсын нийгэмлэгийн тухай асуудал нилээд судлагдан ном зохиолд тусгагджээ. Хедлей Булл⁴³ Адам Уотсон⁴⁴ нар олон улсын нийгэмлэгийг тодорхойлохдоо:

“Олон улсын нийгэмлэг гэж хамтын эрх ашгаа хүлээн зөвшөөрч харилцаагаа зохицуулж байхын тулд хамтран хэлэлцэн тохирсны үндсэн дээр нийтээр дагаж мөрдөх дүрэм журмаа боловсруулсан нэг хэсэг улсыг /ерөнхий утгаар нь бол бие даасан улс төрийн хамтлагууд/ хэлнэ. Системийг бүрэлдүүлэхдээ улс орон бүрийн явуулж буй үйл ажиллагаанд бусдынх нь үйл ажиллагааг зайлшгүй харгалзан үзэх албагүй” гэжээ.

Нийгэмлэг нь системийн оршин тогтнох түүхэн хэлбэр билээ. Буллын баталж байгаагаар олон улсын нийгэмлэг нь тодорхой нэгэн зорилго үнэт зүйлийг хөгжүүлэхийн тулд нийгмийн амьдралын зохицуулалт болох олон улсын дэг журам гэдэг ойлголттой нягт холбоотой.⁴⁵

Түүхэн хөгжлөөрөө олон улсын нийгэмлэг нь Өрнөдийн хөгжлийн үр дүн юм. Арван есдүгээр зууны эцсээр олон улсын систем бүхэлдээ бүрэлдэн тогтож, Европ, Америк, Австрали мөн. Европын улсуудын ялалт, улс гүрнүүдийн харилцан үйлчлэл /нягтрал ба харилцан хамаарлын түвшнээр/ байнга өсөн нэмэгдсэнээр, Өрнөдийн үнэт зүйлс, хэм

⁴² https://european-union.europa.eu/principles-countries-history/history-eu/eu-pioneers/jean-monnet_en

⁴³ Hedley Norman Bull. *Англи, олон улсын харилцааны судлаач*

⁴⁴ John Hugh Adam Watson. *Английн дипломатч, олон улсын харилцааны мэргэжилтэн*

⁴⁵ Берри Бузан. *(орчуулагч Л.Оюунгэрэл). Ард, түмэн, айх аюул. УБ., 1999 он*

хэмжээ, байгууламжууд системийг тодорхойлох болсон.⁴⁶ Булл болон бусад судлаачдын үзэж байгаагаар энэ нь олон улсын нийгэмлэгийн хөгжил өндөр түвшинд хүрсний шинж байсан. Учир нь харьцангуй нэгдэл нягтралтай, үлэмж хөгжсөн Европын дэд системийн олон улсын нийгэмлэг ийнхүү дэлхий даяар олширсон билээ.

Гишүүдийнхээ эрх тэгш статусын талаар үндсэн ойлголт байхыг нийгэмлэг шаарддаг. Энэ үүднээс авч үзвэл арван есдүгээр зууны сүүлчээр дэлхийн хэмжээний олон улсын нийгэмлэг байсангүй. Харин бүх нийтийн шинж чанартай Европын олон улсын нийгэмлэг байсан гэж хэлж болно.

Олон улсын систем шаардлагатай гэдгийг Европын нийгэмлэг тод харуулж, улс төрийн тогтолцоонд үлгэрлэх хэлбэр болсон. Иймээс асуудлын гол нь шинэ систем Европын хамтын нийгэмлэгээс Европын биш улсууд юуг нь авч, юуг нь таягдан хаясан бэ?

Булл, Уотсон нарын нотолж байгаагаар Европын нийгэмлэгийн ихэнх үнэт зүйлийг дэлхийн бусад улс орон тусгаар байдлаа олсны дараа хүлээн зөвшөөрч, ялангуяа бүрэн эрхт улсуудын зохион байгуулалтын гол зарчим болох хууль зүйн хувьд тэгш эрхтэй гэдгийг харилцан хүлээн зөвшөөрсөн нь системийн улс төрийн үйл ажиллагааны үндсэн хэм хэмжээ болжээ.⁴⁷ Судлаачдын үзэж байгаагаар ийнхүү ЕХ-ны үндэс суурь парадигм тавигдах болсон байна. Гэвч цаг хугацааны өөрчлөлтөнд тохирсон парадигм өөрчлөлт зайлшгүй шаардлагатай болж байгааг харуулж байна.

ЕХ-ны Гадаад ба Аюулгүй байдлын нийтлэг бодлого нь 1993 онд Маастрихтын гэрээ буюу ЕХ-ны тухай гэрээгээр үүсэн бий болсон бөгөөд уг гэрээнд тусгасан гурван тулгуурт тогтолцооны нэг тулгуур болж байв.

1997 оны Амстердамын гэрээгээр шийдвэр гаргах илүү үр дүнтэй процесс, түүний дотор үндэслэлтэйгээр түдгэлзэх эрх, шаардлага хангасан олонхын саналаар шийдэх журмыг бий болгосон. 1999 оны 12-р сард Европын Зөвлөл Гадаад ба аюулгүй байдлын нийтлэг бодлогын асуудал эрхэлсэн Дээд төлөөлөгчийн үүргийг бий болгосон бөгөөд 2009 онд хүчин төгөлдөр болсон Лиссабоны гэрээгээр ЕХ-ны Гадаад хэрэг ба аюулгүй байдлын бодлогын Дээд төлөөлөгчийн албан тушаалыг бий болгохын хамт гурван тулгуурт тогтолцоог хүчингүй болгосон.

ЕХ-ны 27 орны элчин сайдуудаас бүрдсэн Улс төрийн ба Аюулгүй байдлын хороо нь Дээд төлөөлөгчийн удирдлагад ажилладаг бөгөөд ЕХ-ны Гадаад ба аюулгүй байдлын нийтлэг бодлогод хамрах хүрээний олон улсын нөхцөл байдалд хяналт тавьж, хямралыг шийдвэрлэхэд Европын Холбооноос авах арга хэмжээг тодорхойлох, хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг.

ЕХ-ны гадаад ба аюулгүй байдлын бодлого нь мөргөлдөөнийг шийдвэрлэх, олон улсын ойлголцлыг бэхжүүлэхэд чиглэсэн бөгөөд дипломат ажиллагаа, олон улсын дүрэм журмыг хүндэтгэх явдалд суурилдаг. Худалдаа, хүмүүнлэгийн тусламж, хөгжлийн хамтын ажиллагаа зэрэг нь ЕХ-ны олон улсын үүрэгт мөн чухал үүрэг гүйцэтгэдэг.

ЕХ-ны Гадаад ба аюулгүй байдлын нийтлэг бодлого нь дараах зүйлсийг зорилгоо болгодог:

- Энх тайвныг сахин хамгаалах
- Олон улсын аюулгүй байдлыг бэхжүүлэх
- Олон улсын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих
- Ардчилал, хууль дээдлэх ёсыг хөгжүүлэн бэхжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэн сахиулах

ЕХ нь дэлхийн голлох тоглогчид, түүний дотор шинээр түрэн гарч буй гүрнүүд болон бүс нутгийн бүлгүүдтэй түншлэлийн харилцааг хөгжүүлдэг. Ингэхдээ бие биений ашиг сонирхлыг харилцан хүндэтгэж, харилцан ашигтай харилцааг эрхэмлэдэг. ЕХ нь дэлхийн голлох тоглогчид, түүний дотор шинээр түрэн гарч буй гүрнүүд болон бүс нутгийн

⁴⁶ Берри Бузан. (орчуулагч Л.Оюунгэрэл). Ард, түмэн, айх аюул. УБ., 1999 он

⁴⁷ Берри Бузан. (орчуулагч Л.Оюунгэрэл). Ард, түмэн, айх аюул. УБ., 1999 он

бүлгүүдтэй түншлэлийн харилцааг хөгжүүлдэг. Ингэхдээ бие биеийн ашиг сонирхлыг харилцан хүндэтгэж, харилцан ашигтай харилцааг эрхэмлэдэг.⁴⁸

ЕХ-ны Байнгын Гадаад, Аюулгүй Байдлын⁴⁹ Бодлого (CFSP) амжилттай хөгжиж байна. Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын үзэл баримтлал болон практик ажиллагаанд огцом өөрчлөлтүүд бий болж буй нь олон ажиглагчдын гайхширлыг төрүүлж байгаа билээ.

Европын Батлан хамгаалахын сан байгуулагдсан он цагаас үүдэлтэй кибер аюулгүй байдал, Байнгын Бүтэцтэй Хамтын ажиллагаа нь (PESCO, товчоор) олон асуудлыг шийдэх томоохон шинэчлэл, шинэчлэлийн саналуудыг хэрэгжүүлж байна.

Энэ нь улс төрийн хуучин үзэл баримтлалаа өөрчлөх зайлшгүй шаардлагатай гэдгийг тодоор сануулж буй гэдэг нь Европт дайн ба сөргөлдөөний эхлэл Югославын дайнаас хойш анх удаа тавигдсан. Үүнтэй зэрэгцэн АНУ Европт хандуулах сонирхол буурсан, Их Британи нь Европын Холбооноос гарсан, терроризмын аюул заналхийлэл, нэн чухал өндөр ач холбогдолтой дэд бүтцийн эмзэг байдал ба дүрвэгсдийн хямрал гээд бүгд ЕХ-г дотоод, гадаад аюулгүй байдлын бодлогын дахин зохион байгуулалт хийхийг шаардаж байна.

Эдгээр хүчин зүйлс нь олон нийтийн зүгээс ирэх дарамт шахалтыг хүртэл нэмэгдүүлж байгаа нь ЕХ-ны одоогийн гадаад бодлого, аюулгүй байдал, батлан хамгаалахын бодлого үр ашиггүй гэдгийг нотолж байна. Дотооддоо ЕХ хууль, эрх зүйн хямралтай тулгарсаар байна. Үүний улмаас ЕХ-ны иргэд аюулгүй байдлыг хамгийн чухал гэж үздэг бөгөөд Европ томоохон үүрэг гүйцэтгэх ёстой гэж үздэг. Улмаар 2017 оны хавар Европын Парламент “*Coalitions of the Willing*” буюу “Санаа зорилгын эвсэл” байгуулсан.

Байнгын Гадаад, Аюулгүй Байдлын бодлого нь өмнөх бодлого, стратегиас онцгой ялгаатай байдлаар баримт бичигт тусгагдсан. ЕХ-ны шинэ Глобал Стратеги нь уян хатан байдлын стратегийн үзэл баримтлалд төвлөрдөг.⁵⁰

Уян хатан хандлага гэдэг нь “эсэргүүцэх ба шинэчлэх чадамж”, “хямралд тэсвэртэй” гэсэн ойлголтыг илэрхийлдэг. Уян хатан байдал нь гадаад болон дотоод бодлогын аль алинд хамрах хүрээнд хэрэгжих ёстой.

Аюулгүй байдал ба Батлан Хамгаалах Холбоо нь гурван баганат бодлого хэрэгжүүлнэ: Аюулгүй Байдлын Холбоо, Батлан Хамгаалахын Холбоо болон ЕХ-НАТО хамтын ажиллагаа. Дотоод бодлогын хувьд кибер аюулгүй байдал, дүрвэлт эсвэл терроризмын эсрэг ажиллагаа нь заавал авах арга хэмжээний талбарууд юм.

Хуучин парадигм: Шилжилт⁵¹

Өнгөрсөн хугацаанд ЕХ-ны гадаад арга хэмжээ ба Байнгын Гадаад, Аюулгүй Байдлын бодлого нь цаг үедээ үл тохирох байдлаар тодорхойлогддог байсан. Тухайлбал, 2003 оны Европын Аюулгүй Байдлын Стратегийн баримт бичиг болон бусад стратегийн бичвэрт ЕХ нь улс төрийн орчны хувьд дан зорилтот бодлогыг тууштай баримтална гэдгийг дахин дахин онцолсон байдаг. Европ нь Югославын дайн шиг нөхцөл байдал дахин хэзээ ч давтагдахгүй гэж үзсэн. 1993 онд Maastricht Treaty/Маастрихтын гэрээний дагуу үүссэн CFSP нь Европын болон глобал улс төрийн сонирхлыг хамгаалах зорилгоор байгуулагдсан. Энэ байгууллагын бүтэц нь онолын хувьд алдаа дутагдалтай гэдгийг академик хэлэлцүүлэгт ихээр дурдагддаг. Улмаар 2009 онд Лиссабоны гэрээ нь гадаад ба аюулгүй байдлын хамрах хүрээг улам тэлж

⁴⁸ МУИС-ийн ОУХНУС-ийн ахлах багш, Д.Оюунсүрэн. “Европын холбооны гадаад бодлого, стратеги”

⁴⁹ https://fpi.ec.europa.eu/what-we-do/common-foreign-and-security-policy_en

⁵⁰ Annegret Bendiek “A Paradigm Shift in the EU’s Common Foreign and Security Policy: From Transformation to Resilienc” RP 11 October 2017 Berlin

⁵¹ Annegret Bendiek “A Paradigm Shift in the EU’s Common Foreign and Security Policy: From Transformation to Resilienc” RP 11 October 2017 Berlin

боловсруулсан. Үзэл баримтлалын хувьд CFSP нь газар зүйн хязгаарлалт үгүй бөгөөд ардчиллын үнэ цэн, хууль дүрэм, хүний эрхийг дээдлэх чиглэлийг баримталдаг.

2012 оны зургаадугаар сард гишүүн орнууд хүний эрхийн стратеги болон зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааны төлөвлөгөөг зөвшөөрсөн. ЕХ-ны хүний эрхийг дээдлэх бодлого нь үйл ажиллагааны чухал нэг бүрдэл хэсэг бөгөөд түншлэл, хамтын ажиллагаа ба холбооны гэрээний дагуу хэрэгждэг. Копенгагений шалгуур/Copenhagen Criteria нь хүний эрхийг дээдлэхтэй холбоотой хууль дүрэм, ардчиллын зарчмуудыг багтаадаг. Практикт Европын Гадаад Арга Хэмжээний Үйлчилгээ нь 139 төлөөлөгч, 5,500 гаруй ажилтантай үйл ажиллагаа явуулж гэрээний зорилтуудыг биелүүлэн ажилладаг. 2016 онд ЕХ-ны төсөв нь 600 сая евро байсан.

Шилжилтийн хандлагын шүүмж

ЕХ-ны шилжилтийн хандлага нь амжилтгүй хэрэгжсэн гэж шүүмжлэлд өртдөг хэдий ч өмнөө тавьсан зорилтуудын тодорхой хэсгийг хэрэгжүүлж чадсан. Тухайлбал, ардчиллыг бэхжүүлэх, хууль дүрмийг хэрэгжүүлэх зэрэгт ахиц гарсан гэдгийг дурдах нь зүйтэй. ЕХ-ны гадаад бодлогын өөрчлөлт нь үр дүн муутай хэрэгжсэн нь CFSP-д стратегиа эргэн харах, сайтар тунгаах түлхэц нь болсон юм.

Шинэ парадигм: Уян хатан хандлага⁵²

2016 оны сүүлээр ЕХ нь Байнгын Гадаад ба Аюулгүй Байдлын Бодлогодоо шинэ Глобал Стратегийг боловсруулж, CFSP-н норматив уян дэд тогтолцоог дахин тодорхойлсон. “Нэгдмэл алсын хараа, нэгдсэн арга хэмжээ: илүү хүчтэй Европ” гэсэн уриа дор Италийн бодлогын зөвлөх институт, Nathalie Tossi нарын чиглэлийн дагуу баг бүрэлдэхүүн нь ЕХ-ны гадаад, дотоод аюул заналхийллийн эсрэг ямар арга хэмжээ авч ажиллах бодлогын талаар уян хатан хандлагыг зарлан тунхагласан.

Глобал стратеги нь гишүүн орон болон хөрш улсуудад уян хатан хандлагын өндөр стандарт тогтоосон. “Уян хатан хандлага” гэдэг нь халдлагаас хамгаалах, хохирлыг сэргээх, даван туулах, юуны түрүүнд халдлага, хохирол үүсэхгүй байх бүтцийг байгуулах явдал юм.

ЕХ-ны стратегийн шинэ “уян хатан” хандлага нь гадаад, дотоод аюулгүй байдлыг дээшлүүлэх цогц үзэл баримтлал бөгөөд “нийт ард түмэн ба нийгмийг бүхэлд” нь хамарсан ойлголт билээ. Үүнээс улбаалан уян хатан нийгэм гэдэг нь ардчилал, институтчилэгдсэн итгэл үнэмшил, тогтвортой хөгжлийг илэрхийлдэг.

Глобал Стратегийн дагуу ЕХ нь уян хатан үндсэн хоёр шинж чанараас бүрддэг: гадаад эрсдэлүүд ба аюулаас зайлсхийх чадамж, хөрш орнуудтай хэвийн харилцаатай байх чадвар.

Богино болон дунд хугацааны мөчлөгт эдгээр сорилтуудыг хэрхэн давах үйл явцыг Европын Цагаан Номын аюулгүй байдал, батлан хамгаалах хэсэгт тодорхой заасан байдаг.

2016 оны ЕХ-ны Глобал Стратеги нь хүчин төгөлдөр баримт бичиг хараахан болоогүй байна. Түүнчлэн Европын Цагаан Ном нь батлан хамгаалах, аюулгүй байдлын талаарх техникийн нэр томъёоны өөрчлөлтийг дахин нягталж хууль, эрх зүйн хувьд хүчин төгөлдөр баримт бичиг боловсруулж үндэсний парламентаар хүлээн зөвшөөрүүлэх байсан.

Дунд хугацааны мөчлөгт Их Британийн ЕХ-оос гарсан нь гэрээ, хэлэлцээрийн шинэчлэлийг хийх боломжийн “цонх”-ыг нээсэн явдал болохын сацуу шаардлагатай өөрчлөлтүүдийг хуульчлах боломжийг давхар бүрдүүлж өгөв.

ЕХ-ны шинэ стратеги уян хатан байдлыг зарим ажиглагчид үүнийг “өөрчлөх хандлагын эсрэг үзэл баримтлал” гэж үздэг бол зарим нь үүнийг зөрчилдөөнийг даван туулах бүтээлч санал, тогтвортой байдлыг дэмжих, ардчиллыг дэмжих гэж үздэг. ЕХ-ны өмнөх өөрчлөлтийн зорилтуудаас чанарын хувьд ялгаатай.

⁵²Annegret Bendiek “A Paradigm Shift in the EU’s Common Foreign and Security Policy: From Transformation to Resilienc” RP 11 October 2017 Berlin

Эндээс ЕХ-ны хөгжлийн хэтийн зорилго нь дотоод интеграц, тэлэлтийн орон зай, бүс нутгийн хамтын ажиллагаа, олон улсын талбарт тоглогч болох гэсэн дөрвөн үндсэн стратеги хэрэгжүүлж буйг ажиглаж болно.⁵³

1. Холбооны дотоод интеграц нь гишүүн улсуудын бүх төрлийн харилцааг зохицуулах 100 мянга орчим хууль, журам, чиглэл, шийдвэрийн баримт бичигт⁵⁴ суурилдаг ба дотоод интеграцыг хангаж өгдөг.
2. Европын Холбоо тэлэлтийн орон зайгаа Баруун Балканы 6 улс (Серби, Монтенегро, Умард Македони, Босни Герцеговин, Косово, Албани), Зүүн Европын 6 улс (Украин, Беларусь, Молдав, Гүрж, Армян, Азербайжан) гэсэн хоёр үндсэн чиглэлд идэвхтэй хэрэгжүүлж байна.⁵⁵ Үүнтэй зэрэгцэн хэрэгждэг “Northern Dimension” нэртэй түншлэлийн өөр нэг формат нь Норвеги, Исланд хоёр улсыг Евро интеграцид ойртуулах зорилготой.
3. Европын Холбооны хэрэгжүүлдэг “Бүс нутгийн хамтын ажиллагаа” нь гадаад бодлогын чухал чиглэл болж хувираад байна. Үүнд: Хөршүүдийн түншлэл (16 улс), Газар дундын тэнгисийн бүс нутгийн түншлэл, Хар тэнгисийн синерги санаачилга, Арктикийн бодлого, Латин Америкийн хамтын ажиллагаа, АСЕАН-ны түншлэл зэрэг үндсэн чиглэлүүдтэй.⁵⁶

Европын Холбоо дэлхийн талбарт үндсэн тоглогчдын нэг болох бодлого нь Евро-Атлантын эвслийн ерөнхий үзэл санаа дээр суурилдаг. Европын Холбооны хөгжүүлж буй НАТО, АНУ-тай түншлэх олон талт стратегийн чиглэл, Европын Холбоо, Японы стратегийн түншлэл зэрэг нь олон улсын талбарт өөрийн нөөц чадамжийг харуулж, бүрэн хүчин чадлаар нь ашиглах боломж бүрдүүлж байна.

Дүгнэлт

Шинэчлэлийн хэтийн төлөв:

Уян хатан хандлага нь өнгөрсөн үеийн CFSP-н интеграци ба үйл ажиллагааны бодлогыг эрс өөрчилдөг. Европын хөрш орнуудын ардчилсан шилжилт хийх санаа болон гишүүн бүх орныг нэгтгэх зорилго аажимдаа суларч зогсонги байдалд орсон. Харин түүний оронд ЕХ нь гадаад аюул заналхийллийн эсрэг чиглэсэн уян хатан хандлагыг бий болгоход төвлөрч нэгдэл, хамтын ажиллагааны шинэ уян хатан загварыг хөгжүүлэхдээ гуравдагч орнуудыг хамруулдаг. Энэ цаг үетэй зэрэгцэн ЕХ нь ойлголцол зөвшилцөлд хүрч үл чадваас хязгаарлагдмал гишүүн орнуудад чиглэсэн хэтийн интеграци хийх нэг бодлого хэрэгжүүлдэг.

Аюулгүй байдал ба батлан хамгаалахын холбоо нь чухал гурван талбарт үйл ажиллагаа явуулдаг: аюулгүй байдлын холбоо, батлан хамгаалах холбоо ба ЕХ-НАТО хамтын ажиллагаа. Энэ нь ЕХ-ны гадаад, дотоод эрсдэлүүд болон сорилтуудыг даван туулах уян хатан хандлагын бодлогыг дэмждэг.

Уян хатан хандлага гэдэг нь “self-assertion” буюу “өөрийгөө баталгаажуулах”, “military empowerment of third countries” буюу “гуравдагч орны цэргийн хүчийг нэмэгдүүлэх”, “digital sovereignty” буюу “тоон тусгаар тогтнол”, “externalising migration” буюу “дүрвэгсдийг гадагшлуулах” гэсэн нэр томъёотой нягт холбоотой ойлголт юм.

Аюулгүй байдал нь бусад улс орнуудын улс төрийн тогтвортой байдлаас ихээхэн шалтгаалдаг. Иймд ЕХ-ны гадаад ба батлан хамгаалахын бодлогыг хэрэгжүүлэхдээ уламжлалт эдийн засаг, тухайн улс руу чиглэсэн бодлогын арга хэмжээг нөхцөл байдалд тохирсон уян хатан хандлага бусаар авч хэрэгжүүлэх нь зохимжгүй болсныг харуулж байна.

⁵³ https://ec.europa.eu/international-partnerships/home_en

⁵⁴ <http://www.dimiter.eu/Eurlex.html>

⁵⁵ https://ec.europa.eu/growth/industry/international-activities/cooperation-regions-and-international-bodies/eastern-partnership_en

⁵⁶ https://eeas.europa.eu/diplomatic-network/european-neighbourhood-policy-enp/330/european-neighbourhood-policy-enp_en

Ном зүй

1. Берри Бузан. (орчуулагч Л.Оюунгэрэл). Ард, түмэн, айх аюул. УБ., 1999 он
2. ОУПХ болон ЗХАХТЖТ – Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт, 2003
3. Barry Buzan Department of International Studies, University of Warwick. Peace, Power, and Security: Contending Concepts in the Study of International Relations.
4. Annegret Bendiek “A Paradigm Shift in the EU’s Common Foreign and Security Policy: From Transformation to Resilienc” RP 11 October 2017 Berlin
5. Mark Leonard, Why Europe Will Run the 21st Century (London, 2005)
6. Mogherini’s presentation of the Global Strategy for the EU’s security architecture can be found here: https://ec.europa.eu/germany/news/mogherini-stellt-globale-strategie%C3%BCr-die-eu-sicherheitsarchitektur-vor_de (accessed 23 August 2017).
7. <https://www.britannica.com/topic/European-Union>
8. <https://niss.gov.mn/archives/1969>
9. <https://www.investopedia.com/terms/e/europeanunion.asp>
10. https://fpi.ec.europa.eu/what-we-do/common-foreign-and-security-policy_en
11. https://european-union.europa.eu/principles-countries-history/history-eu/eu-pioneers/jean-monnet_en
12. https://ec.europa.eu/international-partnerships/home_en
13. <http://www.dimiter.eu/Eurlex.html>
14. https://ec.europa.eu/growth/industry/international-activities/cooperation-regions-and-international-bodies/eastern-partnership_en
15. https://eeas.europa.eu/diplomatic-network/european-neighbourhood-policy-enp/330/european-neighbourhood-policy-enp_en

ЕВРОПЫН ХЭЛНИЙ БОДЛОГО МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХЭЛ СУРГАЛТАД ТУСАХ НЬ

М.Одонтуяа МУИС, ШУС, Европ судлалын тэнхим

Түлхүүр үгс: Хэлний бодлого, чадамж, олон хэл, соёл, шатлал, түвшин

Хэлний бодлого нь гадаад хэлний сургалтын урьдач нөхцөл, гадаад хэл сургах зүйн судалгааны талбар болдог ба тухайн улс орон ямар гадаад хэл зааж сургах нь боловсролын бодлого тодорхойлох төв байгууллагын шийдвэрээс шалтгаалсаар ирсэн үнэн билээ. Хүн ямар гадаад хэл сурч эзэмшин хэрэглэх нь хувь хүний хүсэл сонирхол, сонголтоос илүүтэйгээр нийгэм, эдийн засаг, улс төрийн хүчин зүйлсээс шалтгаалдгийг зарим эрдэмтэд судалсан байдаг (Krumm 2016). 1980-аад оноос хэлний бодлогыг шинжлэх ухааны судлагдахуун мөн хэмээн судалж эхэлсэн байдаг ч гадаад хэлний сургалт, боловсрол судлалын хүрээнд хэлний бодлого хэмээх нэр томъёо нь харьцангуй шинэ ухагдахуун юм. Судлаач Крист (Christ 1991) тухайн нэг хэлний асуудлыг авч үзэх хэлний бодлого (intralingual), олон хэлний асуудлыг авч үзэх хэлний бодлого (interlingual) хэмээн ангилах санал дэвшүүлж байсан боловч одоог хүртэл энэхүү ухагдахууныг нарийн зааглалгүй хэрэглэж байна.

Европын их дээд сургуулиуд кредит системд шилжсэнтэй холбоотойгоор оюутан суралцагчдын хэлний чадамжийг нэгдсэн шалгуураар үнэлэх хэрэгцээ шаардлага бий болсноор Европын хэлний нэгдсэн бодлогын үндэс тавигдсан ажээ. 1975 оноос гадаад хэлний чадамжийг үнэлэх босго түвшнийг тодорхойлон, боловсруулсан бөгөөд хэлний бодлогын тулгуур баримт бичиг 2001 онд батлагдсан ба 2020 онд уг баримт бичгийн “Дагалдах боть” гарснаар Гадаад хэл сургалтын үйл явцад “Хувьсгал” гарав хэмээн дэлхий дахинаа хэлэлцэж байна. Энэхүү бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн талаар уг илтгэлд авч үзэх юм.

Language policy is a prerequisite for foreign language learning and a field of research in foreign language education, and it is a fact that the decision of the central organisation determining education policy has always depended on which foreign language a country should teach. Some scholars have studied that the decision of which foreign language a person learns and uses depends more on social, economic and political factors than on individual preferences and choices (Krumm 2016). Language policy has been studied as a scientific topic since the 1980s, but the term language policy is a relatively new concept in the field of foreign language teaching and education. The researcher Christ (Christ 1991) proposed a classification of language policy to consider the problem of one language (intralingual) and language policy to consider the problem of several languages (interlingual), but until now this term has been used without precise boundaries.

In 1971, when European universities moved to the credit system, there was a need to assess students' language skills against common criteria and the basis for European language policy was established. In 1975, the threshold level for the assessment of foreign language skills was defined and developed, and in 2001, the supporting document for language policy was adopted. In 2020, with the publication of the "supplementary volume" of the document, the world is talking about a "revolution" in the foreign language teaching process. The report will look at the implementation of this policy document.

Өнөө үед олон хэл, соёлын бодлогоо тодорхойлоод амжилттай хэрэгжүүлж байгаа нь Европын зөвлөл, түүний гишүүн улс орнууд байна. Европын зөвлөл нь 70-аад оноос эхлэн насанд хүрэгчдэд гадаад хэл заан сургахад нийтээр мөрдөх нэгдсэн стандарт, тогтолцоо зайлшгүй хэмээгээд үе шаттай олон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд, гадаад хэл суралцагчийн хэлний чадамжийн “босго түвшин”-ий хөтөлбөрийг Уилкинсийн утга-үүргийн (functional-notional approach) хандлагад суурилан боловсруулан гаргасан аж (Wilkins 1976). Ийнхүү гадаад хэл суралцагчдын хэрэгцээнд үндэслэн гадаад хэлний сургалтын зорилгыг тодорхойлох, хөтөлбөр төлөвлөгөө боловсруулахад багш сургагч, сургалт зохион байгуулагч нарт удирдамж, зөвлөмж болохуйц гарын авлага гарсан нь энэхүү үйл явцыг шинэ шатанд гаргажээ (Trim 2014). 1990 оны шинэ хувилбарт нь нийгэм соёлын, стратегийн чадамжийн талаар нэмэгдсэн байна (CEFR 2001). Цаашилбал, уг үйл явц улам бүр өргөжин тэлж Европын иргэн, өөрийн эх хэлнээс гадна хоёроос гурван гадаад хэл сурах хэрэгтэй гэх цоо шинэ нөхцөл байдал үүссэнээр гадаад хэл сурах, сургах, үнэлэх “нэгдсэн хүрээ”-г Европ дахинд улам бүр төгөлдөршүүлэх асуудал урган гарч ирсэн байна (Figuera 2012).

Баримт бичгийн эхний төсөл 1996 онд гарсан ч, нэмж сайжруулсан хувилбарыг “Шинэ Европын төлөө хэл сурахуй” (Language Learning for a New Europe) ОУ-ын хурал дээр 1997 онд танилцуулжээ. Хэрэглэгчдийн гарын авлага зэргийг сайжруулсны эцэст 2001 онд “Европын олон хэлний суурь хөтөлбөр: Сурах, Сургах, Үнэлэх” хэлний бодлогын баримт бичиг эцэслэн гарчээ. Ийнхүү нийт Европын ардчилсан төрийн иргэний ухамсрыг дээшлүүлэх, Европын олон улс үндэстний хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцан ойлголцлыг төлөвшүүлэх, эв нэгдлийг бэхжүүлэх, хэл соёлын аливаа бэрхшээлгүйгээр уламжлал, соёлоо хадгалан үлдэх, хэл соёлын салбарт хамтран ажиллах, хүн амын шилжилт хөдөлгөөнийг хялбаршуулах үүднээс Европын хэлний нэгдсэн бодлогыг тодорхойлсон байна. Энэхүү бодлогын зорилгоос гадна багш, хэл суралцагч нарт хэлэхүйн үйлүүдийг хэрхэн, яаж үйлдэх, хэл сурах, эзэмшихүйн талаарх ойлголт, мэдлэгтэй байх, аливаа шинэ хэл сурах явцад хэлэхүйн үйлд суралцах дараалал, хэл сурах зорилго тодорхой байхаас гадна сурах үйл явцын ахицыг нотлох, өөртөө, бусдад хэл сурахад нь туслах арга замыг нь тусгасан байна.

Энэхүү бодлогын баримт бичиг нь өргөн хүрээтэй буюу хэлний цогц чадамж, мэдлэг, дадал, ур чадварын бүхий л түвшнийг хамарсан, тодорхой, ил тод, уялдаа холбоотой байхын сацуу агуулгын дотоод зөрчилгүй, нээлттэй буюу агуулгыг өргөтгөх, нягтруулах бүрэн боломжтой, уян хатан, ямар ч нөхцөлд хэрэглэхүйц, хүн бүрд ойлгомжтой бөгөөд хэрэгжүүлэхэд хялбар, догматик шинжгүй буюу хэл шинжлэл болон боловсролын ямар нэг онолыг шүтээгүй байна гэжээ. Бодлогын баримт бичиг гарснаас хойш эрдэмтэн судлаачид, багш сурган хүмүүжүүлэгч нар алдаа оноог нь дэнслэн тухайлсан эрдэм шинжилгээний хурал, дугуй ширээний ярилцлага өрнүүлэн хэлэлцэж байв.

Уг зөвлөмж нь эрдэмтэн, судлаач, хэлний мэргэжилтнүүдэд хэл сурах үйл, түүнд суралцагчдыг хэрхэн сургах, тэдний хэр сурсныг нь бодитой үнэлэх зэргийг нарийвчлан авч үзэж цогцоор нь тодорхойлон, жинтэй хариулт өгснөөрөө геополитикийн ач холбогдолтой, хэл сурах, сургах, үнэлэх асуудлыг бодит амьдралтай уялдуулах хандлагын дагуу (real-life oriented approach) нэр томъёо, ухагдахуун, хэрэгжилт нь бүх нийтэд ойлгомжтой, хүртээмжтэйгээрээ хэрэглээний хэл шинжлэлийн салбарт онцгой ач холбогдолтой бөгөөд нэгэн төрлийн хөгжлийн хурдасгуур болсон хэмээн Фигуэрас (2012) үнэлжээ.

Мөн боловсролын бодлогын баримт бичиг болохын хувьд гадаад хэлний чадамжийг хэмжигдэхүйц боломж хэмээн үзэж, хэлний бодлого болоод мэргэжлийн сургах зүйн салбарт олон улсад хүлээн зөвшөөрөгдөх болсон юм. Хэлний чадамжийг шаталсан түвшинд хуваах санааг хөгжүүлснээрээ олон улсад сургах зүй, гадаад хэл сургалтын

бодлогыг шинэ шатанд авчирсан гэж Фоллмер (Vollmer 2003) дүгнэсэн аж. Учир нь гадаад хэлний чадамжийг шаталсан түвшин бүрд сургалтын зорилго болохуйцаар тодорхойлсон тул гадаад хэл сургалтын салбарт хамтран ажиллах, хэлний сорилго, сургалт, төгсөлт зэрэгт нэгдсэн түвшинтэй байж, харьцуулах боломжийг олгосон аж.

Европ дахинд олон хэлний бодлого хэрэгжих үндсэн үзэл баримтлал нь олон хэлний үзэл (Plurilingualism) мөн. Энэхүү үзэл баримтлалыг зөвлөмжид тусгахдаа хэлний бодлогын бодит байдал буюу олон хэлийг төгс эзэмших нь чухал бус, хэл эзэмшсэн түвшин нь хэлэхүйн чадамжийн бүрэлдэхүүн хэсгүүдэд харилцан адилгүй байж болно гэсэн үзэл бодлыг дэвшүүлсэн нь ихээхэн ач холбогдолтой болсон ажээ. Олон хэлтэй байх гэдэг нь олон хэлийг төгс эзэмшихдээ бус, богино хугацаанд аль нэг гадаад хэлээр хэсэг бүлэг чадварыг эзэмших, түүнийг нь үнэлэх, аливаа хэлийг эх хэлтний хэмжээнд сурах нь гадаад хэл сурахуйн эцсийн зорилго биш зэрэг нь хөтөлбөрийн тулгуур, дэвшилтэт үзэл санаа болсон юм. Гадаад хэл сургалтын салбарт эерэг үр дүн авчирсан ажил нь уг баримт бичгийн амин сүнс (Martyniuk&Noijons 2007) болсон үйлээр баримжаалах хандлагад (an action oriented approach) суурилсан шатлал (scales) ба түүний “чадна” илэрхийллүүдийг (can do statements) маш тодорхой, ойлгомжтой, дэлгэрэнгүй томъёолсон явдал билээ. Энэхүү илэрхийллүүд нь туршилт судалгаанд үндэслэсэн, хам сэдвээс үл хамааран хэлний үр чадварыг тодорхойлох товч, ил тод, эерэг утгатай, богино өгүүлбэрүүд юм. Ийнхүү сургалтын зорилго тодорхойлох, агуулга хэлбэрийг сайжруулах, хөтөлбөр хөгжүүлэх, үнэлгээний арга зүйд “чадна” илэрхийллүүдийг хэрэглэх болсон нь өндөр ач холбогдолтой төдийгүй цаашид Европ даяар боловсролын нэгдсэн стандартыг нэгэн зүгт хандуулах сайн талтай байв.

Ийнхүү дэлхийн олон улс орны гадаад хэл сургалтын салбарт амжилттай хэрэгжиж, зөвхөн Европын зөвлөлийн гишүүн орнуудад төдийгүй, тэдний хэл соёлыг сурч судалж, түгээн дэлгэрүүлж буй бусад бүх улс оронд эх хэл, хоёрдох хэл эзэмшихүй болоод гадаад хэлний сургалтад чиг баримжаа, жишиг болсоор хориод жил болж буй “Европын олон хэлний суурь хөтөлбөр: Сурах, Сургах, Үнэлэх” хэмээх баримт бичгийн нэмж, засан сайжруулсан “Дагалдах боть” 2020 онд хэвлэгдэн гарлаа. Энэхүү боть нь хэлний бодлогын тулгуур баримт бичиг хэвээр байх ба боловсролын стандарт тогтоох, сургалтын бодлого боловсруулах, зорилго, зорилт тодорхойлох, сургалтын агуулга томъёолох, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, нэгдсэн шалгуурын үндэслэл, шалгалт, мэдлэгийн түвшнийг тодорхойлох, өөрийн болон гаднын үнэлгээ хийх, сурах бичиг боловсруулахад үндэс болох юм. Өмнөх боть нь суралцагчид А1 түвшинд хэрхэн хүрэх нь тодорхойгүй, шатлал хоорондын уялдаа холбоо муу, зарим шатлалд С1, С2 түвшний илэрхийлэл байхгүй, эх хэлтэн, уугуул хэлтэнг төгс стандарт гэж үзсэн зэрэг сул талтай байв. Түүнээс гадна олон хэл, соёлын боловсролыг “Хүний хөгжлийн нэг хэсэг” гэдгийг дутуу авч үзсэн хэдий ч хэл суралцагч, хэрэглэгчдийн гадаад хэлний чадамжийг А1-С2 буюу зургаан түвшинд 54 төрлийн шатлалаар тодорхойлж, хэлний чадамжийг “... чадна”-ээрэг илэрхийллээр тоочсоноос гадна олон хэл, соёлын боловсролыг тунхагласан, гадаад хэл сургалтын хөтөлбөрийн удирдамж, зөвлөмж болж чаджээ. Түүгээр барахгүй гадаад хэл суралцагчийн зөвхөн сургалтын амжилт, үр дүнг бус, тэдний сурах үйл явцыг нь үнэлэх, хэлэхүйн чадамжийг нь чадвар тус бүрд нь хэсэгчлэн үнэлэх боломжтой болсон нь ахиц дэвшлийг авчирсан ажээ.

ЕОХСХ-ийн анхны хувилбарыг хэрэгжүүлэх явцад засан сайжруулж ирсэн бөгөөд 2014 оноос эхлэн олон орны эрдэмтэн судлаач нар нэгдэн нэмж засаж сайжруулан гаргах нь зүйтэйн улмаас 1500 гаруй эрдэмтэн, багш, судлаач нар, 300 гаруй их дээд сургууль, боловсролын хүрээлэн, байгууллага 100 гаруй удаагийн сургалт семинар, баталгаажуулах ажил хийж, 60 төрлийн туршилтын төслөөр хүчин төгөлдөр байх чанарыг хангаснаар 2018 онд “Дагалдах боть”-ийн эхний хувилбар гарч 2020 онд эцэслэн хэвлэгдсэн байна. Одоогоор

англи, герман, франц, итали, араб, испани, турк хэлнээ хөрвүүлэн гаргасан ба Европын зөвлөлийн улс орнууд дагалдах ботийг орчуулах ажилд шуурхайлан оржээ.

Өмнөх хувилбараас өөрчлөгдсөн томоохон өөрчлөлтүүдийг дурдвал:

1. А1 түвшний урьдал буюу А0
Зургаан түвшинт шатлалууд хэрхэн яаж хүрэх нь тодорхойгүй байсан учир зарим нэг шатлалд А1 урьдал түвшнийг шинээр томъёолсон ба Япон хэлний стандартын рге А1 түвшний илэрхийллүүдийг авч ашигласан.
 1. "... чадна" илэрхийлэл нь цар тахлын нөхцөл байдалтай холбоотой, орчин үеийн техник, технологийн үг хэллэгийг тусгаснаараа илүү бодитой болсон.
 2. Шатлалын төрөл 54 байснаас 80 болж нэмэгдсэн ба тухайн нэг түвшин дотор илүү нарийсаж "+" (B1+) түвшинтэй болсноор ялгамжтай байдал нэмэгдсэн байна.
 3. Авиа зүй, дуудах зүйн тухайд өмнөх хувилбарт хэл шинжлэлийн чадамжийн бүрэлдэхүүн хэсэгт хамруулан дурдах төдий байсан бол дагалдах ботид авиа дуудлага, аялга, өргөлтийн илэрхийллүүдээс гадна аялгууг ялгах, бусдад ойлгомжтой байх үүднээс хичээх зэрэг шатлалууд орсон.
 4. Дагалдах ботид зуучлах үйлийн 19 шатлал шинээр нэмэгджээ. Энэ нь харилцааг (mediation of communication) зуучлах, талуудыг эвлэрүүлэх, холбох, зохицуулахаас гадна, хам сэдвийн (mediation of contexts) мэдээллийг дамжуулах, тайлбарлах, энгийнчлэх, шилжүүлэх, текстийг (mediation of texts) хөрвүүлэх, орчуулах, хэлмэрчлэх үйлийг хамрах аж. Зуучлах үйлийг хэл сурах, сургах, хэлээр харилцах, хэлийг хэрэглэх үйл явцын тулах цэг мөн хэмээн тодорхойлсон байна.
 5. Гадаад хэлний сургалтад харилцах үйлийн үүрэг, ач холбогдлыг тус хөтөлбөрт авч үзэхдээ хувь хүний сэтгэл хөдлөлийн болон олон соёлын туршлагыг харгалзаж үзээгүй, гадаад хэлний хичээл дээр уран зохиолын бичвэр уншихын давуу талын талаар огт дурдаагүй гэх зэргээр Брэдэлла (2003), Крумм (2003), Шмэнк (2004) нар нэгэнтээ дүгнэж байжээ. Тиймээс шинэ ботид олон соёлын чадамжийг олон үндэстэн ястантай харилцах үед соёлын мэдлэг чадвартай байх, туршлагатай байх талаар нэмж сайжруулсан байна.
 6. Уран зохиол-зохиол унших, зохиолынхоо талаар ярих, дүн шинжилгээ хийх, шүүмж хэлэх.
 7. Сургалтын онолын үндэслэл дутуу байгаа нь гадаад хэлний хичээлийн арга зүйд буруугаар нөлөөлөх муу үр дагавартай, тухайлбал хичээлийг зөвхөн гадаад хэл дээр явуулах, ямар ч арга зүйгээр сургаж болно гэх зэрэг нь цаг үедээ нийцээгүй, хэрэгжүүлэхэд төвөгтэй гэж Тенсхоф (2003:187) үзэж байжээ. ЕСХ-ийг хичээлийн арга зүй биш гэж үзэж болох ч гадаад хэл заах арга зүйн хувьд аль нэг онолыг баримтлахгүй гэсэн зохиогчдын багийн хэт ерөнхий байр суурь нь багш, сургагч нарт эргэлзэх, тээнэгэлзэх байдалд хүргэсэн нь буруу юм гэж Шмэнк (2004) үзжээ. Мөн тэрээр, алдаа залруулах арга зүй болоод хэл сурах арга барилын жагсаалтыг эрэмбэ дараагүй, дурын утгаар нь тэнцүү жагсаасан, сургалтад аудио, видео, цахим хэрэгслийг ашиглах тухайд зөвхөн дурдсанаас хэтэрсэнгүй гэж буруушааж байсан учир онлайн ажиллах чадамж-цахим зурвас бичих, Live ажиллах, хэлэлцэх, ярианы болон бичгийн хэлний ялгааг гаргах, теле харилцааны хэрэгслийг ашиглах, хэрэглэх чадвар, мэдээллийг төрөл бүрээр дамжуулах чадвар зэргийг шинэчлэн тусгасан байна.
 8. Дохионы хэлний чадамж-14 шатлалтай цоо шинэ чадамж.
 9. Эх хэлтэн/уугуул хэлтэн стандартыг халсан, хэрэглэгчдийн хэлний чадамжийг харгалзах, тохируулах, жендерийн тэгш эрх харгалзах, тэгш хамран сургах

ЕСХ-ийг нарийвчлан судалж, хэрхэн хэрэгжүүлж буй талаарх өнөөг хүртэл хэвлэгдэн гарсан судалгааны ажлуудыг Мажима (2010) нэгтгэн судлан, ЕСХ-ийг

- хэлний сургалтын хөтөлбөрийн зорилго тодорхойлоход,
- судлагдахууны болон нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулахад,
- бүтээлийн хавтсыг суралцагчдыг сэдэлжүүлэх ба үнэлэхэд,
- стандарт сорилго, шалгалт боловсруулахад,
- үнэлж дүгнэхэд,
- сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулахад,
- тэнхим буюу сургалт, судалгааны нэгжийг хөгжүүлэхэд хэрэглэж, хэрэгжүүлж байгааг дүгнэжээ.

Европын суурь хөтөлбөрөөс юун түрүүнд авч хэрэгжүүлсэн хоёр зүйлийн нэг нь хэлний ур чадварын ерөнхий шатлал бөгөөд үүнийг шалгалт, тестийн төвүүд шууд авч хэрэгжүүлсэн байна. Нөгөө нэг нь олон жилийн судалгааны үндсэн дээр боловсруулсан хэлэхүйн чадамжийн ерөнхий шатлал, 53 дэд шатлалын бүх илэрхийллүүдийг гадаад хэл сургалтын зорилго тодорхойлох, суралцагчдын хэлний ур чадварын түвшнийг тогтоох, өгөгдөл ба нөхцөл байдлыг тодруулах, сургалтын үр дүнг тооцох зэрэг төрөл бүрийн хам нөхцөлд болон зорилго, хэрэгцээ шаардлагаар авч хэрэглэх болжээ.

Дүгнэлт

Монгол Улс дахь гадаад хэлний сургалтын өнөөгийн нөхцөлд байдалд дүн шинжилгээ хийхийн хамтаар Европын хэлний бодлогыг судлан Монгол дахь гадаад хэлний боловсролыг тал бүрээс нь буюу гадаад хэл сургалтын бодлого, хэтийн төлөв, суралцагчдын шилжилт хөдөлгөөн, төгсөгчдийн ажлын байрны даяаршил, гадаад хэлний мэргэжлийн боловсрол, түүний үр дүнг харьцуулахуйц байх, үнэлгээний уян хатан байдал, ил тод шалгуур, багш нарыг сургах, чадавхжуулах асуудал зэргийг судлан судалгааны үр дүнг нийтэлж гадаад хэлний сургалтын нэгдсэн жишиг, стандарттай болох хэрэгцээ шаардлагатай байна.

Ном зүй

Монгол хэлээр:

1. Батринчин П, Оюунхорол Д. “Даяаршил ба XXI зууны дээд боловсролын хөгжлийн чиг хандлага” сэдэвт ОУЭШБХ-ын илтгэлийн эмхтгэл, УБ., 2011. 7-31-р тал
2. Э.Равдан нар. “Европын олон хэлний суурь хөтөлбөр: СУРАХ, СУРГАХ, ҮНЭЛЭХ” МУИС, ГХСС, Улаанбаатар 2012 он.

Гадаад хэлээр:

1. Baldegger, Markus, Müller, Michael & Schneider, Günther, Näf, Anton (1980). Kontaktschwelle Deutsch als Fremdsprache. München: Langenscheidt.
2. Coste, Daniel, Courtillion, Janine, Ferenzi, Victor, Martins-Baltar, Michel & Papo, Eliane (1976). Un Niveau-seuil. Paris: Hatier.
3. Council of Europe (2001). Common European Framework of Reference for Languages: Learning, Teaching, Assessment (CEFR). Cambridge University Press.
4. Figueras, Neus (2012). The impact of the CEFR. ELT Journal Volume 66/4, Special issue, The Janus Papers. Oxford University Press. 477-485.
5. House, Juliane (2003). “Der Gemeinsame europäische Referenzrahmen für Sprachen-Anspruch und Realität“. In: Bausch, Karl-Richard, Christ, Herbert, Königs, Frank G. & Krumm, Hans-Jürgen (Hg.), 95-104.
6. Hulstijn, J. (2007). The shaky ground beneath the CEFR: quantitative and qualitative dimensions of language proficiency. The Modern Language Journal 91/4: 663–667.
7. John L.M. Trim “Modern Languages in the Council of Europe 1954-1997”. Language Policy Division, Strasbourg. http://www.coe.int/t/dg4/linguistic/Publications_en.asp 2014.1.24

8. Kleppin, Karin (2003). „Der Gemeinsame europäische Referenzrahmen für Sprachen: Ärgernis oder Fortschritt?“ In: Bausch, Karl-Richard, Christ, Herbert, Königs, Frank G. & Krumm, Hans-Jürgen (Hg.), 105-112.
9. Leupold, Eynar (2003). „Der Gemeinsame europäische Referenzrahmen: On peut vivre sans, mais vivra-t-on mieux avec?“ In: Bausch, Karl-Richard, Christ, Herbert, Königs, Frank G. & Krumm, Hans-Jürgen (Hg.), 135-139.
10. Majima, Junko “Impact of can-do statements/ CEFR on language education in Japan: On its applicability”. Can do statements in language education in Japan and beyond. Eds. Maria Schmidt, et al. Tokyo: Asahi Press, 2010. 49-65.
11. Martyniuk, W. and J. Noijons. 2007. Executive Summary of Results of a Survey on the Use of the CEFR at National Level in the Council of Europe Member States. Доорх холбоосоор үзнэ ҮҮ.
http://www.coe.int/t/dg4/linguistic/Source/Survey_CEFR_2007_EN.doc
12. Meijer, Dick & van Kleunen, Ella (2006). „Wie kann ich wissen, was ich kann? Selbsteinschätzung mit dem elektronischen Sprachenportfolio.“ Fremdsprache Deutsch 34, 22-35.
13. Quetz, Jürgen (2003). “Der gemeinsame europäische Referenzrahmen: Ein Schatzkästlein mit Perlen, aber auch mit Kreuzen und Ketten“. In: Bausch, Karl-Richard, Christ, Herbert, Königs, Frank G. & Krumm, Hans-Jürgen (Hg.), 145-155.
14. Raupach, Manfred (2003). „Wir stellen nur Fragen, wir geben keine Antworten. Der Gemeinsame europäische Referenzrahmen: ist das mehr drin als man denkt?“. In: Bausch, Karl-Richard, Christ, Herbert, Königs, Frank G. & Krumm, Hans-Jürgen (Ed.). 156-163.
15. Tönshoff, Wolfgang (2003). „Referenzrahmen: Zwischen Ansprüchen und Erwartungen.“ In: Bausch, Karl-Richard, Christ, Herbert, Königs, Frank G. & Krumm, Hans-Jürgen (Hg.), 180-191.
16. Van Ek, Jan, & Trim, John L.M. (1991). Waystage 1990. Cambridge: Cambridge University Press.
17. Vogt, Karin (2004). “Der Gemeinsame Europäische Referenzrahmen für Sprachen: Inhalte, Ziele, Diskussion.“ Der fremdsprachliche Unterricht-Englisch 38/3, 48-51.
18. Vollmer, Helmut J. (2003). „Ein gemeinsamer europäischer Referenzrahmen für Sprachen: Nicht mehr, nicht weniger.“ In: Bausch, Karl-Richard, Christ, Herbert, Königs, Frank G. & Krumm, Hans-Jürgen (Hg.), 192-206.
19. Wilkins, D.A. (1976). Notional Syllabuses. Oxford: Oxford University Press.
20. Krumm, H.-J. (2016). Sprachenpolitische, bildungspolitische und gesellschaftliche Rahmenbedingungen . In: Burwitz-Melzer.E., Mehlhorn, G., Riemer, C., Bausch, K.-R., Krumm, H.-J., Hg. Handbuch Fremdsprachenunterricht, 6.Aufl. Tübingen, 45-51.
21. Christ, H. (1991). Sprachenpolitische Perspektiven. In: Bausch, K.-R., Christ, H., Hüllen, W., Krumm, H.-J., Hrsg. (1991): Handbuch Fremdsprachenunterricht, 2.Aufl. Tübingen, 100-105.

**СОЁЛ ИРГЭНШЛИЙН ЯЛГАА БА НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ ХӨГЖИЛ:
ЕВРОПЫН ХОЛБОО, БРИТАНИ, МОНГОЛ УЛСЫН ЖИШЭЭН ДЭЭР**

Т.Есүхэй МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш

О.Мөнхжаргал МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш

Abstract

Establishing and strengthening local self-government has been a challenge as well as a need for developing countries. For European countries, local self-government has a very ancient history and many years of experience, and it has a rich tradition that has been widely studied by social and political science researchers in Europe.

From the terms related to the local self-governing institutions and to the problems that the local self-governing organizations have been responsible for, they are closely related to the history of the ancient, settled civilizations of Europe. For Mongolians, who combine their settled and nomadic lifestyles, to strengthen their local self-government, decentralize power, and strengthen democracy, they have studied the experiences of other countries, especially developed European countries, and copied models that can be used. As a researcher, we hypothesized that the difference in civilizations could be the cause of the struggle for local self-government in nomadic Mongolia.

It can be seen from the successful systems that the local self-government is particularly compatible with the needs of the citizens of the country, the traditional form of governance, and the state structure. From the good examples of local self-government, the current classical model is exactly in line with what was created in a settled civilization. The competences of the European and British local governments have been similar to the old landowners has it, such as infrastructure, water supply, roads and bridges, and agriculture. Therefore, when strengthening local self-governance in Mongolia, it is necessary to consider the natural origin, development process, and basic conditions mentioned above and adapt it to Mongolia's characteristics.

Нутгийн өөрөө удирдах ёсыг судлах, улс орондоо бэхжүүлэн хөгжүүлэх нь хөгжиж буй улс орнуудын хувьд хэрэгцээ шаардлагын зэрэгцээ, сорилт бэрхшээл байсаар ирсэн билээ. Европын улс орнуудын хувьд нутгийн өөрөө удирдах ёс нь нэн эртний түүхтэй, олон жилийн туршлагатайгаас гадна Европ дахь нийгэм, улс төрийн шинжлэх ухааны судлаачид олон талаас нь өргөн дэлгэр судалсаар ирсэн баялаг уламжлалтай ажээ.

Нутгийн өөрөө удирдах байгууллага, институтийг нэрлэж ирсэн нэршлүүдээс эхлээд нутгийн өөрөө удирдах байгууллагын эрхлэн хариуцаж, бие дааж шийдвэрлэж ирсэн асуудлуудыг харьцуулан судалж үзвэл Европын эртний суурин соёл иргэншлийн түүхтэй нь нягт уялдаа холбоотой болох нь харагдаж байна. Суурин ахуй, нүүдэлчин ахуйгаа хослуулан буй монголчуудын хувьд нутгийн өөрөө удирдах ёсоо бэхжүүлэх, эрх мэдлийн төвлөрлийг сааруулж, ардчиллыг бэхжүүлэх зорилгоо биелүүлэхдээ бусад улс орнуудыг, ялангуяа Европын өндөр хөгжилтэй орнуудын туршлагыг судлан, ашиглаж болох загвараа хуулбарлан ашиглаж ирсэн нь зарим нөхцөлд үр дүнгээ өгөхгүй байгаа нь иргэншлүүдийн ялгаатай байдал нөлөөлж байж болзошгүй хэмээн судлаач бид таамаглан энэхүү судалгааг хийж үзэх шалтгаан болсон юм.

Европ, Британийн улс төрд онцгой нөлөө бүхий газрын эзэд, вант улсууд (kingdom) зэрэг Монголын төрт улс, засаглалын тогтолцоонд байгаагүй ойлголтууд нутгийн өөрөө удирдах ёсонд онцгой нөлөөтэй байж ирсэн нь Европын сайн туршлагыг Монголд шууд нэвтрүүлэхэд хүндрэл бэрхшээл учруулж байх бүрэн боломжтой ажээ.

Жишээ татахад Британийн нутгийн өөрөө удирдлагын анхны нэгжүүд нь анх Ромын эзэнт гүрний үед суурин газруудаа municipium хэмээн нэрлэж байгуулж байснаас үүдэлтэй⁵⁷ бөгөөд энэ үг нь өдгөө суурин газрын захиргаа, удирдлагын нэгжийн утгыг илэрхийлэн хүмүүсийн харилцаанд ашиглагдаж байна. Өнөөгийн Их Британийн нутгийн өөрөө удирдлагын нэгжүүд болох county, borough, town, parish зэрэг нь тэдний суурин иргэншилтэй нь салшгүй холбоотой ойлголтууд юм. Borough нь 1800-аад оны үед “бэхлэгдсэн газар”, “хамгаалагдсан газар” гэсэн утгыг илэрхийлдэг байжээ.⁵⁸ Borough нь parish-уудаас бүрдэх бөгөөд энэ нь нэг сүмд очдог, харьяалагддаг хүмүүсийн нэгдэл (community) юм.

Мөн Норманы байлдан дагууллаас үүдэлтэй удирдлагын хэв маяг Британийн нутгийн удирдлагын түүхээс тод харагддаг. Газрын эзэд буюу лордууд нь өөрийн эзэмшиж буй газар орондоо эдийн засаг болон бусад асуудлаар асар их эрх мэдэлтэй байсан нь орон нутгийн шүүхийг зохион байгуулж, өөрийн гүйцэтгэгч (bailiff)-ийг томилж түүгээрээ өөрийн засаглал, эрх мэдлээ хэрэгжүүлдгээс харагдаж байна.⁵⁹ Түүнчлэн газрын эзэд өөрийн эдлэн газрынхаа дэргэд сүмүүд байгуулж, өөрийн болон хамжлагат иргэд, оршин суугчдын шашин шүтэх, итгэх бишрэх хэрэгцээг хангаж өгдөг байжээ.⁶⁰ Цаашлаад газрын эзэд тухайн газар дээрх ундны ус, байгалийн баялаг, орон сууц, иргэдийн амь зуулга, амьжиргаанд онцгой нөлөөтэй байсан тул өнөөгийн нутгийн өөрөө удирдлагын хэв шинжийг агуулсан бие даасан удирдлагын тогтолцоог бий болгоод байжээ.

XI зуунаас уламжлагдан ирсэн энэхүү сэтгэлгээ, удирдлагын хэв маягийг өнөөгийн Европын холбооны улсуудын бий болгосон нутгийн өөрөө удирдлагын тогтолцооноос бүрэн олж харах боломжтой ажээ. Европын холбооны гишүүн 27 улсын нутгийн өөрөө удирдах институтуудын эрхлэх асуудлуудыг нээлттэй эх сурвалжуудаас шүүж, түгээмэл дурдагдсан асуудлуудыг нэгтгэж авч үзэхэд дараах нөхцөл байдал ажиглагдаж байна.

Хүснэгт 1.	
	НӨУБ нь хариуцаж буй хувь
Газар болон хот төлөвлөлт	85%
Боловсрол (сургууль, цэцэрлэгийн барилга)	85%
Усны хангамж	74%
Зам, гүүр, цэцэрлэгт хүрээлэн	74%
Ус зайлуулах тогтолцоо	63%
Соёл, аялал жуулчлал	63%

⁵⁷ A. Birley, *Life in Roman Britain* (London: Batsford, 2nd edn, 1981), p. 22.

⁵⁸ J. Clarke, *A History of Local Government of the United Kingdom* (London: Herbert Jenkins, 1955), p. 9.

⁵⁹ H. Swanson, *Medieval British Towns* (Basingstoke: Macmillan, 1999), p. 13.

⁶⁰ W. E. Tate, *The Parish Chest: A Study of the Records of Parochial Administration in England* (Cambridge: Cambridge University Press, 1960), pp. 9-10.

Нийтийн тээвэр	67%
Орон сууцжуулах	63%
Хог хаягдал	59%
Орон нутгийн эдийн засаг	59%
Нийтийн хэв журам, иргэдийн аюулгүй байдал	52%
Эрүүл мэнд (Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж)	56%

Дээрх хүснэгтээс авч үзэхэд эртний газрын эздийн бие даан шийддэг байсан асуудлуудаас гадна суурьшмал амьдралд нь үргэлж тулгамддаг чухал асуудлуудыг хамааруулан авч үздэг болох нь харагдаж байна. Мөн нэг сонирхолтой асуудал анхаарал татаж буй нь боловсролын болон эрүүл мэндийн тогтолцооныхоо хүртээмж, дэд бүтэц, барилга байгууламжтай холбоотой асуудлуудыг засгийн газрынхаа эрхэлдэг нэгдсэн тогтолцооноос нь салгаж, нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь эрхэлж хариуцдаг байна. Ингэснээр эрүүл мэнд, боловсролын нэгдсэн бодлого, стандартыг засгийн газраас баталж хэрэгжүүлэх хэдий ч, орон нутгийнхаа онцлогт тохирсон хүртээмжтэй дэд бүтцийг бий болгох нь нутгийн өөрөө удирдлагын хэрэгжүүлдэг үүрэг нь ажээ.

Европын Холбооноос Монгол дахь нутгийн өөрийн удирдлагыг хөгжүүлэхэд нэлээдгүй анхаарч тусалж дэмжиж ирсэн бөгөөд Дархан-Уул аймагт хэрэгжүүлж буй “Найрамдал” төсөл зэрэг маш олон төсөл хөтөлбөрүүдээр дамжуулж санхүүгийн хөрөнгө оруулалт болон арга зүйн туслалцаа үзүүлсээр ирсэн билээ. Монгол дахь нутгийн өөрийн удирдлагын өнөөгийн байдлыг Европын орнууд дахь эртний уламжлалт түүх бүхий нутгийн өөрийн удирдлагын тогтолцоотой харьцуулан авч үзэж, цаашлаад Европын Холбооны орнуудын сайн туршлагыг хуулбарлан авч үзэх гэж оролдох нь зарим талаараа амжилттай болохгүй байж болох юм.

Учир нь монголчуудын засаглал, төрийн байгууллын талаарх уламжлалт ойлголт, итгэл үнэмшил нь нүүдэлчин соёл иргэншилтэй нь салшгүй холбоотой байсаар ирснээс гадна өнөөдрийг хүртэл иргэдийн амьдралын хэв маяг, ертөнцийг үзэх үзэл, хот суурин газраа хэрхэн төлөвлөдгөөс эхлээд улс төрийн үйл байдалд нь хүртэл нөлөөлж иржээ. 2020 оны 12 сарын 24-нд батлагдсан “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулиар засаг захиргааны нэгжүүдийн эрхлэх асуудал, чиг үүргийг нарийвчлан зааж өгч, Европын улсуудын туршлагатай ихэд ойртуулж, ижилсүүлсэн ч орон нутагт буй зарим чухал асуудлууд хариуцах эзэн тодорхойгүй, эсвэл чиг үүрэг нь давхардаж хэтэрхий олон удирдлагатай болох зэрэг асуудлууд гарсаар байна. Жишээлбэл орон нутагт цөөн хүн амтай, алслагдсан сумдын ерөнхий боловсролын сургуулиудын барилга байгууламж, суралцах орчин нь хангалттай биш, стандартад нийцээгүй бөгөөд сайжруулалт, засвар үйлчилгээ нь сонгуулийн циклтэй хамааралтай байсаар байгаа нь нийтлэг дүр зураг болоод байна.

“Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуульд тусгаснаар орон нутгийн өөрөө удирдах байгууллагын эрхлэх чиг үүргийг жагсаавал:

Хүснэгт 2.
Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт
Орон нутгийн өмчийн удирдлага
Орон нутгийн төсөв, албан татвар, төлбөр, хураамж
Орон нутгийн сан
Хүний нөөцийн бодлого төлөвлөлт
Үйлдвэрлэл, хүнс, хөдөө аж ахуй
Хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний усан хангамж
Худалдаа үйлчилгээний зохицуулалт
Орон сууц, нийтийн аж ахуй
Нийтийн тээвэр
Суурин газрын замын хөдөлгөөн, авто зогсоол
Гудамж, талбайн нэр, хаягжуулалт
Нийтийн эзэмшлийн зам, талбай, соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж
Аялал жуулчлалын бодлого, менежмент
Хог хаягдлын менежмент
Оршуулгын газрын зохицуулалт
Төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар
Гал түймэр, үерийн хамгаалалтын байгууламж
Цэвэрлэх байгууламж
Орон нутгийн зам, гүүр
Суурин газрын гэрэлтүүлэг
Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт

Дээрх хүснэгтээс харахад манайх уг хуулийг шинэчлэн найруулж, батлахдаа Европын холбооны улсуудын сайн туршлагаас ихээхэн ач холбогдол өгч дуурайж ашигласан болох нь харагдах боловч Европт үүссэн энэ харилцаа, хаанаас юунаас эхлэлтэйг тооцож үзээгүй байж болзошгүй билээ. Ийм ижил төстэй тогтолцоог бий болгосон байгаа тул Монгол дахь аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг дарга нар газрын эздийн эрхэлж, шийдвэрлэдэг байсан асуудлуудыг эрхэлж, хороо, багийн иргэдийн нийтийн хурал нь parish буюу сүм төвтэй иргэдийн нэгдэл, уулзалтын загварыг авч ашиглаж буй ажээ.

Удирдлага, зохион байгуулалтын хэлбэр, тогтолцоо үр дүнтэй байх эсэх нь тухайн тогтолцоог хэрэгжүүлж буй газар орон, суурь нөхцөл байдал, оролцогч талуудын итгэл үнэмшил, амьдралын хэв маяг, ертөнцийг үзэх үзэл нь ач холбогдолтой байх нь дамжиггүй юм. Жишээлбэл хороо, багийн иргэдийн нийтийн хурал оновчтой, зөв зохион байгуулагдаж, үр дүнтэй шийдвэрүүд гаргаж чадаж байгаа эсэхийг үнэлэх нь битгий хэл тогтмол хуралддаг иргэдийн нийтийн хурлыг олоход бэрх бөгөөд уг иргэдийн нийтийн хурлын талаарх тодорхой статистик мэдээллийг аль ч шатны төрийн байгууллага нэгтгэж гаргаагүй байна. 2022 онд шинэчлэн найруулсан хуулийн дагуу иргэдийн нийтийн хурлаас төдийлөн хамаарахгүйгээр хороо, багийн засаг дарга үйл ажиллагаагаа явуулах боломжтой болгож өгсөн бөгөөд шалтгаан нь иргэд хангалттай идэвхтэй, ирцтэй байдаггүй гэсэн үндэслэл байв. Гэтэл уг иргэдийн нийтийн хурлын анхны загвар болох parish нь монголчуудын төлөвшүүлэхийг зорьсон шууд ардчиллын зарчмуудыг агуулдаг байжээ. Мөн төдийгүй тогтмол сүм дээрээ цугларч мөргөлөө үйлдэхээс гадна өөрсдөдөө нийтлэг тулгамдаж буй асуудлаа олонхын саналаар шийдвэрлэж ирснээс улбаатай тогтолцоо юм⁶¹.

Монгол дахь нутгийн өөрөө удирдлагын тогтолцооны хамгийн амжилттай, иргэдийн оролцоог хамгийн өндөр түвшинд хангаж чаддаг зохицуулалт нь Орон нутгийн хөгжлийн сан бөгөөд уг сан нь иргэдийн санал асуулгад суурилан иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн ажлуудыг санхүүжүүлж хэрэгжүүлдэг билээ. Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүждэг асуудлуудыг ерөнхийлөн нэгтгэвэл авто зам, гэрэлтүүлэг, халуун ус, худаг, спорт заал, дотуур байрны их засвар, бэлчээр хамгаалах хашаа, худаг ус, мал угаалгын газар⁶² зэрэг асуудлууд иргэдийн олонхын саналыг авдаг хэмээн мэдээлжээ.

INTERNATIONALISATION OF HIGHER EDUCATION IN SOME MEMBERS OF THE EU

ODGEREL BATSAIKHAN, KHOSBAYAR NYAMSUREN, ZOLZAYA GANKHUYAG

**SOFT POWER BETWEEN THE EUROPEAN UNION AND MONGOLIA: A CASE OF
GERMANY AND MONGOLIA**

UUR TSAIKH BATBAYAR

THE EUROPEAN UNION AND MONGOLIA: RELATIONS AND COOPERATION

EGIIMAA TSOGT

ХАВСРАЛТ ӨГҮҮЛЭЛ**ЕРРОПЫН ХОЛБООНЫ ДОТООД ЗАРИМ ЗӨРЧИЛ: ГАРЗ, ОЛЗ**

С.ОДХҮҮ

*Доктор (Ph.D), профессор, Отгонтэнгэр Их сургууль***Abstract**

In recent years the European Union has been facing development challenges and difficulties. Mongolia, with its unique geopolitical position, is a "valuable partner" in Asia for the EU, which closely observes its policies and activities, is concerned about internal problems and provides other support for joint solutions.

We express that the main causes of the internal conflict are the different political positions of some member countries, the difference in the living standards of the West and East member countries, the wave of immigrants and refugees and the problems that need to be solved around it. In addition, the internal crisis is believed to have been contributed by the developmental differences of the Member States economic potential, flow of migrant workers, social security systems, energy crisis, climate change and the impact of the Covid-19 pandemic.

Хураангуй.

Европын холбоо \ЕХ\ түүхэн замналынхаа явцад амаргүй замыг туулж, олон хүндрэл бэрхшээлтэй тулгарсаар ирсэн. Ялангуяа хувьсамтгай, тодорхойгүй, ээдрээ төвөгтэй орчин үед өмнө нь бодож төсөөлөөгүй шинэ нөхцөл байдал үүсэх, гэнэтийн гаргалгаа, огцом шийдлийн хувилбар сонгох болоод байна. Монгол Улс нь геополитикийн давтагдашгүй байршилтай ЕХ-ны хувьд Ази дахь “үнэ цэнтэй түнш” мөний хувьд бодлого, үйл ажиллагаанд нь анхааралтай хандаж, дотоодод нь хүндрэлтэй асуудал үүсэж буйд санаа зовнин ажиглаж байдаг юм.

Зөрчлийн гол шалтгаан нь гишүүн зарим орны бодлого, үйл ажиллагааны зөрүүтэй байр

суурь, Өрнөд ЕХ, шинээр элссэн Төв, Зүүн Европын гишүүн орнуудын хөгжлийн түвшин, амьдралын чанарын ялгаа, цагаач дүрвэгсэдийн давалгаа, түүнийг тойрсон шийдвэрлэвэл зохих асуудал, ЕХ-ны Үндсэн хууль гэгддэг Лиссабоны гэрээ нь гишүүн орнуудын нийтлэг эрх ашгаас дээгүүр тавигдаж, бүхий л асуудлыг Брюссельд голлон шийдвэрлэж байгаа нь гишүүн орнуудын бие даасан байдалд нөлөөлж буй хандлага, ЕХ-г дотроос нь хагалах гаднын хүчний санаархал зэргийг дурдаж болно. Түүнчлэн Зүүн, Баруун, Төв европын хөгжлийн ялгаа-эдийн засгийн чадамж, нийгмийн хамгааллын тогтолцоо, эрчим хүчний хямрал, уур амьсгалийн өөрчлөлт, Ковид-19 цар тахлын үр дагавар зэргийг судлаач, шинжээчид онцолж байна.

Түлхүүр үг. *Хөгжлийн сорилт, эрх зүйн зохицуулалт, эрчим хүчний хямрал, дүрвэгсдийн асуудал, бие даасан байдал, эв нэгдэл*

Аливаа организм дотоод зөрчилтэй байдаг, байх ч ёстой. Нийгмийн амьдрал, түүний дотор зохион байгуулалттай үүсгэсэн 450 сая хүн амыг эгнээндээ багтаасан 27 улс орныг хамарсан хамтын ажиллагааны аварга эвсэл холбоо, нийгмийн том институци дэвшүүлсэн зорилтдоо хүрэх замдаа янз бүрийн сорилттой тулгарах нь жам ёсны үзэгдэл, бодит баримт мөн.

Зөрчлийг цаг алдалгүй мэдэрч, зөв оношилж, оновчтой шийдвэрлэвэл хөгжил зүгширч, ололт амжилтад хүрдэг \олз\, харин газар авахуулж, улам гүнзгийрүүлбэл хохирол амсаж, нөхцөл байдал бүр хүндэрдэг \гарз\.

Бид энэхүү бэсрэг өгүүлэлд ЕХ-ны өмнө эдүгээ тулгамдаад байгаа зарим асуудлыг хөндөн, шийдвэрлэх боломж, гаргалгаанд саналаа нэмэрлэхийг зорив.

70 гаруй жилийн түүхтэй энэ том хамтын нийгэмлэг нь дотоод гадаадын элдэв дарамт шахалт, үзэл суртлын болон сэтгэлзүйн гүтгэлэг, дайралтын бай болсоор дотоод зөрчил хурцдах, санал зөрөлдөөн нэмэгдэх, эв нэгдэл сарнихад хүрсэн юм. Сүүлийн 10 гаруй жилд ЕХ-ны зарим оронд 2008 оноос санхүүгийн хямрал нүүрлэж, өрийн дарамт үүсч, 2015 оноос дүрвэгсдийн давалгаанд өртөж дорвитой арга хэмжээг цаг алдалгүй авч чадаагүй нь холбоонд итгэх гишүүн орнуудын итгэл багасч, гол ачааллыг үүрч байсан Их Британи холбооноос гарч, салан тусгаарлах гол шалтгаан болсон. Их Британи шиг том зах зээл, хүчирхэг улс ЕХ-оос гарна гэдэг бол хаана хаанаа таатай үзэгдэл төдийгүй, нөхцөл байдлыг улам амаргүй болгож буй хэрэг. Гишүүнчлэлээ дуусгавар болгох гарц, гарах эрх зүйн зохицуулалт амаргүй ч санал зөрөлдөөнөөс болж бүрэлдэхүүнээс гарсан энэ хүсэшгүй үйл явдал ЕХ-нд хүнд сорилт, хүчтэй цохилт болсон.

Их Британи ЕХ-оос гарсан нь дотоод зөрчлийн илрэл болсон юм. Европын холбооны эдийн засаг, төсөвт тэргүүлэх байр суурь эзэлдэг том улсын¹⁶¹ хувьд эрсдэл, алдах зүйл багагүй байсан ч Их британи улсаас ЕХ-нд тавьсан хүсэлтийг хүлээж авах асуудалд боломжийн хариулт өгөөгүй нь ард түмний санал асуулгад нөлөөлсөн байх талтай. ЕХ-оос гарах болсон шалтгаан нь бүр 2015 оноос эхэлж, өөрийн мөнгөн тэмдэгтээ ашиглах, цагаачдын асуудлыг улс бүр бие даан шийдвэрлэх эрхтэй байх, холбооны улсуудын өрсөлдөх чадварыг сайжруулах, гишүүн орнуудын хууль тогтоох байгууллагын нөлөөг ЕХ-ны парламентад нэмэгдүүлэх зэрэг зарчмын саналыг тавьснаар эхэлсэн гэж үздэг.

Хүсэлтийн хүрээнд гэрээнд өөрчлөлт оруулах, бусад гишүүн улсууд ч үргэлжлүүлэн өөрийн улсад ашигтай байр суурийг тулгах, шийдвэрлүүлэхийг хүсэх тул хүлээн авч шийдвэрлэхэд Европын холбооны хувьд эцсийн шатанд¹⁶² татгалзах шийдвэр гаргахаас өөр сонголт тухайн үед байгаагүй юм. Энэ нь ЕХ-ны хувьд нийтлэг эрх ашиг сонирхлыг хамгаалах, хамтдаа ярилцаж тогтсон гэрээ хэлэлцээр, зарчим, хэм хэмжээгээ нэг мөр дагаж мөрдөхийг чанд хангах зорилготой салшгүй холбоотой байсан.

ЕХ-ны эрх зүйн тогтолцоонд үүссэн зөрчил. Европын холбооны эрх зүйн тогтолцооны шинэчлэлийн хүрээнд Лисабоны гэрээгээр¹⁶³ эрх мэдлийн хуваарилалт, эрх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, хамтын шийдвэр гаргах зүгширсэн механизм, бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх, харилцан хамгаалах, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд чиглэсэн олон талт бодлогыг хэрэгжүүлэх үндэс бүрдсэн юм. Европын эдийн засгийн интеграцчилал нь ЕХ-ны эрх зүйн тогтолцоог бий болгох, зохицуулах хүчирхэг хөшүүрэг болдог.

Холбооны дотоод интеграц нь гишүүн улсуудын олон талт харилцааг зохицуулах үүрэгтэй 100 мянга орчим хууль, журам, чиглэл, шийдвэрийн баримт бичиг¹⁶⁴ суурилж, бодлого, үйл ажиллагааны уялдаа холбоо, ойлголцож ажиллах механизмыг хангадаг.

¹⁶¹ Их Британи Европын холбооны гишүүн орнуудад 2008 онд 2.7 тэрбум фунт стерлинг цэвэр тусламж хандив өгч байсан бол 2013 онд уг дүн 11.3 тэрбум фунт стерлинг болж өссөн байдаг. Энэ авахаасаа илүү өгч Их Британийн хувьд холбооноос гарах уг зардлыг өөр хэрэгтэй зүйлдээ зарцуулах боломж бүрдэнэ

¹⁶² Эцсийн шатанд гэж тодотгож байгаагийн үндэслэлийг Их Британи Европын холбооноос гарах асуудал 5 жил орчим үргэлжилсэн нь Европын холбоо Их Британийг гарахыг дэмжээгүй аль болох авч үлдэхийг эрмэлзэж олон үе шаттай яриа хэлэлцээр хийж байсантай холбон тайлбарлаж болно.

¹⁶³ Энэ гэрээ бол ЕХ-ны Үндсэн хуулийн хэмжээнд үнэлэгддэг чухал баримт бичиг.

¹⁶⁴ <http://www.dimiter.eu/Eurlex.html>

Түүхийн туршид олон соёлт нийгмийн бүтэц бүхий янз бүрийн улс оронд хуваагдаж, тус тусдаа оршин тогтнож ирсэн европынхны хувьд эдүгээ **нэгдсэн стандарт, хууль дүрэмд захирагдах, эв зүйгээр оновчтой зохицуулах асуудал амаргүй сорилт** үүсгэдэг. Эдийн засгийн боломж, чадамж нь тааруу хөгжил буурай орнууд нэгдсэн, өндөр стандарт мөрдөхөд амаргүй. Дэлхийн II дайны дараа социалист системийн хүрээ, нөлөөнд байсан Зүүн Европын орнуудын уламжлалт байр суурь, хөгжлийн түвшин, сэтгэлгээний хандлага бас саад болдог. Унгарын ерөнхийлөгч Виктор Орбан “1990-д онд Европ бидний ирээдүй байсан бол одоо бид Европын ирээдүй” гэж хэлснээс пост социалист улсуудын байр суурь мэдрэгддэг. Эдгээр оронд сэтгэлгээ, хандлагын стереотипээс ангижрах, шүүх засаглалаа боловсронгуй болгох, авлигыг бууруулах зорилго, чиглэлд ихээхэн хэмжээний хандив тусламжийг Баруун Европын хөгжилтэй орнуудын зүгээс үзүүлдэг ч зарим улс орны хувьд нөхцөл байдал сайжрахгүй, хэвээр байна.

ЕХ-ны зүгээс Унгар, Польш, Румын зэрэг улсын эрх баригч намууд нь шүүхийн хараат бус байдалд халдаж, чөлөөт хэвлэл мэдээллийн орон зайг хумих замаар ардчилсан бус засаглалын аргыг хэрэгжүүлж байна хэмээн шүүмжлэлтэй ханддаг. ЕХ-нд элссэнээс хойш 20-оод жил өнгөрсөн ч Баруун Европтой харилцаа тэгтлээ сайжраагүй, улс орнуудын нөхцөл байдал, ард түмний аж амьдралд дорвитой өөрчлөлт гараагүй, барууныхан өөрсдийн дур зоргоор авирлаж, хүссэнээ хийж, давуу талаа хадгалсаар байна гэж Зүүн Европынхон гомдоллодог.

ЕХ-ны хууль тогтоогчид, шинжээч судлаачид, ажиглагчид нь интеграцчилалын ерөнхий чиг хандлага зорилгыг тогтоосон ч хүндрэл бэрхшээл тулгарсаар байна. Интеграцчилал нь нийгмийн чанартай олон асуудалтай тулгарч холбооны гишүүн зарим улсын зүгээс ч Европын холбоог татан буулгах хүртэл санал гаргах болов. Дэлхийн улс төр, олон улсын харилцаанд янз янзын үзэл баримтлал, байр суурь ажиглагдаж байгаа ч нэгдэн нийлж, хүндрэл бэрхшээлүүдийг даван туулах боломжтойг бидний судалгааны үр дүн¹⁶⁵ харуулж байна.

Эрдэмтэн судлаачид европын эрх зүйн тогтолцоог бие даасан, олон улсын эрх зүйн систем юм¹⁶⁶ гэж үзэх хандлага давамгайлдаг. Цаашдаа ЕХ-ны эрх зүйн тогтолцоо зөвхөн бүс нутгийн түвшинд бус өргөн хүрээнд харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар цөөнгүй санал, санаачилга гарч, гэрээ, хэлэлцээр байгуулагдаж байна. Энэ нь бүсийн асуудлыг шийдвэрлэхэд дан ганц гишүүн орнуудаас хамаарахгүй өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулах, бодлогоо өргөжүүлэн хэрэгжүүлэхэд гадаад хүчин зүйлийн нөлөөлөл тасралтгүй нэмэгдэж байгаатай холбоотой юм.

Маастрихтын гэрээгээр (1993) ЕХ-ны байгууллагын шийдвэр гаргах үйл явцыг боловсронгуй болгож гишүүн улсуудын хүсэл зориг, эрх ашгийг хөндсөн гадаад, дотоод бодлогын чухал асуудлаар хамтын шийдвэр гаргах журмыг зохицуулсан¹⁶⁷. Шийдвэрийг олонхийн саналаар гаргах боловч нэгдсэн шийдвэрт хүртэл хэд хэдэн шатанд зөвшилцөж, байр сууриа бүрэн нэгтгэх учиртай¹⁶⁸.

ЕХ-ны байгууллагуудын түвшинд хамтын шийдвэр гаргах нь нийгмийн бодлогын салбарт тэгш байдлыг тогтоох, ажлын байраар хангах, иргэний эрүүл, аюулгүй байдлыг хамгаалах, хууран мэхлэх явдалтай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх, гаалийн хамтын

¹⁶⁵ Г.Золзаяа нар Монгол дахь Европ судлалын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын судалгаа //Политологи ХХ, Эрдэм шинжилгээний бичиг №20 (570): 190-201 дэх тал үзнэ үү

¹⁶⁶ Хууль зүйн Үндэсний хүрээлэн, “Европын эрх зүйн тогтолцоо: Үүсэл, хөгжлийн чиг хандлага”, УБ, 2017 он, хуудас 4

¹⁶⁷ Treaty on European Union 1992 article 54-55

¹⁶⁸ Энэ тухайд О.Хишигмөнх Европын холбооны эрх зүйн тогтолцоо//Европын холбоо УБ., 2022, 122-145 дахь тал үзнэ үү

ажиллагаа, статистик, мэдээллээр үйлчлэх, зөвлөн туслах бүтэц бий болгох зэрэг асуудлуудыг хамрахаар заасан байдаг.

ЕХ дотооддоо шинээр тулгарч буй сорилт, гаднын улс орнуудын нөлөөллөөс шалтгаалан эрх зүйн тогтолцоогоо улам боловсронгуй болгох, бусад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах шаардлагын үүднээс бүсийн хүрээний болон холбооны түвшинд үйлчлэх үнэт зүйл, хэм хэмжээ тогтоохоос илүү өргөн хэмжээнд эрх зүйн тогтолцоог үйлчлүүлэх үйл явц үргэлжилж байна.

ЕХ-ны эрх зүй нь гишүүн улсуудын хууль тогтоомжийг өөрчлөх, үйлчлэлийг нь алдагдуулах зорилготой бус улс бүрийн харилцан адилгүй тогтоосон эрх зүйн тогтолцооны өвөрмөц, ялгаатай байдлыг зөвшөөрөх, ойртуулах, харилцан ашигтай байж хамтарч ажиллан дэлхийд өрсөлдөх эдийн засагтай, аюулгүй байдлаа хамтдаа хамгаалах, ирээдүйдээ итгэлтэй, илүү сайхан нийгмийн амар амгалан, энх тайван байдлыг өвлүүлэн үлдээхэд чиглэгдэх юм.

“Хуучин”, “шинэ” болон баруун, зүүн Европын орнуудын хөгжлийн ялгаа, зөрчил. Зүүн, Төв Европ нь хөгжлийн түвшин, амьдралын чанараараа ялгаатай, тэгш биш байдалтай оршдог нь зөрчлийг үүсгэх бодит шалтгаан болдог. Хүйтэн дайны үе дуусах, ЗХУ задарснаас хойш ЕХ-нд нэгдсэн Балканы хойгийн болон Зүүн Европын улсууд болон Баруун Европын улсууд хоорондын нэг гол ялгаа нь хөгжлийн түвшин, эдийн засгийн чадамж, түүнээс үүдсэн, социаль асуудлууд, нийгмийн хамгааллын тогтолцоо зэрэг юм. ЕХ-ны зүгээс Зүүн Европын зарим орны төрийн тогтолцоог авлагад өртөмхий, олигархижсан, автократ хэмээн шүүмжлэлтэй ханддаг нь анхаарах ёстой асуудал мөн. ЕХ-нд сүүлд элссэн Зүүн Европын орнуудын зүгээс Европын интеграцчилал санасан хэмжээнд явагдахгүй байна, өөрсдийгөө ялгаварлан гадуурхдаг гэж үздэг. Эдийн засгийн боломж, чадамж сул улс орнууд байгаль орчны стандартыг дагаж мөрдөх нь хүндрэлтэй, тухайлбал Польш улс нүүрсний олборлолтоо хамгаалахыг хичээдэг бол Унгар, Словак улсууд авто машины үйлдвэрлэлээ чухалчилдаг. Ингэснээрээ европ даяар мөрдөх нэг стандартыг хангахгүй болж зөрчилддөг нь нууц биш юм.

Гомдоллоод, тунирхаад, айлгаад суух уу, хамтын ажиллагаанд идэвхтэй, ухаалгаар оролцож байр суурь, оролцоо нөлөөгөө дээшлүүлэх үү гэдэг нь чухамхүү өөрсдөөс нь хамаарна. Зүүн Европын улсууд эдийн засгаа сэргээх, хамгаалах хэрэгцээ, шаардлагаас үүдэн худалдааны протекционист бодлого явуулах магадлалтайг мэргэжлийн шинжээчид илэрхийлэх боллоо.

ЕХ-ны бодлогын хувьд мэдээж ялгаварлан гадуурхах, хагалан хуваах хүсэл сонирхол, байр суурь байхгүй нь ойлгомжтой, ялангуяа Брекситын дараа илүү нэгдмэл бодлого баримталж, үйл ажиллагаагаа хамтарч явуулахын давуу талыг ойлгож, хамтдаа чармайж байна. Үл ойлголцол, талцал, хуваагдлын тухайд улс төрийн ажиглагчид, шинжээчид, тинк-танк судалгааны байгууллагуудын хэмжээнд л таамаглал байдлаар яригдаж, бичигдэж байгаа ч энэ үзэл санаа нь тэдний хоорондын харилцаа, хамтын ажиллагаа, бодлогын шийдвэрт нөлөөлж болзошгүй.

Зүүн Европын орнуудад ЕХ-ны зүгээс ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт, тусламж дэмжлэгийг үзүүлдэг, зарим гишүүн орны шүүмжлэлийг үл харгалзан тэдгээр орнуудад бүх талаар тусалсаар ирсэн, одоо ч тусалдаг.

2017 оны 6 дугаар сард болсон Версалын дээд хэмжээний уулзалтаар Европын хөгжлийн 2 өөр түвшин, хурдыг хүлээн зөвшөөрч дэмжсэн, Брекситийн дараа Лондонд

төвтэй зарим агентлагийг шилжүүлэн байрлуулахаар Төв болон Зүүн Европын хэд хэдэн хотын нэр дэвшүүлсэн ч Парис, Амстердамд байрлуулах шийдвэр гарсан нь Зүүн Европынхны дургүйцлийг хүргэж, зөрчлийг хурцатгасан болно.

ЕХ-ны дотоод зөрчлийн нэг гол цэг нь цагаачлал, дүрвэгчдийн асуудал мөн. Дүрвэгсэд, цагаачдын асуудал Баруун, Зүүн Европын хувьд улс төрийн хуваагдлын хамгийн том шалтгааны нэг хэдий ч Польш, Унгарын ардчиллын хямрал болон ер нь Зүүн Европын орнуудын хууль дээдлэх байдал сул, хөдөө аж ахуйн болон бусад сангийн санхүүжилт, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн, байгаль орчны стандарт, хүнсний чанар зэрэг асуудлаар зөрүүтэй байр суурьтай байдаг.

Дублины гэрээгээр дүрвэгсдийг анх хүлээж авсан улс орон нь хариуцах учиртай. Дүрвэгсдийн тоо нэмэгдэж, хүлээн авч буй орны ачаалал ихэссэнээр гэрээний энэ заалт зөрчигдөх болсон. 2015-2016 онуудад Төв болон Зүүн Европын орнуудад Ойрх Дорнод болон Хойд Африкийн улсуудаас их хэмжээний дүрвэгсэд ирж, тэд эдгээр орнуудаар дамжин Баруун Европыг чиглэх зорилготой нь тодорхой болсон. Ийм дүрвэгсдийн давлагаа, хямрал одоо дахин үүсэж болзошгүй нөхцөл байдал үүсээд байна. Энэ асуудлаар ЕХ-Туркийн хооронд асуудал үүсэх магадлал өндөр болсныг шинжээчид анхааруулах боллоо. Их Британи ЕХ-оос гарсан шалтгааны нэг нь чухамхүү бусад улсуудаас ирэх цагаачлалыг хязгаарлах, дүрвэгсдийн асуудал байсан. Европ руу чиглэсэн дүрвэгсдийн урсгал нэмэгдсэн, цагаачид Засгийн газрын халамж, тэтгэмжийг хүртэж байгаа нь татвар төлөгчдийн мөнгийг үрэлгэн зарцуулах шалтгаан болж байна, мөн цагаачид ажлын байрыг булааж байна хэмээн үзсэн тул өөрийн бодлогоороо бие даан шийдвэрлэх давуу тал үүснэ гэж үзсэнтэй холбоотой. Олон асуудлыг араасаа дагуулдаг цагаачлалын менежмент нь биеэ даасан доктрина болжээ.

Маргаан үүсэж, зөрчилд хүрсэн гол шалтгаан нь ЕХ-ны улсууд цагаач, **дүрвэгсдийн талаар нэгдсэн бодлогогүй**, дүрвэгсдийн хөлд нэрвэгдсэн Зүүн Европын орнууд тэгш бус хуваарилалтын талаар шүүмжилж бусад гишүүн улсууд адил ачаа үүрэлцэх ёстой хэсэн шуугиан дэгдээсэн юм.

Хөдөлмөрийн хөлсний үнэлэмжийн зөрүү буюу Зүүн Европт ажилчдын цалин хөлс Баруун Европын цалин хөлсний 1/3-тэй тэнцэх хэмжээний байдаг нь ажилчдын шилжилт хөдөлгөөнийг ихэсгэх шалтгаан болдог.

Орос, Украйны мөргөлдөөн ч Олон мянган хүний амь нас хохирч, иргэд хөдөө орон нутаг, жижиг тосгон зэрэг эрсдэл бага, аюулгүй газар руу орон гэрээ орхиж нүүхэд хүрсэн. Мөн Европын холбооны орнууд руу албан ёсны тоогоор 5 сая хүн дүрвэсэн судалгаа байна¹⁶⁹. Зөвхөн 3023 он гарсаар 250 орчим мянган хүн ЕХ-нд хууль бусаар нэвтэрсэн байна.

ЕХ-ны цагаачлалын асуудлаарх дээд хэмжээний уулзалт нэг сарын өмнө Испани улсын Гранада хотноо болж, цагаачлалын нөхцөл байдалд Ром, Мадрид, Берлин санаа зовниж байгаагаа илэрхийлсэн боловч, Польш, Унгар улсууд эсэргүүцэж, байр суурь зөрөлдсөнөөс шийдвэр гаргаж чадсангүй.

Ойрхи Дорнод, Африкийн орнуудаас ирж буй цагаачдыг хүлээн авахаас татгалзвал торгууль ногдуулах тухай ЕХ-ны шинэ хуулийг батлахын тулд Герман улс Польшийн сөрөг хүчний удирдагчидтай уулзаж байна гэж Польшийн Ерөнхий сайд Матеуш Моравецки

¹⁶⁹ <https://said.mn/content/11/123412>;

буруутгалаа. "Гэр орныг маань өөр хүн тохижуулахыг Польш улс зөвшөөрөхгүй" гэж тэр бээр мэдэгдсэн нь байдлыг хурцатгахад хүрэв.

Түүнтэй ижил үзэл бодолтой, цагаачлалын эсрэг хатуу байр суурь баримталдаг Унгарын удирдагч Виктор Орбан цагаачлалын асуудлаар ЕХ-г буруутгасан байр суурийг удаа дараа илэрхийлсээр байна.

ЕХ-ны дотоодод өрнөж буй ээдрээт үйл явдлууд нь улс орнуудыг эрчим хүчний аюулгүй байдлын бодлого, төлөвлөлт, доктринаа эргэн харахад хүргэв. Аливаа улс орон, тэр тусмаа том эвсэл холбоо нь өөр нэг орны эрчим хүчний хангамж, хангалтаас хэт хамааралтай, хараат¹⁷⁰ байж болохгүйг ЕХ-ны улсууд сүүлийн жилүүдэд ойлгож, эрчим хүчний аюулгүй байдлын доктринаа өөрчлөхөөс аргагүй байдалд хүрсэн нь дотоод хүндрэлийнх нь нэг болсон юм. Эрчим хүчний хямрал нь уг салбарын зах зээлийн тогтоц, ханган нийлүүлэлтийн болон дэд бүтцийн эмзэг байдлыг тод харуулсан болно.

ЕХ-ны эдийн засаг нь гишүүн орнуудын хамтарсан эдийн засаг бөгөөд хэмжээгээрээ дэлхийд АНУ, Хятадын дараа ордог. 2022 оны байдлаар уг холбооны дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 16 орчим их наяд ам.доллар болж, дэлхийн эдийн засгийн зургааны нэгийг эзэлж байна. Эдийн засгийн багтаамжаар нь авч үзвэл эрчим хүчний анхдагч нөөцийн ханган нийлүүлэлт, эрэлт, үнэ нь дэлхийн нийт эдийн засагт хүчтэй нөлөөлөх нь ойлгомжтой¹⁷¹

Украинд үүссэн төвөгтэй нөхцөл байдалтай холбогдуулан Европын Холбоо 48 цагийн дотор ОХУ-ын эсрэг анхны багц хориг арга хэмжээг зарлаж 20 хоногийн дотор дангаараа 4 цуврал багц хориг зарласан¹⁷². Эдийн засгийн болон бусад хатуу хориг арга хэмжээний хариуд ОХУ эрчим хүчний нийлүүлэлтээ улс төрийн зэвсэг болгосон юм. ОХУ Украинд цэргийн тусгай ажиллагаа явуулж эхэлснээр Европын холбооны төдийгүй дэлхийн эрчим хүчний төлөвлөлт, хуваарилалт, дэг журам эрс өөрчлөгдөв. Эрчим хүчний анхдагч нөөцийн олборлолт, нийлүүлэлтийн хэмжээ, хэлхээ холбоо доголдож, гадаад бодлогодоо нүүрс, газрын тос, байгалийн хий, уран гэх мэт нөөцийнхөө давуу байдлаа чадмаг ашигладаг ОХУ нь уг салбарын бараа бүтээгдэхүүний үнийг эрс өсгөв¹⁷³.

Хориг арга хэмжээний хариуд ОХУ нийлүүлэлтээ хязгаарласнаас эрчим хүчний үнэ Европ төдийгүй дэлхий даяар өсөв. Цэргийн тусгай ажиллагаа эхлэхээс өмнө 1 мегаватт цаг (МВт цаг) байгалийн хий 53 ам.доллар байсан бол 2021 оны сүүлчээр 360 орчим ам.доллар болж түүхэн дээд өсөлт үзүүлсэн. Ийм нөхцөлд ЕХ-ны зүгээс эрчим хүчний аюулгүй байдлын доктрин, замын зураглалаа өөрчилж, өөр эх үүсвэр хайж эхэлсэн нь бас нэг амаргүй сорилт болсон юм. Нөөц боломжоо ашиглан зохицуулж болдгийг сүүлийн хоёр жилийн туршлага, сургамж харууллаа.

¹⁷⁰ 2021 оныг хүртэл Европын холбооны байгалийн хий, газрын тос, нүүрсны гол ханган нийлүүлэгч нь ОХУ байв. 2021 онд Европын холбоо нийт нүүрсний хэрэглээнийхээ 45 хувь, байгалийн хийн 36 хувь, газрын тосны 25 хувийг ОХУ-аас импортоор авч байлаа.

¹⁷¹ https://european-union.europa.eu/principles-countries-history_en

¹⁷² https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip_22_1761

¹⁷³ Хориг арга хэмжээнүүд хэрэгжиж эхэлснээр 2023 оны эхний хагасын байдлаар ОХУ-аас импортоор авдаг газрын тосны хэмжээ 26-аас 3.2 хувь, байгалийн хийн хэмжээ 36-аас 17 хувь болтлоо эрс буураад байна[3].///

Зарим гишүүн улс дүрвэгсдийн эсрэг протекционист байр суурь баримталж, популист үзэл бодол цухалзах болсон нь ЕХ-ны эв нэгдэлд заналхийлсэн хандлага ажиглагдах болов.

Украины нөхцөл байдлын нөлөөгөөр улс орнууд дотооддоо тархмал, бие даасан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх нь эрчим хүчний аюулгүй байдлаа хангах, үнэ тогтворжуулах арга хэрэгсэл болж, асуудлаа бие даан шийдвэрлэх боллоо.

Дүгнэлт, санал.

ЕХ сүүлийн арван жилд олон сорилттой учирч, эдийн засгийн хүндрэл, төсвийн алдагдал, өрийн өсөлт, БРЕКСИТ хямрал, цагаачлалын давалгаа, COVID-19-ийн хүндрэл, евроскептицизмийн өсөлт зэрэг нь нь ЕХ-ны интеграцийн үйл явц, хөгжлийн доктрин, нэгдсэн стандарт, хууль тогтоомжид суурилсан олон талт бодлогоо ойр ойр өөрчилөхөд хүрэв.

Европын Холбоог илүү эв нэгдэлтэй, итгэл тээсэн, хамтын ажиллагаа нь амжилттай, үр дүнтэй болж, олон туйлт дэлхий ертөнцөд, олон улсын хүчний харьцаанд нэг хүчирхэг тулгуур байлгаж чадах эсэх нь гишүүн орнууд зорилго тэмүүлэл, хүсэл зоригоо нэгтгэж харилцан ойлголцож, хамтран ажиллаж чадах эсэхээс хамаарах боллоо.

ЕХ-ны эрчимтэй интеграци нь үндэстэн дамнасан бүтцийг бий болгож, эдийн засаг, хөдөө аж ахуй, эрчим хүч, мөнгө санхүү, гадаад бодлого, батлан хамгаалах, шинжлэх ухаан, технологи, инновацийн чиглэлээр өргөн хүрээний бодлогыг уялдуулан хөгжиж байна. ЕХ нь олон улсын бодлогод нөлөөлөгч, бүтээгч төдийгүй, түүнийг тээгч, хэрэглэгч нь юм.

Олон улсын болон бүс нутгийн шинжтэй ЕХ нь худалдаа, эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагааны найдвартай түнш, гишүүн орнуудынхаа улс төр, аюулгүй байдлын өмөг түшиг болсоор ирснийг олон талт, баялаг агуулга, янз бүрийн хэлбэр бүхий бодлого, үйл ажиллагаа нь харуулдаг.

ЕХ нь гадаад тааламжгүй нөхцөл байдлын улмаас 2016 оноос хойш стратегийн бие даасан байдлаа хангах зорилго тавьсан билээ. Гадаад, аюулгүй байдлын нэгдсэн бодлого, батлан хамгаалах зорилт, эдийн засаг, технологи, инновацийн салбарт томоохон өөрчлөлтийг хийхээр төлөвлөсөн нь дотооддоо учирч буй хүндрэл бэрхшээлийг даван туулах бодит боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

ЕХ-ны стратегийн бие даасан байдал нь гадаад, аюулгүй байдлын бодлогынхоо тэргүүлэх чиглэлийг өөрөө тодорхойлох, бие дааж шийдвэр гаргах боломжтой байх, бүтэц зохион байгуулалт, улс төрийн болон материаллаг урьдчилсан нөхцөлийг шаардлагатай тохиолдолд гуравдагч талтай хамтрах болон бие даан хангах чадвартай болох үндэстэй.

ЕХ-ны дотоод үйл ажиллагаанд зарим зөрчил үүссэн нь бодит баримт, гэхдээ харилцан ойлголцож, хамтран ажиллаж чадвал хүндрэл бэрхшээлээ даван туулж, дэвшлийн замаар хамтдаа урагшлах болно гэсэн өөдрөг байр суурийг гишүүн орнуудын удирдлага мэдэгддэг.

ЕХ-ны гишүүн орны удирдагчид Ромын шинэ тунхаглалд **"Европын эв нэгдэл нь зоригтой, алсыг харсан хүчин чармайлт юм"** хэмээн тэмдэглэсэн зарчим, заалтаа хэрэгжүүлж, хил хязгаарыг үл харгалзан бүс нутгийн хэмжээнд иргэдийн эрх чөлөө, аюулгүй байдал, шударга ёсны баталгааг хангаж чадвал орон зай, цаг хугацааны хүндрэл бэрхшээлээс ангижрах бүрэн боломжтой гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

1. Г.Баасанхүү, С.Энхцэцэг, Ж.Баттогтох, (2019). Олон улсын харилцааны үндэс ба даяаршил, УБ,
2. К.Дэмбэрэл. (2018). Олон улсын харилцааны онол, үйл ажиллагаа. Улаанбаатар.
3. Европт Үндсэн хууль батлах гэрээ 2004 (Treaty establishing a Constitution for Europe)
4. Европын холбооны тухай гэрээ, Европын нийгэмлэгийг үүсгэн байгуулах гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Лиссабоны гэрээ 2007 (Treaty amending the Treaty on European Union)
5. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт хүний эрхийн газраас хамтран гаргасан “Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах удирдамж (2020)
6. Европын эрх зүйн тогтолцоо: Үүсэл, хөгжлийн чиг хандлага (2017)
7. Б.Жаргалсайхан. (2004). Хувь тавилангийн эрхшээл.
8. Г.Золзаяа нар Монгол дахь Европ судлалын өнөөгийн байдал ба тулгамдаж буй асуудлуудын судалгаа //Политологи ХХ. Эрдэм шинжилгээний бичиг №20(570) 189-200 дахь тал
9. Европын Холбооны стратегийн бие даасан байдал ба Монгол улс. Олон улс судлал, 1 (110)
10. Г.Төмөрчулуун (2020) Монголын геополитикийн мандан бууралт ба сэргэлт

Цахим эх сурвалж:

1. https://european-union.europa.eu/index_en
2. <https://www.europarl.europa.eu/portal/en>
3. <https://www.rbc.ru/rbcfreenews/61bb6e439a79472e43932639>
4. <https://www.thebalance.com/what-is-the-european-union-how-it-works-and-history-3306356>
5. <https://europe.unc.edu/toolkits/chapter-3/>
6. <https://www.euronews.com/2020/06/16/hungary-debates-end-to-emergency-powers-but-new-law-opens-up-potential-to-re-apply-them>
7. <https://www.theatlantic.com/international/archive/2020/04/europe-hungary-viktor-orban-coronavirus-covid19-democracy/609313/>
8. <https://www.euronews.com/2020/07/13/what-does-duda-s-victory-mean-for-eu-poland-relations>
9. <https://www.civitas.org.uk/eu-facts/eu-overview/history-of-the-european-union/>
10. [Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газар https://www.eeas.europa.eu/delegations/mongolia_mn?s=171](https://www.eeas.europa.eu/delegations/mongolia_mn?s=171)

ДИЖИТАЛ УР ЧАДВАР ӨНӨӨГИЙН БОЛОВСРОЛЫН ЧИГ ХАНДЛАГАД НӨЛӨӨЛӨХ НЬ TODAY'S EDUCATIONAL TRENDS TO INFLUENCE DIGITAL SKILLS

Р.Оюунсүвд

ДХИС-ийн Гадаад хэлний институтийн багш, дэслэгч

МУБИС-ийн докторант

Агуулга: Мэдээллийн технологийн хөгжил нь бидний боловсролын хэв маяг, хандлага, сургалтын орчныг өөрчилж цоо шинэ эрин үеийг авчирч байна. Өнөөдөр дэлхий дахинд хиймэл оюун ухаан, ухаалаг тоног төхөөрөмж, үүлэн технологи зэрэг дэвшилтэт технологиуд нь сургалт явуулах арга зам, мэдээлэл солилцох боломж, суралцагчтай харилцах харилцаанд маш их нөлөөтэй болжээ. Энэ нөлөөлөл нь боловсролын орчин, ажиллах нөхцөл, амьдралын хэв маягийг өөрчилж, багш болон оюутнуудын харилцаа онлайн дижитал орчинд шилжүүлэн илүү өргөн хүрээг хамарсан олон улсын чанартай боловсролын тогтолцоо руу шилжих боломж олгож байна. Дижитал орчин нь суралцагчдын хандлага, суралцах хэв маягт тохируулан үйл ажиллагаа явуулах, тааламжтай орчныг бүрдүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж чадахуйц технологийн шийдэл бүхий талбар юм. Тиймээс программ хангамжийн компаниуд, мэдээллийн технологийн мэргэжилтнүүд, боловсролын байгууллагууд үйл ажиллагаагаа оновчтой болгож, илүү сайжруулж, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлж, шинэ техник технологийг санаачилж хөгжүүлсээр байна. Ингэснээр боловсролын байгууллагууд болон оюутан суралцагчдын интернэт болоод ухаалаг гар утасны хэрэглээ өндөр байгаа хэдий ч дижитал орчинд сурах, мэдээлэл авах боломж, дижитал чадамж ямар байгааг тодорхойлж цаашдын чиг хандлагыг тодорхойлохыг зорилоо. Үүний дүнд багш, сурган хүмүүжүүлэгч бид сүүлийн үеийн техник технологийг ашиглан сургалтын үйл ажиллагаа явуулах шаардлага бидэнд тулгарч байна.

Abstract: The development of information technology is bringing a whole new era by changing our educational style, attitude, and learning environment. In today's world, advanced technologies such as artificial intelligence, smart equipment, and cloud technology greatly impact the way learning is conducted, and the ability to exchange information and relationships with students. The digital environment is a field of technological solutions that can adapt to student's attitudes and learning styles, create a pleasant environment, and increase competitiveness. Therefore, software companies, IT specialists, and educational institutions continue to optimize their operations, improve them, increase their competitiveness, and innovate and develop new technologies. In this way, we aim to identify the possibilities of learning and obtaining information in the digital environment and the digital capabilities of educational institutions and students, despite the high internet and smartphone use, and determine future trends. As a result, we as teachers and educators are faced with the need to use the latest technology to conduct educational activities.

Түлхүүр үг: дижитал чадвар, оюутан суралцагчид, мэдээллийн технологи, дижитал орчин, боловсролын чиг хандлага

1. Introduction

Digital skills have been necessary for the workplace for decades. For as long as there have been computers, servers, and electronic communications there has been a need for digitally inclined professionals, like IT specialists and employees who can safely eject a floppy disk. (Centre, 2019)

Digital skills are defined as the ability to find, evaluate, share, and create content using digital devices, such as computers and smartphones.

These days, the digital skills required in the workplace is a bit more advanced, and companies expect the vast majority of their employees to have them, not a select few. Technology is at the center of our lives, and as our dependence on the internet and digital communications increases, our workforce must keep up with the evolving skill demand.

1.1 What skills are necessary for entry-level positions?

When you stand out in the modern workplace, you improve your chances of excelling in your career. Whichever career path you choose, keep in mind that there are always new skills to learn and new technology to master.

For entry-level positions, the bare minimum digital skills required include the ability to carry out tasks, such as:

- ✓ Communicating via email
- ✓ Researching information online
- ✓ Handling sensitive information in virtual ecosystems
- ✓ Safely using cloud-based collaboration tools like Google Drive, DropBox, and Microsoft Teams
- ✓ Creating and managing spreadsheets and online documents
- ✓ Basic device management like connecting to the internet or installing software updates
- ✓ Using online calendars and efficiently managing your schedule (and possibly others on the team)

1.2 What are the critical digital skills?

Depending on your career trajectory, you may need additional skills that pertain to your specific role. Digital skills in the workplace can include original creation, e-commerce, network and information security, design, digital marketing, social media marketing, and data analytics.

Advanced digital skills range from data visualization and basic programming skills to data engineering.

While these may be more advanced, you can obtain them with hands-on training and consistent exposure.

McKinsey research has identified foundational skills that will “help citizens thrive in the future of work,” below is a sample of their findings. (C.Audrin, 2022)

According to “many of the highest-paying jobs are positions that require a significant amount of education, professional training, and advanced skills.” If you want to cover your bases as quickly as possible, here is how you can determine which digital skills you should focus on building.

1. Research the industry or profession you’re curious about and read through job descriptions to understand which skills you already have and which you will need to build.
2. Understand how you can add value outside of automated systems and AI. As automation becomes the norm, our roles must adapt to the digital environment.
3. Your desired industry to keep tabs on trends and what skills professionals are talking about. LinkedIn groups are also a great place to build your network and ask real professionals your burning questions.

2. How to develop or improve digital skills.

Almost a third of the workforce lacks the foundational digital skills employers are looking for, meaning a large population of professionals need reskilling. According to those who are unemployed have placed a greater emphasis on learning digital skills, including information technology and data science.

Whether you're looking to sharpen your digital skills or you're hoping to enter the workforce with a strong resume, you can benefit from further training. Here are some methods for developing digital skills that don't include attending a traditional four-year program.

Self-Learning: We've talked all about how technology is part of our lives, so we must acknowledge how critical it is in helping us learn. There is a vast amount of information on any topic you can think of online, making basic skills easier to acquire. Connecting with professionals in your field is another great way to supplement your self-learning and understand which skills need more refining.

Free Online Courses: For a more structured experience, you may want to explore free online courses that let you learn at your own pace at a slightly deeper level than self-learning. You may not get all of the advanced material you need to land your dream job, but it's a step towards gaining basic knowledge and essential digital skills.

Certificate Programs: Universities offer dedicated certificate programs that deliver intense, in-depth instruction to ensure students are equipped with the digital skills and training to get them hired in today's workforce. offer accelerated courses led by industry experts and help you find the right job for you with professional career coaching. You can even increase your professional visibility with our exclusive hiring partner network.

The need for digital skills will only increase, so if you need to gain skills fast, there's no better time to get started than now. Learn more about the digital skills. They will walk you through your options as you discuss your career goals and education needs. You don't have to commit right away. You can test-drive our program for 30 days to get a feel for our learning environment before making up your mind. The future is here. Let's conquer it together.

Why learn digital skills?

Digital transformation is on the rise and affecting every industry imaginable.

Farmers are no longer merely sowing seeds and harvesting a crop; they're using sensors and information technology to automate, monitor, and regulate their systems to become more profitable, efficient, and sustainable.

Food delivery apps now provide their menu options to hungry patrons without them having to leave their homes. This adds a complex layer of responsibilities for restaurant workers who now must manage orders through digital devices, as well as any in-person interactions.

Even real estate, a traditionally face-to-face industry, relies on digital skills. Virtual walk-throughs are available to prospects looking to relocate, and signing documents remotely with services like DocuSign is a quick and convenient way to finalize an agreement.

The mass shift to online business operations in recent years further accelerated the need for digitally literate workers who could help traditional businesses successfully transition to and grow in an e-commerce world.

Without a firm command of digital skills, there is no way to propel innovation and remain competitive. Employers realize this, so they're prioritizing candidates who can showcase their digital literacy. By developing better digital skills, employees have a chance to contribute to their communities, future-proof their careers, and explore a wide range of professional opportunities.

3. Methodology

This study was conducted using the methods of scientific research such as quantitative analysis and comparative research. Here are some information showing the increasing demand for digital literacy professions.




Figure -1

This table shows that students are developing their knowledge of professional digital competence and digital literacy software.




Figure -2

Students will gain self-management and self-confidence the ability to innovate and make decisions to achieve their goals.

3. Cognitive

Critical thinking	Communication	Planing and ways of working
<ul style="list-style-type: none"> •Structured problem solving •Logical reasoning •Understanding biases •Seeking relevant information 	<ul style="list-style-type: none"> •Storytelling and public speaking •Asking the right questions •Synthesizing messages •Active listening 	<ul style="list-style-type: none"> •Work-plan development •Time management and prioritization •Agile thinking

Figure -3

Its important skills for students include cognitive, planning with work, interpersonal, and critical thinking.

4. Conclusion

As a result of research unequal access to digital skills and technologies often overlaps with known cracks in social protection systems. And, with the rise of e-government, online shopping, banking, and smart mobility, a lack of basic digital skills may lock individuals not only out of work but also out of society.

Just as numeracy and literacy skills are fundamental for every citizen, regardless of discipline and profession, so too are digital literacy skills. They will become necessary to succeed in today's society and labor markets where ubiquitous connectivity is the new normal.

In the future:

- ✓ Students of with the right skill set will remain their biggest challenge over the next years.
- ✓ All teachers will need reskilling in the next few years.
- ✓ Mongolia believes that digital skills will be important to success in today's workplace.
- ✓ According to, a study published about digital skills for career progress "the number of jobs requiring digital skills is predicted to increase by 2024."
- ✓ The universities expect teachers to acquire new skills on the job.

Reference

1. Цахим засаг дижитал хийх аргачлал. Жайдип Прабху .(2021)
2. C.Audrin. (2022). Key factors in Digital literacy in learning and education. *Education and Information Technologies* , 8-9.
3. Centre, E. P. (2019). Digital is the new lieracy . *10 Trends transforming education as we know it* , 2.
4. <https://nationalcareers.service.gov.uk/careers-advice/build-foundation-digital-skills-to-help-your-career>
5. <https://digitalskills.unlv.edu/digital-marketing/what-are-digital-skills/>

**ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС-УКРАИН УЛСЫН ДАЙНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ
ДЭЛХИЙН ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ**

**THE SITUATION OF THE WAR BETWEEN THE RUSSIAN FEDERATION AND
UKRAINE IMPACT ON GLOBAL FOOD SECURITY**

*С.Бямба-Эрдэнэ Үдотгоод хэргийн их сургуулийн эрх зүй, нийгмийн ухааны
сургуулийн багш, ахлах дэслэгч*

Abstract: The armed conflict between the Russian Federation and Ukraine has escalated into a war, the parties cannot reach a mutual agreement, and it is not clear how it will be resolved. Today, when the number of the world's population is growing rapidly, the longer the war lasts, the more it will affect the world's food security, and the country's food needs and grain shortages will occur. Russia and Ukraine are the world's largest exporters of agricultural products and play a leading role in the fertilizer and food industries. The war between the Russian Federation and Ukraine began on February 24, 2022, with the invasion of Ukraine by the Russian Federation and an armed conflict.

As a result of the war, large cities in Ukraine were destroyed, suffered heavy losses, thousands of innocent lives were lost, and people were forced to leave their homes for safe places such as rural areas and small villages. There is also a study of 5 million people who have fled to the European Union countries according to the official figures.

The two sides decided to conclude an agreement in Turkey with the help of the United Nations in July 2022, and the agreement included the clause "...not to open fire on any vehicle transporting grain..." after the agreement was signed by the parties on July 7, 2022. On March 26, Russia fired two missiles at the Ukrainian port of Odessa, which shocked the world. Russia's violation of the provision not to open fire on grain-carrying vehicles under the failed cease-fire agreement has become a threat to food security not only in Ukraine, but in many countries around the world.

It is not clear how the situation of the war between the Russian Federation and Ukraine will be resolved, due to the stagnation of the export of wheat, fertilizers and grains of the two countries, the price of grain will increase, and the world economy and food security of many countries, the European Union, Mongolia expressed the high risk of affecting sustainable development and resulting in negative consequences, sought solutions, and shared my conclusions.

Key words: European Union, Russian Federation, Ukraine, war, food security.

Хураангуй: Оросын Холбооны Улс, Украин улс хоорондын зэвсэгт мөргөлдөөн нь дайн болон өргөжин тэлж, талууд харилцан тохиролцоонд хүрч чадахгүй, хэрхэн шийдвэрлэгдэх нь тодорхойгүй удаан үргэлжилж байгаа нь дэлхийн улс орнуудын анхаарлын төвд байгаа билээ. Дэлхийн хүн амын тоо хурдацтай өсөн нэмэгдэж байгаа өнөө цагт дайн удаан үргэлжлэх тусмаа дэлхийн хүнсний аюулгүй байдалд нөлөөлж, улс орнуудын хүнсний хэрэгцээ, үр тарианы хомсдол үүсэх нөхцөл бүрдээд байна. ОХУ болон Украин улс нь дэлхийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хамгийн том экспортлогч улсууд бөгөөд бордоо болон хүнсний бүтээгдэхүүний салбарт тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг. Оросын Холбооны Улс, Украин улс хоорондын дайн нь 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Оросын холбооны улсаас Украин улсад халдан довтолж, зэвсэгт мөргөлдөөнөөр эхэлсэн.

Дайны улмаас Украин улсын томоохон хот сууринууд сүйрч, их хэмжээний хохирол амсаж, гэм зэмгүй олон мянган хүний амь нас хохирч, иргэд хөдөө орон нутаг, жижиг тосгон

зэрэг аюулгүй газар руу орон гэрээ орхиж нүүхэд хүрсэн. Мөн Европын холбооны орнууд руу албан ёсны тоогоор 5 сая хүн дүрвэсэн судалгаа байна¹⁷⁴.

Хоёр тал 2022 оны 7 дугаар сард Нэгдсэн үндэстний байгууллагын тусламжтайгаар Турк улсад хэлэлцээр байгуулахаар шийдвэр гаргаж, тус хэлэлцээрт "...үр тариа тээвэрлэж буй аливаа тээврийн хэрэгсэл рүү гал нээхгүй байх..." гэсэн заалт оруулж талууд хэлэлцээр байгуулсны дараа 2022 оны 7 дугаар сарын 26-ны өдөр Украин улсын Одесса боомт руу ОХУ-ын талаас хоёр пуужин харвасан үйлдэл нь дэлхий нийтийг цочроосон билээ. Гал зогсоож чадаагүй хэлэлцээр ёсоор үр тариа тээвэрлэж байгаа тээврийн хэрэгсэл рүү гал нээхгүй гэсэн заалтыг ОХУ-ын талаас зөрчсөн явдал нь Украин улс төдийгүй дэлхийн олон орны хүнсний аюулгүй байдалд заналхийлсэн үйлдэл болсон юм.

Оросын Холбооны Улс, Украин улс хоорондын дайны нөхцөл байдал хэрхэн шийдвэрлэгдэж дуусах нь тодорхойгүй, тус хоёр улсын улаан буудай, бордоо, үр тарианы экспорт зогсонги байдалд байгаагаас үр тарианы үнэ өсөж, дэлхийн эдийн засаг, олон орны хүнсний аюулгүй байдалд, Европын холбоо, Монгол улсын тогтвортой хөгжилд нөлөөлж, улмаар сөрөг үр дагаварт хүргэх өндөр эрсдэлтэй байгаа талаар илэрхийлж, шийдвэрлэх арга замыг эрэлхийлж, өөрийн дүгнэлт саналыг хуваалцахыг зорилгоо.

Түлхүүр үг: Европын холбоо¹⁷⁵, Оросын Холбооны Улс, Украин улс, дайн, хүнсний аюулгүй байдал¹⁷⁶

¹⁷⁴ <https://said.mn/content/11/123412>;

¹⁷⁵ https://mn.wikipedia.org/wiki/Европын_холбоо., "...Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Урьд нь байсан Европын Нүүрс Гангийн Нийгэмлэг, болон Европын Эдийн Засгийн Нийгэмлэгийг 1958 онд нийлүүлж, 6 улсын гишүүнчлэлтэйгээр Европын Нийгэмлэгийг байгуулагджээ. Эхний хэдэн жилүүдээс гишүүд шинээр элссээр бүх талын үйл ажиллагаа нь өргөжсөөр 1992 оны "Маастрихт"-ын Гэрээгээр тохиролцож Европын Холбоо (ЕХ) хэмээх одоогийн нэрээ авч 1993 оны 11 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болжээ..."

¹⁷⁶ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор "Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ыг баталсан. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дахь хэсэг Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга замыг тодорхойлж, Хүнсний аюулгүй байдлын 9 хэсэгт хувааж тодорхойлон бичсэн.

- Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "...Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн зохистой нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ..."
- Мөн хэсгийн 3.4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...Монгол хүний амьдралын зайлшгүй хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүний 70-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэлээр тогтвортой хангах техник, эдийн засгийн арга хэмжээ авна..."
- Мөн хэсгийн 3.4.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "...Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулах урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах, гамшгийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц, хот, суурин газрын хүн амын хүнсний эрэлт нийлүүлэлтийг тогтвортой байлгах улирлын нөөцийг бүрдүүлэх замаар хүнсний хангамжийн баталгааг хангана..."
- Мөн хэсгийн 3.4.2 дугаар зүйлийн 4 дахь хэсэгт "...Хүн амыг ундны усаар хүртээмжтэй хангах, чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг өндөржүүлэх арга хэмжээ авна..."
- Мөн хэсгийн 3.4.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "...Хүнсний түүхий эд бэлтгэл, үйлдвэрлэл, худалдаа-үйлчилгээ, хадгалалтын бүх үе шатуудад чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоог бий болгоно..."
- Мөн хэсгийн 3.4.2 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт "...Мал эмнэлгийн тогтолцоог шинэчилж, малын халдварт өвчинтэй тэмцэх чадавхийг дээшлүүлж, халдвар, хамгаалал, биоаюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгоно. Монгол малын удмын сан, үр тарианы нутагшмал сортыг хамгаална. Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хүнсний сав, баглаа

Украин улсад зэвсэгт мөргөлдөөн эхлэхээс өмнө олон улсын хүнсний боловсруулсан болон хагас боловсруулсан барааны үнэ түүхэн дээд хэмжээндээ хүрсэн. Үүнд зах зээлийн нөхцөл байдал, мөн эрчим хүч, бордоо болон бусад бүх хөдөө аж ахуйн үйлчилгээний өндөр үнэ нөлөөлсөн хэмээн олон улсын байгууллагын шинжээчид үзэж байна.

Нэгдсэн үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын хүнсний үнийн индекс 2022 оны 3 дугаар сард түүхэн дээд хэмжээнд хүрснийг зарлаж, 2021 оны мөн үе буюу 2 дугаар сараас 12,6%, 2021 оны 3 дугаар сараас 33.6%-аар өссөн байна.

ОХУ, Украин улсууд нь дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний гол экспортлогч орнууд бөгөөд 2021 оны байдлаар ОХУ, Украин улсын улаан буудайн экспорт дэлхийн зах зээлийн 30 орчим хувийг эзэлж байсан. Мөн 2021 оны байдлаар ОХУ эрдэнэ шишийн экспортын 3%, Украин улс 16%-ийг дангаараа нийлүүлж байсан бол хоёр орны наранцэцэгийн экспорт дэлхийн зах зээлийн 78%-ийг эзэлж байсан.

Мөн ОХУ-ын хувьд 2021 онд дэлхийн зах зээлд азотын бордооны тэргүүлэгч экспортлогч, калийн бордооны хоёр дахь тэргүүлэгч, фосфорын бордооны гурав дахь том экспортлогч орон байсан.

Дэлхийн 50 гаруй улс улаан буудайны хэрэгцээнийхээ 30 гаруй хувийг ОХУ, Украин улсаас импортоор авдаг бөгөөд үүнээс 26 улс нь улаан буудайн хэрэгцээнийхээ 50%-ийг импортоор авч байсан¹⁷⁷.

Хоёр улсын дайны улмаас дэлхийн зах зээл, хүнсний хангамжид олон талын нөлөө үзүүлж, олон орны хүнсний аюулгүй байдал, ялангуяа хүнсний импортоос хамааралтай бага орлоготой улс орнууд болон хүн амын эмзэг бүлгийн хувьд хүнсний аюулгүй байдалд том сорилт учруулсан.

2021 оны байдлаар ОХУ болон Украин улс нь улаан буудай, эрдэнэ шиш, рапс, наранцэцэгийн үр, наранцэцэгийн тосны дэлхийн хамгийн том гурван экспортлогчийн тоонд багтсан бол ОХУ нь азотын бордоогоор дэлхийн тэргүүлэгч экспортлогч болж, калийн бордооны нийлүүлэлтээр хоёрдугаарт бичигдэж, фосфорын бордооны гурав дахь том экспортлогч болж байсан. Дайны улмаас Украин улсын хүн амын хамгийн ихээр оршин суудаг бүсүүдэд хоол хүнс, ус, эрчим хүчний хангамж хомсдолд хүрсэн. Тухайлбал,

1. Намрын ургац хураалт, хаврын тариалалт тасалдсан.

боодол, бордоо, ургамал хамгааллын бодис ашиглах хяналтыг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ...”

- Мөн хэсгийн 3.4.2 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “...Хүнсний чанар, аюулгүй байдлын техникийн шаардлагыг олон улсын стандарттай нийцүүлэн шинэчилж, хяналтын тогтолцоог бэхжүүлэн, олон улсын итгэмжлэлд хамруулах арга хэмжээ авна...”
- Мөн хэсгийн 3.4.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт “...Хүнсний бүтээгдэхүүнийг зөвхөн аж ахуйн нэгж, байгууллагаар дамжуулан импортлох тогтолцоог бүрдүүлж, импортын хүнсний бүтээгдэхүүнд чанарын урьдчилсан хяналт, бүртгэлжүүлэлт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоо бий болгох, импортлох үеийн чанарын баталгаат байдалд эрсдэлийн үнэлгээ хийх замаар чанар, аюулгүй байдлын баталгааг хангана...”
- Мөн хэсгийн 3.4.2 дугаар зүйлийн 9 дахь хэсэгт “...Нанотехнологи, биотехнологийн эрсдэлийг үнэлэх, хянах, түүний хор хөнөөлөөс хамгаалах арга хэмжээ авна... гэж тус тус заасан байдаг.

¹⁷⁷ Б.Анхбаяр, Ц.Амар, Л.Бямбаханд, Н.Гэрэлт-Од, Б.Индра, Т.Ишгомбо, Ц.Мөнхбаяр, Ч.Наваанпунцаг, П.Нямбаяр, Х.Урангоо, Н.Соёлгэрэл, Ч.Сумъяа, С.Сүхчулуун, Г.Тод, Б.Хуягбаатар, Б.Эрдэнэчимэг, “Гадаад орчны эргэлт, хувирал 2022”, УБ., 2023 он., /ОХУ, Украинаас үүдсэн хүнсний аюулгүй байдал/ 179 дахь тал;

2. Хөдөө аж ахуйн салбар дахь ажиллах хүчний хомсдол үүссэн.
3. Ургацын бордоо, түлшний нийлүүлэлт тасалдсан.
4. Хаврын тариалалтын үед зэвсэгт мөргөлдөөнөөс үүдэн ургац ихээр гэмтсэн.
5. Хөдөө аж ахуйн тариалалтын дэд бүтэц ерөнхийдөө устсан.
6. Тариалалтын газрууд хоосорсон.

НҮБ-ын ХХААБ нь Украин улсын Хөдөө аж ахуйн яам, орон нутгийн засаг захиргааны удирдлагуудтай өнөөгийн нөхцөл байдал дээр тулгуурлан үнэлгээ хийж үзсэний үндсэн дээр анхан шатны дүгнэлтэд хүнсний аюулгүй байдал хүнд байгаа хэд хэдэн бус нутгуудын талаар дурдсан байдаг.

ОХУ болон Украин улс нь импортын хүнсний бүтээгдэхүүний бордооноос ихээхэн хамааралтай олон орны гол нийлүүлэгч юм. Тухайн улс орнуудын ихэнх нь нэн буурай орнуудын бүлэгт хамаардаг бол бусад нь бага орлоготой хүнсний хомсдолд өртөх магадлалтай орнуудын бүлэгт багтдаг. Жишээлбэл, Африк тивийн Эритрей улс 2021 онд улаан буудайн импортынхоо 53 хувийг ОХУ-аас харин 47 хувийг Украин улсаас бүрдүүлсэн байна. Хойд Африк, Баруун болон төв Азийн олон орны улаан буудайн импорт нь ОХУ, Украин улсын нийлүүлэлтээс ихээхэн хамааралтай¹⁷⁸.

Дайны улмаас үүсэж буй ОХУ болон Украин улсын хүнсний экспортын тасалдал нь дэлхийн хүнсний зах зээлийн олдоц муудах, импортын тасалдал үүсэх цаашлаад хүнсний үнийн өсөлт зэрэг эрсдэлд хүргэж байна.

НҮБ-ын ХХААБ-аас хоёр улсын дайны өмнө гаргасан 2021, 2022 оны улирлын чанартай худалдааны таамаглал болон 2 дугаар сар хүртэл бүртгэгдсэн экспортын нөхцөл байдал дээр үндэслэн Украин улс 2022 оны 3-6 дугаар сарын хооронд ойролцоогоор 6 сая тонн улаан буудай экспортлох төлөвтэй байсан. Энэ хугацаанд ОХУ дахин 8 сая тонныг тээвэрлэх төлөвтэй байсан. Гэсэн хэдий ч Украин дахь боомтуудыг хааж, нийлүүлэлтийн сүлжээ тасалдсан, санхүүгийн хориг арга хэмжээний улмаас ОХУ-д хүлээгдэж буй борлуулалтын хүндрэлүүд нь эдгээр экспортыг бодитоор хэрэгжүүлэх эсэх талаар эргэлзээ төрүүлж эхэлсэн байдаг.

Дэлхийн улаан буудайн хэрэгцээний хомсдол нь Ойрх Дорнод болон хойд Африкийн улс орнуудад онцгой хүндрэл учруулж байгаа бөгөөд эрэлт хэт их байгаагаас улаан буудайны үнэ өсөх нөхцөл бүрдүүлсэн.

Дэлхийн хамгийн том улаан буудайн импортлогчид болох Египет, Турк, Бангладеш, Иран улсууд дунджаар (2016/17/2020/21) улаан буудайн импортын 60 ба түүнээс дээш хувийг Украин, ОХУ-аас авсан. 2021/22 онд Египет, Турк, Бангладеш, Иран тус тус 6.6, 4.0, 3.7, 1.7 сая тонн импортын үлдэгдэлтэй байна. Ливан, Тунис, Йемен Ливи, Пакистан зэрэг улсууд Украин, ОХУ-аас гаралтай улаан буудайн бүтээгдэхүүнд ихээхэн түшиглэдэг бөгөөд дунджаар (2016-2021) улаан буудайн худалдан авалтынхаа тал орчим хувийг эдгээрээс авдаг¹⁷⁹.

Украин дахь зэвсэгт мөргөлдөөн Европын эдийн засагт онцгой нөлөө үзүүлж, ОХУ эрчим хүчний экспортоо зогсоосон тул эрчим хүчний үнэ 40 хувиар өссөн. Европын

¹⁷⁸ Б.Анхбаяр, Ц.Амар, Л.Бямбаханд, Н.Гэрэлт-Од, Б.Индра, Т.Ишгомбо, Ц.Мөнхбаяр, Ч.Наваанпунцаг, П.Нямбаяр, Х.Урангоо, Н.Соёлгэрэл, Ч.Сумъяа, С.Сүхчулуун, Г.Тод, Б.Хуягбаатар, Б.Эрдэнэчимэг, “Гадаад орчны эргэлт, хувирал 2022”, УБ., 2023 он., /ОХУ, Украинаас үүдсэн хүнсний аюулгүй байдал/ 180 дахь тал;

¹⁷⁹ Б.Анхбаяр, Ц.Амар, Л.Бямбаханд, Н.Гэрэлт-Од, Б.Индра, Т.Ишгомбо, Ц.Мөнхбаяр, Ч.Наваанпунцаг, П.Нямбаяр, Х.Урангоо, Н.Соёлгэрэл, Ч.Сумъяа, С.Сүхчулуун, Г.Тод, Б.Хуягбаатар, Б.Эрдэнэчимэг, “Гадаад орчны эргэлт, хувирал 2022”, УБ., 2023 он., /ОХУ, Украинаас үүдсэн хүнсний аюулгүй байдал/ 181 дахь тал;

орнуудын имфляци 8.9 хувьд хүрч, гадаад худалдаа 28.3 гаруй тэрбум еврогийн алдагдалтай гараад байна¹⁸⁰.

2022 оны 5 дугаар сарын байдлаар Украин улсын тал 20 сая тонн үр тариаг бэлтгэж Африк тивийн хөгжиж буй, буурай орнууд руу экспортлох болсон. Үүний үр дүнд ОХУ-тай үр тариа тээвэрлэх хэлэлцээр байгуулахаар тохиролцоонд хүрч, ОХУ-ын арми хар тэнгист цэргээ байрлуулсан бөгөөд ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин ОХУ-ын эсрэг тавьсан хоригийн хариуд үр тарианы экспортоо зогсоосон.

Гэрээнд гарын үсэг зурснаас хойш 24 цаг хүрэхгүй хугацааны дараа гэрээнд дурдсан үндсэн боомт Оросын хоёр Калибр далавчит пуужингийн довтолгоонд өртсөн байдаг¹⁸¹. ОХУ сүүлийн хэд хоногт Украин улсын Одесса боомт руу довтолж буйтай зэрэгцэн улаан буудайн үнэ 8.5 хувиар өссөн.

ОХУ-ын Батлан хамгаалах яам 2023 оны 7 дугаар сарын 25-ны өдөр "Одесса боомтыг чиглэн ирсэн бүхий л иргэний хөлөг онгоцыг цэргийн тээвэрлэгч хэмээн үзэх болно. Түүнчлэн ямар ч төрлийн үр тариа Одесса боомтоос гарах учиргүй" хэмээн анхааруулга өгсөн¹⁸² байна. Дайнаас болоод дэлхийн улс орнууд импортын үр тариагаа авч чадахгүй хүнсний хомсдолд орох эрсдэл улам их нэмэгдэж байна.

Монгол улсын хувьд 2021 оны сүүлийн 5 сарын байдлаар 490 мянган тонн азотын бордоог 138 мянган ам.доллараар худалдан авсан. Харин улаан буудайн хувьд 1130 мянган тонн улаан буудайг импортолж 303 мянган ам доллароор худалдан авсан байдаг¹⁸³.

Монгол улсын эдийн засгийн 2022 оны эхний хагас жилийн тайланд дурдсанаар 1.9 хувиар өссөн. Эдийн засгийн өсөлтийг салбараар авч үзвэл уул уурхай олборлолтын салбар 3.7%, үйлдвэр барилгын салбар 0.1% агшсан нь улсын төсвийн орлого бүрэлдэхгүй алдагдалтай гарах магадлалыг нэмэгдүүлж байна. Орлого буурснаас болж зарим санхүүжүүлэх төсөл хөтөлбөр болон Засгийн газрын худалдан авах ажиллагаа зогсох эрсдэл дагуулж байна.

Харин хөдөө аж ахуй, үйлчилгээний салбар өсөлттэй гарсан ч энэ бол түр зуурын өсөлт болж байна. Монгол улсын хөдөө аж ахуйн салбар улирлын чанартай Засгийн газрын дэмжлэгээр богино хугацаанд өсөлт үзүүлсэн. Үйлчилгээний салбарын хувьд ковидын дараах эдийн засгийн сэргэлттэй холбоотойгоор иргэдийн үйлчилгээний салбараар үйлчлүүлэх давтамж нэмэгдсэнтэй холбоотой. Цар тахлын үед авсан арга хэмжээ, мөнгөний нийлүүлэлт, ипотекийн зээлийн төлөлтийг хойшлуулалт 2022 оны эдийн засгийг сэргэж, үйлчилгээний салбар өсөлттэй гарсан боловч 2023 оноос зээлийн төлөлт хэвийн явагдаж эхэлсэн тул иргэдийн хэрэглээ татарч, үйлчилгээний салбар өсөлт үзүүлж чадахгүй байна.

Европын холбооны санхүүжилтээр хэрэгжүүлж буй төслүүдийг нийтэд авч үзэхэд 150 сая орчим еврогийн дүнд хүрч, эдийн засгийг солонгоруулж төрөлжүүлэх, засаглалыг сайжруулах, шүүх засаглалыг дэмжиж, ардчиллыг бэхжүүлэх, цаашлаад эрчим хүчний хангамж, аюулгүй байдал, тогтвортой ХАА-г хөгжүүлэх, ойн чиглэлээр гээд их олон салбарт

¹⁸⁰ Б.Анхбаяр, Ц.Амар, Л.Бямбаханд, Н.Гэрэлт-Од, Б.Индра, Т.Ишгомбо, Ц.Мөнхбаяр, Ч.Наваанпунцаг, П.Нямбаяр, Х.Урангоо, Н.Соёлгэрэл, Ч.Сумъяа, С.Сүхчулуун, Г.Тод, Б.Хуягбаатар, Б.Эрдэнэчимэг, "Гадаад орчны эргэлт, хувирал 2022", УБ., 2023 он., /Дэлхийн эдийн засаг хямрах болов уу/ 188 дахь тал;

¹⁸¹ <https://mpress.mn/p/9689>;

¹⁸² <https://news.zangia.mn/34931>;

¹⁸³ Б.Анхбаяр, Ц.Амар, Л.Бямбаханд, Н.Гэрэлт-Од, Б.Индра, Т.Ишгомбо, Ц.Мөнхбаяр, Ч.Наваанпунцаг, П.Нямбаяр, Х.Урангоо, Н.Соёлгэрэл, Ч.Сумъяа, С.Сүхчулуун, Г.Тод, Б.Хуягбаатар, Б.Эрдэнэчимэг, "Гадаад орчны эргэлт, хувирал 2022", УБ., 2023 он., 184 дахь тал;

төсөл хэрэгжиж байна. Үүнээс голлохыг дурдвал төсвийн дэмжлэг үзүүлэх 50 сая еврогийн төслийг Сангийн яамтай шууд хамтран хэрэгжүүлж байгаагаараа онцлог юм¹⁸⁴.

Хөдөө, орон нутагт тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх, ногоон эдийн засаг руу шилжих гэсэн хоёр гол чиглэлээр төслүүдийг 2021-2027 оны хооронд хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарч, эдгээр нь хүнсний аюулгүй байдлыг хангах, уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох үүднээс ойжуулалтыг нэмэгдүүлэхэд чиглэж байгаа талаар Европын холбооноос Монгол улсад суугаа Элчин сайд Аксель Никэйз илэрхийлсэн.

ДҮГНЭЛТ

Оросын Холбооны Улс, Украин улс хоорондын дайн удаан үргэлжилж байгаагаас шалтгаалан дэлхийн олон оронд улаан буудай, үр тариа, бордоо, наранцэцэг зэрэг хүнсний гол бүтээгдэхүүнүүдээ импортоор авч чадахгүй хүнсний хомсдолд орж, үр тарианы үнэ тасралтгүй өсөж, улмаар дэлхийн эдийн засагт нөлөөлж байна.

Дэлхийн олон орон, Европын холбооны зүгээс дайн эхлүүлсэн Оросын Холбооны Улсын эсрэг хориг арга хэмжээг ихээр авсан. ОХУ-ын гадаад худалдаа зогсонги байдалд шилжиж, Украин улсын худалдааны гол зам болох Хар тэнгис ОХУ-ын мэдэлд орсон нь экспортыг хумьсан. Харин олон улсад хүнсний салбарт тус хоёр улсаас хамааралтай олон орнууд ялангуяа хөгжиж байгаа болон буурай орнууд их байгаа нь хүнсний хомсдол үүсэх, өлсгөлөнд нэрвэгдэх зэрэг эрсдэлүүд тулгарсан.

Хоёр талаас Турк улсад үр тарианы экспортын хэлэлцээрийг байгуулсан ч төдийлөн үр дүнд хүрээгүй байгаа өнөө цагт дэлхийн энх тайван, хүн төрөлхтний сайн сайхны төлөө талууд гал зогсоох хэлэлцээр байгуулж, Оросын Холбооны Улсын зүгээс Украин улсаас цэргээ гаргаж, үр тариа, улаан буудайн экспортоо хэвийн явуулах хэрэгцээ шаардлага үүссэн.

Монгол улсын хувьд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн дагуу Улсын их хурал, Засгийн газар хүнсний хангамж, аюулгүй байдалд анхаарч “Хүнсний хувьсгал” эхлүүлсэн тул 2023-2024 оны хооронд үр тариа, улаан буудай, бордооны импортын асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна.

САНАЛ

1. Оросын Холбооны Улсын зүгээс Украин улсаас цэргээ гаргаж, Украин улсын экспортын гол зам хар тэнгисийг чөлөөлөх.
2. Оросын Холбооны Улсаас Украин улсын Одесса боомт руу довтлохоо зогсоох.
3. Оросын Холбооны Улс, Украин улс хооронд гал зогсоох хэлэлцээр байгуулах.
4. Оросын Холбооны Улс, Украин улсын үр тариа, улаан буудайн экспортыг дэмжиж, олон улсад үр тарианы үнийн өсөлтийг тогтворжуулах.
5. Монгол улсын зүгээс Оросын холбооны улс, Украин улс руу хандан дайныг зогсоох талаар уриалах.

¹⁸⁴ <https://montsame.mn/mn/read/318990>;

НОМ ЗҮЙ

➤ **Судалгаа, хурлын эмхэтгэл:**

1. Б.Анхбаяр, Ц.Амар, Л.Бямбаханд, Н.Гэрэлт-Од, Б.Индра, Т.Ишгомбо, Ц.Мөнхбаяр, Ч.Наваанпунцаг, П.Нямбаяр, Х.Урангоо, Н.Соёлгэрэл, Ч.Сумъяа, С.Сүхчулуун, Г.Тод, Б.Хуягбаатар, Б.Эрдэнэчимэг, “Гадаад орчны эргэлт, хувирал 2022”.УБ.,2023 он;

➤ **Цахим хуудас:**

1. <https://mpress.mn/p/>;
2. <https://news.zangia.mn/>;
3. <https://montsame.mn/>;

ЕВРОПЫН ХОЛБОО БА МОНГОЛ УЛС: ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА*ҮБХИС-ийн багш С.Мандалмаа***Abstract**

Mongolia has established diplomatic relations with the European Union since 1989 and has been developing official relations and cooperation. In Mongolia's foreign policy concept, it is defined as the second direction of Mongolia's political foreign relations policy to expand and develop partnership relations and cooperation within the policy of the third neighboring countries, such as the European Union.

The national security concept stipulates the development of bilateral and multilateral relations and cooperation with advanced democracies in the political, economic, cultural and humanitarian fields within the framework of the Third Neighborhood Policy.

The partnership and cooperation agreement concluded in 2013 became the legal basis for expanding relations between the European Union and Mongolia. It provides opportunities for cooperation in political relations, trade, mutual development assistance, agriculture, community development, energy, climate change, research and innovation, education and culture.

The development assistance to support Mongolia will strengthen sustainable development, meet the goals of the Millennium Development and New Revival policies, and cooperate with the Government of Mongolia and civil society organizations of Mongolia with the main goal of reducing poverty. projects and programs are being implemented in two directions.

The total amount of funding for development cooperation projects implemented in Mongolia is 190 million euros, and the amount of grants provided by the European Commission in 2014-2020 is equal to 85 million euros, and 31 million euros of grant funding will be provided in 2021-2024.

We continue to create progress and further opportunities for cooperation developed within the medium-term cooperation program and the Global Gateway program. Mongolia's relations and cooperation with the European Union play an important role in strengthening the country's independence and sovereign independence and economic development.

Түлхүүр үг: Европын холбоо, харилцаа, хамтын ажиллагаа.

Үндсэн хэсэг

Европын холбоо нь Европын хорин долоон орноос бүрдсэн гишүүн орнуудын эдийн засаг, улс төр, нийгмийн хамтын ажиллагааг дэмжих зорилготой олон улсын холбоо юм.

Европын холбооны гол зорилтууд нь:

- Энх тайван, иргэдийн сайн сайхан байдлыг дэмжих
- Хүний үнэт зүйлийг хүндэтгэж хамгаалах
- Дотоодын хил хязгаарыг үл харгалзан бүс нутгийн хэмжээнд байгаа иргэдийн эрх чөлөө, аюулгүй байдал, шударга ёсны баталгааг хангах
- Гишүүн орнуудын эдийн засгийн хөгжил, амьдралын чанарт хүрч, хадгалах
- Үүнийг бүрдүүлдэг орнуудын эв нэгдэл, ахан дүүс, эв нэгдлийг дэмжих
- Байгаль орчны талаар баримтлах бодлого, тогтвортой хөгжлийн эрэл хайгуул хийх
- Европын холбооны соёлын болон хэл шинжлэлийн олон янз байдлыг хүндэтгэж хамгаалах
- Шинжлэх ухаан, технологийн хөгжлийг дэмжих
- Европын соёлын ба байгалийн өвийг хамгаалах явдал.

Олон улсын тавцанд Европын Холбоо дэлхийн олон улс, холбоо, тивийн хамгийн том худалдааны түнш нь болж байна.¹⁸⁵

1. БНХАУ–Европын Холбооны худалдаа эргэлт \$828 тэрбум (1)

¹⁸⁵ <https://ec.europa.eu/eurostat/web/international-trade-in-goods/overview>

2. АНУ–Европын Холбооны худалдаа эргэлт \$696 тэрбум (1)
3. ОХУ–Европын Холбооны худалдаа эргэлт \$273 тэрбум (1)
4. Африк–Европын Холбооны худалдаа эргэлт \$317 тэрбум (1)
5. ASEAN–Европын Холбооны худалдаа эргэлт \$210 тэрбум (2)¹⁸⁶

Худалдаа, эдийн засгийн болон бусад хамтын ажиллагааны талбарт Европын Холбоо өөрийн түнш бүрийн тэргүүлэх хамгийн чухал түншид тооцогдож улс орнууд Европын Холбоотой худалдааны ашигтай хэлцэл байгуулах, худалдан авах өндөр чадвартай зах зээлд нь нэвтрэх, өндөр технологи авах, бусад хамтын ажиллагааны хөтөлбөрт нь нэгдэхийг зорьж байна. Зөөлөн хүчний энэ үнэмлэхүй давуу талаа ашиглан ирээдүйд Европын Холбоо дэлхийн бодлогод оролцогч бүх талуудад нөлөөлж чадах, заримдаа бодлого шийдвэр тулгаж чадах чадамжтай геополитикийн нэгэн шинэ хүндийн төв болон хувирч байна.¹⁸⁷

Европын Холбооны эдийн засгийн болон улс төр, дипломатын хүчин чадал, стратеги төлөвлөгөө зэргээс харахад олон туйлт харилцааны орчинд геополитикийн үндсэн тоглогчдын нэг болох нь харагдаж байна.

Монгол улс Европын хамтын нийгэмлэгтэй 1989 оны 8 дугаар сарын 1-ний өдөр дипломат харилцаа тогтоосон бөгөөд Монгол улс 1992 оноос Брюссельд элчин сайдын яамаа нээн ажиллуулж, 1991 оноос ЕХН-ийн Төлөөлөгчийн газар Монгол улсыг Бээжингээс хавсран сууж байсан бөгөөд 2017 оны 11-р сараас Улаанбаатар хотод Европын Холбооноос Монгол улсад суугаа Төлөөлөгчийн газраа албан ёсоор нээн ажиллуулж байгаа нь хоёр талын харилцаанд чухал ахиц болсон юм.

Монгол улс ба Европын холбооны харилцаа, хамтын ажиллагаа нь

- 1993 онд “Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”
- 1995 онд “Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн худалдаалах тухай хэлэлцээр”
- 1997 онд “Европын хөрөнгө оруулалтын банкттай хамтран ажиллах ерөнхий хэлэлцээр”
- 2000 онд “Европын сэргээн босголт, хөгжлийн банкны гишүүн”-ээр элссэн
- 2009 онд “Агаарын харилцааны тухай хэлэлцээр”
- 2013 онд “Түншлэл, хамтын ажиллагааны тухай хэлэлцээр”
- 2013 онд “Монгол улсын стандартчиллын тогтолцоог боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх” тухай төслийн санхүүжилтийн гэрээ
- 2015 онд Хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх олон жилийн баримжаалсан хөтөлбөрийг эхлүүлэх тухай санамж бичиг
- 2022 онд “Ойн хамтын ажиллагааны тухай харилцан ойлголцлын санамж бичиг”
- 2022 онд “Газар зүйн заалтын тухай” хэлэлцээрээр тус тус зохицуулагддаг.

Европын холбоо нь 130-аад сая еврогийн санхүүжилт бүхий 32 төсөл, арга хэмжээг Монгол улсад хэрэгжүүлж байна.

Монгол улсын гуравдагч хөршийн бодлогын хүрээнд Европын холбоотой тогтоосон харилцаа, хамтын ажиллагаа өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд цогц байдлаар хөгжиж ирснийг хоёр талын харилцан хийсэн өндөр дээд түвшний айлчлалууд, тэдгээрийн дүнд гаргасан мэдэгдэл зэргээс тодорхой харж болно.

Монгол Улс ба Европын холбооны харилцаа, хамтын ажиллагаа нь дараах үндсэн чиглэлүүдээр хийгдэж байна. Үүнд:

- Улс төрийн харилцаа
- Эдийн засгийн харилцаа
- Хөгжлийн хамтын ажиллагаа
- Шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаа
- Боловсрол, соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагаа

¹⁸⁶ https://ec.europa.eu/eurostat/statistics-explained/index.php?title=China-EU_-_international_trade_in_goods_statistics

¹⁸⁷ https://ec.europa.eu/international-partnerships/home_en

Монгол улс, Европын хамтын нийгэмлэгийн хооронд 1993 онд байгуулсан Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрт заасны дагуу байгуулагдсан Монгол улс, Европын холбооны хамтын ажиллагааны хамтарсан хорооны хуралдаан жил бүр зохион байгуулагдаж хоёр талын улс төр, гадаад бодлого, эдийн засгийн харилцааны асуудлаар харилцан мэдээлэл, санал солилцож, байр сууриа илэрхийлэх, хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлох чухал механизм болоод байна.¹⁸⁸

Европын холбоо болон түүний гишүүн орнуудаас Монгол улсад суугаа элчин сайд нарын уулзалтыг 2009 оноос хойш жил бүр уламжлал болгон зохион байгуулж, хоёр талын харилцааны байнгын механизм болгон тогтмолжуулсан нь Европын холбооны гишүүн улсуудаас тус улсад суугаа, хавсран суугаа элчин сайд нар Улаанбаатар хотноо цуглан Монгол улсын Засгийн газрын гишүүдтэй уулзаж, манай улсын улс төр, нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах, хамтын ажиллагааны талаар санал солилцох боломжийг олгодог бөгөөд Монгол улсын Засгийн газрын гишүүд элчин сайд нарт мэдээлэл хийж, элчин сайд нарын сонирхсон асуултад хариулж ирсэн уламжлалтай болжээ.¹⁸⁹

Европын холбоо Монгол Улсын харилцааг өргөжүүлэх эрх зүйн үндэс болсон түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээрт 2013 оны дүгээр сард гарын үсэг зурсан бөгөөд уг хэлэлцээр нь улс төрийн харилцан яриа, худалдаа, хөгжлийн туслалцаа, хөдөө аж ахуй, орон нутгийн хөгжил, эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлт, судалгаа шинжилгээ ба инновац, боловсрол ба соёлын салбарт хамтран ажиллах боломжийг бий болгосон.¹⁹⁰

Хөгжлийн хамтын ажиллагаа

Хөгжлийн туслалцаа нь Европын холбоо Монгол улсын хоорондох харилцааны тогтвортой хөгжлийг бэхжүүлэн, мянганы хөгжлийн зорилгыг хангаж, ядуурлыг бууруулах туйлын зорилготойгоор Монгол улсын Засгийн газар, Монголын иргэний нийгмийн байгууллагуудад дэмжлэг үзүүлдэг.

Европын холбоо нь Монгол улстай 1993 оноос хөгжлийн хамтын ажиллагаа эхлүүлэн өнөөг хүртэл амжилттай явуулж ирсэн. Европын холбооноос үзүүлж буй тусламжуудыг товч дурдвал:

1993-2005 “Европын комиссын хүмүүнлэгийн ЭКО алба”-ны хүмүүнлэгийн тусламжийн хүрээнд – 9,6 сая евро

1994-2004 ТАСИС хөтөлбөрийн хүрээнд – 48,5 сая евро

2004-2006 АЛА хөтөлбөрийн хүрээнд – 11,5 сая евро

2007-2013 DCI Үндэсний стратегийн баримт бичгийн хүрээнд 29 сая евро

2014-2020 Олон талт баримжаат хөтөлбөрийн хүрээнд 65 сая еврогийн хөгжлийн тусламж үзүүлэх шийдвэрийг баталгаажуулсан санамж бичигт талууд 2015 оны 6 дугаар сард гарын үсэг зурсан.¹⁹¹

Монгол улсад хэрэгжүүлж буй хөгжлийн хамтын ажиллагааны төслийн нийт санхүүжилтийн хэмжээ 190 сая евро бөгөөд Европын комиссоос 2014-2020 онд үзүүлэх буцалтгүй тусламжийн хэмжээ 85 сая евротой тэнцэж байна.¹⁹²

¹⁸⁸ Монгол улсын ГХЯ, Монгол улс, Европын холбооны харилцааны товч лавлах http://www.mfa.gov.mn/?page_id=41777#1489557940850-f4787a77-bbec

¹⁸⁹ Европын холбоо болон түүний гишүүн улсуудаас Монгол улсад суугаа, хавсран суугаа элчин сайд нарыг хүлээн авч уулзлаа, 2019/05/28 <https://president.mn/9145/>

¹⁹⁰ Монгол улс ба ЕХ, 12/05/2016 https://eeas.europa.eu/headquarters/headquarters-homepage/14771/node/14771_mn

¹⁹¹ Монгол улс - Европын холбооны харилцаа <https://brussels.embassy.mn/subcategory/364>

¹⁹² Түншүүд сайн сайхан ирээдүйн төлөө: ЕХ, түүний гишүүн орнууд ба Монгол улсын хоорондын хамтын ажиллагаа, Европын холбоо, 2016, т.4. https://eeas.europa.eu/sites/eeas/files/20160706monmongolia_0.pdf

Европын холбооноос Монгол улсад 2014-2020 онд хэрэгжүүлэх хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд орлогыг тогтвортой хөгжилд зарцуулж, сайн засаглалыг бий болгох, ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх гэсэн хоёр чиглэлд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Монгол улсын стандартчиллын тогтолцоог боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх төсөл (2017 оны 6 дугаар сард хэрэгжүүлж дууссан)
2. Техник болон мэргэжлийн боловсрол сургалтын салбарыг дэмжих төсөл
3. Эдийн засгийн тэгш өсөлтийг хангах сайн засаглал төсөл
4. Ажлын байр нэмэгдүүлэх: Хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийн өртгийн сүлжээг хөгжүүлэх
5. Гадаад худалдааг нэмэгдүүлж, экспортод дэмжлэг үзүүлэх зорилготой “Trade related assistance” төсөл зэрэг болно.¹⁹³

Европын холбоо, Дэлхийн банкны хамтран хэрэгжүүлж буй Европын холбооны санхүүжилттэй Монгол улсад засаглалыг бэхжүүлэх төсөл нь 2018 оноос эхлэн төсвийн сахилга бат, төрийн санхүүгийн удирдлага болон ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах замаар засаглалыг бэхжүүлэх чиглэлд хэрэгжиж байна. Уг төсөл нь Европын холбооноос 4.8 сая еврогийн буцалтгүй тусламжийн санхүүжилттэй бөгөөд төсөв санхүүгийн удирдлагын шинэчлэл хийх стратеги, ажлын төлөвлөгөө (2018-2022)-нд туссан тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Сангийн яам, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Үндэсний аудитын газарт техникийн туслалцаа үзүүлдэг. Уг төслийн хүрээнд 680,000 еврогийн санхүүжилтийг коронавируст халдвар (COVID-19)-тай холбоотой үүсээд байгаа онцгой байдалд хариу арга хэмжээ авах, түүний богино болон дунд хугацаанд үзүүлэх нөлөөг зохицуулахад чиглэсэн Засгийн газрын үйл ажиллагааг дэмжихэд зориулахаар болсон.

Европын холбоо “зөөлөн хүч”-ний бодлогоо Монгол улсад амжилттай хэрэгжүүлж байгааг боловсрол, соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагаанаас харж болно. 2015 оны байдлаар Европын холбоо болон түүний гишүүн орнуудын Монгол улсын боловсрол, шинжлэх ухаан, соёл, эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж буй хөгжлийн хамтын ажиллагааны төслийн нийт санхүүжилтийн хэмжээ 21.6 сая евро байгаа бөгөөд Европын комиссоос 2014-2020 онд үзүүлэх буцалтгүй тусламжийн хэмжээ 85 сая евротой тэнцэж байна.¹⁹⁴

Европын холбооны гишүүн орнууд монгол оюутныг тэтгэлэгтэйгээр суралцуулдаг бөгөөд тухайлбал, Унгар улс жил бүр 100 тэтгэлэг бакалавр (BA/BSc), магистр (MA/MSc) болон докторантурын (PhD) сургалтад¹⁹⁵, Герман улс жил бүр 10-15 оюутанд Холбооны засгийн газрын тэтгэлэг олгодог. Монгол улсын БСШУЯ, БНФУ-ын Гадаад хэрэг, олон улсын хөгжлийн яам хооронд сургалтын хамтарсан тэтгэлгийн хөтөлбөрийн хэрэгжүүлэх хэлэлцээрийг 2015 оны 11 дүгээр сарын 19-нд байгуулсан бөгөөд энэ хүрээнд 10 монгол оюутанд тэтгэлэг олгоод байна.¹⁹⁶

Монгол улс, Европын холбооны хооронд байгуулсан түншлэл, хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийн хүрээнд Монгол улс, Европын холбооны хамтын ажиллагааны хамтарсан хорооны 2023 оны 7 дугаар сарын 26-ны өдөр Брюссель хотноо зохион

¹⁹³ Монгол улс, Европын холбооны харилцааны товч лавлах http://www.mfa.gov.mn/?page_id=41777#1489557942077-7a16c984-be1b

¹⁹⁴ Түншүүд сайн сайхан ирээдүйн төлөө: ЕХ, түүний гишүүн орнууд ба Монгол улсын хоорондын хамтын ажиллагаа, Европын холбоо, 2016, т.4. https://eeas.europa.eu/sites/eeas/files/20160706monmongolia_0.pdf

¹⁹⁵ Мадари Акош: Унгар, Монголын харилцааг шинэ шатанд гаргана. 2015 оны 07-р сар 30. <http://mongolcom.mn/read/24315>

¹⁹⁶ ГХЯ, Монгол улс, ХБНГУ-ын харилцааны товч лавлах. http://www.mfa.gov.mn/?page_id=18989#1489558188581-0e8f4131-00fd

байгуулсан ээлжит хуралдааны үеэр Монгол улс гуравдагч хөршийн бодлогыг тууштай дэмжихээ Европын холбоо нотолж, олон талт хамтын ажиллагаанд оруулж буй Монгол улсын хувь нэмрийг сайшаасан билээ.

Европын холбооноос Монгол улсад 2021-2027 онд хэрэгжүүлж буй “Хамтын ажиллагааны дунд хугацааны хөтөлбөр” болон Европын холбооны “Дэлхийд гарах гарц хөтөлбөр”-ийн тэргүүлэх чиглэл болох тогтвортой ногоон хөгжлийг хөхиүлэн дэмжих асуудлаар Монгол улс, Европын холбоо нийтлэг зорилготой бөгөөд Дэлхийд гарах гарц хөтөлбөрийн чухал зорилт болох Ойн түншлэлийн хэлэлцээрт 2022 оны 11 дүгээр сард болсон уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дээд түвшний уулзалтын үеэр гарын үсэг зурсан 5 улсын нэг нь Монгол улс юм. Хоёр тал уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, байгаль орчныг хамгаалах, Парисын хэлэлцээр болон тогтвортой хөгжлийн зорилтыг бүрэн хангахад үр дүнтэй хамтран ажиллахаар тохиролцсон.

Эдийн засаг, гадаад худалдааны бүтцээ тогтвортой төрөлжүүлэх, бизнесийн орчныг сайжруулах, худалдааны бодлого, үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр Монгол улсын хүчин чармайлтад үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэхээ Европын холбоо нотлон Газарзүйн заалтыг хамгаалах тухай хэлэлцээрийн төслөөр 2022 онд эхлүүлсэн яриа хэлэлцээг эцэслэх эрмэлзлээ Монгол улс, Европын холбоо илэрхийлсэн.

Түүнчлэн хоёр талын хамтын ажиллагааг аюулгүй байдлыг хангах тухайлбал, энхийг сахиулах үйл ажиллагааны хүрээнд өргөжүүлэх боломжийг судлахаар болж Монгол улс, Европын холбоо болон түүний гишүүн орнуудтай хөгжүүлж буй харилцаа, тэр дундаа Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хувьд Зэвсэгт хүчний НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд энхийг сахиулагчдын чадавхыг бэхжүүлэх, бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, хамтран үүрэг гүйцэтгэх чиглэлд хамтын ажиллагааг өргөжүүлэхээр ажиллаж байна.

Европын холбооны Дэлхийд гарах гарц хөтөлбөр, Европын холбооны гишүүн орнуудын Европын баг санаачилга, Европын хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр ногоон шилжилт, цахимжуулалтын салбар дахь хамтын ажиллагаагаа Монгол улсын дунд болон урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан бэхжүүлэхээр талууд тохиролцсон.

.Дүгнэлт

Монгол улс Европын холбоотой 1989 оноос дипломат харилцаа тогтоож, албан ёсны харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж ирсэн бөгөөд Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд “... Европын холбоо ... зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх” нь Монгол улсын улс төрийн гадаад харилцааны бодлогын хоёр дахь чиглэл болохыг тодорхойлж, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Гуравдагч хөршийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ” гэж заасан, Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулсан нь Европын холбоо, Монгол улсын харилцааг өргөжүүлэх эрх зүйн үндэс бүрдэж, улс төрийн харилцан яриа, худалдаа, хөгжлийн туслалцаа, хөдөө аж ахуй, орон нутгийн хөгжил, эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлт, судалгаа шинжилгээ ба инновац, боловсрол ба соёлын салбарт хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн.

Гэвч Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Алсын хараа-2050 зэрэг бодлогын баримт бичигт Европын холбоо болон тус холбооны гишүүн орнуудтай харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх талаар тодорхой зүйлгүй байгаа нь учир дутагдалтай хэмээн судлаачид үздэг.

Тиймээс Монгол улсын томоохон гуравдагч хөрш болох Европын холбооны гадаад бодлого, Монгол улстай харилцах харилцаа, хамтын ажиллагаа тухайлбал хөгжлийн хамтын ажиллагааг судлах нь ач холбогдолтой гэж үзэж байна.

Монгол улс, Европын холбооны хамтын ажиллагааны эхлэл 1993 онд Худалдаа, хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулагдсанаар анх тавигдсан бөгөөд Монгол улсаас

Европын холбоотой хоёр талын худалдаа, эдийн засаг, байгаль орчин, боловсрол, шинжлэх ухаан, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, стандартчилал зэрэг олон салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх, Европын холбооны Улаанбаатар дахь Техникийн товчоог Төлөөлөгчийн газар болгон өргөжүүлэх, Европын холбоон дахь үйл ажиллагаагаа өргөжүүлэх зэрэг чиглэлийг баримтлан ажиллаж байна.

Манай улсын хувьд 2016 онд батлагдсан Европын холбооны Гадаад ба Аюулгүй байдлын бодлогын глобал стратегийн тэргүүлэх чиглэлүүдийн 4 дүгээрт заасан Ази тивтэй хэлхээ холбоогоо бэхжүүлэх, 5 дугаарт заасан НҮБ, ялангуяа НҮБ-ын энхийг сахиулах, зуучлалын болон энхийг цогцлоох, хүмүүнлэгийн ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх, тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар хүлээсэн үүрэг амлалтаа хэрэгжүүлэх зэрэг зорилтын хүрээнд хамтын ажиллагаагаа өргөжүүлэх боломжтой.

Европын холбооны зүгээс гуравдагч орнууд руу чиглэсэн “зөөлөн хүч”-ний бодлого, олон нийтийн дипломат ажиллагаанд анхаарал хандуулж, гишүүн орнуудаараа дамжуулан Монгол улсад боловсрол, соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагааг амжилттай хэрэгжүүлж байна.

Мөн Монгол улс, Европын холбооны харилцаа, хамтын ажиллагааны гол баримт бичиг болох “Түншлэл, хамтын ажиллагааны тухай хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, дунд хугацааны “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан зорилтот арга хэмжээ, Европын холбооны “Дэлхийд гарах гарц” хөтөлбөртэй уялдуулан ногоон шилжилт, цахимжуулалт, сэргээгдэх эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт зэрэг дэлхийн улс орнуудын өмнө тулгамдсан нийтлэг зорилтуудыг хангах хүрээнд Монгол улс, Европын холбоотой байгуулсан “Ойн түншлэл”-ээр бодит үр дүн гаргаж ажиллахаар байна.

Монгол улсад дэмжлэг үзүүлэх хөгжлийн туслалцаа нь тогтвортой хөгжлийг бэхжүүлэн, Мянганы хөгжлийн болон Шинэ сэргэлтийн бодлогын зорилтыг хангаж, ядуурлыг бууруулах үндсэн зорилготойгоор Монгол улсын Засгийн газар, Монголын иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах байдлаар орлогыг тогтвортой хөгжилд зарцуулж, сайн засаглалыг бий болгох, ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх гэсэн хоёр чиглэлд төсөл, хөтөлбөр хэрэгжиж байна.

Монгол улсад хэрэгжүүлж буй хөгжлийн хамтын ажиллагааны төслийн нийт санхүүжилтийн хэмжээ 190 сая евро бөгөөд Европын комиссоос 2014-2020 онд үзүүлсэн буцалтгүй тусламжийн хэмжээ 85 сая евротой тэнцэж, 2021-2024 онд 31 сая еврогийн буцалтгүй тусламжийн санхүүжилт олгохоор болоод байна.

Хамтын ажиллагааны дунд хугацааны хөтөлбөр /2021-2027 оны/, Дэлхийд гарах гарц хөтөлбөрийн хүрээнд өрнүүлсэн хамтын ажиллагааны ахиц, цаашдын боломжийг бий болгосоор байна.

Монгол улсын Европын холбоотой тогтоосон харилцаа, хамтын ажиллагаа нь гуравдагч хөршийн бодлогын нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг төдийгүй улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт бие даасан байдлыг бэхжүүлэх, эдийн засгийг хөгжүүлэхэд ихээхэн чухал үүрэгтэй.

Ном зүй

1. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УБ, 2010.
2. Монгол улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, УБ, 2011.
3. Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, УБ, 2015.
4. Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, УБ, 2020.
5. <https://ec.europa.eu/>
6. <http://www.mfa.gov.mn/>
7. <https://president.mn/>
8. <https://eeas.europa.eu/>
9. <https://brussels.embassy.mn/>

ЕВРОПЫН ХОЛБОО БА БОЛОВСРОЛЫН ДАЯАРШЛЫН ЗАРИМ АСУУДАЛД (МОНГОЛ УЛС)

Ц.Нямцэцэг ДХИС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн багш, дэслэгч

ТҮЛХҮҮР ҮГ: Европын холбоо, боловсролын даяаршил, гэр бүлийн боловсрол, бага насны хүүхдийн цогц хөгжил, эрасмус хөтөлбөр

Summary

Along with the transition to a democratic regime, Mongolia has established relations with the European Union, which has led the world in all spheres of economy, politics and society. Cooperation with the European Union, which accounts for about one-third of the world's science and technology industry, gives us many positive results, such as increasing economic growth, improving livelihoods, making progress in the field of science and innovation, increasing employment, and supporting education at all levels. Looking at the historical period of cooperation, various projects and programs have been successfully implemented until now, including the investments made in the education sector. In the framework of the Erasmus program of the European Union, the training of Professor Pier Giorgio Borbone of the University of Pisa in Italy at the Department of History of the University of Mongolia on the Syrian Correspondence of the Mongol Empire was conducted for students, and within the framework of the program, "Leathub" was funded by the Higher Education Capacity Building Program. Within the framework of the project "Leather training, research and innovation center establishment project, courses conducted in the field of financial education for civil society organizations, Within the framework of "Sustainable Green Development", a 14 million euro grant from the European Union to Mongolia's agricultural, technical and vocational education, and many projects such as the protection of the procedures for the criteria for master's and doctoral training scholarships and doctoral programs for strengthening the capacity of higher education within the framework of the Erasmus program, activities show that the European Union is making a significant contribution to the globalization of education.

Судалгааны ажилдаа боловсролын даяаршлын өнөөгийн чиг хандлага, Монгол Улсад Европын холбооноос боловсролын салбарт хэрэгжүүлж буй сургалт, үйл ажиллагааны хэрэгжилт цаашид боловсролын салбарын асуудлыг шийдвэрлэх арга замыг хамтран зөвлөлдөж, түгээн дэлгэрүүлэх зорилгоор энэхүү илтгэлийг бичлээ.

ЗОРИЛГО:

Боловсролын даяаршил ба Европын холбооны хамтын ажиллагааны тухай судалж, цаашдын чиглэлийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх.

ЗОРИЛТ

1. Боловсролын даяаршил ба боловсролын өнөөгийн чиг хандлага
2. Европын холбооны Монгол улсад боловсролын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа - Эрасмус хөтөлбөр
3. Европын холбоо Монголын боловсролын салбарын хамтран ажиллах чиглэлийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх

СЭДВИЙН ҮНДЭСЛЭЛ:

21 дүгээр зуунд дэлхийн улс орнуудын боловсролын тогтолцоонд томоохон өөрчлөлт, шинэчлэл хийгдэж байгаа. Боловсролын даяаршлын нөхцөлд явагдаж буй шинэчлэл нь нийгэмд хувь хүний дасан зохицож амьдрах шинэ сэтгэлгээ, чадварыг хөгжүүлэхэд анхаарч байна. Үндэсний өв соёлыг эрхэмлэн дээдэлсэн, монгол хүний хөгжлийг дэмжихийн тулд хөгжлийн үндсэн суурь тавигдах, бага насны хөгжилд нь цогцоор нь анхаарах, өндөр хөгжилтэй орнуудын холбооны хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлага нэн тэргүүнд тавигдаж байна. Энэхүү шаардлагын үүднээс боловсролын даяаршил, шинэчлэлийн хүрээнд хийгдэх салбар чиглэлээ тодорхойлох, Монгол улсад Европын холбооноос хэрэгжүүлж буй сургалт, үйл ажиллагааны цаашдын чиглэлийг тодорхойлох хэрэгцээ үүсэж байна. Европын холбоо Монгол улстай харилцаа, боловсролын чиглэлд явуулж буй сургалт, тэтгэлэгт хөтөлбөр, үйл ажиллагаа нь даяаршлын үйл ажиллагаанд жинтэй хувь нэмэр оруулж байгааг илтгэж буй хэрэг юм.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ: Судалгааг хийхдээ шинжлэх ухааны ерөнхий ба тусгай аргуудаас ажиглалт, харьцуулалт, анализ, синтез, түүврийн арга, анкетын арга зэргийг ашигласан.

СУДАЛГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ, ШИНЭЛЭГ ТАЛ:

Энэхүү судалгааг Европын холбооны боловсролын салбарт хэрэгжүүлсэн ажлыг судлах чиглэл бүхий судлаач төдийгүй мэдээлэл авахыг хүссэн хэн бүхэнд нээлттэй судлагдахуун болж байгаа болон холбооны үйл ажиллагааны боловсролын чиглэлийн үйл ажиллагааг тоймлон схемчилснээрээ шинэлэг болон практик ач холбогдолтой юм.

ДЭВШҮҮЛЖ БУЙ ТААМАГЛАЛ:

Таамаглал 1. Европын холбооны боловсролын салбарт хийгдэж буй үйл ажиллагаа нь боловсролын даяаршлын үйл ажиллагааг дэмжин тэтгэдэг.

Таамаглал 2. Европын холбооны үйл ажиллагааны талаар оюутан залуусын мэдээлэл хомс байх магадлалтай.

ҮНДСЭН ХЭСЭГ

Цаг үеэ олсон хөрөнгө оруулалт бизнест ашиг орлого авчирдаг бол үр дүнтэй харилцаа улс орны хөгжлийн гарц, шийдлийг олоход тусална.

Боловсролын даяаршил ба боловсролын өнөөгийн чиг хандлага

Боловсрол бол нийгмийн ба суралцагчийн амьдралын эрэлт хэрэгцээг хангахын тулд оюун ухаан, ажиллах ур чадвар, амьдрах ухаанд үндэслэсэн хөрөнгө оруулалт юм.¹⁹⁷ Боловсролд оруулж буй хөрөнгө оруулалтын талаар эдийн засгийн Нобелийн шагналтан Ж.Хейкман “Зургаа хүртэлх насны хүүхдийн хөгжилд оруулсан 1 доллар тутмын өгөөж нь 12.90 доллар болохыг тооцоод, “Энэ хөрөнгө оруулалт нь зөвхөн боловсрол эзэмшиж буй хүмүүсээс гадна улс орны эдийн засгийн хөгжилд өндөр ашигтай” учраас хөгжлийн стратегийн амин чухал хэсэг гэж дүгнэсэн¹⁹⁸ байдлаас үзэхэд улс орнууд нийгмийн хөгжилд гэхээсээ хүнийхээ хөгжилд, ялангуяа бага насны хүүхдийн хөгжилд хөрөнгө оруулах нь чухал болохыг Монгол улс НҮБ-ын Хүүхдийн сан Юнисеф болон МУИС, МУБИС, Нийгмийн эрүүл мэндийн төвийн хамтран гаргасан “Бага насны хүүхдийн цогц хөгжил гарын авлагаас харж болно. **Боловсрол даяаршина гэдэг** нь боловсролын үйл явцын мөн чанарыг

¹⁹⁷ Б.Галбадрах, Боловсрол сургалт “Боловсролын байгууллагын хөгжил”, УБ, 2018.

¹⁹⁸ Ж.Хейкман

өөрчилж, дэлхийн боловсролыг бий болгох, хэрэгцээтэй ур чадвар, мэдлэгийг улс орны хэмжээнд төдийгүй дэлхий даяар сургах санааг илэрхийлэхийг эрмэлздэг.¹⁹⁹ Дэлхийн иргэн байхын тулд орчин үеийн нийгэмд амьдрах зайлшгүй шаардлагатай чадваруудын талаар ойлголтой болж, бодлогоор түүний чиглэлийг тодорхойлох нь хүний хөгжлийн чухал хөдөлгүүр болох юм. Мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологийг ашиглах нь боловсролын даяаршлын бүх үйл явцын шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн үндэс юм. Даяаршлын нөхцөлд боловсролын хөгжлийн чухал шинж чанар нь интеграцийн үйл явц, улс орнуудын хоорондын эрчимтэй харилцан үйлчлэл байгааг харуулдаг.

Интеграцийн үйл явцын чухал илрэл болсон Дэлхийн шинжлэх ухаан, технологийн салбарын гуравны нэг орчим хувийг эзэлдэг Европын холбоо нь гишүүн орнуудынхаа эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, амьжиргаагаа дээшлүүлэх, шинжлэх ухаан инновацийн салбарт ахиц гаргах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, бүх шатны боловсролыг дэмжих зэрэг олон талын эерэг үр дагаврыг өгч байна. Боловсролын салбарт улс орнуудын хамтын ажиллагаа нь НҮБ, ЮНЕСКО-гийн үйл ажиллагааны зайлшгүй чухал талуудын нэг юм. Энэхүү шинэ загварын дагуу боловсрол нь ардчилсан, хамааралтай, тасралтгүй, уян хатан, ялгаваргүй байх ёстой.

Орчин үеийн боловсролын чиг хандлагыг шинжлэхэд бид нэг талаас бие биеэ эсэргүүцдэг, нөгөө талаас харилцан уялдаатай, бие биеэ нөхөж байдаг дэлхийн хоёр үйл явцыг ялгаж салгаж болно. Эдгээр нь боловсролыг төрөлжүүлэх, олон улсын болгох үйл явц юм. Төрөлжилт нь шинэ боловсролын байгууллагуудыг зохион байгуулах, төрийн байгууллагуудад боловсролын чиг үүргийг өгөх, шинэ сургалтын чиглэл, шинэ курс, хичээлүүдийг нэвтрүүлэх, салбар хоорондын хөтөлбөрүүдийг бий болгохтой холбоотой. Боловсролын удирдлагын тогтолцоо, боловсролын байгууллагын бүтэц, санхүүжилтийн журмыг шинэчлэн зохион байгуулж байна. Боловсролыг олон улсын болгох нь эсрэгээрээ үндэсний тогтолцоог ойртуулж, тэдгээрийн доторх нийтлэг ойлголт, бүрэлдэхүүн хэсгүүдийг олж, хөгжүүлэх, үндэсний соёлын олон талт байдлын үндэс суурийг бүрдүүлж, харилцан баяжуулахад хувь нэмэр оруулахад чиглэгддэг. Олон улсын болгох арга хэрэгсэл нь оюутан, багш, судлаач солилцох, диплом хүлээн зөвшөөрөх явдал юм.

Судалгааны хэсэг.

Европын холбооны Монгол улсад боловсролын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа ба Эрасмус хөтөлбөр

1991 оноос Европын Холбооны Төлөөлөгчийн газар Монгол Улсыг Бээжингээс хавсран сууж байсан бөгөөд 2017 оны 11 сард Улаанбаатар хотод албан ёсоор Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газраа нээн ажиллуулж байна. Төлөөлөгчийн газар буюу Элчин сайдын яам нь дипломат халдашгүй бүрэн эрхтэй ба Төлөөлөгчийн Газрын тэргүүн нь Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын статустай юм.

Төлөөлөгчийн газар нь Монгол улс, Европын Холбооны хоорондын албан ёсны харилцааны асуудлыг хариуцдаг бөгөөд ЕХ-той холбоотой аливаа асуудлаар ЕХ-ны гишүүн орнуудын ЭСЯ-тай нягт хамтран ажилладаг төдийгүй хоёр талын эрх бүхий байгууллага, институт хоорондын харилцаа, холбооны гол хэрэгсэл юм. Төлөөлөгчийн Газар нь улс төр, эдийн засаг, хөгжлийн асуудлаар Европын Холбоог цаг алдалгүй мэдээллээр хангаж Монгол улстай хөгжүүлж буй хоёр талт хамтын ажиллагаанд ихээхэн түлхэц болж байна.

¹⁹⁹ Чадамжид суурилсан сургалтын гарын авлага, УБ, 2013.

Европын холбооноос Монгол улсад боловсролын чиглэлээр явагдсан төсөл, үйл ажиллагаанууд

№	Чиглэл	Үйл ажиллагаа	Хөтөлбөр	Зорилго	Ач холбогдол
1	Сургалт, судалгаа	Италийн Пизагийн их сургуулийн профессор Пиэр Жиоржио Борбонийн оюутнуудад хийсэн сургалт	Эрасмус	МУИС-ийн түүхийн тэнхимд Монголын эзэнт гүрний үеийн Сири сурвалж бичгийн судалгаа танилцуулах	Монголын оюутнуудад түүхэн эх сурвалж, бичиг соёлын талаар судалгаа танилцуулах
		“Мал төхөөрөх, арьс шир эсгэлтгүй өвчих (SFF) технологи” нэвтрүүлэх цахим сургалт 2021 оны 5-р сарын 3-5-ны өдрүүд	SECiMC2 төсөл	Малыг үйлдвэрийн орчинд төхөөрөх, арьс шир түүхий эдийн үнийг нэмэгдүүлэх, зах зээлд ойртуулах	Арьс шир эсгэлтгүй өвчих “SFF” төхөөрөмж суурилуулан ашиглах дадлага
		2020 онд хүрээнд дээд боловсролын чадавхыг бэхжүүлэх магистр, докторын хөтөлбөрийн шалгуур баталсан	Эрасмус	Дээд боловсролын чадавхыг бэхжүүлэх	Магистр, докторын сургалтын тэтгэлэг, докторын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн журмыг хамгаалуулах
		Европын холбооноос монгол улсын хөдөө аж ахуй, техник, мэргэжлийн боловсролд оруулж буй 14 сая еврогийн буцалтгүй тусламж	“Тогтвортой ногоон хөгжил”	Хөдөө аж ахуйн салбар, мэргэжлийн боловсролыг хөгжлийг дэмжих	(МСҮТ)-ийн төвийн чадавхыг сайжруулах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх нь төслийн гол зорилтуудын нэг юм.

2	Дээд боловсрол	2022 оны 08 дугаар сарын 30. 10 монгол оюутан бүрэн тэтгэлэгт хамрагдав.	Эрасмус хөтөлбөр	Европын их сургуульд 2 жил магистрын хөтөлбөрт хамрагдах	Өндөр хөгжилтэй орны хэлийг сурч, соёл болон нийгмийн орчинтой танилцан, хувь хүний хөгжлийг дэмжих, хамтын ажиллагааг бэхжүүлэх
		Их дээд сургуулийн багш нарт зориулсан “Leadership for responsible society new environments, new skills” сургалт семинар	Эрасмус	Манлайллын оролцооны арга зүйн туршлага, биеийн зураглалыг ашиглах талаар илүү мэдээлэлтэй болох	Биеийн газрын зургийн талаар мэдлэгтэй болох, хүмүүсийг ойлгохын тулд тэднийг сонсох, шүүмжлэлт сэтгэлгээг төлөвшүүлэх, удирдахын тулд ойлгох
3	Эдийн засаг, санхүү	Орон нутгийн банк, санхүүгийн салбарын ажилтнуудад зориулсан сургалт Дорнод, Дархан-Уул аймагт 2023 оны 9-р сарын 8-16-ны өдрүүд	Banking and Finance Academy	"Бичил бизнесийн хөлөгт тоглоом" сургалтыг явуулж, бизнесийн тайлан тэнцэл, борлуулалтыг яаж илүү хөгжүүлэх	Хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, хувь хүний нууц болон цахим гарын үсгийн тухай хуулийн мэдлэг өгөх сургалт
4	Хүний эрх Экологийн боловсрол	"Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах" төсөл	SWITCH-Asia II хөтөлбөр	Хог хаягдлаа багасгах, ялгахын ач холбогдолын талаар мэдээлэл олгох (Сургууль, цэцэрлэг)	Багш нар сурагч хүүхдүүддээ хогоо багасгах, ангилан ялгах мэдлэг олгож цаашид төслийн багтай хамтран ажиллах
		"Цөлжилт болон түүний үр дагавар" фото зургийн уралдаан		Цөлжилт Монголын хүн, амьтанд хэрхэн нөлөөлж буйг гэрэл зургаар шинэлгээр харуулах	Монголд оршин суугаа 18-аас доош насны хүүхэд, залуусын байгаль эх дэлхийгээ хайрлах, мэдрэмжийг бий болгох,

	Ийзи аппликейшн 2021 оны шилдэг боловсролын оролцоог хангасан бүтээл	EBRD in Mongolia	2021 оны шилдэг боловсролын оролцоог хангасан бүтээл шалгаруулах уралдаан	Шилдэг боловсролын оролцоог хангасан бүтээлээр шалгарч Монгол улсаас анх удаа Дижитал Оскар хүртсэн байна
	ЕХ-ны Монгол дахь Төлөөлөгчийн газарт төгсөгч залуусыг санхүүжүүлэн дадлагажуулах	Европын холбоо	Шинэ төгссөн төгсөгчдийг чадваржуулах, ажлын байранд зуучлах	Дадлага хийсэн оюутан мэргэжлийн чиглэлээр цаашид үргэлжлүүлэн ажиллах боломжтой.
	НҮБХХ-ийн “Бизнес ба хүний эрх” төсөл, Монгол Улсын Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтарсан төсөл	НҮБХХ-ийн сан	Бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй зөрчигдсэн эрхийг сэргээх, механизмыг бэхжүүлэх	Бизнесийн харилцаанд зөрчигдсэн эрхийг сэргээх бизнесийн байгууллагын үйл ажиллагаа хүний эрхэд сөргөөр нөлөөлж байгаа эсэхийг тодорхойлох, хэрхэн бууруулах, арилгах талаар мэдлэгтэй болох

Европын холбооны Ерасмус хөтөлбөр нь 35 жилийн түүхтэй, боловсрол, сургалт, залуучууд, спортын хөтөлбөр ба өргөн хүрээний олон төрлийн үйл ажиллагааг хамаардаг. Ерасмус хөтөлбөрт идэвхтэй байдаг 2 төрлийн орнууд байдаг байна.

1. Европын холбооны гишүүн орнууд болон хөтөлбөрт хамаарах гуравдагч орнууд: Энэ орнууд хөтөлбөрийн бүх арга хэмжээнд бүрэн оролцох боломжтой ба үүнд ЕХ-ны гишүүн орнууд, Европын чөлөөт худалдааны нийгэмлэгийн гишүүд багтдаг.
2. Хөтөлбөрт хамааралгүй гуравдагч орнууд: Хөтөлбөрийн тодорхой арга хэмжээнд оролцож болно. Дэлхий даяар олон байдагт түнш орнууд юм.


Хөтөлбөрт оролцохыг хүсвэл өөрөө болон байгууллагуудаар дамжуулан Ерасмус программыг судлан өргөдөл гаргаж болно. Түүнчлэн энэхүү хөтөлбөр нь:

1. Хувь хүнд зориулсан боломжууд
2. Байгууллагад зориулсан боломжууд
3. Европын холбооноос гаднах боломжуудыг олгодог байна.


Европын холбооны Эрасмус хөтөлбөр нь өнөөгийн болон ирэх жилүүдэд нийгэмд тулгарч буй уур амьсгалын өөрчлөлт, нийгэмд тулгарч буй сорилтуудыг даван туулах ур чадвар, мэдлэг туршлагатай үе үеийн Европын идэвхтэй иргэд болоход нь туслах чиг зорилготой. Эдгээр сорилт нь ажилгүйдэл нэмэгдэж, уур амьсгалын эдийн засгийн болон мөргөлдөөний дараах цагаачлалын дижитал, даяаршил, хөдөлгөөний хомсдол, олон улсын хэл ярианы бүтэц зэрэг орно. Эрасмус нь үрэлгэн байдлыг багасгах, ногоон эдийн засаг руу шилжихэд тусалдаг төслүүдийг санхүүжүүлдэг. Европ дахь ардчиллын үйл явц, түүний нөлөөг дэлхий дахинаа хөгжүүлдэг. 2014 оноос хойш 600 гаруй оюутан, багш, боловсролын салбарын ажилтан [ERASMUS+ Projects](#) хөтөлбөрийн үр шимийг хүртсэн байна. 2021-2027 онд Европын Холбооноос ERASMUS+ хөтөлбөрт зориулан 26 тэрбум еврог төсөвлөөд байгаа ажээ.

Европын Холбооноос Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд хатагтай Аксель Никэйз хэлэхдээ: “Европод суралцахаар тэмүүлж буй олон залуусыг хараад үнэхээр сайхан байна. Эрасмус+ хөтөлбөр нь Европыг мэдэрч, шилдэг их сургуулиудад академик болон мэргэжлийн хувьд өсөх онцгой боломжийг олгож байна. 2021-2027 онд Эрасмус+ хөтөлбөр бараг хоёр дахин нэмэгджээ. Иймээс бид олон олон монгол залууст ийм боломж байгаа гэдгийг мэдэхийн тулд бүх хүчин чармайлтаа гаргах болно гэж хэлэв. Өөр улс руу нүүж суралцах нь одоогийн болон ирээдүйн олон оюутнуудын хайж байгаа зүйл юм. Оюутнууд Европ дахь олон улс орон, соёл, уламжлал, эрдэм шинжилгээний баялаг олон янз байдлыг мэдрэх боломжийг олж авдаг. Европын Холбооны Төлөөлөгчийн газрын ажилтнууд мөн Европын холбогдох орнуудад суралцах шинэ амьдралын хэв маягийн талаар оюутнуудтай хувийн туршлагаасаа хуваалцахаар илгээлтийн цугларалтад нэгдэн, соёл, эрдэм боловсрол, хоол хүнс, эрүүл мэнд, нийгмийн амьдрал, хэл ярианы талаар өөрсдийн санал бодлоо хуваалцаж, оюутнуудыг мартагдашгүй, гүн гүнзгий туршлагад бэлтгэдэг.

Сүүлийн жилүүдэд Европын Холбооны санхүүжилтээр 135 сая еврогийн төсөл хөтөлбөр манай улсад хэрэгжээд байна. Монгол улсад 2014-2020 оны хооронд 160 гаруй хүн хөтөлбөрт хамрагдсан. Эрасмус+ хөтөлбөр нь магистрын тэтгэлгээс гадна бакалаврын оюутнууд, эрдэмтэн судлаачид болон бусад бүх насны хүмүүст маш олон боломжийг олгож, тэднийг хөгжүүлэхэд нь тусалдаг. Европын холбоог бүрдүүлдэг бүх улс орны байгууллагуудад мэдлэг, туршлагаа хуваалцах. 2020 оны байдлаар Эрасмус+ бараг 640,000 хүнийг гадаадад суралцах, дадлага хийх, сайн дурын үндсэн дээр ажиллахад нь дэмжсэн. Энэ нь 126,900 орчим байгууллага, 20,400 орчим төслийг санхүүжүүлсэн байна. Энэ бүгдээс харахад Европын холбоо ялангуяа боловсролын салбарт маш олон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, санхүүжүүлсэн байна. Бид энэхүү үйл ажиллагааны хэрэгжилт болон холбооны талаар нийгмийн идэвхтэй бүлэг болох оюутан залуус хэр мэдлэг, мэдээлэлтэй байгааг тодруулах зорилгоор асуулгын аргаар 101 оюутнаас судалгаа авч боловсрууллаа. Судалгаанд:




Судалгаанд 16-18 насных 40 хувь, 19-25 насных 60 хувь, 79,8 хувь эмэгтэй, 20,3 хувь эрэгтэй оролцогч оролцсоноос харахад нийгмийн аливаа үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн идэвх оролцоо өндөр байдаг нь харагдаж байна. Оролцогчдын суралцдаг сургуулиудыг



хүснэгтээр үзүүлбэл ДХИС болон МУИС, СЭЗИС, Шихихутаг, ШУТИС-ийн оюутнууд оролцжээ.

Та Европын холбооны талаар хэр зэрэг мэдэх вэ? Асуултад оролцогчдын 53.3 хувь нь сонсож байсан, 26.7 хувь нь мэднэ, 20 хувь нь огт сонсож байгаагүй гэж хариулснаас харахад төдийлөн сайн мэддэггүй болох нь харагдаж байна.



Өмнөх асуултад оролцогчдын 53.3 хувь нь холбооны талаар сонсож байсан боловч, тэдний хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, төслийн талаар мэдээлэлгүй байгаа нь ач холбогдол өгч, сонсож судалдаггүй гэдгийг харуулж байна. Та Европын холбооноос хэрэгжүүлсэн ямар нэг өдөрлөг, үйл ажиллагаа, төсөлд хамрагдаж байсан бол нэрлэн бичнэ үү? гэсэн асуултад оролцогчдын 100 хувь мэдэхгүй, оролцож байгаагүй гэж хариулснаас харахад залуус мэдээлэл авдаггүй, очдоггүй болох нь харагдаж байна.



Манай улсад боловсролын талаар хамгийн тулгамдаж буй ямар асуудал байна вэ?



Оюутнуудын хувьд англи хэлний мэдлэг, багшийн арга зүй, сургалтын орчин, харилцаа, эрх тэгш байдал, цалинг боловсролын байгууллагын тулгамдсан асуудал гэж үзсэн байна.

Судалгааны үр дүн

- Нийгмийн идэвхтэй хэсэг болох оюутан залуучууд Европын холбооны талаар сонсож байсан боловч, үйл ажиллагаа хэрэгжилтийн талаар ойлголт бага байгаа нь цаашид мэдээллийг хүргэх ажлыг эрчимжүүлэх (оюутны холбоотой хамтран ажиллах)
- Оюутнууд тулгамдаж буй асуудлыг сургалтын орчин харилцаа, төлөвшил, англи хэлний мэдлэгтэй холбон үзэж байгаа нь өнөөгийн нийгэмд эдгээр асуудлууд анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.

Европын холбоо Монголын боловсролын салбарын хамтран ажиллах чиглэлийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх

Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Европын холбооноос Монгол улсад суугаа элчин сайд бөгөөд төлөөлөгчийн газрын тэргүүн Аксель Никэйзийг хүлээн авч уулзан, Эрасмус плас хөтөлбөрийн хүрээнд дээд боловсролын чадавхыг сайжруулах төслүүд амжилттай хэрэгжиж байгаад талархал илэрхийлээд цаашид

- ✔ Ерөнхий боловсролын сургуульд ажиллах сэтгэл зүйчдийг богино дунд хугацаанд сургах, МУИС, МУБИС-ийн сэтгэл зүйн багш нарыг чадавхжуулах чиглэлээр хамтран ажиллах.
- ✔ Шинжлэх ухааны салбарын залуу эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтнуудыг Horizon Europe хөтөлбөрт хамруулах.
- ✔ Эрасмус плас хөтөлбөрийг үргэлжлүүлэх талаар санал солилцон хатагтай Никэйз дээрх хүсэлтүүдийг дэмжин ажиллахаа илэрхийлсэн. Эдгээр чиглэлүүд нь боловсролын даяаршил, шинэчлэлийн асуудалд томоохон ахиц гаргаж байна. Дээрх чиглэлүүдээс гадна дараах чиглэлд анхаарлаа хандуулан хамтарч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.
- ✔ Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч, нийгэмд тулгарч буй асуудлыг хамтран тодорхойлох.
- ✔ Бага насны хүүхдийн цогц хөгжилд эцэг эх, багш, сургууль, бодлого боловсруулагчид онцгой анхаарах - Ж.Хейкийн онол.
- ✔ Үе шаттайгаар гэр бүлийн боловсролыг олгоход илүү анхаарах (ойрын хугацаанд болж буй хүүхдийн амь настай холбоотой асуудлууд тодорхой хэмжээгээр гэр бүлийн боловсрол зайлшгүй шаардлагатайг илэрхийлж байна.)
- ✔ Европын холбооны шинжлэх ухаан, инновацын төвүүдтэй хамтран ажиллах.
- ✔ Оюутнуудаас авсан судалгаагаар англи хэлний асуудал тулгамдсан асуудлын нэгээр тодорхойлогдсон. Бид өндөр хөгжилтэй орноос суралцахын тулд үе шаттайгаар тэдгээр орнуудад суралцах боломжийг эрэлхийлэх, туршлагаа байнга бусдад хуваалцаж байх хэрэгтэй байна.
- Хүний хамгийн үнэ цэнтэй хөрөнгө болох үр хүүхдээ хүмүүжүүлэх эцэг эхийн мэдлэг боловсролыг дэмжиж ажиллах нь улс орны хүн амын өсөлт, хөгжилд хамгийн чухал үндэс болох юм. Бодлогоор үр хүүхдэдээ зарцуулах цаг хугацаа, өдрүүдийг гаргаж өгөхөд анхаарах.

Дүгнэлт

Боловсролын даяаршил нь улс орнуудыг хүнээ хөгжүүлэх, дэлхийн иргэн бэлтгэх үйл явцын нэгэн тал юм. Дэлхийн иргэн бэлтгэх холын зорилгоо биелүүлэхийн тулд тэрхүү иргэдийг бэлтгэж буй улс орнуудтай харилцаа тогтоож, хамтран ажиллах нь боловсролын даяаршлын чухал хүчин зүйл юм. Бидний судалгаагаар дэвшүүлсэн:

Таамаглал 1. “Европын холбооны боловсролын салбарт хийгдэж буй үйл ажиллагаа нь боловсролын даяаршлын үйл ажиллагааг дэмжин тэтгэдэг гэсэн” таамаглал тус холбооноос монгол улсад хэрэгжүүлсэн Эрасмус хөтөлбөрийн дээд боловсролын салбарт хийсэн хөтөлбөрийн шалгуурууд, технологийн өндөр түвшинд сонирхолтой байдлаар хийгдсэн Ийзи аппликашны хичээлүүд, Европын өндөр хөгжилтэй орнуудад тэтгэлгээр суралцаж буй оюутнуудын хөтөлбөр, экологийн болон хүний эрхийн боловсролын хүрээнд явагдсан ажлуудын зорилго болон үр дүнгээр тодорхойлогдож байна. Нийгэм хөгжих гэж хүнээ хөгжүүлэхийн тулд боловсролын салбараа тэр дундаа гэр бүлийн сэтгэл зүйн боловсрол рүү чиглэсэн цогц бодлогыг хэрэгжүүлж, санхүүжүүлэх хэрэгтэй.

Таамаглал 2. “Европын холбооны үйл ажиллагааны талаар оюутан залуусын мэдээлэл хомс байх магадлалтай” гэсэн таамаглал оюутнуудаас авсан ярилцлага болон асуулгын судалгааны үр дүнгээр батлагдаж байна. Цаашид оюутан залуус төдийгүй ард иргэдэд

өндөр хөгжилтэй орны төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах нь нийгмийн олон салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах болно. (Эрасмус хөтөлбөр)

Хүн төрөлхтөн хөгжлийн дээд шатанд хүрсэн үед ч хамгийн үнэ цэнтэй баялаг бол үр хүүхэд, тэдний боловсрол ирээдүйд хэн болох нь хамгийн чухал асуудал байсаар байх болно.

Цаг үеэ олсон хөрөнгө оруулалт бизнест ашиг орлого авчирдаг бол боловсролын шинэчлэлийг тусгаасан хөрөнгө оруулалт дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын хамтын ажиллагаа даяаршин хөгжих чухал хөдөлгүүр байх болно.

“Санал зөвлөмж”

- Эцэг эхчүүд бага насны хүүхдийн цогц хөгжилд анхаарах нь гэр бүлдээ төдийгүй улс орны боловсрол, соёл, хүний хөгжилд үнэтэй хувь оруулах болно. (6 хүртэлх насны хүүхдийн хөгжил насан туршийн суурь хүмүүжил бий болдог)
- Гэр бүлийн боловсролыг (хэрхэн хүн байх, хүн бүтээх ухаан) шат дараатайгаар сургалтын системд оруулах, зохион байгуулах
- Боловсролын шинэчлэлийн салбараа тодорхойлон, Европын холбооны төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах (сэтгэл зүйн боловсрол, гэр бүлийн боловсрол)
- Европын холбооны үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй мэдээлэх, нээлттэй өдөрлөг, хөтөлбөрт оюутан залуусыг уриалах
- Европын холбооны Монгол дахь төлөөлөгчийн газар их дээд сургуулиудын оюутны холбоотой байнгын үйл ажиллагаатай байх.

Номзүй

1. Бага насны хүүхдийн цогц хөгжил, УБ, 2020.
2. Боловсролын хөгжил, судалгаа, арга, зүй, УБ, 2018.
3. О.Мягмар, Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд.
4. Чадамжид суурилсан сургалтын гарын авлага, УБ, 2013.

**БОЛОВСРОЛЫН ДАЯАРЧЛАЛ БА СУРАЛЦАГЧДЫН ХАРИЛЦАА ХАНДЛАГА,
НӨЛӨӨЛӨЛ**

*Г.Оюунтуяа ҮБХИС-ийн АБДС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын тэнхимийн ахлах багш,
М.Индрабүд ҮБХИС-ийн АБДС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын тэнхимийн дэд профессор багш*

Abstract:

Due to socio-economic changes, the countries of the world said goodbye to the stormy years of globalization in economic, political, social and cultural relations. During this period, the great process of globalization has enlightened mankind, and social, cultural, political, and economic relations have been brought together through one path and one relationship. On the one hand, we often see globalization in both positive and negative economic terms. At this stage between today's globalization period and the next period, it is important to analyze the positive and negative effects of the globalization of education on the relations and attitudes of students who are subjects of the education system, and determine that their results depend on the social factors of the country. This process, to some extent, expresses the relationship between students and students in educational institutions, and the attitudes that emerge from it. We have a question: whether the level of education in Mongolia is an advantage compared to the level of education in international universities, or...

Key words: Globalization of education, impact, students, learners, relational approach.

УДИРТГАЛ

Монгол улс нь өөрийн хөгжлийн зорилтдоо хүрэхийн тулд өндөр хөгжилтэй, хөгжингүй орнуудын томоохон нэгдэл болох Европын Холбоотой тогтоосон харилцаа хамтын, ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх үйл явц олон арван баримтуудад дурдагдсан байдаг. Тухайлбал,

- Монгол улс нь Европын холбоотой 1989 оны 8-р сарын 1-ний өдөр дипломат харилцаа тогтоож, хамтын ажиллагаагаа эхлүүлсэн;
- 1990 онд Монголын нийгэм социалист системээс задран унаж зах зээлийн нийгэмд шилжсэнээр олон улсын түвшинд нийгэм-эдийн засгийн харилцаа тогтоох үндэслэл болсон;
- 1994 онд Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд Европын гишүүн орнууд болох Финланд, Австри, Дани, Швед, Нидерланд, ХБНГУ, 2004 оноос хойш Чех, Унгар, Польш, Словак зэрэг олон оронтой эдийн засаг болон бусад салбараар (соёл боловсрол) хамтран ажиллах, найрсаг харилцаатай байх бодлогыг баримталсан;
- 2008 онд УИХ-аас баталсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” хэмээх баримт бичигт дурдагдсанаар Европын холбоотой иж бүрэн түншлэлийн түвшинд хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн;
- 2010 онд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Европын холбоо гэж нэр цохоогүй ч “Гуравдагч хөршийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ”²⁰⁰ хэмээн заасан;
- 2015 онд батлагдсан Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
- 2020 оны Монгол улсыг хөгжүүлэх “Алсын хараа-2050” бодлогын баримт бичгүүдэд олон улс оронтой хамтын ажиллагаагаа гадаад харилцаа, эдийн засаг, улс төрийн хувьд

²⁰⁰ Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.1.5-р заалт, УБ.,2010.

өргөжүүлэн хөгжүүлнэ хэмээн тус тус зааж өгсөн нь Монгол улс Европын холбоо болон Европын холбооны гишүүн орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх гол үндсэн хөгжлийн баримт бичгүүд болсон гэж үздэг.

Европын холбооны гадаад ба аюулгүй байдлын нийтлэг бодлого нь дараах зүйлсийг зорилгоо болгодог. Үүнд:

- ❖ Энх тайвныг сахин хамгаалах
- ❖ Олон улсын аюулгүй байдлыг бэхжүүлэх
- ❖ Ардчилал, хууль дээдлэх ёсыг хөгжүүлэн бэхжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэн сахих

Европын холбооны дээрх зорилгын хүрээнд түүний гишүүн орнуудын хувьд нэг үзэл суртал, нэг боловсролын чиг зорилгоор улс орныг нэгтгэх, ардчилсан хүмүүнлэг иргэнийг төлөвшүүлэх, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн нийгмийг бүтээлцэхэд улс орнуудын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд орших юм.

Ингэхийн тулд тухайн улсын иргэн бүрийг боловсрол, соёлын хувьд даяарчлалд нэгтгэх, дэлхийн боловсролыг хамтдаа суралцах, хаана ч суралцах үүд хаалгыг нээх гарч нь болж өгсөн нэг системт боловсролын даяарчлал юм.

Даяарчлал хэмээх том үйл явц хүн төрөлхтнийг соён гэгээрүүлж, нийгмийн харилцаа, соёл, улс төр, эдийн засгийн хувьд нэг систем, нэг харилцаагаар нэгтгэх, улмаар нэг улс нөгөө улсдаа нөлөөлөх харилцааны асуудал дэвшигдэн гарч ирж байна.

Бид нэг талаас даяарчлалыг эдийн засгийн хувьд эерэг ба сөрөг талаас нь ихэвчлэн харж байдаг. Өнөөдрийн глобалчлалын үе, дараах үе хоорондын энэ шатанд боловсролын даяарчлал нь боловсролын системийн субъект болох оюутан суралцагчдын харилцаа, хандлагад эерэг болон сөрөг нөлөөллийг үзүүлж, тэдгээрийн үр дүн тухайн улс орны нийгмийн хүчин зүйлүүдээс шалтгаалж байна гэсэн таамаглал дэвшүүлж, таамаглалаа шалгахын тулд энэ нүсэр боловсролын даяарчлалын салхи оюутан суралцагчдын харилцаа хандлагад нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох орчны болон үйл явцын шинжилгээ хийхийг оролдлоо.

Даяарчлалыг боловсролын салбарт өргөжүүлэх гүүр нь их дээд сургуулийн оюутан суралцагчдын суралцах үйл явц юм. Энэхүү үйл явц бол өөрсдийн эрхийнхээ хүрээнд хаана ч, ямар ч боловсролыг эзэмших, сурах хөтөлбөр, кредитээ сонгох, хангах бүрэн боломжийг Европын холбооны гишүүн орнуудын боловсролын систем олгож байгаа юм. Тухайлбал, Европ тив бол дэлхийн түвшний боловсрол олгодог их дээд сургууль, дээд боловсролын байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэн олонтой. Тэр чинээгээр маш олон боловсролын хөтөлбөр санал болгодог, оюутнуудын хамгийн их сонгон суралцагч газруудын нэг юм.

Төв болон баруун, зүүн Европын орны Франц, Герман, Чех, Румын, Унгар, Польш, Словак зэрэг улсын их дээд сургуулиудад монгол оюутнууд суралцаж байна. Тус судалгааныхаа ажилд Боловсролын даяарчлалын нэг илэрхийлэл болох цахим, техник технологи Монгол улсын их сургуульд суралцаж буй болон Европын зарим их дээд сургуульд боловсрол эзэмшиж буй Монгол оюутан суралцагчдын харилцаа хандлагад хэрхэн нөлөөлж буйг харьцуулалт хийж, шинжлэн үзэж, үнэлэлт дүгнэлт өгөхийг зориллоо.

ҮНДСЭН ХЭСЭГ

1. Монголын их дээд сургуульд болон гадаадад суралцаж буй суралцагчдын мэдээлэл.

Монгол Улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд 69 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж байгаагийн 33 буюу 47.8 хувь нь их сургууль, 35 буюу 50.7 хувь нь дээд сургууль, 1 буюу 1.4 хувь нь коллеж байна. Нийт их, дээд сургууль, коллежийн 16 буюу 23.2 хувь нь төрийн өмчийн, 50 буюу 75.5 хувь нь хувийн өмчийн, 3 буюу 4.3 хувь нь олон нийтийн/шашны өмчийн сургалтын байгууллага байна. Нийт сургалтын байгууллагын 64

буюу 92.8 хувь нь Улаанбаатар хотод, 5 буюу 7.2 хувь нь хөдөө, орон нутагт сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Их, дээд сургууль, коллежид нийт **145,267 суралцагч** (56,444 буюу 38.9 хувь нь эрэгтэй, 88,823 буюу 61.1 хувь нь эмэгтэй) суралцаж байгаа нь өмнөх хичээлийн жилийн нийт суралцагчдын тооноос 3,387 буюу 2.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нийт суралцагчдын 79,718 буюу 54.9 хувь нь төрийн өмчийн, 58,828 буюу 40.5 хувь нь хувийн өмчийн, 6,721 буюу 4.6 хувь нь олон нийтийн/шашны өмчийн сургуульд суралцаж байна. Суралцагчдын 135,993 буюу 93.6 хувь нь нийслэлд, 9,274 буюу 6.4 хувь нь орон нутагт суралцаж байна.²⁰¹

Монгол Улсын Гадаад харилцааны яамны албан бус мэдээллээр 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 197.0 мянган иргэн гадаад улс орнуудад ажиллаж, амьдарч байна. Үүнээс, АНУ-д 40.1 мянган иргэн, Европын холбооны улсуудад 43.7 мянган иргэн, БНСУ-д 50.8 мянган иргэн, Япон улсад 16.3 мянган иргэн, Австрали улсад 7.0 мянган иргэн тус тус ногдож байна. Дээрх 5 улс, бүс нутгуудад нийт 158.0 мянган иргэд ажиллаж амьдарч байгаа нь нийт иргэдийн 80.1 хувийг эзэлж байна. Эдгээр иргэдийн ойролцоогоор 80.0 орчим хувь нь хууль ёсоор ажиллаж, сурч, хөдөлмөрлөж байна.²⁰²

Олон улсын боловсролын салбар дахь зах зээлийн судалгаа, шинжилгээ хийдэг ICFE Monitor байгууллагаас Монголын оюутнууд, хандлага, боловсролын талаар мэдээлэл судалгааг гаргасан²⁰³ бөгөөд тус судалгаанд монгол оюутан залуус сүүлийн жилүүдэд гадаад руу явж сурах сонирхол их, гадаадын боловсролын зах зээл эрэлттэй байгааг судлан гаргасан байна. Судалгаанд ялангуяа БНХАУ, Япон, Америк, ОХУ руу ихэвчлэн оюутнууд суралцаж байгаагаас хоёр хөрш улсууд болон гуравдагч их гүрэн Япон улсын сонирхол Монгол улсын зах зээлийг сонирхон эдийн засгийн болон боловсролын салбарт хөрөнгө оруулалт хийхийг сонирхож байна.

Сүүлийн жилүүдэд хэд хэдэн улс оронд суралцагчдын тоо UNESCO (2017 онд 10000 оюутан) болон олон улсын боловсролын сэтгүүлд (2017 онд 15000 оюутан) мэдээлснээс ч илүү өндөр байна гэжээ.

Тухайлбал, 2018 оны байдлаар гадаадад суралцаж буй монгол оюутнуудын тоо БНСУ-д 7300 оюутан, БНХАУ-д 10,100 гаруй оюутан, ОХУ-д 2000 гаруй оюутан, Австрали улсад 3500 гаруй оюутан, Япон улсад 3125 оюутан, АНУ-д 148 оюутан, Канад улсад 250 гаруй оюутнууд буюу макро түвшнээр харвал 25000 гаруй оюутан гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан мэдлэг боловсрол эзэмшиж суралцаж байна.

Тодорхой зах зээлийн динамик буюу эдийн засгийн өсөлт, залуучуудын тоон өсөлт, дээд боловсрол эзэмшигчдийн өсөлт, Монголын их дээд сургуулийн чанарын асуудал зэрэг стратеги төлөвлөлтөөс харахад дээрх оюутан суралцагчдын тоо цаашид өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Түүнчлэн 2014-2020 онд Монгол улс дахь Европын холбооны төлөөлөгчийн газраас зохион байгуулдаг Европын 100 гаруй их дээд сургуульд богино болон урт хугацаагаар суралцах боломжийг олгодог Erasmus+ хөтөлбөрийг хэрэгжүүлж байсантай холбоотойгоор гадаадад суралцах ялангуяа Европт суралцах оюутны тоо өсөн нэмэгдсэн байх магадлалтай юм.

Монголын оюутан суралцагчид дэлхийн зах зээлийг сонирхож, түүн рүү хүсэл тэмүүлэл нь оргилж буй тэр хэрэгцээг харсан АНУ, БНХАУ, Япон, ОХУ, БНСУ, БНГУ, Франц, Унгар, Польш, Чех, Австрали, Норвеги зэрэг дэлхийн өндөр хөгжилтэй улс оронд чанартай

²⁰¹ БШУЯ. Дээд боловсролын 2022-2023 оны хичээлийн жилийн статистик мэдээллээс. <https://www.meds.gov.mn/post/125506>

²⁰² Home mortgage corporation. Мэдээ, мэдээлэл. Гадаадад ажиллаж, амьдарч буй иргэдийн тоо. 2023. Эх сурвалж линк: <http://hmc.mn/medee/v/6#>

²⁰³ Б.Бөртэ-Үжин. IKON.MN. Монгол оюутнуудын дийлэнх нь Азийн орнуудыг зорьж байна. Эх сурвалж: <https://ikon.mn/n/1olw>. Нийтэлсэн огноо: 2019.09.27.

боловсрол эзэмшиж, суралцаж байгаа нь олзуурхууштай. Чанартай боловсролыг хаанаас ч хэзээ ч авах боломжийг олгож буй Европын холбооноос явуулж буй үйл ажиллагаа нь цаашид улам бүр даяаршиж буй хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай Монгол мэргэжилтэн бэлтгэх боломжийг улам өргөжүүлэх, энэ гарцыг сайжруулах шаардлагатай.

2. Оюутан суралцагчдын харилцаа хандлага

Улсын хөгжлийн гол эх үүсвэр, үндсэн шалгуур нь тухайн улсын оюуны чадавх, нөөц юм. Нийгмийн хамгийн оюунлаг давхарга нь их дээд сургуульд байгаа гэвэл энд улсын хөгжлийн үндэс байна гэсэн үг. Тиймээс Монгол улсын ирээдүй хойч үе болох их дээд сургуульд суралцаж буй оюутан залуус мэдлэг, оюуныг эрхэмлэж, цаг ямагт суралцах хэрэгтэй. Цаг ямагт хөгжиж суралцана гэдэг нь дэлхийн цохилох эрдмийн уурхайтай хөл нийлүүлэн алхах их үүдийг өнөөдрийн цахим ертөнц нээж өглөө. Тэр цонхыг арчиж, зүлгүүрдэж, өнгөлөх нь өнөөдрийн оюунлаг залуусын үүрэг, хариуцлага бөгөөд бас тэд их аз золтой хүмүүс юм. Өөрөөр хэлбэл дэлхийн бүх мэдээллийн систем тэдний нүдний өмнө байгаа бөгөөд түүнийг зохицуулан, зохион байгуулах мэдлэг, ур чадвар, чадамж тэдэнд байвал энэ нь дэлхийн глобалчлалтай хөл нийлэн алхаж хөгжил рүү тэмүүлж байна гэсэн үг. Өнөөдрийн боловсролыг залуу судлаач оюутны блогоос иш татсан үгээр илэрхийлбэл: “Боловсрол бол шивээлсэн армиас ч илүү эрх чөлөөний шилдэг харуул ...” гэсэн нь ортой үг ажээ.

Энэ цаг үеийн “Оюутан” гэдгийг википедиа чөлөөт нэвтэрхий тольд дурдсанаар суурь боловсрол болон бүрэн дунд боловсролтой болж, их, дээд сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд элсэн боловсролын зэрэг горилон суралцаж буй хүн” хэмээн тодорхойлжээ.²⁰⁴ Тиймээс оюутан нь нийгэмд тодорхой бие даасан байр суурьтай бие хүн бөгөөд онцгой цаг хугацаанд амьдарч, суралцаж байгаа оюунлаг бүрэлдэхүүн юм. Өөрөөр хэлбэл хэн нэг нь эсвэл чиний ч хувьд хэдийгээр сонголт байсан боловч оюутан байх замыг өнөөдөр сонгосон бол эрдэм, мэдлэгт шамдаж, боловсролтой болох нь нэн тэргүүний зорилт юм. Оюутан хүнд оршиж буй байгаль, нийгмийн давуу тал, боломжийг өөрийн олж авсан давуу тал, чадамж, мэдлэгтэй хамт шатрын хөлөг мэт өрж тавиад харан баясаж, бахархах нь дайнд бол жагссан баатар эрс шиг сүрлэг харагдана. Харин дайнд ялалтыг тактикаар, шатарт хожлыг нүүдлээр шийддэг. Сайн нүүх л хэрэгтэй. Хожлынхоо төлөө санаа зовних биш, харин хожлынхоо тухай бодож эргэцүүлэх, илүү хөгжих, эрэл хайгуул хийх оюунлаг гаралтай хүмүүн байх нь чухал юм.

“Суралцагч” гэж Боловсролын ерөнхий хууль (УБ.,2021)-ийн 1-р бүлгийн 3-р зүйлийн 3.1.11-т зааснаар “боловсролын байгууллагад албан ёсоор элсэн суралцаж байгаа иргэнийг”²⁰⁵ хэлнэ гэжээ. Тэгвэл оюутан суралцагч хэмээх нь боловсролын байгууллага болох их дээд сургуульд мэргэжил боловсрол эзэмшиж буй бүхий л иргэнийг хэлдэг.

Өнөөдрийн оюутан суралцагчдын сэтгэл зүйн орчныг боловсролын байгууллага эерэг хандлагад чиглүүлэх бодлого баримтлах буюу мөн суралцагчдын сурах үйл нь боловсролын даяарчлалын үйл явцаар цахим системд шилжсэнээр сургалтын үйл явц дахь багшийн оролцоо, хяналт багассантай холбоотойгоор цахим системээр дамжуулан мэдээллийг шууд авч суралцаж байгаа юм. Тиймээс энэ үед цахим мэдээллийн орчноос боловсролыг хүртэж буй оюутан суралцагчдын харилцаа, түүнд илрэх хандлагын өвөрмөц хэлбэрийг ялгаж тодруулах, тэдгээрийн анхаарал, сэтгэлийн хөдөлгөөн, хариу үйлдэл, тэдний хүртэхүйн ертөнцийг судлан шинжлэх Модуль 4-ийн хүрээгээр үйл явцыг шинжилж үзье.

Эндээс бид дараах модуль шинж төлөвийн хувьд сонгон шинжлэв.

I модульд суралцагчид өөрсдөө боловсролыг цахим техник технологиос хүртэж байгаа нь тэдний харилцаа хандлагад эерэг эсвэл сөргөөр нөлөөлж байгааг судлах.

²⁰⁴ Википедиа. Чөлөөт нэвтэрхий толь. Нийтэлсэн огноо: 2021.01.28. <https://mn.wikipedia.org/wiki/%>

²⁰⁵ Монгол улсын Боловсролын ерөнхий хууль. УБ., 2021. 06.28. Эх сурвалж линк: <https://lawforum.parliament.mn/draft/75/>

II модульд суралцагчид бие биедээ харилцааны эерэг хандлагаар нөлөөлж, чиглүүлж байгааг шинжлэх.

III модульд боловсролын байгууллага интернет, цахим технологиор дамжуулан оюутан суралцагчдын харилцаанд дүгнэлт хийж, цаашид тулгамдаж буй асуудалд (хичээлийн хөтөлбөр, агуулга, хичээлийн уялдаа холбоо гэх мэт боловсролын албан ёсны хичээлийн хэлбэрүүд) нөлөөлөх боломж байгаа эсэх.

IV модульд оюутан суралцагчийн дотоод сэтгэл зүйн хүчин зүйлд гадаад хүчин зүйл (глобалчлал, даяаршил гэх мэт нийгмийн хүчин зүйл)-ийн сөрөг нөлөөлөл байдаг эсэх, ямар тохиолдолд түүнийг яаж даван туулах талаар асуулга тестээр судалгаа хийв. (Хүснэгт 1-д үзүүлэв.)

Судалгааг энэхүү эх олонлогийн хэмжээнд хийх цаг хугацаа, санхүү, хүний нөөц хязгаарлагдмал тул бага нөөц зарцуулж аль болох эх олонлогийг судалсантай адил дүгнэлтэд хүрэх шаардлагыг хангаж, түүврийн оновчтой хэмжээг тодорхойлохын тулд судалгааны объектыг сонгохдоо мужилсан магадлалт түүвэрлэлтийн загварыг ашигласан.

Европын холбооны гишүүн орнууд болон хамтран ажиллах гэрээт гадаадын сургуулиудыг мужилсан түүвэрлэлт тодорхой шинж чанараар нь сонгож 5 их сургуулийг адил магадлалтайгаар санамсаргүй сонгон авав. Түүвэрлэлтэд сонгогдсон АНУ, БНСУ, ХБНГУ, БНЧУ, ОХУ-ын 5 их сургуулийн оюутан суралцагчдыг тухайн судалгаа авах боломжтой цаг үед таарч энгийн санамсаргүй түүвэр бүрдүүлэлтээр тус бүр 5 оюутныг судалгааны объект болгон сонгон авав.

Хүснэгт 1. Улс орны их дээд сургуульд Монгол оюутнуудын цахим технологийн орчинд боловсрол эзэмших модулийн шинж төлөв

(0-5 онооны үнэлгээг өгсөн. Үүнд 0- нөлөөлөлгүй, сөрөг нөлөөллийг, 5- хамгийн эерэг үзүүлэлт, эерэг нөлөөллийг үзүүлэх.)

Улс орон	АНУ	БНСУ	ХБНГУ	БНЧУ	ОХУ	МУ
Модуль шинж төлөв						
I модуль	5	5	4	4	3	4
II модуль	2	5	5	4	4	3
III модуль	5	5	5	4	4	4
IV модуль	4	5	4	4	2	3
Дундаж үзүүлэлт	4	5	4.5	4	3.25	3.5

Тайлбар: Нийт модуль дээр тухайн улсын их сургуульд сурч байгаа суралцагчдын нийлбэр үнэлгээ (Хавсралт 1-д асуулга-сорилго харуулав.)

АНУ-д суралцагчдын хувьд цахим технологи дээд зэргийн хөгжсөн байдаг нь тэдний хувьд давуу тал болдог, гэхдээ хүн бүрийн зорилгод нийцэж байгаагаас ихээхэн хамаарна. Мөн америкийн сургалтын төлбөр өндөр ч төдий хэрээр санхүүгийн дэмжлэг их авдаг, хичээлийн хажуугаар чөлөөт цаг, ажлыг оюутан өөрөө зохицуулах хэрэгтэй. Эдгээр шалтгаанаас оюутанд цаг зарцуулалт гэсэн зүйл байхгүй бүх зүйл төлөвлөгдөж байдаг, биеэ даасан, хэн нэгэнд туслах, дэмжлэг үзүүлэх боломж харьцангуй бага. Оюутнууд өрсөлдөөнт нийгэмд цагтай уралдаж суралцдаг учир бие даасан шинжтэй, хичээлийн төлөвлөлт хуваарь, сургууль бүрийн хичээл нь харилцан адилгүй хэв маягаар ордог. Олон орны оюутнуудтай мөр зэрэгцэн суралцдаг учир ертөнцийг өөр өнцгөөс харах, тэр хэмжээгээр олон янзын үзэл бодлыг ойлгож, хүлээн зөвшөөрөхөд суралцдаг. Хичээлийн ерөнхий үйл явц нь кредит цагийн үнэлгээгээр, өөрөө хичээлээ сонгож хичээллэх бүрэн боломжтой, бие даалгах, багаар ажиллуулах системтэй учир оюутан харьцангуй бие даах чадвартай, туршиж, бүтээх сэтгэлтэй болдог. Цахим орчны нөлөөлөл оюутнуудад эерэг сөрөг нөлөөллийн харьцаа адилхан. АНУ-д суралцаж оюутнуудын хувьд II модулийн шинж

тэмдэг ажиглагдаж байгаа нь их эрх чөлөөтэй, өөрийн гэсэн үзэл бодолтой зөвхөн өөрийн төлөвлөгөөгөөр ганцаараа бие дааж суралцаж, бас хөдөлмөрлөж байна.

БНСУ-ын хувьд оюутан суралцагч нь их сургуульд аль ч шатны чиглэлээр суралцахад хичээлийн ерөнхий төлөвлөгөөгөөр явна, дэг журамтай, соёлтой, харилцааны өндөр чадварыг эзэмшсэн байх ёстой. Хичээлийн жилд оюутан тавьсан зорилгоо хэрэгжүүлж чадахгүй бол хариуцлага хүлээж нэг анги доош суралцана, сургалтын орчин, технологи дээд зэргийн, орчинтой нийцэж багш суралцагчийн харилцаа бие биеийгээ хүндэтгэх ёс зүйтэй, суралцах, амьдрах орчныг цогцоор нь шийдсэн, хичээлийн ерөнхий үйл явц зарим нэгэн их сургуульд догматик хэлбэрийн, ...ёстой гэсэн төлөв хандлагатай. Цахим орчны хувьд эерэг хандлага давамгайлдаг. БНСУ-д суралцаж буй Монгол оюутнуудын хувьд бие биедээ туслах, нөхөрлөх, харилцах, дэмжлэг үзүүлэхийн хувьд эерэг хандлагатай. Харилцааны сөрөг хандлагууд нэг их илэрсэнгүй.

ХБНГУ- Герман, Францад суралцсан монгол залуус өөрийн зорилгодоо хүрэхийн тулд маш нягт нямбай зарчимч, тогтвортой, харилцааны хувьд дэгтэй, үг дуу цөөн, цаг баримтлагч байдаг. Герман улс нь ардчилсан системт Монгол улсад олон үйл ажиллагааг дэмжин тусалж ажиллахыг хичээдэг. Оюутан тус бүр өөрсдийн сурах төлөвлөгөөтэй. Харилцан бие биедээ итгэлцэх итгэл дээр харилцаа тогтдог. Итгэлийг алдвал харилцаа дуусна гэсэн уламжлалтай. Ялангуяа нарийн мэргэжилд (Community College) суралцаж буй оюутнуудын хувьд бие биетэйгээ уулзах, ярилцах, чөлөөт цагаа өнгөрүүлэх боломж бага. Суралцах үйл явц, хэвшмэл, дэг ёс суртахуун заавал байна. Түүнийг хэрэгжүүлэх оюутны үүрэг гэж үздэг. Лаборатори болон туршилтын хичээлүүдийн сургалтын танхим илүү хөгжсөн. Механик, инженерийн чиглэлийн оюутнуудын үйл ажиллагааг илүү дэмжиж тэтгэлэгт хөтөлбөрүүд байдаг. Цахим орчин дахь оюутнуудын хандлага маш их дэг соёлтой.

Бүгд Найрамдах Чех Улсын их дээд сургуулиудад суралцах Монгол оюутнуудын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа, тэдгээрийн ихэнх нь чех хэлний шалгалт өгч шаардлагатай түвшинд хүрсэн нь сургуульдаа үнэ төлбөргүй суралцах боломжтой. Сургалтын орчин нэгэн хэвийн, техник технологи, цахим, танхим хосолсон. Сургалтын явц оюутан хичээлийг их боловсруулалт шинжилгээ хийж үр дүнг буцааж удирдагчид хянуулах гэх мэт их шат дараалсан олон үйл ажиллагааг удаан хугацаанд гүйцэтгэнэ. Оюутнуудын бие биеийгээ хүндэтгэх харилцаа, хандлага их чөлөөтэй, илэн далангүй нийтэч, гэхдээ ихэнх нь өөрийн үзэл бодол, зорилгодоо хүрэхийн тулд шулуухан үг, хэл яриатай. Ийм харилцааг монгол оюутнууд ч мөн эзэмшсэн байдаг.

ОХУ- нь газар нутгийн хувьд өргөн учир хот бүр сургалтын өөр өөр онцлог системтэй, сургалтын орчин техник тоног төхөөрөмж цахим, танхим хосолсон хэлбэрээр сургалт явагддаг, оюутан бүр бүлгийн, ангийн зохион байгуулалтаар хичээл, кредитээ сонгоно. Орост сурч буй оюутнууд нэг холбоо, зөвлөлөөр дамжуулан бие биетэйгээ чөлөөтэй харилцдаг, одоо зөвхөн өөрийн дотоод сүлжээ ви-контактаар харилцдаг. Бие хүний дотоод мөн чанар нийгмийн харилцаа их нөлөөлдөг, үймээн дайн самуун хэзээ ч, хаана ч болох боломжтой учир олон нийтийн газраар явахгүй зөвхөн сургууль-оюутны байр гэсэн маршрутаар явдаг. Бусад мэдээллийн сүлжээ дутмаг учир хоорондоо сүлжээ тогтоох боломж муу. Тэгэхээр ОХУ-д суралцаж Монгол оюутнуудын хувьд IY модулийн хувьд их өөрчлөлт, шинж тэмдэг ажиглагдаж байна.

Монгол улсын хувьд оюутан суралцагчдын харилцаа хандлагын модуль хэмжээс нь ойролцоогоор 3.5 хувь гарчээ. Энэ нь оюутнууд цахим техник технологийн орчинд бие биедээ нөлөөлөх харьцангуй тогтвортой, эерэг мөн түүнийг дагаад сөрөг нөлөөлөл ч байдаг. Их дээд сургуулийн орчны хувьд улсын сургууль, хувийн хэвшлийн сургуулиас орчны хувьд эрс ялгаатай, танхимын хичээл сургалт илүү давамгай ордог. Цахим тоног төхөөрөмжийн хувьд улсын сургууль дутмаг. Их дээд сургуульд суралцагч оюутнууд танхимын сургалтаар явагдаж байгаа тохиолдолд багийн зохион байгуулалтаар хичээлийг явуулна, бие биедээ туслах, дэмжих нь хүртээмжтэй байдаг.

Дүгнэлт, санал

Монгол улсын хэмжээнд 69 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж 145,267 суралцаж байна. Харин 2018 оны байдлаар гадаадад суралцаж буй монгол оюутнуудын тоо БНСУ-д 7300 оюутан, БНХАУ-д 10,100 гаруй оюутан, ОХУ-д 2000 гаруй оюутан, Австрали улсад 3500 гаруй оюутан, Япон улсад 3125 оюутан, АНУ-д 148 оюутан, Канад улсад 250 гаруй оюутнууд буюу макро түвшнээр харвал 25000 гаруй оюутан гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан өөрийгөө хөгжүүлж, улс эх орныхоо статус байр суурийг өндөрт өргөж явж байна. Энэ оюутны суралцаж буй статистик мэдээлэлд анализ хийхэд гадаадын тэтгэлэгт хөтөлбөрүүд их зарлагдаж түүний шалгуурт нийцэх оюутнуудын мэдлэг ур чадвар дутмаг байдаг нь ажиглагдлаа.

Тэгэхээр боловсролын удирдлага тогтолцооны хувьд анхаарч оюутан суралцагчдыг мэдлэгийн цар хүрээг тэлэх, ялангуяа хэл, соёл иргэншлийн ерөнхий мэдлэгийг хөтөлбөрт шингээх нь зүй.

Боловсролын даяаршил хэмээх том үйл явц хүн төрөлхтнийг соён гэгээрүүлж, нийгмийн харилцаа, соёл, улс төр, эдийн засгийн хувьд хөгжүүлэх харилцааг нийтийн зарчмаар явуулж байна. Энэ харилцааг түгээж буй байгууллага бол Европын холбоо, түүний түншлэгч улс орнууд юм. Европын холбооны үйл ажиллагаа нь зөвхөн нийгэм-соёл, хүмүүнлэг, улс төр-эдийн засгийн үйл ажиллагаанд чиглэгдэхээс гадна глобалчлалын үе, дараах үе хоорондын энэ шатанд боловсролын даяарчлал руу анхаарлаа хандуулах нь зүй.

Боловсролын даяарчлал нь оюутан суралцагчдын харилцаа, хандлагад нэг харилцаа, нэг мэдээллийг түргэн, хүртээмжтэй, ёс зүйтэй хүртээж байгаа хэдий ч бас оюутан суралцагчдад бүх зүйлийг бэлэнчлэх сэтгэлгээг суулгах сөрөг талууд ажиглагдаж байна.

Боловсролын даяарчлалын хамгийн гол арга зүй бол дэлхийн жишигт хүрсэн их дээд сургуулиас ямар ч түвшний боловсролыг жигд хүртэх боломжийг олгож байгаагаараа оюутан суралцагчдад эерэг хандлагыг төрүүлж байгаа юм.

I-IV модулийн түвшинд дүгнэн үзэхэд Монгол оюутнуудын гадаадад суралцах үйл явцад орчны нөлөөлөл, ялангуяа нийгэм-улс төрийн хүчин зүйлээс шалтгаалж тэдгээрийн үр дүн тухайн улс орны нийгмийн хүчин зүйлүүдээс шалтгаалж суралцах үйл явцад сөргөөр нөлөөлдөг. I модулийн хувьд харьцангуй сөрөг хандлага гаргадаггүй, гадаадад суралцаж буй оюутнууд бие биедээ дэмжлэг үзүүлж, гадаадад дахь Монголын оюутны холбоогоор дамжуулан өөрт болон бусдад тулгамдаж буй асуудлуудыг аль болох зөв өнцгөөс шийдвэрлэдэг, хамтач сэтгэлгээтэй харилцаа сайтай орчныг бүрдүүлж байна.

Аль ч улсын боловсролын байгууллагад Боловсролын даяарчлал нь оюутан суралцагчдын харилцаанд эергээр нөлөөлж, түүнээс илрэх хандлага нь биен биеийгээ хүндэтгэх, харилцааны ёс зүйтэй, харьцангуй нийгэм-соёлын мэдлэгтэй, эерэг хандлагаар (X үеийнхнээс Z үеийнхний бие биетэйгээ харилцах хандлага ч үүгээр илэрхийлэгдэж байна.) харилцаж, зөв бодолтой иргэнийг төрүүлж байгаагаар нийгэмд жинтэй хувь нэмэр оруулж байна.

Монгол улсын боловсролын түвшин олон улсын их дээд сургуулийн боловсролын түвшинтэй харьцуулахад эн тэнцүү хөл нийлүүлэн алхаж байгааг гадаадад суралцаж буй оюутан суралцагчдын ярилцлага, асуулгын үр дүнгээс ажиглагдаж байна.

Ном зүй

- [1] Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.1.5-р заалт, УБ.,2010.
 [2] БШУЯ. Дээд боловсролын 2022-2023 оны хичээлийн жилийн статистик мэдээллээс. <https://www.meds.gov.mn/post/125506>
 [3] Home mortgage corporation. Мэдээ, мэдээлэл. Гадаадад ажиллаж, амьдарч буй иргэдийн тоо. 2023. Эх сурвалж линк: <http://hmc.mn/medee/v/6#>

- [4] Б.Бөртэ-Үжин. IKON.MN. Монгол оюутнуудын дийлэнх нь Азийн орнуудыг зорьж байна. Эх сурвалж: <https://ikon.mn/n/1olw> . Нийтэлсэн огноо: 2019.09.27.
- [6] Википедиа. Чөлөөт нэвтэрхий толь. Нийтэлсэн огноо: 2021.01.28. <https://mn.wikipedia.org/wiki/%>
- [7] Монгол улсын Боловсролын ерөнхий хууль. УБ., 2021. 06.28. Эх сурвалж линк: <https://lawforum.parliament.mn/draft/75/>
- [8] Л.Сүхбат. Америкийн шилдэг их дээд сургуулиудад суралцах нь. УБ., 2017.
- [9] Zeine, R., Boglarsky, C. A., Blessinger, P & Hamlet, M. T, "Organizational Culture in Higher Education," in The Strategic Management of Higher Education Institutions: Serving Students as Customers for Institutional Growth, NY, Business Expert Press, 2011, pp. 1-27.
- [10] Ж. Нарантуяа, Боловсролын мэргэшсэн менежерийг бэлтгэх асуудал, Улаанбаатар: (Боловсрол судлалын философийн доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл), Боловсролын хүрээлэн, 2000.
- [11] Н. Бэгз, Глобалчлалын үеийн Монгол Улсын боловсролын хөгжлийн онол арга зүйн үндсэн асуудлууд, Улаанбаатар, 2001.

Хавсралт 1.

Гадаадад суралцаж буй оюутан суралцагчдын харилцаа, хандлагыг тодорхойлох асуулга-тест /УБ., 2022/

1. Танд цахимаар мэдээ, мэдээллийг хүртэхэд хүндрэлтэй байдаг уу?
 - А. Тийм
 - Б. Үгүй
2. Та өөрөө тухайн мэргэжлийнхээ кредит, хөтөлбөрийг цахимаар сонгодог уу?
 - А. Цахимаар
 - Б. Бичгээр /шуудангаар/
 - В. Өөрийн биеэр очиж
3. Цахимаар мэдээ, мэдээллийг авахад ямар эерэг нөлөөллийг үзүүлж байна вэ?
 - А. Харилцахад амар хялбар
 - Б. Мэдээллийг авахад түргэн шуурхай
 - В. Бусдад мэдээллийг түгээхэд амар хялбар
 - Г. Мэдээлэл илүү баялаг
4. Цахимаар мэдээ, мэдээллийг авахад ямар сөрөг нөлөөллийг үзүүлж байна вэ?
 - А. Мэдээллийн үнэн худлыг мэдэх боломжгүй
 - Б. Заримдаа цахим технологи хэрэглэх дургүй
 - В. Цахимаар бусадтай харилцах явцад сэтгэлээсээ ярилцдаггүй
 - Г. Ойлгомжгүй, системгүй мэдээлэл илүү байдаг
5. Сургалтын орчин, суралцах нөхцөл боломж хэр байна?
 - А. Маш тохилго, нөхцөл боломж сайн
 - Б. Цахим, техник, технологи илүү хөгжсөн
 - В. Хамгийн сайн нөхцөлөөр хангагддаг
 - Г. Техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан
 - Д. Дунд түвшинд / танхим болон цахим хосолсон/
 - Е. Орчин нөхцөл муу, сайжруулах шаардлагатай
6. Таны сурч буй улс оронд оюутан суралцагчдын харилцаа хандлагыг үнэлбэл та хэд гэж үнэлэх вэ? /0-5 буюу доороос дээш баллын үзүүлэлтийг баганад байршуулан үнэлнэ үү? 0- муу, 5- сайн гэх мэт

Хүчин зүйл	0-1	1-2	2-3	3-4	4-5
Өөрийгөө хүндлэх					
Бусдыг ойлгож, хүндлэх					
Цахим орчин, технологитой харилцах байдал					
Бусадтай хамтрах байдал					
Бие даах чадвар					
Бусад орны суралцагчдыг хүндлэх байдал					
Бусдад мэдлэг, ур чадвараа хуваалцах байдал					
Харилцааны соёл, ур чадвар					
Хичээл сургуульдаа хандах хандлага					
Манлайлах ур чадвар					

7. Гадаадад суралцаж байхдаа та бусдад эергээр нөлөөлье гэвэл ямар хандлага үзүүлэх вэ?

- А. Аль болох үзэл бодлыг нь түрүүлж сонсох
- Б. Нэг нэгнийгээ хүндэтгэж байгаагаа илэрхийлэх
- В. Үйлдлээрээ
- Г. Үгээрээ
- Д. Онлайнаар харилцах
- Е. Огт харилцахгүй

ИХ СУРГУУЛИЙН АХИСАН ШАТНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗАРИМ АГУУЛГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

(МОНГОЛ, ФИНЛЯНД УЛСЫН ЖИШЭЭГЭЭР)

А.Мөнхцэцэг, Ц.Түвшинбаяр

ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн

Нийгмийн ухааны тэнхимийн багш, цагдаагийн дэслэгч

Товч агуулга:

Бид энэхүү илтгэлээрээ Монгол, Финлянд улсын дээд боловсролын тухай хууль, ахисан шатны сургалтын зарим хөтөлбөрийг харьцуулан судлахыг зорьсон. Дээрх зорилгыг биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Монгол, Финляндын дээд боловсролын тухай хуульд харьцуулсан судалгаа хийх;
- Монгол, Финляндын Их сургуулийн ахисан шатны сургалтын хөтөлбөрийн онцлог;

Abstract:

We aimed to compare and analyze the higher education laws of Mongolia and Finland, as well as some advanced education programs in this article. In order to achieve the above objectives, the following objectives are proposed. It includes:

- Comparative study of higher education laws of Mongolia and Finland;
- Features of the postgraduate programs of Mongolian and Finnish Universities;

Түлхүүр үг:

Монгол, Финлянд, Боловсролын тогтолцоо, Их сургууль, Бакалавр, Магистр, Доктор,

Keywords:

Mongolia, Finland; education system, University, Bachelor, Master, Ph.D

Судалгааны үндэслэл

Монгол улс 1990-ээд оноос нийгмийн хөгжлийн шинэ сонголтыг хийж дэлхийн улс орнуудын хөгжлийн жам ёсны чиг хандлагад нэгдэж, чөлөөт зах зээлийн харилцаат нийгмийн байгуулалтад шилжсэнээр боловсролын тогтолцоо, түүний агуулга, шатлал сургалтын технологийн шинэчлэлд нэгдсэн байдаг.²⁰⁶

Аливаа улс орны хүний нөөцийн өрсөлдөх чадварын гол үзүүлэлт нь боловсрол юм. Монгол, Финлянд улс нь цөөн хүн амтай, боловсролын түүхийн хувьд харьцуулан авч үзэхэд ижил төсөөтэй замналыг туулсан байдаг. Богино хугацаанд нийт хүн амын бичиг үсэг тайлалтад бодит ахиц гарч байсан хоёр улсын боловсролын салбарын өнөөгийн нөхцөл байдал харьцангуй өөр түвшинд байгаа нь бидний судалгааны үндэслэл болсон юм.

²⁰⁶ Төмөр-Очир.С “Дэлхийн боловсролын харьцуулсан судалгаа”, УБ.,2020 он

Research rationale:

Since the 1990s, Mongolia has changed its course toward social growth and joined the global trends by natural development. It has contributed to the modernization of the educational system, its content, and its hierarchies by embracing a free market social structure.

The main indicator of human resource competitiveness of any country is education. Mongolia and Finland have a small population, and in terms of educational history, they have had similar trajectories. The reason for our research is that the current situation in the education sector of the two countries, where there has been real progress in the literacy of the entire population in a short period of time, is at a relatively different level.

Education is the key factor in determining a country's ability to compete in the human resource market. The populations of Finland and Mongolia are similar in size, and their educational histories have followed comparable paths. The current state of affairs in the two countries' educational systems, where there has been noticeable development in the population's overall literacy rate over a relatively short period of time, is at a comparatively different level, which is the impetus for our research.

Үндсэн хэсэг:

Дэлхийн тэргүүлэх орнуудад сүүлийн 25 жил дээд боловсролын систем эрс өөрчлөгджээ. Энэ үйл явц эдийн засгийн дэвшилд дээд сургуулийн үүрэг өсөн нэмэгдэж байна.²⁰⁷

Монгол улс зах зээлийн эдийн засаг бүхий хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлон байгуулж хөгжүүлэхийг зорьсон.

Нийгэм хувьсан өөрчлөгдөхийн хэрээр боловсролын салбарт шинэчлэл хийгдсээр байна.

Боловсролын удирдлагын тогтолцоо нь Монгол улсын засгийн газар, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын үндэсний зөвлөл, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, боловсролын байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, боловсролын сургалтын байгууллагын удирдлагаас бүрдэнэ.

Боловсролын байгууллагын тогтолцоо нь албан ба албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцахуйгаас бүрдэнэ.²⁰⁸

Албан боловсрол нь сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсрол гэсэн түвшинтэй байна.²⁰⁹ Монгол улсын дээд боловсролын сургалтын байгууллага нь коллеж, дээд сургууль, их сургууль байна.²¹⁰

Их сургууль нь дэд бакалавр, бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгаа, туршилт- үйлдвэрийн байгууллага байна. Мөн их

²⁰⁷ Төмөр-Очир.С “Дэлхийн боловсролын харьцуулсан судалгаа”, УБ.,2020 он.

²⁰⁸ Боловсролын тухай хуулийн 7.1 дэх хэсэг

²⁰⁹ Боловсролын тухай хуулийн 7.2 дахь хэсэг

²¹⁰ Дээд боловсролын тухай хуулийн 6.1 дэх хэсэг

сургууль нь харьяалалдаа коллеж, технологийн коллеж, политехник коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, судалгааны лаборатори, төв, хүрээлэн, ахлах сургууль, дадлагын баазтай байж болно.

Сургалтын байгууллага нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:²¹¹

- Эрдмийн эрх чөлөөг эрхэмлэх;
- Оюуны бүтээл, судалгааны ёс зүйг дээдлэх;
- Дээд боловсролын сургалтын байгууллагын бие даасан байдлыг дэмжсэн байх;
- Хамтын удирдлагатай улс төр, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

Харин Финлянд улсын дээд боловсролын тогтолцоо нь эрдмийн болон хэрэглээний шинжлэх ухааны их сургууль гэсэн 2 байгууллагаас тогтоно.

Анхны технологийн дээд буюу хэрэглээний шинжлэх ухааны сургууль 1991-1992 оны хичээлийн жилд туршилтаар хэрэгжүүлж эхэлсэн. Олон улсын тэргүүлэх 100 их сургуульд Финляндын Хельсинкийн их сургууль багтаж 96 дугаар байранд жагссан статистик тоон үзүүлэлт байдаг.

Мөн 2017 оноос эхлэн Европын холбооны бус улс орны оюутныг төлбөртэй сургах болсон. Эрдмийн их сургууль нь шинжлэх ухааны судалгааны шинжтэй байна. Энэ сургуульд 3 жил суралцаад бакалаврын зэрэг, ахисан шатанд буюу магистр, докторын түвшний сургалтад үргэлжлүүлэн суралцах боломжтой байдаг. Бүх их сургууль нь улсын өмчийнх. Хамгийн алдартай, нэр хүндтэй сургалтын чиглэл бол технологийн салбар юм.

Финлянд улсын сургуулийн боловсролын онцлог нь дараах 7 зарчмаар тодорхойлогддог. Үүнд:²¹²

Адил тэгш байх	Үнэ төлбөргүй байх зарчим	Ганцаарчлан хандах зарчим	Практикт айнаг холбоотой зарчим	Итгэлтэй байх зарчим	Сайн дурын зарчим	Бие даасан байдалтай байх зарчим
- Сургуулийн тэгш байдал; - Бүх хичээлийн тэгш байдал; - Эцэг эхийн тэгш байдал; - Суралцагчийн тэгш байдал; - Багшийн тэгш байдал	- Сургалтаас бусад ажил; - Эцэг, эхээс нэмэлт зардал гаргахгүй байх	Суралцагч бүр хувь хүний хөгжлийн тусгай төлөвлөгөө боловсруулдаг.	Сургалтын зорилго нь шалгалтад бэлтгэх биш, амьдралд бэлтгэхэд оршино.	Суралцагч бүр өөрийн хүсэл сонирхолд суурилан суралцах үйл явц юм.	Хэн сурахыг хүснэ, тэр суралцагч л сурна.	Суралцагч бүр өөрийн хүсэл сонирхолд тулгуурлан бие даан сурах үйл явцыг хэлнэ.

Үүнээс үзэхэд Монгол, Финлянд улсын боловсролын салбар түүхэн цаг хугацааны хувьд ижил төстэй замналыг туулсан байна. Боловсролын салбарын хоцрогдолтой байсан

²¹¹ Дээд боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйл

²¹² Төмөр-Очир.С “Дэлхийн боловсролын харьцуулсан судалгаа”, УБ.,2020 он

хоёр улсын хувьд маш хурдтай хугацаанд эерэг өөрчлөлт бий болсон байдаг. Өнөөгийн байдлаар хоёр улсын боловсролын салбарын бодит нөхцөл байдал эрс ялгаатай байна.

Тус улс нь 2016 оноос хичээлд суурилсан сургалтаас татгалзаж **үзэгдэлд** суурилан судлах сургалтыг нэвтрүүлж байна.

Дээд боловсролын тухай хуульд хийсэн харьцуулсан судалгаа

№	Монгол улс	Финлянд улс
Дээд боловсролын зорилго		
1	Нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах, олон соёлын орчинд ажиллаж, амьдрах чадвартай, ёс суртахуунтай иргэнийг бэлтгэхэд оршино.	Чанартай боловсролын үйлчилгээгээр хангах, насан туршдаа үнэ төлбөргүй суралцуулахад боловсролын үндсэн зорилго оршино.
Тайлбар: Манай улсад төрөөс баримтлах бодлогод нийцүүлэн дээд боловсролын тухай хуулиар зохицуулагддаг, харин Финлянд улсад чанартай боловсролын үйлчилгээгээр хангах, насан туршдаа үнэ төлбөргүй суралцуулж байгаагаараа ялгаатай байна		
Дээд боловсролын зорилт		
2	Дээд боловсролын удирдлага, зохион байгуулалт, сургалт, судалгаа, санхүүжилт тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулна.	Хүмүүнлэг, нийгмийн хариуцлагатай гишүүн болон төлөвшихөд дэмжлэг үзүүлэх, тэдний практик мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, боловсролын тэгш байдлыг хангахад чиглэгдэнэ.
Тайлбар: Дээд боловсролыг тэгш олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдэж байгаагаараа ижил төстэй байна гэж үзэж байна.		
3	Дээд боловсролын сургалтын байгууллага	
Их сургууль		
3.1	Их сургууль нь дэд бакалавр, бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгаа, туршилт- үйлдвэрийн байгууллага байна.	Эрдмийн болон хэрэглээний шинжлэх ухааны их сургууль гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Их сургууль нь бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг. Их сургуулийн зэрэглэлийн тогтолцоо нь бүхэлдээ академик шинжтэй байна. Тухайлбал, Доод академик зэрэг нь бакалавр, дээд академик зэрэг нь магистр, судлаачийн зэрэг нь доктор юм
3.1.1	Дэд бакалавр	
	Дэд бакалаврын сургалт нь 90 багц цагаас доошгүй байна.	-

<p>Тайлбар: Финлянд улсын ахисан шатны боловсролын түвшинд дэд бакалавр гэсэн томъёолол байхгүй байна. Харин манай улсад Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлд тусгасан байна.</p>	
Бакалавр	
3.1.2	<p>Бакалаврт бүрэн дунд боловсрол эзэмшсэн элсэлтийн шаардлага хангасан хүнийг элсүүлнэ. 120 багц цагийн сургалтыг 4 жилд багтаан эзэмшсэн байна.</p>
	<p>Дээд боловсролын анхан шат. Эрдмийн их сургуульд 180 багц цагийн сургалтыг 3 жилд багтаан эзэмшдэг. Харин хэрэглээний шинжлэх ухааны их сургуульд 210-270 багц цагийн сургалтыг 3.5-4.5 жилд багтаан эзэмшдэг. Хэрэглээний шинжлэх ухааны их сургуулийн хөтөлбөр практик чиглэлтэй байдгаараа онцлог юм.</p>
<p>Тайлбар:</p> <ul style="list-style-type: none"> - Финлянд улсад дээд боловсролын анхан шатанд Эрдмийн их сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны их сургуульд шалгалтгүйгээр бакалаврт элсэх боломж нээлттэй, тухайн суралцагч өөрийн хүсэл сонирхолд тулгуурлан үнэ төлбөргүй суралцах боломжтой бөгөөд 2017 оноос эхлэн Европын холбооны бус орнуудын суралцагчид төлбөртэй сургах болсон. Харин манай улсад бакалаврын сургалтад бүрэн дунд боловсрол эзэмшиж, элсэлтийн шалгалт өгч тухайн улсын болон хувийн их дээд сургуульд төлбөртэйгөөр элсэн суралцдагаараа ялгаатай байна. - Дээрх хоёр улсын суралцах хугацаа нь харьцангуй төсөөтэй байна. - Финляндын сургалтын багц цагийг Монгол улстай харьцуулан үзэхэд <u>нэг</u> хоёр дахин их байгаагаараа ялгарч байна. 	
Магистр	
3.1.3	<p>Магистрын хөтөлбөрт 2 жил сурдаг. Магистрын зэрэг авахын тулд 120 багц цагийн сургалтад хамрагдана.</p>
	<p>Магистрын хөтөлбөрт дунджаар 2 жил сурдаг. Магистрын зэрэг авахын тулд 120 багц цагийн сургалтад хамрагдана.</p> <p>Их сургуулиудын хувьд ихэнх нь магистрын хөтөлбөрөө англи хэлээр явуулдаг.</p> <p>Хэрэглээний шинжлэх ухааны их сургуулийн магистр 1.5 жилд 60-90 багц цагийн хөтөлбөрт хамрагдана. Харин бакалаврын зэрэг аваад хамгийн багадаа 2 жил ажилласан байхыг шаарддаг.</p>
<p>Тайлбар: Дээрх хоёр улсын Их сургуулийн магистрын хөтөлбөрийг суралцах хугацаагаар нь харьцуулан авч үзэхэд Финлянд улсын суралцах хугацаа, танхимын сургалтыг судлах багц цагийн хувьд харьцангуй бага байна. Мөн тухайн суралцагч нь бакалаврын зэрэг хамгаалаад 2 жил практик ажилласан байхыг шаарддаг. Харин манай улсад үргэлжлүүлэн магистрт сурахад ажлын туршлага шаардахгүй нээлттэй байгаагаараа ялгаатай байна.</p>	
Доктор	
3.1.4	<p>Докторын сургалт нь 210 цагаас доошгүй 4 жилд багтаан эзэмшинэ.</p>
	<p>Эрдмийн их сургуульд докторын сургалт явуулахыг зөвшөөрдөг. Тус сургалтад 240 багц цагийн сургалтыг 4 жилд багтаан эзэмшинэ.</p> <p>Докторын сургалт нь 2 хувилбартай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үндэсний хөтөлбөр: Энэ нь улс орны хэмжээний чухал ач холбогдолтой бүх

		<p>их сургуулийн ерөнхий чиглэлтэй тохирч байх ёстой.</p> <p>2. Судалгааны докторын хөтөлбөр: Энэ нь суралцагч өөрөө бие даан сонгосон сэдэвтэй байна. Энэ нь бусад докторын хөтөлбөртэй төсөөтэй юм.</p>
<p>Тайлбар: Суралцах хугацаа, багц цагийн хувьд дээрх хоёр улсын хувьд төсөөтэй байна. Харин Финлянд улсад докторын сургалтыг 2 хөтөлбөрийн хүрээнд элсүүлж, Эрдмийн их сургууль нь докторын сургалтыг эрхлэн явуулахыг хуулиараа зөвшөөрдөг. Манай улсад улсын болон хувийн их сургуульд докторын сургалт явуулахад нээлттэй байгаараа онцлог ялгаатай байна.</p>		

Дүгнэлт

Бид энэхүү илтгэлээрээ Монгол, Финлянд улсын дээд боловсролын тухай хууль, ахисан шатны сургалтын хөтөлбөрийн онцлогийг харьцуулан судалсан. Үүнд:

Боловсролын зорилгоор нь харьцуулан авч үзвэл: Манай улсад төрөөс баримтлах бодлогод нийцүүлэн дээд боловсролын тухай хуулиар зохицуулагддаг, харин Финлянд улсад чанартай боловсролын үйлчилгээгээр хангах, насан туршдаа үнэ төлбөргүй суралцуулж байгаагаараа ялгаатай байна.

Боловсролын зорилтоор нь харьцуулан авч үзвэл: Дээд боловсролыг тэгш олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдэж байгаагаараа ижил төстэй байна гэж үзэж байна.

Ахисан шатны боловсролын түвшнээр нь авч үзвэл:

Дэд бакалаврт: Финлянд улсад дэд бакалавр гэсэн томъёолол байхгүй байна. Харин манай улсад Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлд тусгасан байна.

Бакалаврын түвшинд: Финлянд улсад дээд боловсролын анхан шатанд Эрдмийн их сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны их сургуульд шалгалтгүйгээр бакалаврт элсэх боломж нээлттэй, тухайн суралцагч өөрийн хүсэл сонирхолд тулгуурлан үнэ төлбөргүй суралцах боломжтой бөгөөд 2017 оноос эхлэн Европын холбооны бус орнуудын суралцагчид төлбөртэй сургах болсон. Харин манай улсад бакалаврын сургалтад бүрэн дунд боловсрол эзэмшиж, элсэлтийн шалгалт өгч тухайн улсын болон хувийн их дээд сургуульд төлбөртэй элсэн суралцдагаараа ялгаатай байна. Дээрх хоёр улсын суралцах хугацаа нь харьцангуй төсөөтэй байна.

Финляндын сургалтын багц цагийг Монгол улстай харьцуулан үзэхэд нэг дахин их байгаагаараа ялгарч байна.

Магистрын түвшинд: Дээрх хоёр улсын их сургуулийн магистрын хөтөлбөрийг суралцах хугацаагаар нь харьцуулан авч үзэхэд Финлянд улсын суралцах хугацаа, танхимын сургалтыг судлах багц цагийн хувьд харьцангуй бага байна. Мөн тухайн суралцагч нь бакалаврын зэрэг хамгаалаад 2 жил практик ажилласан байхыг шаарддаг. Харин манай улсад үргэлжлүүлэн магистрт сурахад ажлын туршлага шаардахгүй нээлттэй байгаагаараа ялгаатай байна.

Докторын түвшинд: Суралцах хугацаа, багц цагийн хувьд дээрх хоёр улсын хувьд төсөөтэй байна. Харин Финлянд улсад докторын сургалтыг 2 хөтөлбөрийн хүрээнд элсүүлж, Эрдмийн их сургууль нь докторын сургалтыг эрхлэн явуулахыг хуулиараа зөвшөөрдөг. Манай улсад улсын болон хувийн их сургуульд докторын сургалт явуулахад нээлттэй байдгаараа ялгарч байгаагаараа онцлог байна.

Санал

Бид дээрх харьцуулсан судалгаандаа үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Улсын болон хувийн сургуулиудын ялгаатай чадамж нь нийт иргэд тэгш боловсрол эзэмших үндсэн зарчмыг алдагдуулж байна. БШУЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвөөс жил бүр эмхэтгэн гаргадаг элсэлтийн ерөнхий шалгалтын тайлан үүнийг гэрчилж байна. Тиймээс сургалтын чанар, стандартыг нэг түвшинд хүргэх бодлого, төлөвлөгөө боловсруулах шаардлагатай байна.
- Мөн 4 жилийн хугацаатай нийгэм, улс төрийн өөрчлөлт шинэчлэл нь боловсролын салбарын бодлого, хөтөлбөрт шууд нөлөөлж байна. Бид урт хугацааны тогтвортой хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай байна.

Ном зүй

1. Боловсролын тухай хууль
2. Дээд боловсролын тухай хууль
3. Төмөр-Очир.С “Дэлхийн боловсролын харьцуулсан судалгаа”, УБ.,2020 он
4. Бабатунд, Э.Д (1984) Харьцуулсан Боловсролын Арга зүй: Хөгжиж буй орнуудад нийцэх загварын судалгаа /unilorn.edu.ng/journals/education/ije/june/1984
5. Бередэй, Г.Ф. (1957) Харьцуулсан боловсролын аргуудын тухай зарим хэлэлцүүлэг, Харьцуулсан боловсролын тойм,
6. Холмс, Б. (1975) Боловсролын харьцуулсан судалгаа, Үргэлжилсэн боловсролын түүвэр бичвэр, Нью-Йорк, Сиракус хэвлэл

ЕВРОПЫН ХОЛБООНЫ ЗАРИМ УЛС ДЭЭД БОЛОВСРОЛЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА (INTERNATIONALISATION)

*Г.Золзаяа, Отгонтэнгэр Их Сургуулийн Сэтгүүл зүй,
Олон улсын харилцааны тэнхимийн эрхлэгч, Докторант
Н.Хосбаяр, Отгонтэнгэр Их Сургуулийн
Гадаад харилцааны албаны дарга, Доктор (Ph.D.)
Б.Одгэрэл, Отгонтэнгэр Их Сургуулийн
Сургалт, Эрдэм шинжилгээ эрхэлсэн Дэд захирал, Доктор (Ph.D.)*

Оршил хэсэг

Монголын дээд боловсролын чанарыг өнөөдрийн хүрсэн түвшнээс ахиулах, олон улсад өрсөлдөх чадвараа сайжруулах, дотоодын их сургуулиуд (ИС) олон улсад дээгүүр эрэмбэлэгдэх зэрэг боловсролын салбарын ахиц дэвшилд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх нь онол, практикийн өндөр ач холбогдолтой хэвээр байна. Монгол Улсын ИДС-иудын олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, шинэ түвшинд гаргаж учирч буй хүндрэл, бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд дэлхийн улс орнууд, ялангуяа гадаад хамтын ажиллагааг амжилттай хэрэгжүүлж ирсэн Европын улс орнуудын сургамж, туршлагыг судлах нь чухал юм.

Энэхүү өгүүлэлд бид ИС-иудын олон улсын хамтын ажиллагааны тухай ойлголт, түүний нийгмийн ач холбогдол, Европын зарим улс орны олон улсын хамтын ажиллагааны үр нөлөөтэй бодлого, давуу тал, сайн жишгийг чанарын судалгаагаар тодрууллаа.

Үндсэн хэсэг

ИС-ийн гадаад хамтын ажиллагааны тэргүүлэх эрдэмтэд болох Ханс де Вит, Фиона Хантер, Лаура Ховард, Эва Эгрон-Поллак нар их сургуулийн гадаад хамтын ажиллагаа гэдэг нь “Оюутан, багш, ажилтнуудын боловсрол, судалгааны чанарыг дээшлүүлэх, нийгэмд бодитой хувь нэмэр оруулах зорилгоор дээд боловсролын чанарыг олон улсын хэмжээнд хүргэхийн тулд их сургуулийг олон улсын, соёл хоорондын эсвэл дэлхийн жишигт ойртуулж нэгтгэх зорилготой үйл явц” хэмээн тодорхойлсон байдаг. Дээд боловсролын харилцаа, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх нь тухайн улсын боловсролын чанар, чансаа, эрэмбэ нэмэгдэхэд чухал нөлөөтэй гэж үздэг.

Ихэнх дээд боловсролын байгууллагууд эрдэм шинжилгээний болон эдийн засгийн хүндрэл бэрхшээлээс болж дэлхийн хэмжээний институт болох зорилгоосоо няцдаг. Их сургуулиудын олон улсын хамтын ажиллагааны тухай ойлголт шинэ үзэл санаа биш, цаг хугацаа өнгөрөх тусам өргөжин тэлж, дээд боловсролын байгууллагууд төдийгүй засгийн газрын стратегийн чухал ач холбогдолтой үнэт зүйл болж байна. Судалгааны их сургууль бүр өөрсдийн эрдэм шинжилгээ, оюутнууд, профессор багш нараа улам бүр хөгжүүлэх, орчноо сайжруулахыг эрмэлздэг. Дэлхийн хэмжээнд 115 гаруй орны дунд явуулсан олон

улсын түвшний судалгаанаас үзэхэд дэлхийн дээд боловсролын байгууллагуудын удирдлагуудын дийлэнх олонхи нь гадаад хамтын ажиллагаа нэн чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа бөгөөд энэ нь 2010 оноос хойшхи судалгаануудад улам бүр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.²¹³ ИДС-ийн гадаад хамтын ажиллагаа (Internationalization) нь олон талыг өөртөө багтаадаг томоохон ойлголт юм.²¹⁴ Энэ чиглэлийн эрдэмтэн, судлаачид олон янзын агуулгыг энэ ойлголтод багтаасан байдаг. Тухайлбал, Марде, Ингермэн нар ИДС-ын гадаад харилцаа хамтын ажиллагаа гэдэг нь гадаадад байгаа оюутнууд, солилцооны оюутан, багш нар, олон улс судлал, гадаад хэлээр бакалаврын зэрэг олгох, бүс нутаг судлал, гадаад хэлний чиглэлээр явагддаг ахисан түвшний сургалт зэргийг хамруулж авч үзсэн байна.²¹⁵ Харин эрдэмтэн Эллингбое дээрх ойлголтод коллежийн манлайлал, олон улсын үйл ажиллагаан дахь багш нарын оролцоо, олон улсын сургалтын хөтөлбөр, оюутнуудад зориулсан олон улсын судалгаа, олон улсын оюутны хотхон, эрдэмтэд, гадаад оюутны асуудал/хамтарсан сургалтын нэгж зэргийг багтаана гэж тодорхойлжээ. Судлаач Мэйстэнхаусерын үзсэнээр олон улсын боловсролын цогц бодлого, хяналт-шинжилгээ, үнэлгээний механизм, стратегийн төлөвлөгөө, засаглалын бүтэц, төсөв/нөөцийн хуваарилалт, багш нарын хөгжлийн хөтөлбөр, олон улсын чанартай сургалтын хөтөлбөр, олон улсын боловсролд оюутны оролцоог урамшуулах тогтолцоо, эдгээрийн сурталчилгаа зэргийг онцолсон бол эрдэмтэн Найтын тодорхойлсноор сургалтын хөтөлбөр, сургалтын үйл явц, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, орон нутгийн соёл, угсаатны бүлгүүдтэй харилцах, судалгаа, эрдэм шинжилгээний үйл ажиллагаа, иргэдийн шилжилт хөдөлгөөн, олон улсын хөтөлбөр зэргийг хамруулан авч үзжээ.

Европын орнуудаас Финланд, Герман, Франц, Австри Улсуудын боловсролын чанар дэлхийд тэргүүлэхээс гадна гадаад хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж, дэлхийд тэргүүлсэн хэвээр байна. Иймд уг өгүүлэлд дээрх улс орнуудын дээд боловсролын салбарын гадаад хамтын ажиллагааг судалж, өнөөгийн байдал, ололт амжилтыг тодрууллаа.

ФИНЛАНД УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Европын судалгаа, боловсролын хөтөлбөрүүд, тэдгээрийн санхүүжилт нь Финландын дээд боловсрол, судалгааг олон улсын болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн. Жишээлбэл, 1992 онд Эрасмус хөтөлбөр Финландад хэрэгжихээс өмнө оюутан солилцоо маш бага байсан, Европ дахь боловсролын хамтын ажиллагааны бусад хэлбэрүүд ч ховор байжээ. Финланд улс 1995 онд Европын Хамтын Нийгэмлэгийн гишүүн болсон бөгөөд энэ нь Европын санхүүжилттэй хөтөлбөрүүдэд бүрэн хамрагдах төдийгүй Финландын дээд боловсролын байгууллагуудын сэтгэлгээний өөрчлөлтийн эхлэлийг тавьсан юм. Улмаар Европын бодлого, тэр дундаа оюутнууд, багш, судлаачдын солилцооны хөтөлбөрийг онцолсон зэрэг нь дээд боловсрол, судалгааны бодлогод ихээхэн эерэг нөлөө үзүүлсэн. 1990-ээд онд

²¹³ Asma Mohsin, Khalid Zaman, "Internationalization of universities: emerging trends, challenges and opportunities", Journal of Economic info (JEI), No,1 (2014) 1-9, page 1

²¹⁴ Gundsambuu.S, "Internationalization and English as a Medium of Instruction in Mongolian Higher Education" IAFOR Journal of Education, Volume 7 – Issue 1 – Summer 2019, page 73

²¹⁵ European Union. Retrieved from http://ec.europa.eu/education/library/study/borders_en.pdf

Боловсролын яам Финландын дээд боловсролын байгууллагуудад солилцооны хөтөлбөрийг нэмэгдүүлэх санаачлага, ялангуяа Эрасмус хөтөлбөрт нэмэлт санхүүжилт олгохын зэрэгцээ үр дүнд суурилсан хэлбэрээр санхүүгийн урамшууллыг санал болгож эхэлсэн. Үүний нэгэн адил Финланд улс Болоньягийн үйл явцын үндсэн зарчмуудыг нэлээд хурдацтай баталж, байгууллагууд хоёр шатлалт зэрэглэлийн бүтэц болох Европын зээлийн шилжүүлгийн систем (ECTS), бусад үнэлгээний шатлалыг нэвтрүүлж эхэлжээ.

Финляндын ИС-ийн гадаад хамтын ажиллагаа хөгжихөд тус улсын Боловсролын яам ихээхэн нөлөөлсөн. Их дээд сургуулиуд, ялангуяа хэрэглээний шинжлэх ухааны их сургуулиудыг олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц болгоход дэмжлэг үзүүлэхэд Боловсролын яам онцгой анхаарал хандуулсан юм.

Сүүлийн хорин жилийн хугацаанд оюутан солилцоог нэмэгдүүлэх, гадаад оюутнуудыг татах ажлыг Европын хамтын ажиллагаа, санхүүжилтийн төвлөрөл зэрэг сэдвүүдээр дамжуулан нэвтрүүлсэн. Боловсролын Яамнаас 2008 онд анх удаа Финландын дээд боловсролыг олон улсын хэмжээний болгох стратегийг гаргасан. Өмнө нь олон улсын түвшний стратегийн цогц баримт бичиг гараагүй байв. 2009-2015 онд дээд боловсролын байгууллагыг гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх стратегийг их сургуулиудтай зөвшилцсөний үндсэн дээр гаргасан байна.

Стратегид нийт 33 үйл ажиллагааг тусгасан бөгөөд дараах таван сэдэвт хуваагджээ. Үүнд:

1. Олон улсын дээд боловсролын нийгэмлэг
2. Чанарыг сайжруулах
3. Туршлага экспортлох
4. Олон соёлт нийгмийг дэмжих
5. Нийгмийн хариуцлага

Олон улсын оюутан солилцоо, тэтгэлэг, гадаад оюутнуудын тоог нэмэгдүүлэх нь тус стратегийн тулгын чулуу хэвээр байна. Эдгээр хоёр зорилгын хувьд стратеги нь Финландын дээд боловсролын тогтолцооны тоон зорилтуудыг тодорхойлсон бөгөөд дараа нь эдгээр зорилтуудыг бие даасан байгууллагуудын гүйцэтгэлийн гэрээнд шилжүүлжээ. Эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагааг олон улсын чанартай болгох асуудлыг мөн тусгасан.

Финландын Боловсролын Яам нь анх интернационалчлахыг дэмжих гол хөдөлгөгч хүч байсан хэдий ч эдүгээ бие даасан их дээд сургуулиуд стратегийн болон бодлого боловсруулалтын хувьд манлайлах болсон.²¹⁶ Тус яамнаас байгууллагуудын гадаад хамтын ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт, тоон зорилтуудыг тогтоож, тэдний ахиц дэвшлийг жил бүр хянадаг бол их, дээд сургуулиуд стратегийн ялгаатай хандлагыг эрэлхийлж байна. Тухайлбал, оюутан солилцоо, гадаад оюутны элсэлт зэрэг нь гол хүчин зүйл хэвээр хэдий ч олон улсын сүлжээнд оролцох, гадаадаас академик боловсон хүчин

²¹⁶ Beelen, J. (Ed.) (2007). "Implementing internationalization at home". EAIE Professional Development Series for International Educators, No. 2. Amsterdam: European Association for International Education.

элсүүлэх, дэлхийн их дээд сургуулиудын зэрэглэл зэрэг асуудлуудад байгууллагын хариу арга хэмжээ ялгаатай байна.

Финландын дээд боловсролын байгууллагуудыг гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд тодорхой нийтлэг талууд байдаг. Ялангуяа бүх сургуулиуд англи хэлээр заадаг хичээлүүд хөтөлбөрийг ихээхэн анхаарал хандуулж ирсэн. Эхний ээлжинд ирж буй солилцооны оюутнуудын хэрэгцээг хангах зорилгоор ганцаарчилсан сургалтуудыг зохион байгуулж байсан бол сүүлийн 10 жилийн хугацаанд англи хэл дээр бүрэн хэмжээний хөтөлбөрүүд бий болсон. Их, дээд сургуулиудын хувьд бүрэн англи хэл дээрх сургалтыг ихэвчлэн магистр, докторын түвшинд санал болгодог бол хэрэглээний шинжлэх ухааны их сургуулиуд бакалаврын түвшний хөтөлбөрүүдэд анхаарлаа хандуулдаг. Байгууллагын үүднээс авч үзвэл англи хэлээр заадаг курс, хөтөлбөрүүдийг бий болгох нь сургалтын хөтөлбөрийг интернационалчлах, ялангуяа сургалтын хөтөлбөрүүдийн агуулгыг боловсруулахаас илүү чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Оюутны солилцоо, шилжилт хөдөлгөөнийг хэрэгжүүлэхдээ Финландын институтууд улирлын болон жилийн солилцоонд ихээхэн анхаарал хандуулдаг. Энэ нь 1990-ээд онд Боловсролын яамнаас нэвтрүүлсэн үр дүнд суурилсан санхүүжилтийн загвартай холбоотой, үүнийг тооцохын тулд солилцооны хугацаа нь дор хаяж гурван сар байх ёстой байв.

2013 онд их дээд сургуулиас гадагшаа явж буй оюутнуудын нийт тоо 10 189 байсан нь 2003 онтой харьцуулахад (7 555) 35%-иар өссөн бол ирж буй оюутнуудын тоо 9 739 болж 2003 оныхоос 47%-иар өссөн байна. Энэ хоёр баримт нь түүхэн дээд үзүүлэлт боловч 2010 оноос хойш гадагшаа гарсан оюутнуудын хувьд энэ үзүүлэлт нэлээд тогтвортой байна. Их сургуулийн оюутнуудын ойролцоогоор 25% нь оюутны шилжилт хөдөлгөөнд хамрагддаг. Арван жилийн дотор орж, ирж буй оюутнуудын тоо гурав дахин, гадагшаа явж буй оюутнуудын тоо хоёр дахин нэмэгджээ.

ФРАНЦ УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Европын судалгаа, дээд боловсролын томоохон хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлснээс хойш Франц улс маш идэвхтэй ажиллаж, Эрасмус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр өндөр амжилтад хүрч байна. Франц улс Европын дээд боловсролын бүс, Европын судалгааны бүсийг бий болгоход томоохон үүрэг гүйцэтгэсэн. 1998 онд Сорбоны тунхаглал нь Болонийн үйл явц үүссэнийг тэмдэглэсэн. Түүнээс хойш Франц улс Болонийн үйл явцын ихэнх бүрэлдэхүүнийг дэмжиж, хэрэгжүүлсэн. 1980-аад оны сүүл үед Европын боловсролын чанарын үзүүлэлт нь дээд боловсролын байгууллагуудын гадаад хамтын ажиллагаа байв.²¹⁷

2003 онд Шанхайн эрэмбэ зэрэглэл гарч ирэхэд Францын гуравхан их сургууль буюу "grandes écoles" болон судалгааны байгууллагуудын аль нь ч шилдэг 100-д багтсангүй. 2010 оноос хойш их дээд сургуулиудын нэгдэл нь нөхцөл байдлыг сайжруулсан боловч Францын институциудын олон улсын зэрэглэлд арай ядан шилжиж байгаа нь тэдний байр суурь

²¹⁷ Altbach, P.G., Reisberg, L. & Rumbley, L.E. (2009). Trends in global higher education: Tracking an academic revolution. Chestnut Hill, MA: Boston College Center for International Higher Education.

технологийн болон шинжлэх ухааны үйлдвэрлэл, улс орны эдийн засгийн байдалтай ч холбоогүйг харуулж байв.

Иймд Бразил, Хятад, Энэтхэг, Япон, Орос, Өмнөд Солонгос зэрэг улстай хоёр талын дээд түвшний комиссууд байгуулж, шинжлэх ухааны салбаруудад хамтран ажиллах, хүлээн зөвшөөрөх талаар тохиролцоонд хүрсэн, мөн тэтгэлэгт хөтөлбөрүүдийг санал болгож, хоёр талын форум зохион байгуулж байна.²¹⁸

Францын дээд боловсролыг интернационалчлах үйл явцын томоохон зорилго нь оюутан, залуу судлаачдыг магистр, докторын түвшний тодорхой сургалтын хөтөлбөрт татан оролцуулах явдал юм. Эдгээр оюутнууд эдийн засгийн өндөр хөгжилтэй орнууд, ялангуяа хөгжиж буй орнуудаас гадна дэлхийн бөмбөрцгийн өмнөд хагасын орнуудаас ирж, эв нэгдэл, хамтын ажиллагааны хүрээнд хүлээн авах болсон. Тиймээс шинээр элсэж буй оюутнуудын 30 орчим хувь нь (зэрэг болон кредитийн шилжилт хөдөлгөөн) хэрэгцээнд суурилсан тэтгэлэг авдаг.

Үндэсний хэмжээнд зохицуулсан төслүүдийн зарим жишээ:

- 1846-1928 оны хооронд байгуулагдсан таван 'Францын сургууль' нь нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухаанд судалгаа, сургалтыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.
- Өөр өөр үндэсний статустай ч франц хэлээр ярьдаг автономит их сургуулиуд: Галатасарай их сургууль (Истанбул, Турк), Université Française d'Égypte, Université Française d'Arménie (UFAR, Эреван), Université des Sciences et Technologies à Hanoi (Вьетнам)
- Хоёр талын хэлэлцээрээр байгуулагдсан сургууль, их дээд сургуулиуд Франц улсаас их хэмжээний санхүүгийн болон дипломат дэмжлэг үзүүлсний дараа бие даасан статустай болсон. Үүнд: Хойд Африк ба Ойрхи Дорнодод: Ливан, Алжир дахь École Supérieure de Beyrouth болон École Supérieure Algérienne des Affaires; Вьетнамд: Төв Франц-Вьетнам pour la Gestion, Program Franco-Vyetnamien pour la Formation des Ingénieurs; 1999 оноос хойш Хятадад: Бээжин (Төв Пекин), Ухань, Шанхай, Тяньжин, Кантон дахь инженер, технологийн төрөл бүрийн хүрээлэнгүүд.

1998 оноос хойш оюутан соилцоо 90%-ийн өсөлт үзүүлсэн нь Франц улс 2008 он хүртэл олон улсын солилцооны хувьд гуравдугаарт жагссан. Гадаад оюутнууд (ойролцоогоор 295,000) 2013 онд нийт оюутны 12%-ийг эзэлж байсан. Тэдний 75% нь их дээд сургуульд суралцдаг. Өнөөгийн байдлаар нэгдүгээр зэрэг буюу бакалаврын түвшинд элсэн суралцагчдын 11 хувийг гадаад оюутнууд, магистрын түвшинд 18 хувь, докторын түвшний 41.5 хувийг гадаад оюутнууд эзэлдэг байна. Докторын зэрэгт хамрагдаж буй хоёр хүн тутмын нэг нь олон улсын байдаг тул Франц улс докторын түвшний сургалт, судалгааны чиглэлээр өндөр түвшний сонирхол татахуйц болохоо харуулдаг, докторын сургуулиуд олон улсын ажилд авах, хамтарсан нийтлэл гаргах талаар тодорхой бодлогыг боловсруулан хэрэгжүүлдэг.

Боловсролын яамны мэдээлснээр, ЮНЕСКО-гийн тоо баримтад үндэслэн Франц улс гадагшаа явуулах үзүүлэлтээрээ дөрөвдүгээрт (гадаадад 55 000 орчим оюутан) ордог боловч хэрэв бид бүх төрлийн хөдөлгөөн, тэр дундаа дадлага, сургалтын төлбөрийг оруулбал бодит үзүүлэлт өндөр байна. Их дээд сургуулиудын нэгдсэн тоон мэдээлэл.

²¹⁸ European Parliament, Directorate-General for Internal Policies: Internationalization of Higher Education,

'Agence Erasmus+ France Education Formation'-д гадагшаа явах хөдөлгөөний тоог 130,000 орчим гэж тооцоолжээ.

Эрасмус+ хөтөлбөрийн эхний үр дүн нь Францад дээд боловсролын салбарт эерэг үр дүн үзүүлж, төсөв нь 14%-иар өссөн байна. Францын оюутнууд гадны улс оронд суралцах тоон үзүүлэлтээр ЕХ-ны хоёр дахь орон (ойролцоогоор 26 000 оюутан, Испаниас арай бага, Германаас илүү), харин ирж буй хөдөлгөөнөөр гуравдугаарт (Испани, Германы дараа) ордог. Франц бол дадлага хийх хөдөлгөөнд тэргүүлэгч орон юм; Энэ нь магистрын түвшний сургалтын хөтөлбөр, гадаадын компаниудад байр олоход дэмжлэг үзүүлж байгаатай нийцэж байгаа юм.

GERMAN УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Германы дээд боловсролд нөлөөлсөн үндэстэн дамнасан хамгийн чухал хоёр санаачилга бол 1999 онд эхэлсэн Болонийн үйл явц, 1988 оноос эхэлсэн Эрасмус оюутны хөдөлгөөнт хөтөлбөр юм. 1999 онд Герман улс Болонийн үйл явцыг үүсгэн байгуулагчийн хувьд Европын бусад 28 улстай (өнөөдрийн байдлаар 46) нэгдэн 2010 он гэхэд Европын дээд боловсролын тогтолцооны хооронд ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрдмийн зэрэг олгох, Европ хоорондын оюутан, ажилтнуудын шилжилт хөдөлгөөнийг хурдасгах, хүлээн зөвшөөрөх үйл явцыг оновчтой болгох зорилготой Европын дээд боловсролын бүсийг (ЕНЕА) байгуулсан. Германы хувьд Болонья бол 1810 онд Вильгельм фон Хумболдтын хэрэгжүүлсэн их сургуулийн номлолд сургалт, судалгааны ажлыг нэгтгэснээс хойшхи дээд боловсролын хамгийн чухал шинэчлэл гэж хэлж болно. Энэ үйл явц нь "Германы дээд боловсролыг бүрэн өөрчилж, оюутны суралцахад төвлөрсөн арга хэмжээ, үр дүнгийн ил тод байдал, хөдөлмөр эрхлэх боломж" руу шилжүүлж, одоо үргэлжилсээр байгаа холбооны /федерал/ бүтцийн хүрээнд ч илүү жигд болсон тогтолцоонд шилжүүлсэн. Болонья нь Англи-Америкийн бакалавр, магистр, доктор гэсэн гурван шатлалт бүтцийг хэрэгжүүлэх, чанарын баталгаажуулалтын шинэ механизм, сургалтын төлбөрийн схемийг нэвтрүүлэх зэрэг тодорхой арга замаар төдийгүй Европ, Германы дээд боловсролын бүтэц, засаглалыг эрс өөрчилсөн. Зарим оронд дээд боловсролын байгууллагуудын олон мянган удирдлага, боловсон хүчний бүтцэд томоохон өөрчлөлт хийж, дунд болон дээд боловсролд улс төр, санхүүгийн эх үүсвэрийг хэрхэн хуваарилах талаар шинэ сэтгэлгээний Болоньягийн шинэчлэлийг тунгаан бодох ур чадварыг хөгжүүлэхэд хэт их анхаарсан гэж үздэг.

ХБНГУ-ын үндэстэн дамнасан хоёр дахь санаачилга бол "Erasmus" хөтөлбөр гэгддэг. Их сургуулийн оюутнуудын солилцоо, гадаадад суралцахыг дэмжих Европын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагааны загвар бөгөөд 2014 онд Эрасмус+ хөтөлбөр болж шинэчлэгдсэн. Эрасмусыг зарим хүмүүс Европ дахь дээд боловсролыг олон улсын болгох бодит боломж бөгөөд гадаадад суралцах үнэ цэнийг дэмжих олон нийтийн дэмжлэгийг нэгтгэх "ололт амжилт" гэж дүгнэдэг. Татвар төлөгчдийн санхүүжилтээр хэрэгжиж байсан энэхүү хөтөлбөрийг 1987 онд Европын Комиссын хамтарсан судалгааны хөтөлбөр болгон эхлүүлсэн.

Германд Эрасмусыг "DAAD"²¹⁹ удирддаг, одоогоор 33 оролцогч улсаас (дээд боловсролын 3000 гаруй байгууллагыг төлөөлдөг) 2.5 сая гаруй оюутан, боловсролын 300,000 мэргэжилтэн хамрагдаж байгаа бөгөөд тус бүр нь Европын өөр улсад 3-12 сарын

²¹⁹ German Academic Exchange Service (DAAD)

хугацаатай байдаг. Зарим ажиглагч Эрасмусыг Европын амжилтын түүх, тэр байтугай "ЕХ-ны бодлогын хамгийн амжилттай бүрэлдэхүүн хэсэг" гэж тодорхойлсон байдаг.²²⁰

Германы олон улсын байдлыг тогтмол хянаж байдаг өндөр түвшний олон судалгааны тайлангийн дотроос "DAAD" болон Дээд боловсролын мэдээллийн систем (HIS) "Wissenschaft Weltoffen"-ийн жил бүр гаргадаг хамтарсан тайлан нь Германы дээд боловсролын гадаад хамтын ажиллагааны өсөлтийн талаар гол эх сурвалж болж өгдөг.

Өнөөдөр дэлхийн солилцоо болон гадаадад суралцаж буй 4.5 сая оюутны 45 хувийг Европ, 6 хувийг Герман эзэлж байгаа нь дэлхий даяар томоохон тав дахь "хүлээн авагч" орон болж байна.²²¹ Одоогийн байдлаар Германд суралцаж буй гадаад оюутнуудын дотор Хятад (12.5%), Орос (5.1%), Польш (3.7%), Австри (3.7%), Итали, Украин (хоёулаа 3.4%), Болгар (2.8%), Франц (2.5%), Испани (2.3%), бусад (52.8%) эзэлж байна. Олон улсын оюутнууд эдүгээ Германы дээд боловсрол эзэмшигчдийн 12.5%-ийг эзэлж байна. Герман улс жил бүр дээд боловсрол эзэмшиж буй оюутнуудынхаа 33 орчим хувийг гадаадад илгээдэг, 2014 онд шинэчлэгдсэн Эрасмус+ хөтөлбөрөөр энэ тоо нэмэгдсэн.

АВСТРИ УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА БА ҮНДЭСНИЙ БОДЛОГО

Австри Улсад боловсролын олон улсын хамтын ажиллагааны асуудлыг авч үзэхдээ дэлхийн судалгааны зах зээл, ялангуяа шинжлэх ухаан, технологийн салбар дахь Австрийн судалгааны ололт амжилтын өрсөлдөх чадварыг хөгжүүлэх гол зорилготой байсан. 1987 оны Австрийн Засгийн газрын хөтөлбөрт "олон улсын эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг хөгжүүлэх", "Европын судалгаа, технологийн нийгэмлэгт идэвхитэй оролцоотой байх"-ын ач холбогдлыг тодорхой тусгасан байв. 1990 онд олон улсын жишигт нийцүүлэн зэрэг олгох хөтөлбөрүүдийг шинэчлэх асуудлыг авч үзсэн. Ингэхдээ Европын нийтлэг зах зээлийн өрсөлдөөн сорилтод бэлтгэх шаардлагатай Австрийн хувийн хэвшлийн хэрэгцээ, хүлээлтийг харгалзан үзсэн байдаг. 1980-аад оны дунд үеэс дээд боловсролын бодлогын оролцогчид ОУХА-ны ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, дээд боловсролын хөтөлбөрт тусгажээ. Тус бодлогын хүрээнд бүс нутаг, улс орнуудтай хөгжүүлэх хамтын ажиллагааны бүсчлэл тус бүрт зорилтуудыг дэвшүүлсэн.

- Төв, зүүн Европ
- Америк, Канад, Латин Америк
- Хөгжиж буй орнууд

1993 оноос хойш Австри улс ERASMUS хөтөлбөрт хамрагдсаны шууд үр дагаврын нэг нь дунд боловсролын дараах, их дээд сургуулийн бус коллежид суралцах боломжийг өргөтгөсөн явдал байв. Австри улс ОУ-ын хамтын ажиллагааг дэмжих, оюутнууд, төгсөгчид, докторантууд, нэр хүндтэй эрдэмтдийн "гарах", "орж ирэх" хөдөлгөөнийг нэмэгдүүлэхийн тулд төрөл бүрийн арга хэрэгслийг боловсруулжээ. Он цагийн дарааллаар авч үзвэл, эхний чухал арга хэмжээ бол Европын улсуудтай хэлэлцээр хийж, хоёр талын гэрээг хэлэлцэн батласан. Уг гэрээ нь Австрийн их сургуулиуд гадаадын их дээд сургуулиудтай оюутан,

²²⁰ Altbach, P. & Teicher, U. (2001). "Internationalisation and exchanges in a globalized university". Journal of Studies in International Education, 5(5), хуудас 25.

²²¹ Project Atlas, 2013

багш солилцох хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байв. Мөн Австри улс бусад томоохон нэр дэвшигчидтэй соёлын солилцооны гэрээ байгуулаагүй орнуудыг "орлогсдод" зориулсан тусгай хөтөлбөр бий болсон: 1980-аад оны сүүлээр Австри улс Европын боловсролын хөдөлгөөн, судалгааны хөтөлбөрүүдэд оролцож эхэлснээр олон улсын хэмжээний гурав дахь давалгаа гарч ирэв. 1990-ээд оны эхэн үеэс Австрийн олон их дээд сургуулиуд хамтарсан сургалтын хөтөлбөрийн дагуу олон улсын сургалтын хөтөлбөр боловсруулахад оролцож байна. Хэд хэдэн их дээд сургуулиуд тодорхой сэдэв, асуудлын талбарт чиглэсэн олон улсын эрчимжүүлсэн зуны тусгай сургалтуудыг зохион байгуулжээ.

1991 онд Шинжлэх ухаан, судалгааны яаманд гадаад харилцааны тусгай алба байгуулагдсан, энэ нь зөвхөн их сургуулийн салбар төдийгүй эрдэм шинжилгээний салбар дахь олон улсын хамтын ажиллагааг дэмжих, зохицуулах зорилготой юм. Австрийн их дээд сургуулиудад гадаад оюутнуудад зөвлөгөө өгөх үүргийг хариуцдаг мэргэшсэн багш нар ажилладаг уламжлалтай.

1997 онд Их дээд сургуулийн шинэ хууль батлагдсанаар Австрийн их дээд сургуулиудад цаашид зэрэг олгох хөтөлбөрүүдийг зохион байгуулах арга хэлбэрт зарчмын өөрчлөлт орсон. Их сургуулийн байгууллагын баримт бичиг нь Австрийн их сургуулийн боловсролын хэлбэрийг өөрчилсөн; Их сургууль судлалын тухай хуулийг баталж, хэрэгжүүлснээр түүний агуулгыг өөрчилсөн.

Дүгнэлт

Азийн шилдэг 100 их, дээд сургуульд Монгол Улсаас эрэмбэлүүлэх, судалгааны их сургуулиудыг байгуулах зорилгуудыг дэвшүүлсэн. Гэвч өнгөрсөн хугацаанд энэ зорилгуудад хүрэх үүднээс бүтэц, зохион байгуулалтын шинэчлэлд түлхүү анхаарал хандуулж байгаа нь хэрэгжүүлж буй үйл ажиллагаанаас харж болох юм. Бодлогын түвшний ахиж гаргахын тулд судлаачдын зүгээс манай улс ИДС-иудын олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага байна гэдэг нь чанарын судалгаанаас харагдаж байна. Түүнчлэн уг асуудлаар үндэсний бодлого шаардлагатай байна гэсэн дүгнэлтэд судалгааны үр дүнд хүрсэн болно. Энэ нь хэд хэдэн шалтгаантай, нэгдүгээрт, хөгжиж буй улс орнуудын дийлэнх хувь нь өөрсдийн үндэсний боловсролын олон улсын хамтын ажиллагааны бодлого, стратегийн баримт бичгүүдийг баталж тэр хүрээнд үйл ажиллагааны хувьд эрчимжиж, үр дүнд хүрсэн байна. Хоёрдугаарт, Монгол улсын дээд боловсролын гадаад хамтын ажиллагааны хувьд их сургуулиуд бие даасан шинжтэй. Хамтын ажиллагааны суурь нь ИС хоорондын хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр, хувийн шугамаар холбогдсон хамтын ажиллагаа гэсэн нийтлэг жишиг байна.

Бид судалгааны ажлын хүрээнд Европын дөрвөн улсын интернационалчлалын үйл явцыг харьцуулсан юм. Үүний үр дүнд улс орнуудын дээд боловсролын гадаад хамтын ажиллагаа, ялангуяа бодлого нь дараах шинжүүдээр нийтлэг байна. Үүнд:

1. Бодлого хэрэгжүүлэх зорилгоо нэг мөр тодорхойлжээ. Тухайлбал судалсан гурван улсын хүрээнд Австри улс судалгааны чиглэлийг түлхүү дэмжих бодлого баримталсан бол Франц улс солилцооны хөтөлбөрийг үндэслэлээ болгожээ. Финланд улсын хувьд үндэсний боловсролын чанарыг дэлхийн түвшинд ойртуулах хүргэх, зах зээлийн өрсөлдөөнд давамгайлах зорилгыг тус тус дэвшүүлжээ. Иймд Монгол Улсын хувьд Үндэсний бодлогын баримт бичиг боловсруулах, ингэхдээ тодорхой салбарт чиглүүлэх нь үр дүнтэй байж болох юм.

2. Оролцогч талуудыг бодлого, үйл ажиллагааны хүрээнд тодорхой болгох, тэдгээрийн уялдаа холбоог хангахаас гадна бодлого хоорондын уялдаа холбоог хангадаг байна. Жишээ нь, гадаад иргэдийн суралцах тоотой төрийн холбогдох бусад бодлогуудтай уялдуулах хэрэгцээ байдаг нь тус сургуулиудын иуршлага, жишгээс харагдаж байна.
3. ИДС-иудын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд санхүүгийн хүндрэл, хэлний бэрхшээл зэрэг нь нийтлэг тулгамдаж буй асуудал юм. Иймд төрөөс санхүүгийн болон бодлогын тодорхой дэмжлэг үзүүлснээр уг салбар хөгжихөд түлхэц үзүүлдэг байна. Мөн дээр судалгаанд дурдсан улсууд дээд боловсролын гадаад хамтын ажиллагааны хүрээнд солилцооны хөтөлбөр, төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг учир бидний зүгээс идэвхи санаачлагатай ажиллах, хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлэх эрмэлзэл чармайлт чухал байна.

Ном зүй

1. Г.Хосбаяр, Г.Золзаяа, Г.Жаргалмаа, “Их Сургуулиудын олон улсын хамтын ажиллагаа, хөгжүүлэх боломж” илтгэл, 2022 он
2. Asma Mohsin, Khalid Zaman, “Internationalization of universities: emerging trends, challenges and opportunities”, *Journal of Economic info (JEI)*, No,1 (2014) 1-9
3. Bedenlier, Svenja; Zawacki-Richter, Olaf., "Internationalization of higher education and the impacts on academic faculty members". *Research in Comparative and International Education*, 2015
4. Gundsambuu.S, “Internationalization and English as a Medium of Instruction in Mongolian Higher Education” *IAFOR Journal of Education*, Volume 7 – Issue 1 – Summer 2019, page 73
5. European Parliament, “Internationalisation of Higher Education”, 2015
6. International Association of Universities, “Internationalization of Universities: 70 years of experience”, “The Promise of Higher Education”, Springer Nature, 2021
7. *Khorsandi Taskoh, Ali., "Internationalization in Canadian Higher Education Institutions: Ontario". Compare: Higher Education for the Future, 2020*
8. Robson, Sue., "Internationalization: a transformative agenda for higher education?". *Teachers and Teaching Vol 6*, 2011
9. Knight, J. (2004). Internationalization remodeled: Definition, approaches, and rationales. *Journal of Studies in International Education*, 8(1), 5–31.
10. Knight, J. (2015). International universities: Misunderstandings and emerging models? *Journal of Studies in International Education*, 19(2), 107–121.
11. Netherlands Association of Universities of Applied Sciences (Vereniging Hogescholen) and the Association of Universities in the Netherlands (VSNU). (2018). Internationalisation Agenda for Higher Education. <http://www.vsnu.nl/files/documents/Internationalisation%20Agenda%20for%20Higher%20Education.pdf>.
12. Sandström, A.-M., & Hudson, R. (2018). The EAIE Barometer: Internationalisation in Europe (2nd edition): The European Association for International Education (EAIE). <https://www.eaie.org/our-resources/barometer.html>.

13. Söderqvist, M. (2002). Internationalisation and its management at higher-education institutions. Applying conceptual, content and discourse analysis. Helsinki, Finland: Helsinki School of Economics.
14. Yemini, M. (2015). Internationalisation discourse hits the tipping point. *Perspectives: Policy and Practice in Higher Education*, 19(1), 19–22.

Цахим эх сурвалж:

1. https://msmhighered.com/blog_posts/5-reasons-why-internationalization-in-higher-education-is-important/
2. <https://must.edu.mn/mn/page/700>
3. <https://web.msue.edu.mn/Category/Read/e5fc4d54-4e8d-4e58-817e-a4fa22884c24>
4. https://warwick.ac.uk/fac/cross_fac/globalpeople2/he_institutions/profiling/
5. <https://www.insidehighered.com/blogs/world-view/national-policies-internationalization---do-they-work>

ЕВРОПЫН ХОЛБОО БА МОНГОЛ УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА: ХБНГУ-ЫН ЗӨӨЛӨН ХҮЧНИЙ БОДЛОГО БА МОНГОЛ УЛС

Б.Үүрцайх

Удирдлагын Академийн Төрийн захиргааны тэнхимийн багш, доктор

Хураангуй: Монгол улсын гуравдагч хөрш, түүхэн уламжлалын хувьд ойр ХБНГУ-ын зөөлөн хүчний бодлого, түүнд нөлөөлж буй гол шалгуур үзүүлэлтүүд болох улс төр дипломатын бодлого, эдийн засгийн тусламж, Хөгжлийн хамтын ажиллагааны бодлогын зарим асуудлыг судлав. Энэ илтгэлдээ ХБНГУ-ын хөгжлийн зөв бодлого, зөөлөн хүчний бодлогыг тодорхой хүрээнд судалж туршлага, сургамж авах, Монгол Германы хамтын ажиллагааны хүрээнд дүн шинжилгээ хийв.

Түлхүүр үг: Зөөлөн хүч, Монгол, Улс төр-дипломат, Соёл хүмүүнлэг, Хөгжлийн хамтын ажиллагаа, ХБНГУ.

Удиртгал

Гадаад бодлогын үйлдлийн нэг төрөл болох зөөлөн хүчний талаарх парадигмыг шинэ түвшинд хөгжүүлэгч судлаач доктор Ж.Най энэ чиглэлийн бүтээлүүддээ цэрэг батлан хамгаалах болон эдийн засгийн бодлого нь хатуу хүчний бодлого бол соёл хүмүүнлэг, улс төрийн үнэт зүйлс, төрийн гадаад бодлого нь зөөлөн хүчний бодлого юм гэж тайлбарласан байдаг. Мөн зөөлөн хүчний бодлого нь албадах, урамшуулах аргаар бус бусад улсуудын сэтгэлийг татах арга замаар хүсэж буй үр дүндээ хүрэхийн тулд бусдад нөлөөлөх чадварыг хэлнэ гэж тодорхойлсон байна. Өнөө үед голдуу өндөр хөгжилтэй орнууд зөөлөн хүчний бодлого болон ухаалаг хүчний бодлого гэсэн хосолсон нэр томъёог төрийн удирдлага, гадаад бодлогын баримт бичгүүддээ хэрэглээд эхэлжээ. Ухаалаг хүч нь зөөлөн хүчний бодлогод хамаарах ойлголт бөгөөд хатуу хүчний бодлоготой хосолж байж хэрэгждэг гэж Ж.Най тэмдэглэсэн байна. Тухайлбал, өндөр хөгжилтэй орнууд батлан хамгаалах, стратегийн асуудлаар унагасан нэр хүндээ ухаалаг хүчний бодлогын хүрээнд нөөцийн зөв ашиглалт, стратеги, интеграци, соёл хүмүүнлэг, эдийн засгийн харилцан туслалцаа хөтөлбөрүүд хэрэгжүүлснээр олж авах бөгөөд энэ чиглэлийн дотоодын нөөц бололцоог ашиглан хөгжүүлж байдаг. Ялангуяа өнөө үед хэвлэл мэдээллийн хэрэгсэл, улс хоорондын тусламжийн хөтөлбөрүүд, мэдээлэл харилцаа, холбооны технологи, цахим засаглалын элементүүд зэрэг олон нийтийн дипломат ажиллагааны хэрэгслүүд нь ухаалаг хүчний бодлогод голлох үүрэгтэй болоод байна. Мөн зөөлөн хүчний салшгүй гурван үндсэн багана бол соёл хүмүүнлэгийн бодлого, улс төрийн үнэт зүйл, гадаад бодлого буюу хамтын ажиллагаа гэж үзсэн (Най, 2004). Энэ гурван баганын хүрээнд дэлхийн улс орнуудын зөөлөн хүчний бодлогыг харьцуулан, үр дүн, үр нөлөөг нь гаргадаг бие даасан институтууд үйл ажиллагаа явуулж байгаа юм. ХБНГУ-ын хувьд зөөлөн хүчний бодлого нь олон улсын анхаарлын төвд байдаг, амжилттай хэрэгждэг цөөн орны нэг юм. Энэ бодлого нь цаашид хэрхэн өөрчлөгдөх талаар тайлбарлах нь цаг хугацааны хувьд учир дутагдалтай тул соёл хүмүүнлэгийн болон эдийн засгийн тусламж, хөгжлийн тусламжийн бодлогын хүрээнд судлах нь зүйтэй гэж үзэн илтгэлийн хүрээгээ тодорхойлов. Эдийн засгийн асуудал хэдийгээр хатуу хүч мэт боловч зарим шинжээрээ ухаалаг хүчний болон зөөлөн хүчний категорид хамаарагддаг бөгөөд үүнийг хүчний шилжилт гэж Ж.Най тайлбарласан байдаг. Тухайлбал, эдийн засгийн хоригууд, эдийн засгийн авлигын асуудлууд хатуу хүчний бодлого бол эдийн засгийн дэмжлэг туслалцаа, хамтын ажиллагааны асуудлууд нь зөөлөн хүчний бодлого юм. Иймд ХБНГУ-ын төрийн удирдлагын хөгжил, хандлага нь илүү ухаалаг хүчний бодлоготой уялдаж байгаа тул хөгжиж буй орнуудад санаа авах сургамжтай кэйс

судлалын түвшинд нарийвчлан судлах боломжтой гэж үзэж байна. Өнөө үед ХБНГУ-ын төрийн удирдлагын хөгжил, хандлага нь харьцангуй тогтвортой байгаа юм. Эдгээр нь боловсрол, эрүүл мэнд, эдийн засаг, үйлдвэрлэлийн зөв бодлогуудын үр дүн, үр нөлөөгөөр илэрч байна гэж үзэж болно. Иймд ХБНГУ-ын ухаалаг хүчний бодлого, соёл хүмүүнлэгийн болон эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд гаргасан амжилт ба Монгол Улс, ХБНГУ-ын хамтын ажиллагааны зарим асуудлыг судалж үзэв.

Монгол – Германы улс төр - дипломатын бодлого

Монгол Улсын хувьд Европын Холбоотой 1989 оны 8 дугаар сарын 01-ний өдөр дипломат харилцаа анх тогтоосон билээ. Ингээд төд удалгүй 1991 оноос хойш Монгол Улсын Их Хурал, Европын Парламент хоорондын харилцаа өргөжин 1992 оноос Европын Холбооны дэргэд Брюссель хотноо ЭСЯ-аа нээн ажиллуулж байна. Европын Холбооны Төлөөлөгчийн газар манай улсыг Бээжингээс хавсран ажиллаж байгаад 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс Улаанбаатарт Төлөөлөгчийн газраа нээжээ. Хэдийгээр Европын холбоотой 1990-ээд оноос харилцаа тогтоож эхэлсэн ч Монгол улсын Европ дахь гол түншүүдийн нэг Германтай 1974.01.31-нд дипломат харилцаа тогтоожээ. Үүнээс хойш хоёр Герман Улс нэгдсэний дараа 1990 оны сүүлээр ЭСЯ-аа харилцан нээсэн байна. Үүнээс өмнө Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсын ЭСЯ Улаанбаатарт ажиллаж байв. Одоогийн Элчин сайд нар нь Монгол Улсаас ХБНГУ-д суух Элчин сайд Б.Мандахбилэг 2021.12.06-нд ИЖБ-ээ барьсан бол ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Хельмут Рудольф Кулитц 2023.08.28-нд ИЖБ-ээ барьжээ.

Монгол Улс, ХБНГУ-ын хамтын ажиллагаа, гадаад харилцааны эрх зүйн гол баримт бичгүүдийн түрүүч нь 1995 онд Монгол Улс, ХБНГУ хоорондын Харилцааны үндсийн тухай Хамтарсан тунхаглалд гарын үсэг зурж харилцааны үндсэн зарчим, хамтын ажиллагааны чиглэлүүдийг тогтоожээ. Энэ хүрээнд 2008 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр Улаанбаатар хотноо Монгол Улс, ХБНГУ хоорондын Иж бүрэн түншлэлийн харилцааны тухай Хамтарсан тунхаглалд гарын үсэг зурсан. Мөн ашигт малтмал, аж үйлдвэр болон технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2011 оны 10 дугаар сард ХБНГУ-ын Канцлер А.Меркелийн Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр байгуулсан байна.

Хоёр орны хувьд иж бүрэн түншлэлийн харилцааг 2008 онд байгуулж 6 голлох салбарт төвлөрнө гэж заажээ. Эдгээр нь:

1. Улс төрийн харилцаа,
2. Батлан хамгаалах харилцаа
3. Эдийн засгийн харилцаа
4. Хөгжлийн бодлогын хамтын ажиллагаа
5. Боловсрол, соёлын салбарын хамтын ажиллагаа
6. Хүмүүнлэг олон нийтийн салбарын хамтын ажиллагаа зэрэг болно.

Дээрх 6 салбарт уламжлалт, найрсаг харилцаатай хоёр орны хувьд ямар нэгэн зөрчилтэй аливаа нэг асуудал өнөөг хүртэл үүсээгүй юм. Түүнчлэн Техникийн хамтын ажиллагааны тухай ЗГ хоорондын хэлэлцээр, Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай зэрэг 2 талт олон тооны гэрээ хэлэлцээртэй билээ. Зөөлөн хүчний бодлогын улс төр-дипломатын хамтын ажиллагааны гол ноён нуруу нь талуудын төрийн тэргүүний харилцан юм. Эдгээр айлчлалууд нь бусад улсуудтай харьцуулахад илүү идэвхтэй хэрэгжиж ирсэн байна. Тухайлбал,

Монголын талаас:

1. Ерөнхийлөгч: 1995, 2000, 2012, 2015 (ажлын)
2. УИХ-ын дарга: 1993, 2007, 2015
3. Ерөнхий сайд: 1992, 2002, 2005, 2009
4. Гадаад хэргийн сайд: 1991, 1997, 1999, 2003, 2010, 2012

Германы талаас:

1. Холбооны Ерөнхийлөгч: 1998, 2008, 2015
2. Бундестагийн Ерөнхийлөгч: 2006
3. Холбооны Канцлер: 2011, 2016 /АСЕМ/
4. Холбооны Гадаад хэргийн сайд: 1996, 2014

Улс төр-дипломатын энэхүү найрсаг харилцааны зэрэгцээ Ханнс Зайделийн сан, Фридрих-Эбертийн-Сан, Конрад-Аденауэр-Сан зэрэг олон нийгмийн шинжлэх ухааны сургалт, судалгааг дэмжиж ажилладаг нийгэм, улс төрийн хувийн сангууд Монгол Улсад болон дэлхийн олон оронд үйл ажиллагаагаа явуулж байгаа юм. Эдгээр сангууд Монгол Улсад Ардчилсан шилжилт хийсэн 1990-ээд оноос хойш байгуулагдаж 30 жилийнхээ арга хэмжээг зохион байгуулсаар байгааг бид бэлхнээ мэдэх билээ. Эдгээр улс төрийн сангууд манай улс төрийн намууд болон төр, засгийн байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, ардчилсан төр, засаг, шүүхийн тогтолцоог бэхжүүлэх, улс төр, хууль зүй, боловсрол, хэвлэл мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгоход зөвлөгөө өгөх, сургалт явуулах, тэтгэлэг олгох чиглэлээр ажиллаж байна. Эдгээрээс Хайнрих Бөллийн сан /Ногоон нам/ бурхны шашны уламжлалт соёл, өв уламжлалыг сэргээх чиглэлээр 1997 оноос төсөл хэрэгжүүлж эхэлсэн юм.

Монгол Германы эдийн засгийн хамтын ажиллагаа

ХБНГУ нь Монгол Улсын хувьд хөгжлийн бодлого хамтын ажиллагааны хүрээнд илүү найрсаг бодлого хэрэгжүүлдэг найрсаг харилцаатай орнуудын нэг билээ. Энэ бодлогын хүрээнд 1992 оноос хойш манай улсад 500 сая орчим еврогийн буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. Гэвч Монгол Улсын эдийн засгийн үзүүлэлт харьцангуй сайжирч, хүн амын орлого нэмэгдсэн гэсэн үндэслэлээр германы тал 2020 оны 5 дугаар сард хөгжлийн албан ёсны дэмжлэг, туслалцаагаа зогсоож буйгаа мэдэгдэж байв. Гэсэн хэдий ч 2021 оны Бундестагийн сонгуулиар байгуулагдсан эвслийн Засгийн газар Монгол Улсыг хөгжлийн албан ёсны дэмжлэг туслалцаа авах улсуудын жагсаалтад дахин оруулснаа 2022 оны 6 дугаар сард манай талд мэдэгдсэн билээ.

Зөөлөн хүчний бодлогын хамтын ажиллагааг өргөжүүлэх өөр нэгэн салбар бол аялал жуулчлал билээ. Цар тахлаас өмнө буюу 2019 он хүртэл жилд дунджаар 10-12 мянган Германы иргэн манай улсад жуулчилдаг байв. 2015 онд Монгол Улс Берлин хотноо зохион байгуулдаг олон улсын ИТВ үзэсгэлэнгийн түнш орноор өргөн хүрээтэй оролцож байсан юм. Энэ онд ч Монгол Улсын сонирхол Штуттгарт хотноо аялал жуулчлалын СМТ үзэсгэлэнгийн түнш орноор оролцохоор ажиллаж байна. Хоёр орны зүгээс мөн Берлин хотод 2021 онд албан ёсоор нээгдэн ажиллаж буй “Европ дахь Монголын мэдээлэл, худалдааны төв”-д аялал жуулчлал, гадаад сурталчилгааны арга хэмжээг дэмжиж ажиллаж байгаа юм.

Хоёр орны эдийн засгийн гол харилцааны нэг гадаад худалдааны эргэлт нь сүүлийн 5 жилийн байдлаар өсөлттэй дүнг үзүүлж байсан бол 2022 оны сүүл үеэс буурах болжээ. Иймд энэ асуудалд талууд сайтар анхаарч ажиллах хэрэгтэй юм (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Худалдааны эргэлт сая ам.доллороор

Он	018	2019	2020	2021	2022
					Эхний 7 сарын байдлаар
Нийт	181.0	202.4	196.4	235.4	97.6
Экспорт	12.3	13.5	11.6	12.2	9.6
Импорт	168.7	188.9	184.8	223.2	89,0

Эх сурвалж: Гадаад харилцааны яам.

Монгол – Германы соёл хүмүүнлэгийн бодлого

Түүхэн цаг хугацааны хүрээнд Монгол Германы идэвхтэй соёл хүмүүнлэгийн харилцаа нь Монгол Улс 1911 онд тусгаар тогтнолоо зарласны дараа Оросын нийслэл Санкт-Петербург дахь төлөөлөгчдөөрөө дамжуулан Германтай харилцаа тогтоох оролдлого хийж байсан боловч амжилтад хүрээгүй байдаг. Ингээд 1921 оны Монголын хувьсгалын дараа Монгол Ардын Нам Герман улстай эдийн засгийн харилцаа тогтоохыг зорьж улмаар 1927 онд Монголын орчин үеийн утга зохиолыг үндэслэгч Дашдоржийн Нацагдорж тэргүүтэй 50 гаруй монгол оюутан сурагчдын анхны ээлжийг Герман, Франц руу илгээж байсан юм. Харамсалтай нь Монгол Улс 1930-аад оноос Сталины бодлогоор чиг баримжаа авах болж, 1929 оны 6 дугаар сарын 27-ны БНМАУ, ЗСБНХАУ-ын хооронд нууц гэрээ байгуулагдсанаар барууны аж үйлдвэржсэн орнуудаас бүрэн тусгаарлагдсан байна (Беманн, хууд. 72). Түүгээр ч үл барам 1929, 1930 онуудад тухайн үеийн Герман, Францад сурч байсан оюутнууд, сурагч, насанд хүрэгчдийг бүрэн татаж, Монгол дахь Герман мэргэжилтнүүдийг ч мөн нутаг буцаажээ.

Харин өнөө үед улс орнуудын төрийн бодлогод боловсролын салбартаа хөрөнгө оруулж олон улсын оюутнуудыг татаж чадах зөв бодлогыг хэрэгжүүлж буй нь зөөлөн хүч, ухаалаг хүчний бодлогын гол үндэс болж байгаа юм. ХБНГУ-ын зөөлөн хүч, ухаалаг хүчний бодлогыг соёл хүмүүнлэгийн салбартаа хэрэгжүүлж буй арга хэмжээ нь ХБНГУ-ын талаарх мэдээллийг түгээх, герман хэлийг дэлгэрүүлэх, улс орныхоо талаарх судлалыг дэмжих, гадаад оюутныг суралцуулах хөтөлбөрөө идэвхжүүлэх, Германд элэгтэй хүний тоог нэмэгдүүлж аялал жуулчлалаа дэмжих зэрэг юм. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэгч гол олон улсын хамтын ажиллагааны байгууллага нь ХБНГУ-ын Засгийн газар, олон нийтийн байгууллагууд юм. Эдгээрийн нэг бол Goethe Институт билээ. Уг институт нь Герман улс болон Европ, дэлхийн улс орнуудын харилцан ойлголцоход хувь нэмрээ оруулж байгаа байгууллагуудын нэг юм. Уг институтын үйл ажиллагааны үндэс нь Холбооны Гадаад хэргийн яамтай байгуулсан суурь гэрээ бөгөөд яамны зүгээс дэмжин ажилладаг юм. Герман болон Европын соёл, нийгмийн олон талт байдлыг дэлхий даяар түгээх зорилгынхоо хүрээнд дэлхийн 98 оронд байрлах 158 Гёте-Институт өөрсдийн түнш байгууллагын хамт дэлхийг хамарсан сүлжээг бий болгожээ. Тэд бие даасан, аль нэг улс төрийн болон намын бодлогоос ангид ажилладаг байна. Уг институтээр дамжин дэлхийн өнцөг булан бүрт Герман хэлний сургалтыг дэмжиж ажиллахын сацуу, Германы түүх, уран зохиолыг дэмждэг байна.

Соёлын харилцааны хүрээнд Берлин хотын Хумболдтын Их сургууль, Бонн хотын Их сургуулийн дэргэд Монгол судлалын тэнхим тус тус ажилладаг билээ. Эдгээр Монгол судлалын тэнхимүүдээс эрдэм шинжилгээний судалгааг дэмжиж ажиллаж буйн нэг илрэл нь хоёр орны Ерөнхийлөгч нарын ивээл дор эртний нийслэл Хархорум хот, Орхоны хөндийн археологийн малтлагын төсөл 2000 оноос хойш хэрэгжиж байна. 2021 онд тус хамтын

ажиллагааны дүнгээр “Хархорин” ном монгол, герман, англи хэлээр гаргаж археологийн хамтарсан малтлага, судалгааны үр дүнг олон нийтэд харуулах үзэсгэлэнг 2025-2026 онд ХБНГУ-д гаргахаар ажиллаж байгаа юм.

Боловсролын салбарын хүрээнд 2021 оны байдлаар 780 монгол оюутан Германд суралцаж байна. Оюутнууд ихэвчлэн өөрийн зардлаар суралцдаг ба хувийн сангийн шугамаар оюутан өөрөө хөөцөлдөж тэтгэлгээр суралцах сонирхол цөөнгүй бөгөөд Засгийн газрын тэтгэлгээр сургах хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах шаардлага байгааг Монголын тал анхаарч ажиллах хэрэгтэй байна. Харин Монгол Улсад Хоёр улсын Засгийн газрын санаачилгаар Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургууль (GMIT) 2013 оноос үйл ажиллагаа явуулж байна. Тус сургуулийн чадавхыг бэхжүүлэх хүрээнд 2016-2019 онд 4.2 сая евро, 2019-2022 онд 3.5 сая еврогийн буцалтгүй тусламжийн төсөл, 2020-2024 онд 7 сая еврогийн зээлийн төсөл хэрэгжүүлж байна.

Эдгээр соёлын албан харилцаанаас гадна иргэд, олон нийт, төрийн бус байгууллагуудын харилцаа илүү өргөжиж байгаа улс бол ХБНГУ юм. Тухайлбал, “Монгол-Германы Форум”, “Монгол, Германы Гүүр ТББ”, “Герман-Монголын бизнес эрхлэгчдийн холбоо” зэрэг байгууллага хоёр орны харилцааг хөгжүүлэхэд чиглэсэн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. ХБНГУ-д ч монгол иргэдийн үүсгэл санаачилгын байгууллагууд олноор бий. ЭСЯ-ны санаачилгаар ХБНГУ дахь Монгол, монгол-германы ТББ-уудын Зөвлөл 2014 онд байгуулагдаж идэвхтэй ажиллаж байгаа юм. Мөн Орон нутгийн түншлэлийн хамтын ажиллагааны амжилттай жишээг дурдвал, Улаанбаатар хотын Баянгол дүүрэг ба Бранденбург мужийн Шөнефелд дүүрэг, Барут/Марк хот ба Хөвсгөл аймгийн Мөрөн хот, Өвөрхангай аймаг ба Хессен мужийн Майн Таунус дүүрэг зэрэг болно. Түүнчлэн Төв аймгийн Зуунмод хот ба Нойштадт Доссе хот, Хэнтий аймаг ба Баден-Вюртемберг мужийн Кальв дүүрэг түншлэл тогтоохоор яриа хэлэлцээний түвшиндээ байна.

Дүгнэлт

Зөөлөн хүчний бодлогын хэрэгжилтийн урсгал нь гол төлөв өндөр хөгжилтэй орноос хөгжиж буй орнууд чиглэж байна. Уг бодлогын хэрэгжилт нь улс төр, дипломат харилцааны, эдийн засаг-хамтын ажиллагааны болон соёл хүмүүнлэгийн хүрээнд явагдаж байгаа юм. Эдгээр хүрээнд ХБНГУ-ын зөөлөн хүчний нөлөө Монгол Улсад хэрхэн нөлөөлөх, цаашид хамтын ажиллагааны асуудлууддаа хэрхэн анхаарах талаар дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

- Хоёр орны найрсаг харилцаа 1920-иод оноос идэвхтэй эхэлсэн боловч 1930-аад оноос идэвхгүй, дайсагнагч орнуудын хэлбэрт шилжсэн байна. Харин өнөө үед улс төр-дипломатын харилцаа нь “иж бүрэн түншлэлийн” харилцааны түвшинд шилжиж, амжилттай хэрэгжиж байгаа юм.
- ХБНГУ-тай хийж буй гадаад худалдааны дүн сүүлийн нэг жилийн хугацаанд буурч байгаа нь энэ тал дээр талууд хамтын ажиллагаагаа өргөжүүлэх шаардлагатай юм.
- ХБНГУ-ын тэтгэлэгт хөтөлбөр, хувийн сангуудын дэмжлэгийг амжилттай хүлээн авснаар Монгол Улс хөгжлийн гол нөөц болох хүний нөөцөө чадавхжуулаад авах нь ач холбогдолтой юм. Гэхдээ үүнийг тодорхой зорилготойгоор уул уурхай, археологи-түүх, аялал жуулчлал, хөдөө аж ахуй зэрэг хамтын ажиллагааны гол салбарууддаа хэрэгжүүлэхээр төлөвлөх шаардлагатай байна.
- Цаашид зөвхөн хоёр орны парламент, засгийн газрын түвшинд гэхээсээ илүү орон нутгийн байгууллагууд хоорондын хамтын ажиллагаагаа сайжруулах шаардлагатай юм.

Ном зүй

1. Удо Б.Баркманн. Монгол Германы харилцаа, өнөөгийн байдал хэтийн төлөв, 2013 он.
2. Конрад Аденауэр сан. Иж Бүрэн Түншлэлийн төлөө. 2003 он.
3. Гадаад харилцааны яам. <https://mfa.gov.mn/>
4. Улсын Их Хурлын Тамгын Газрын мэдээлэл <https://www.parliament.mn>
5. Үүрцайх, Б. (2018). “Япон Улсын Зөөлөн хүчний бодлого ба Монгол Улс, Япон Улсын эдийн засгийн хамтын ажиллагаа” Төрийн Удирдлага сэтгүүл. Улаанбаатар. Удирдлагын Академи, 2018 он. Хуудас 52-66.
6. Гомбосүрэн, Ц. (2014). Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын 20 жил. Улаанбаатар. Конрад Аденауэр сангийн Улаанбаатар дахь суурин төлөөлөгчийн газар. Хуудас 25-33.
7. Үүрцайх, Б. (2016). Монгол улсын эдийн засгийн гадаад харилцаа: Гадаадын шууд хөрөнгө оруулалт ба Эдийн засгийн эрх чөлөө. Олон улсын харилцааны байдал, төлөв ба Монгол Улс. Илтгэлийн эмхэтгэл. Улаанбаатар. МУИС-ийн ОУХНУС. Хуудас 44-51.
8. Joseph S. Nye, Jr. (2004). Soft Power: The Means to Success in World Politics. New York: Public Affairs.
9. Vietor, R. (2006). How Countries Compete. Boston. Harvard University Press.

ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС БОЛОН МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЛИЙН САЙТЫН НИЙТЛЭЛИЙГ ХАРЬЦУУЛАХ НЬ

Г.Жаргалсайхан

ОТИС-ийн багш, доктор (Ph.D.), дэд профессор

Б.Атарцэцэг

ОТИС Сэтгүүл зүйн магистрант,

IA Medi Mongolia ХХК эмч, төлөөлөгч

Түлхүүр үг: Эрүүл мэндийн сэтгүүл зүй, эрүүл мэндийн зөвлөгөө, эм бэлдмэлийн хэрэглээ, сурталчилгаа

Оршил

Олон улсад Сэтгүүл зүйн салбар улам нарийсаж, төрөлжиж, мэргэжин хөгжсөөр байна. Тэр хэрээр нарийвчилсан судалгааг ч мөн шаардаж байна. Манай улсад эрүүл мэндийн мэдээллээр дагнасан сайтууд ховор, Оточ.мн, Эмч.мн гэх мэт цөөн сайт идэвх сулхан ажиллаж, бусад сайтууд нь эрүүл мэндийн талаарх улсын бодлого шийдвэрүүдийг мэдээлэх төдийхөн үйл ажиллагаа явуулдаг байна. Мөн эрүүл мэндийн талаарх мэдээллийг эмнэлгүүд өөрсдийн цахим хуудсандаа, эмч эмнэлгийн ажилчид өөрсдийн фэйж хуудсаараа дамжуулан мэдээллийг оруулдаг байдалтай. Дээрх цахим орчны мэдээллүүд нь шинжлэх ухаанд суурилсан бус, баттай эх сурвалж нь тодорхойгүй байдаг ч иргэд үүгээр дамжуулан оношилгоо эмчилгээний талаарх мэдээллийг авч өөртөө болон үр хүүхдэдээ туршин үзэж эрүүл мэндээрээ хохирох нь ч байна. Иймээс өндөр хөгжилтэй Европын Холбооны улс ХБНГУ-ын сайтыг нийтлэлийг судалж, сайн туршлагыг нэвтрүүлэх хэрэгцээ байна гэж үзлээ. Энэ үүднээс Монгол улсад эрүүл мэндийн чиглэлээр дагнасан хамгийн идэвхтэй ажиллагаатай, олон мэдээлэл оруулдаг Otoch.mn /39K Likes, 56K Followers/-ыг сонгон, ХБНГУ-ын хамгийн цөөн дагагчтай, ойролцоо тооны мэдээлэл оруулдаг, мэдээллийн хандалт ойролцоо Zentrum der Gesundheit /249K Likes, 254K Followers/ сайтыг мэдээллийн сэдэв агуулгатай харьцуулсан ажиглалтыг хийхээр зориллоо.

Судалгааг 2023 оны 04 сарын 1 өдрөөс 2023 оны 10 сарын 01 хүртэлх сүүлийн 6 сарын хугацааны Otoch.mn сайтыг 62, Zentrum der Gesundheit сайтыг 99 нийтлэл-мэдээллийн хүрээнд харьцуулалт хийж нэгтгэн дүгнэж үзсэн болно.

Бид эл өгүүллээ:

1. Эрүүл мэндийн сэтгүүл зүйн тухай товч
2. Otoch.mn, Zentrum der Gesundheit сайтыг нийтлэлийн сэдэв агуулгын харьцуулсан судалгаа гэсэн хоёр хэсгээр авч үзье.

Нэг. Эрүүл мэндийн сэтгүүл зүйн тухай товч:

Эрүүл мэндийн сэтгүүл зүй буюу Анагаах ухааны сэтгүүл зүй бол анагаах ухааны мэдээ, онцлог шинж чанаруудын тухай мэдээ мэдээлэх юм. Англи хэлээр Medical journalism эсвэл Health journalism гэж нэрлэж ирсэн бол монгол хэлнээ Эрүүл мэндийн сэтгүүл зүй нэршлээр хэрэглэдэг. Энэ нь нийтийн эрүүл мэндийг дэмжих чиглэлд онцгой үүрэгтэй оролцдог сэтгүүл зүйн мэргэжлийн нэг салбар төрөл юм²²². Эрүүл мэндийн сэтгүүл зүй нь ерөнхийдөө олон нийтэд, иргэдэд хандсан анагаах ухаан, эрүүл мэндийн нийтлэл мэдээг эрүүл мэндийн чиглэлийн тусгай хэвлэлд юм уу, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тусгай булан нүүр, хөтөлбөрт нийтэлж нэвтрүүлнэ. Олон улсад сэтгүүл зүй нь эрүүл мэндийн, эдийн засгийн, улс төрийн, хүмүүнлэгийн, экологийн гэх зэргээр төрөлжин хөгжсөөр буй билээ.

Манай улсын хүн амын ердөө 3.9-хөн хувь нь эрүүл, зөв зан үйл, идэвхтэй амьдралын хэв маягтай. Харин үлдсэн нь амьдралын буруу дадал, хэвшил, урьдчилан сэргийлэлт хангалтгүйгээс өнөөдрийн олон өвчлөл, эндэгдэл үүсэхэд голлон нөлөөлж буй²²³ гэсэн судалгаа бий. Тиймээс иргэдийн эрүүл мэндийн мэдлэг, боловсролыг нэмэгдүүлэхэд шинжлэх ухаанд суурилсан, баттай эх сурвалжийн мэдээ, мэдээллийг баримт болгон нийтэд түгээх нь эрүүл мэндийн сэтгүүл зүйн үүрэг юм.

Анагаах ухааны сэтгүүл зүй гэдэг нь анагаах ухаанд гарсан хөгжлийн талаар мэдээлэхийг хэлдэг. Үүнд шинэ эм, ерөнхий эрүүл мэнд, тахал өвчний тухай мэдээлэл багтаж болно.

Анагаах ухааны сэтгүүл зүй нь эмнэлгийн мэдээ, онцлогийг мэдээлэх /хэрэглэгчийн үнэлгээний нийтлэлээс ялгаатай/ юм. Эмнэлгийн сэтгүүл зүй олон талт бөгөөд үзэгчдийг тусгадаг. Үндсэн хэсэг нь олон нийтэд зориулсан эмнэлгийн сэтгүүл зүй бөгөөд үүнд ерөнхий мэдээний хэвлэлүүд болон төрөлжсөн эмнэлгийн хэвлэлүүд дэх эмнэлгийн мэдээ, эмч болон бусад мэргэжилтнүүдэд зориулсан эмнэлгийн сэтгүүл зүй багтдаг бөгөөд энэ нь үе тэнгийнхний үнэлгээтэй сэтгүүлд ихэвчлэн гардаг. Анагаах ухааны сэтгүүл зүйн үнэн зөв байдал нь маш олон янз. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гарсан нийтлэлүүдийн тойм нь ихэнх мэдээллүүдийг хангалтгүй гэж үнэлдэг боловч шилдэг жишээнүүд байдаг. Бусад тоймууд нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хэвлэгдсэн нийтлэлүүдийн ихэнх алдаа нь сэтгүүлийн анхны нийтлэл эсвэл тэдгээрийн хэвлэлийн мэдээн дэх алдаануудыг давтсанаас үүдэлтэй болохыг тогтоожээ.

Эмнэлгийн сэтгүүл зүй нь янз бүрийн эх сурвалжаас гаралтай байж болно. Үүнд:

- Телевизийн мэдээллийн хөтөлбөрүүд
- Сонин сэтгүүл
- Интернет сайтууд

²²² https://mn.wikipedia.org/wiki/%D0%AD%D1%80%D2%AF%D2%AF%D0%BB_%D0%BC%D1%8D%D0%BD%D0%B4%D0%B8%D0%B9%D0%BD_%D1%81%D1%8D%D1%82%D0%B3%D2%AF%D2%AF%D0%BB_%D0%B7%D2%AF%D0%B9

²²³ <https://www.facebook.com/whitepenassociation/posts/pfbid02Pmv3hU8kPfkRgqVE7v2J9PEFDcgGGh ofNdU4LfbNqyf8BtoRPzZ8yN5EV54t2KM4I>

- Шинжлэх ухааны сэтгүүлүүд /эрүүл мэнд, анагаах ухаантай холбоотой мэдээ гаргадаг/²²⁴ бол Монгол Улсад Эрүүл мэндийн сэтгүүл зүйн мэдээ нийтлэл хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хэд хэдэн янзаар гарч байна. Үүнд:
- Мэдээллийн вэб сайтад “ Эрүүл мэнд” булан,
- Телевизэд гол төлөв тусгай хөтөлбөрөөр /Ёо ёог анагаах нь, Цахим эмч, Дугархүү эмч зөвлөж байна...../ гэх мэт. Нарийвчилбал,

ТВ-ийн эрүүл мэндийн нэвтрүүлгүүд:

1. Edutainment TV “Good Mood” Эрүүл амьдралын боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр Хөтлөгч Л.Баатарцогт
2. NTV “TV доктор” Эрүүл мэндийн нэвтрүүлэг Хөтлөгч хүний их эмч Г.Ууганцэцэг
3. TV5 “Эрүүл амьдарцгаая” Эрүүл мэндийн нэвтрүүлэг хөтлөгч Б.Уянга
4. Like HD TV “Телемедицин” Эрүүл мэндийн нэвтрүүлэг
5. Mongolian National Broadcaster “120/80” Эрүүл мэндийн нэвтрүүлэг хөтлөгч Ч.Манлайбаатар

Эрүүл мэндийн сонин сэтгүүлүүд: Одоогоор эрүүл мэндээр дагнасан сонин сэтгүүл хэвлэгдээгүй байна.

Монголын эрүүл мэндийн сэтгүүлчдийн “Цагаан үзэг” холбоо тэргүүн сэтгүүлч Д.Ариунцэцэг

“Цагаан үзэг” холбооны харьяа Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг олгох “Вакцин” клубтэй. Эрүүл мэндийн сэтгүүлч, докторант Б. Ундрах нар ажиллаж байна.

Энэ мэтээр Эрүүл мэндийн сэтгүүл зүй хөгжиж буй боловч анхаарах, мэргэших шаардлага байсаар байна.

Хоёр. Otoch.mn, Zentrum der Gesundheit сайтын нийтлэлийн сэдэв агуулгын харьцуулсан судалгаа

Одоо дурдсан хоёр сайтын сонгон авсан хугацааны нийт мэдээллийг сэдэв агуулгаар нь ангилан, харьцуулж харъя.

²²⁴

<https://homework.study.com/explanation/what-is-medical-journalism.html?fbclid=IwAR1bO2kYHVlHyIAG6PhgSmEGeVWgl5DsRuj2xJIBNUZPRVd1JtUFkptrlpk>

Хүснэгт 1. Otoch.mn, Zentrum der Gesundheit.mn сайтын нийтлэлийг сэдэв агуулгын харьцуулалт

1. Сайтын нэр	
Otoch.mn	Zentrum der Gesundheit.mn
2. Хамрах хугацаа	
2023.04.04- 2023.10.04	2023.04.03-2023.10.03
3. Нийт мэдээний тоо	
62	99
4. Эрүүл мэндийн ерөнхий мэдээлэл	
<p>1. Анги танхимын будагч бодис хүүхэд хорт хавдраар өвчлөхөд нөлөөлж байна</p> <p>2. Дэлгэцтэй цагийг их өнгөрүүлдэг хүүхдийн тархинд юу болдог вэ?</p> <p>3. Хаалгаа түгжсэн билүү яалаа гэж бодох нь "Мэдрэлийн ядаргаа"-нд өртсөний нэг шинж тэмдэг.</p> <p>4. Эрт илрүүлгээр сүрьеэгийн халдварын 214 тохиолдол илрүүлжээ.</p> <p>5. Орост Улаанбурхан эрчимтэй тархаж байна</p> <p>6. Монголд анх удаа дээд мөчний ясны том хэмжээтэй хавдрын хиймэл үе суулгах мэс заслыг амжилттай хийлээ</p> <p>7. Унтаад боссон ч амарсан мэдрэмж авахгүй, тархи ажиллаж, байнга зүүдлэх нь нойргүйдлийн шинж.</p> <p>8. КОВИД-ын шинэ хувилбараар халдварласан хүүхдүүдэд өвөрмөц шинж тэмдэг илэрч байна.</p> <p>9. Эрт илрүүлгийн хугацаа дуусаагүй, цаашид үргэлжилнэ</p> <p>10. НҮБ: Веган дэглэм шим тэжээлийг нөхөж чаддаггүйг анхааруулав.</p> <p>11. Хавдар оношлоход хиймэл оюун ухааныг ашиглах туршилт амжилттай болжээ</p> <p>12. Агаарын бохирдол нэмэгдэхэд зүрхний хэм алдагдаж эхэлдэг</p> <p>13. Ургамлын харшил нь жил бүрийн 4-9 сард үргэлжилдэг</p> <p>14. Амралтын өдрөөр их унтаж нойроо нөхнө гэх бодол хамгийн том өрөөсгөл ойлголт</p>	<p>1. Короно вирусын вакцин чонон хөрвөс үүсгэх үү</p> <p>2. Хэт авиа бие махбодид гэмтэл учруулдаг уу</p> <p>3. Урт хугацааны ковид- байгалийн эмчилгээ</p> <p>4. Хашимото- Сүүны хэрэглээг багасгасанаар шинжилгээний үзүүлэлт сайжирна</p> <p>5. Цусны хорт хавдрын эрсдэлийг мах ихэсгэдэг</p> <p>6. Сүүний үйлдвэр хуурамч судалгаа ашигласан</p> <p>7. Артерын даралт ихсэлт:Эдгээр эмнүүд буруутай байж болно</p> <p>8. Олон эм уушгийг гэмтээдэг</p> <p>9. Витамин Д дутагдал хавдар үүсгэх үү</p> <p>10. Ковидын үйл явц гэдэсний эсээс (darmflora) хамаарах</p> <p>11. Сепсисын хүндрэл нь хооллолтоос шалтгаалдаг.</p> <p>12. Маалингын үрийг халааж болох уу</p> <p>13. Нурууны өвдөлт: Энэ шалтгааныг хэн ч боддоггүй</p> <p>14. Дундаж наслалт: 100 жилээс огцом буурсан</p> <p>15. Байнгын утасны хэрэглээтэй холбоотой бэлгийн бойжилт эртэссэн</p> <p>16. 45-доош насныхны бүдүүн гэдэсний хорт хавдар нэмэгдсээр байна- Шалтгаан нь</p> <p>17. Эрүүл хооллолт нь хорт хавдрыг даван туулах боломжийг нэмэгдүүлдэг</p> <p>18. Эмэгтэйчүүд эрчүүдээс илүү урт насалдаг ч илүү өвчтэй байдаг</p>

